



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ



МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААРХ САНАЛ

Улаанбаатар хот
2020 он

О.МӨНХСАЙХАН

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн

Нийтийн эрх зүйн тэнхимийн профессор,

Хууль зүйн доктор

2020.03.05

ГАРЧИГ

ОРШЛЫН ОРОНД: САНАЛЫН ТОВЧЛОЛ.....	5
1. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН.....	14
1.1. ШЕЗ-ийн шүүгч гишүүнд тавих шаардлага, тэдгээрийг сонгох журам.....	14
1.2. ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнд тавих шаардлага	16
1.3. ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг томилох эрх бүхий этгээд	22
1.4. ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох журам.....	25
1.5. ШЕЗ-ийн бүрэлдэхүүн дэх жендэрийн эрх тэгш байдлыг хангах.....	33
1.6. ШЕЗ-ийн гишүүнээр нөхөн сонгогдсон, томилогдсон хүний бүрэн эрхийн хугацаа.....	34
1.7. ШЕЗ-ийн гишүүдийн бүрэн эрх ба эрх тэгш байдал	36
1.8. ШЕЗ-ийн тайлан ба ил тод байдал.....	38
1.9. ШЕЗ-ийн гишүүний баримтлах зарчим, хориглох зүйл	41
1.10. ШЕЗ-ийн дарга, гишүүний сахилгын зөрчил, сахилгын шийтгэл	45
2. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТОМИЛГОО	52
2.1. Шүүгчид тавих болзол, шаардлага	52
2.2. Шүүхийг бүрдүүлэхэд олон талт байдлыг хангах	56
2.3. Хуульчдаас шүүгчийг шилж олох ШЕЗ-ийн чиг үүрэг.....	59
2.4. Шүүхийн мэргэшлийн хороо, түүний бүрэн эрх	63
2.5. Шүүгчийн томилгоонд мерит зарчмыг хэрэгжүүлэх	69
2.6. ШЕЗ-өөс шүүгчид нэр дэвшигчийг дахин санал болгох босгыг өндөрсгөх.....	72
2.7. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн томилгоо.....	74
2.8. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийг сонгох	75
3. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ..	78
3.1. Шүүгчийн дотоод хараат бус байдал ба Улсын дээд шүүх.....	78
3.2. Шүүгчийг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах.....	87
3.3. Шүүгчийг чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах	90
3.4. Шүүгчийн урамшуулал ба хараат бус байдал	91
3.5. ШЕЗ-өөс шүүхийн төсвийн төслийг УИХ-д шууд өргөн мэдүүлэх	94

3.6.	Шүүхийн төсвийн төслийг хэлэлцэх явцад саналаа хэлэх боломжийг ШЕЗ-д олгох.....	96
3.7.	Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх	96
3.8.	Шүүгчийн тусгай саналыг хэвлэн нийтлэх	99
3.9.	Шүүгчдийн зөвлөл	102
4.	ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ЗӨРЧИЛ БА ШИЙТГЭЛ	106
4.1.	Шүүгчийн ёс зүйн дүрмийг иргэний нийгмийн оролцоотой, нээлттэйгээр боловсруулах.....	106
4.2.	Шүүгчийн ёс зүйн зөрчил ба сахилгын зөрчил.....	110
4.3.	Шүүгчийн ёс зүйн тайлбар ба зөвлөгөө.....	113
4.4.	Сахилгын тодорхой зөрчлийн жагсаалтыг хуульчлах	117
4.5.	Сахилгын шийтгэлийн төрлийг олшруулах	126
4.6.	Шүүгчийг огцруулах үндэслэлийг тодруулах.....	128
4.7.	Тохирсон байх зарчмыг хуульчлах	130
4.8.	Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгчийг түр түдгэлзүүлэх	132
5.	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО	134
5.1.	Шүүхийн сахилгын хорооны гишүүнд тавих шаардлага.....	135
5.2.	Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орохыг хориглох этгээд.....	139
5.3.	Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа	141
5.4.	Сахилгын хорооны дарга, гишүүнийг сонгох, томилох.....	143
5.5.	Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах.....	148
6.	ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА.....	149
6.1.	Шүүгчийн албан тушаал эрхлэхээс өмнөх болон дараах зөрчил	149
6.2.	Гомдлын хүрээгээр хязгаарлагдах эсэх.....	153
6.3.	Шүүгчийн сахилгын хэргийн хөөн хэлэлцэх хугацаа	157
6.4.	Мөрдөн шалгах чиг үүрэг ба бүрэн эрх	166
6.5.	Шалгах, нотлох болон шийдвэрлэх чиг үүргийг тусгаарлах ...	172
6.6.	Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг Улсын дээд шүүхэд давж заалдах.....	181
6.7.	Ил тод байдал	186

ОРШЛЫН ОРОНД: САНАЛЫН ТОВЧЛОЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны цахим хуудас дээр 2020.01.31-ний өдөр нийтэлсэн Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төсөл (цаашид "ШТХ-ийн төсөл" гэх)¹-ийг судалсны үндсэн дээр санал боловсруулав. Энэ саналд уг төслийн заалт бүрийг нэг бүрчлэн үнэлж дүгнэх бус, харин шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан, хариуцлагатай байдалд нөлөөлөх гол заалтуудыг сонгон авч, олон улсын сайн туршлага, дотоодод тулгарч байсан бэрхшээлээс авсан сургамж, өмнө хийж байсан судалгаанууддаа үндэслэн анализ хийхийг зорилоо. Мөн, Шүүхийн тухай хуулийн төслийн агуулга 2019.11.14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, түүнийг товч илэрхийлэл болсон Монгол Улсын Их Хурлын 2020.01.09-ний өдрийн "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 02 дугаар тогтоолд нийцсэн байдлыг нягтлахыг хичээсэн юм.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар байгуулсан Ажлын хэсэг нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн төслийг боловсруулах чиг үүрэгтэй ажиллаж байна. Энэ саналыг тус Ажлын хэсэгт 2020.03.05-ны өдөр цахим шуудангаар хүргүүлээд байна. Ажлын хэсгээс судлаач миний төдийгүй бусад иргэн, байгууллага, албан тушаалтны саналыг хүлээн авч, нухацтай хэлэлцэн ШТХ-ийн төслийг чамбайруулахаар ажиллаж буйд гүнээ талархаж байна.

Энэ санал нь (1) Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, (2) Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо, (3) Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал, (4) Шүүгчийн сахилгын зөрчил ба шийтгэл, (5) Шүүхийн сахилгын хороо, (6) Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн үндсэн бүлгээс бүрдсэн. Эдгээр зургаан бүлэг тус бүрт дэвшүүлсэн саналын товчлолыг танилцуулъя.

¹ Монгол Улсын Шүүхийн тухай хууль (Шинэчилсэн найруулга), Үзэл баримтлал, Танилцуулга, Дагалдах хуулиудын төслүүдийг ХЗДХЯ-ны цахим хуудаснаас харна уу.

1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн:

- Шүүхийн ерөнхий зөвлөл (цаашид "ШЕЗ" буюу "Ерөнхий зөвлөл" гэх)-ийн шүүгч биш гишүүн "шударга зан чанар, өндөр ёс зүйтэй" байх шаардлагыг тодруулан тусгах;
- Сүүлийн дөрвөн жил шүүгчийн албан тушаал, улс төрийн албан тушаал, улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлсэн хүнийг ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнээр томилохыг хориглох;
- ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүний дөрвийг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос дийлэнх олонхын саналаар, нэгийг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс томилох;
- ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүний нээлттэйгээр нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг нарийвчлан хуульчлах;
- ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байхаар заах;
- ШЕЗ-ийн гишүүний бүрэн эрх сонгож, томилсноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болохоор өөрчлөх;
- ШЕЗ-ийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авах, танилцах, хүндэтгэн үзэх шалтгаантай бол хуралдаанд цахим хэлбэрээр оролцох эсхүл саналаа бичгээр өгөх бүрэн эрхийг ШЕЗ-ийн гишүүнд олгох;
- ШЕЗ-ийн ээлжит бус хуралдааныг түүний даргын санаачилгаар, эсхүл дөрвөөс доошгүй тооны гишүүний шаардсанаар зарлан хуралдуулахаар заах;
- ШЕЗ-ийн ажлын тайланг бус харин шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой тайланг Шүүгчдийн зөвлөлд танилцуулахаар заах;
- ШЕЗ-ийн хуралдааныг нээлттэй явуулах, хуралдааныхаа товыг гурваас доошгүй хоногийн өмнө зарлаж хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, сонирхсон иргэдийг танхимын багтаамжийн хүрээнд болон цахим хэлбэрээр оролцуулах боломжоор хангах;

- ШЕЗ-ийн шийдвэрээ өөрийн цахим хуудсанд тогтмол нийтлэх, ажлын тайлангаа цахим хуудсанд жил бүр нийтлэх;
- ШЕЗ-ийн дарга, гишүүний хүлээх үүрэг, хориглох зүйлийг дэлгэрэнгүй, тодорхой хуульчлах;
- ШЕЗ-ийн дарга, гишүүнийг огцруулах үндэслэлийг тодруулах;
- ШЕЗ-ийн шүүгч гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Шүүгчдийн зөвлөл, бусад гишүүнийг огцруулах асуудлыг Хууль зүйн байнгын хороо тус тус нээлттэйгээр хэлэлцэж нийт гишүүнийхээ гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэх (огцруулах шийтгэл ногдуулахаас бусад зөрчлийг ШЕЗ өөрөө шийдвэрлэх), сахилгын зөрчилд буруутгагдаж буй ШЕЗ-ийн гишүүнд шударгаар шүүлгэх эрхийг эдлүүлэх, ШЕЗ-ийн гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан эсхүл санал өгсөн шийдвэрийнх нь агуулгад үндэслэн сахилгын шийтгэл ногдуулахыг хориглох.

2. Шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо:

- Шүүгчээр ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, өндөр ёс зүйтэй байхыг шүүгчид тавих шаардлагад нэмж тусгах;
- Шүүгч, өмгөөлөгч, прокуророо төдийгүй хууль зүйн их, дээд сургуулийн багшаар ажилласан туршлагатай хуульч Улсын дээд шүүхэд нэр дэвшихийг зөвшөөрөх;
- Дараах гурван хувилбарын аль нэгийг хуульчлах: (1) Шүүхийн мэргэшлийн хороо (цаашид "Мэргэшлийн хороо" гэх)-г татан буулгаж, ШЕЗ өөрөө шүүгчийн сонгон шалгаруулалт хийсний үндсэн дээр шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид санал болгох, (2) ШЕЗ нь Мэргэшлийн хорооны үнэлгээ процессын хувьд зөв явагдсан эсэхийг нягталсны үндсэн дээр уг үнэлгээний эрэмбээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгох, (3) ШЕЗ зөвхөн хуульд тодорхой заасан болзол, шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр Мэргэшлийн хорооны үнэлгээний эрэмбийг өөрчлөн өргөн мэдүүлж болох ч үндэслэлээ бичихийг үүрэгжүүлэх;

- Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд ШЕЗ-ийн болон Шүүхийн сахилгын хороо (цаашид "Сахилгын хороо" гэх)-ны дарга, гишүүн орохыг хориглох;
- ШЕЗ-ийн эсхүл Мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллаж байхдаа болон бүрэн эрх дуусгавар болсноос хойш гурван жилийн дотор шүүгчийн эсхүл ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвшихийг хориглох;
- Давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүнээс хүргүүлсэн тогтоолын дагуу Мэргэшлийн хороо шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэн дүгнэлт гаргасан бол шүүгчийг чөлөөлөх зохицуулалтыг хасах;
- Ерөнхийлөгч ШЕЗ-ийн санал болгосон нэр дэвшигчийг томилохоос татгалзсан бол ШЕЗ Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, үндэслэл тогтоогдоогүй бол хуралдаанд оролцсон гишүүний дийлэнх олонхын саналаар тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, үндэслэл тогтоогдсон бол хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгохоор өөрчлөх;
- Ерөнхийлөгч Улсын дээд шүүхийн санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхий шүүгчээр томилохоос татгалзсан бол үндэслэлээ мэдэгдэхийг үүрэгжүүлэх, үндэслэл тогтоогдоогүй бол Улсын дээд шүүхийг хуралдаанд оролцсон гишүүний дийлэнх олонхын саналаар тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, харин үндэслэл тогтоогдсон бол хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгохоор зохицуулах;

3. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал:

- Шүүхийн шийдвэрийг бичих аргачлал, журмыг тогтоох, зөвлөмж гаргах, ШЕЗ-тэй хамтран шүүгчийн сургалт зохион байгуулах (Улсын дээд шүүхийн дэргэдэх судалгааны хүрээлэнд сургалтын чиг үүрэг өгөхөөс татгалзах), шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар Мэргэшлийн хороонд хүргүүлэх бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд өгөхөөс татгалзах

(мөн, Улсын дээд шүүх хуульд заасны дагуу тахим байгуулахдаа Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэдэг байх);

- Шүүгч "томилолтоор ажиллах" болон "сэлгэн ажиллуулах" нь ялгаатай агуулгатай бол түүнийг тодруулах, томилолтоор ажиллахад шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг авах;
- Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид өгсөн агуулгатай заалтуудыг хасах;
- Шүүгчийн буруутай үйл ажиллагаатай холбоогүй үндэслэл (ШЕЗ-ийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсон, сураггүй алга болсонд тооцогдсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон зэрэг)-ээр шүүгчийг түдгэлзүүлэх, уул үндэслэл арилсан тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг сэргээх, мөн шүүгчийн буруутай үйл ажиллагаатай холбоогүй үндэслэл (хүсэлтээ бичгээр гаргасан, өөр албан тушаалд шилжсэн, томилогдсон, сонгогдсон зэрэг)-ээр шүүгчийг чөлөөлөх бүрэн эрхийг ШЕЗ-д өгөх;
- Шүүгчид олгох урамшууллын зохицуулалт нь урьдчилан тогтоосон, тодорхой байх шалгуурыг хангахгүйгээс шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулах магадлалтай тул уг зохицуулалтыг хасах;
- ШЕЗ бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг хуульд нийцүүлэн боловсруулж УИХ-д шууд өргөн мэдүүлэхээр хуульчлах (ийнхүү өргөн мэдүүлэхийн өмнө Засгийн газартай зөвшилцсөн байх заалтыг хасах);
- Шүүхийн төсвийн төслийг УИХ дээр хэлэлцэх үед уг төсөлтэй холбоотой асуултад хариулах, саналаа хэлэх боломжийг ШЕЗ-д олгохоор заах;
- Шүүх шийдвэрээ хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор цахим хуудсанд тогтмол байршуулж, хэвлэн нийтлэх, эдгээр ажиллагааг хийх хугацааг тодорхой тусгах;
- Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж архивт заавал хадгалж байхаар зохицуулах;

- Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтлэх эрхтэй байхаар заах;
- Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд анхан болон давж заалдах шатны шүүх тус бүр нийт шүүгчийнхээ тавин хувьтай тэнцүү тооны төлөөлөгчийг дотроосоо нууц санал хураалтаар сонгон илгээх эсхүл бүх шатны шүүхийн бүх шүүгчид оролцохоор зохицуулах;
- Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонхи төдийгүй нийт шүүгчийн 10 хувиас доошгүй тооны шүүгчид санал гаргасан бол Шүүгчдийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулах.

4. Шүүгчийн сахилгын зөрчил ба шийтгэл:

- Шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулахдаа олон улсын сайн туршлага, шүүгчийн хараат бус болон хариуцлагатай байдлын зарчимд тулгуурлах, хуульчид, эрдэмтэд, хууль зүйн чиглэлийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулах, Шүүгчийн ёс зүйн дүрмийн төслийг цахим хуудаст байрлуулснаас хойш 21 хоногийн дараа Шүүгчдийн зөвлөл нээлттэй хэлэлцэж батлах, Шүүгчийн ёс зүйн дүрэм Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байхаар заах;
- “Шүүгчийн ёс зүйн зөрчил” гэсэн нэр томъёог “шүүгчийн сахилгын зөрчил” гэж өөрчлөх,
- Шүүгчид тулгарч буй ёс зүйн асуудлаар өөрийнх нь хүсэлтээр зөвлөгөөг өгөх болон Шүүгчийн ёс зүйн дүрмийн тайлбар гаргах чиг үүрэгтэй хороог шүүгч болон шүүгч биш гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр Шүүгчдийн зөвлөл байгуулахаар тусгах;
- Шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх, урьдчилан харж үйл ажиллагаа зохицуулах боломжийг шүүгчид олгох, шүүхэд итгэх итгэлийг хамгаалахын тулд шүүгчид хориглох зүйлсийг тодорхой, дэлгэрэнгүй жагсаах, эдгээрийг зөрчвөл сахилгын шийтгэл ногдуулахаар хуульчлах;

- “Оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр хууль зүйн чиглэлээр багшлах” заалт нь багшлахыг шүүгчид зөвшөөрч буй мэт боловч бодит байдалд хэрэгжих боломжгүй тул “оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр” гэсэн шаардлагыг хасах;
- Шүүгчийн сахилгын зөрчилд ногдуулах шийтгэлийн төрлийг олшруулах (хаалгтай сануулах, нээлттэй сануулах, зэрэг дэвийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар бууруулах, зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах, нэг жил хүртэл хугацаагаар шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, огцруулах шийтгэлийг хуульчлах);
- Шүүгчийг огцруулах үндэслэлийг тодруулах (хуулиар хориглосон зүйл эсхүл Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой буюу удаа дараа зөрчиж шүүгчийн албан тушаал эрхлэхэд тохирохгүй нь илэрхий болсон бол огцруулахаар заах);
- Шүүгчийн сахилгын зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон сахилгын шийтгэл ногдуулах зарчмыг хуульчлах;
- Сахилгын хэрэгт буруутгагдаж буй шүүгчийн бүрэн эрхийг түр түдгэлзүүлэхгүй бол олон нийтэд эсхүл шударга шүүхийн тогтолцоонд ноцтой хохирол учрах үндэслэл, нотлох баримт байгаа бол Сахилгын хороо тухайн шүүгчийн бүрэн эрхийг 6 сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлэхээр зохицуулах.

5. Шүүхийн сахилгын хороо:

- Сахилгын хороог шүүгч, хуульч, эрдэмтдийн тэнцүү төлөөлөөс бүрдүүлэх, эдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх;
- Сүүлийн дөрвөн жилд шүүгчийн албан тушаал, улс төрийн албан тушаал, улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлсэн хүнийг Сахилгын хорооны шүүгч бус гишүүнээр томилохыг хориглох;
- Сахилгын хорооны гишүүний гурвыг Шүүгчдийн зөвлөлөөс, тавыг УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос дийлэнх олонхын саналаар, нэгийг Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус тус сонгох буюу томилох;

- Сахилгын хорооны гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг нарийвчлан хуульчлах;
- Сахилгын хорооны бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байх.

6. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа:

- Шүүгчийн албан тушаалд тохирох эсэхэд нь ноцтой эргэлзээ үүсгэж буй тохиолдолд тухайн шүүгчийн албан тушаалд томилогдохоос өмнө үйлдэгдсэн сахилгын зөрчлийг, мөн тэтгэвэрт гарсан, чөлөөлөгдсөн хүний шүүгчээр ажиллаж байх үеийн шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх эрх хэмжээг Сахилгын хороонд өгөх;
- Сахилгын хороо гомдол, мэдээллийг шалгах явцад гомдолд дурдагдаагүй боловч шүүгчийн сахилгын зөрчилд хамаарч болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйн талаарх үйл баримт илэрвэл тусгаарлан шалгах, хянан шийдвэрлэх;
- Шүүгчийн сахилгын зөрчил гарснаас хойш 5 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй байх, гомдол, мэдээллийг Сахилгын хороонд гаргаснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох, шүүгчид огцруулах шийтгэл ногдуулахаар зөрчил гаргасан бол энэхүү хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй байхаар заах;
- Шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхэд шаардлагатай мөрдөн шалгах бүрэн эрх (дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах, хууль сануулж мэдүүлэг авах, шинжээч томилох)-ийг Сахилгын хороонд өгөх (Сахилгын хорооны гишүүн дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, шаардсан мэдээлэл, нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй, худал мэдүүлэг өгсөн, мэдээлэл, нотлох баримтыг устгасан, өөрчилсөн бол торгох, үүнтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг Зөрчлийн тухай болон Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудад оруулах);

- Шүүгчийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгах, нотлох болон шийдвэрлэх чиг үүргүүдийг салгах (шүүгчийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгах, нотлох чиг үүрэг гүйцэтгэсэн Сахилгын хорооны гишүүн тухайн хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд оролцохыг хориглох);
- Зөвхөн сахилгын хэргийг шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлалын талаарх гомдлыг Улсын дээд шүүх хянан шийдвэрлэх, Улсын дээд шүүхийн эрх хэмжээг тус магадлал дахь хууль зүйн асуудлаар л хязгаарлах;
- Шүүгчийн сахилгын зөрчлийг илрүүлэх зорилгоор явуулж буй мөрдөн шалгах ажиллагаа нууц байх, харин сахилгын хэргийг шийдвэрлэх хуралдааныг нээлттэй явуулахаар заах;
- Шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн Сахилгын хорооны магадлал болон түүнийг гомдлын дагуу хянаж гарсан Улсын дээд шүүхийн тогтоолыг хүчинтэй болсон өдрөөс хойш долоо хоногийн дотор цахим хуудсанд байрлуулах, жил бүр эмхэтгэн хэвлүүлдэг байхаар хуульчлах.

1. ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ШТХ-ийн төслийг сайжруулахад санаа өгөх үүднээс саналын энэ бүлэгт (1.1) ШЕЗ-ийн шүүгч гишүүнд тавих шаардлага, тэдгээрийг сонгох журам; (1.2) ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнд тавих шаардлага; (1.3) ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнийг томилох эрх бүхий этгээд; (1.4) ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох журам; (1.5) ШЕЗ-ийн бүрэлдэхүүн дахь жендэрийн эрх тэгш байдлыг хангах; (1.6) ШЕЗ-ийн гишүүнээр нөхөн сонгогдсон, томилогдсон хүний бүрэн эрхийн хугацаа; (1.7) ШЕЗ-ийн гишүүдийн бүрэн эрх ба эрх тэгш байдал; (1.8) ШЕЗ-ийн тайлан ба ил тод байдал; (1.9) ШЕЗ-ийн гишүүний баримтлах зарчим, хориглох зүйл; (1.10) ШЕЗ-ийн дарга, гишүүний сахилгын зөрчил, сахилгын шийтгэл гэсэн хэсгийн хүрээнд санал, түүний үндэслэлийг бичиж, төсөлд тусгаж болох томъёоллыг бэлдсэн болно.

1.1. ШЕЗ-ИЙН ШҮҮГЧ ГИШҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА, ТЭДГЭЭРИЙГ СОНГОХ ЖУРАМ

ШТХ-ийн 78.2-т "...ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох таван шүүгчийг Шүүгчдийн зөвлөлөөс нууцаар санал хураан сонгосон Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн тус бүр нэг, анхан шатны шүүхийн гурван шүүгч тус тус орно" гэж заасан нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүдийн тавыг шүүгчид дотроосоо сонгож," УИХ-аас 2020.01.09-ний өдөр баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын 02 дугаар тогтоолын 3.1.1-д "Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож" гэж тус тус заасантай нийцэж байна. Нэг талаар, ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд анхан, давж заалдах, хяналтын гэсэн гурван шатны шүүхийн шүүгчдийг оруулах төдийгүй Монгол Улсын дийлэнх шүүгчид ажилладаг гэдгээр нь шүүгч таван гишүүний гурвыг анхан шатны шүүхийн шүүгчдээс сонгохоор заасан нь шүүгчдийн тоонд

хувь тэнцүүлсэн, тэнцвэртэй, шударга төлөөллийн зарчмыг хангажээ. Нөгөө талаар, гурван шатны шүүгчдийн тэнцвэртэй төлөөлөөс бүрдсэн Шүүгчдийн зөвлөлөөс ШЕЗ-ийн шүүгч гишүүдийг сонгохоор хуульчлах нь шүүгчдийн өөрөө удирдах ёсыг хангаж, ШЕЗ-д орох улс төрийн зүй бус нөлөөллийг саармагжуулсан сайн зохицуулалт болохоор байна.

ШТХ-ийн төслийн 20.5, 20.7-д зааснаар Шүүгчдийн зөвлөл нь ШЕЗ-ийн шүүгч гишүүнийг нууц санал хураалтаар олонхын саналаараа сонгохоор байна. Шүүхийн зөвлөлийн шүүгч гишүүдийг шүүгчдийн өргөн төлөөлөл нууц санал хураалтаар сонгох нь шүүх эрх мэдэлд хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс оролцох, улс төрийн нөлөөлөл орохоос хамгаалж, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах үүргээ биелүүлэхэд нь тусалдаг.

ШЕЗ-ийн шүүгч таван гишүүнд тавих шаардлагыг төсөлд тусгасан байна. ШТХ-ийн төслийн 78.3-т "Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч нь шүүгчээр таваас доошгүй жил ажилласан" байна, мөн төслийн 20.6-т "Шүүгчээр 5 жил ажиллаагүй, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгохгүй" гэж заажээ.

Шүүхийн зөвлөлийн шүүгч гишүүдийг сонгоход зөвхөн хяналтын болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид давамгайлбал шүүх эрх мэдлийг бүхэлд нь төлөөлж чадахгүй, шүүгчдийн өөрийн удирдлагын зарчим хэрэгжихгүй. Үүний оронд анхан шатыг оруулаад бүх шатны шүүхийн шүүгчийг шударгаар төлөөлөх байдлаар ардчилсан сонгуулиар бүрдүүлэхийг илүүд үздэг. Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага болон ХБНГУ-ын Макс Планкын институтээс зохион байгуулсан уулзалтаас гарсан Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах тухай Киевийн зөвлөмж (цаашид "Киевийн зөвлөмж" гэх)-д "шүүхийн зөвлөл дэх шүүгч гишүүд нь анхан шатны шүүхийн шүүгчдийг багтаах зэргээр шүүх эрх мэдлийг бүхэлд нь төлөөлдөг байх хэрэгтэй"² гэж заажээ. Мөн, Европын зөвлөлд үндсэн

² OSCE and Max Planck, "Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability," (Kyiv, 23-25 June 2010) 3.

хуулийн асуудлаар зөвлөх чиг үүрэгтэй Венецийн комисс (цаашид "Венецийн комисс" гэх)³ удаа дараагийн зөвлөмждөө шүүхийн зөвлөлийг шүүх эрх мэдлийг бүхэлд нь төлөөлж чадахуйцаар шударгаар бүрдүүлэхийг санал болгосон: "Шүүхийн зөвлөлийн шүүгч гишүүдийн хувьд өөр өөр шатны болон шүүхүүдээс шүүгчдийг тэнцвэртэй төлөөлж байх хэрэгтэй."⁴ Европын зөвлөлийн Сайд нарын хороо "Шүүхийн зөвлөлийн гишүүдийн талаас доошгүй нь шүүх эрх мэдэл доторх олон ургалч байдлыг хүндэтгэн бүх шатны шүүхийн шүүгчдээс сонгогдсон байх хэрэгтэй"⁵ гэжээ.

1.2. ШЕЗ-ИЙН ШҮҮГЧ БИШ ГИШҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА

Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгч биш гишүүнийг бодитой нөлөөтэй оруулах нь шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг сайжруулах, шүүх эрх мэдэл дэх ил тод, шударга, хариуцлагатай байдлыг хангах ач холбогдолтой. Шүүхийн зөвлөлд шүүгч биш гишүүнийг оруулах нь шүүх эрх мэдэлд нийтийн ашиг сонирхлоос илүү шүүгчийн явцуу ашиг сонирхлыг хамгаалах эрсдэлээс бууруулж, гаднын хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх нэг хэлбэр. Эдгээр шүүгч биш гишүүд нь шүүх эрх мэдэл доторх ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэхийн зэрэгцээ шүүх эрх мэдлийн хууль ёсоор хүлээн зөвшөөрөгдөх байдлыг дээшлүүлж, иргэн бүрийн үндсэн эрхийг

³ Энэхүү комиссын албан нэр нь "Ардчиллыг хуулиар бэхжүүлэхийн төлөө Европын комисс" (the European Commission for Democracy through Law) боловч Венец хотод хуралддаг учраас "Венецийн комисс" (the Venice Commission) гэсэн товч нэрээрээ алдаршсан. Иймд энэхүү саналд уг товч нэрийг нь хэрэглэсэн болно. Венецийн комиссын тухай дэлгэрэнгүйг дараахаас уншина уу: "The Venice Commission of the Council of Europe," https://www.venice.coe.int/WebForms/pages/?p=01_Presentation&lang=EN

⁴ CDL-AD(2012)024, Opinion on two Sets of draft Amendments to the Constitutional Provisions relating to the Judiciary of Montenegro, §23; CDL-AD(2011)010, Opinion on the Draft Amendments to the Constitution of Montenegro, as well as on the Draft Amendments to the Law on Courts, the Law on the State Prosecutor's Office and the Law on the Judicial Council of Montenegro, §39; CDL-AD(2011)019, Opinion on the introduction of changes to the constitutional law 'on the status of judges' of Kyrgyzstan, §31.

⁵ Recommendation CM/Rec(2010)12 of the Committee Of Ministers To Member States On Judges: Independence, Efficiency And Responsibilities, 4.

хамгаалагч гэдгийг нь бататгаж өгдөг.⁶ Шүүхийн зөвлөл дэх шүүгч биш гишүүдийн төлөөлөл нь зөвлөлийн бүрэлдэхүүний 1/3-1/2-ийн хооронд байвал түүний шийдвэр гаргалтад чухал хувь нэмэртэйд тооцогддог.⁷ “Шүүхийн зөвлөлийг шүүгч болон шүүгч биш гишүүдийн тэнцүү төлөөллөөр бүрдүүлэх нь улс төржилт, дарангуйллаас сэргийлэхийн зэрэгцээ нийгмийн оролцоог хангана”⁸ гэж Венецийн комисс зөвлөж байв.

Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүд нь иргэний нийгмийн аль болох олон талын төлөөллийг жинхэнээр төлөөлж байх хэрэгтэй. Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд шүүгчдээс сонгогдсон гишүүний жинтэй төлөөллийг оруулахаас гадна уг зөвлөлийн төлөөлөх чадварыг дээшлүүлэх, ил тод байдлыг хангах үүднээс хуульч болон хууль зүйн профессорыг тэнцвэртэй багтаах нь шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагын зарчмыг нэгэн зэрэг хангах нөхцөл болдог.⁹ Хамгийн амжилттай загвар бол шүүхийн зөвлөлийг хуулийн практик, академик (эрдмийн), иргэний нийгмийн хүрээнээс сонгогдсон эсхүл томилогдсон гишүүд бүхий холимог бүрэлдэхүүнтэй байгуулж, шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагыг хамгаалахад шаардлагатай эрх мэдлийг өгөх явдал юм.¹⁰

Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Шүүхийн ерөнхий зөвлөл (ШЕЗ) нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах зорилготой учраас өөрөө хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлийн оролцооноос ангид

⁶ Councils For The Judiciary – Report 2010-2011, paragraph 2.4.

⁷ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 9.

⁸ CDL-AD(2011)010, Opinion on the Draft Amendments to the Constitution of Montenegro, as well as on the Draft Amendments to the Law on Courts, the Law on the State Prosecutor’s Office and the Law on the Judicial Council of Montenegro, §520-22.

⁹ OSCE and Max Planck, “Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability,” (Kyiv, 23-25 June 2010) 3; European commission for democracy through law (the Venice Commission), “Judicial appointments” (Venice, 16-17 March 2007), 8; Venice Commission, Opinion on Recent Amendments to the Law on Major Constitutional provisions of the Republic of Albania, CDL-INF(1998)009, para. 12.

¹⁰ Councils For The Judiciary – Report 2010-2011, paragraph 2.2.

хараат бус, төвийг сахисан байх шаардлагатай. Үүний тулд ШЕЗ-ийн бүрэлдэхүүний талаас доошгүй нь шүүгчдээс сонгогдсон шүүгчид байх төдийгүй бусад гишүүн нь шүүгч бус байх хэрэгтэй боловч уг бүрэлдэхүүнд парламентын гишүүн болон сайдыг оруулахаас татгалзах шаардлагатай. ШТХ-ийн төслөөр ШЕЗ-ийн шүүгч бус таван гишүүнийг нэр дэвшүүлж, томилоход олон талын оролцоог хангах механизмыг тусгаж өгсөн нь тус зөвлөлд аль нэг субъектээс зүй бусаар нөлөөлөх эрсдэлийг бууруулж, тэнцвэрийг хангасан сайн талтай болжээ.

ШТХ-ийн төслийн 78.3-т "Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч нь шүүгчээр таваас доошгүй жил ажилласан, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна" гэж заажээ. Мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан байх шаардлага тавьж буй нь хууль зүйн мэргэжлийн онцлогийг ойлгох туршлага, мэдлэг, ур чадвартай байх суурь нөхцөл болж байна. Хууль зүйн өндөр мэргэшилтэй гэдэг нь туршлага, мэдлэг, ур чадвараас гадна уг ажлыг хийж чадах ёс зүй, зан төлөвтэй байх агуулгыг илэрхийлдэг тул энэ бүгд хамтдаа олон улсын сайн туршлагад харьцангуй нийцэх талтай. Эдгээр шалгуурыг хангасан хуульчид, эрдэмтэд, бусад иргэд ШЕЗ-д нэр дэвших боломж нээлттэй байна.

ШТХ-ийн төслийн 78.3-д заасан ШЕЗ-ийн шүүгч бус гишүүнд тавих шаардлагыг тусгасан сайн талтай болжээ. Гэвч, энэхүү шаардлагыг илүү нарийвчлан заах нь тэдгээрийг сонгон шалгаруулалт явуулж томилоход тустай. Тухайлбал, хуульчдаас шүүгчдийг шилж олох, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах зэрэг чухал чиг үүрэг бүхий ШЕЗ-ийн гишүүний үүргийг үнэнч, шударгаар биелүүлэхэд "шударга зан чанар, өндөр ёс зүйтэй" байх нь шийдвэрлэх үүрэгтэй тул үүнийг ШТХ-ийн төслийн 78.3-т нэмж хуульчлах саналтай байна. "Хууль зүйн өндөр мэргэшилтэй" гэдэг ерөнхий шаардлагад "шударга зан чанар, өндөр ёс зүй" багтах¹¹ боловч илүү нарийвчлан заах нь уг шалгуурыг хэрэглээнд оруулахад дөхөмтэй.

¹¹ О.Мөнхсайхан, "Монгол Улсын Үндсэн хуулийн хүрээнд Цэцийн гишүүний хараат бус, хариуцлагатай байдлыг хангах нь," Эрх зүй сэтгүүл №4 (36) (МУИС-Хууль зүйн сургууль 2016), 1-28.

Олон улсын сайн туршлагаар шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүн нь шүүх эрх мэдлээс гадуурх туршлага, ур чадварыг шүүхийн захиргаанд оруулж чадахуйц ёс зүйн өндөр шаардлага хангасан байх хэрэгтэй.¹² Шүүгчийг шилж олох, томилох чиг үүрэгтэй байгууллагад шүүгч, эрдэмтэн, хуульч зэрэг хууль зүйн өндөр мэргэжилтэн төдийгүй иргэний нийгмийн төлөөлөөс нь ёс зүйн өндөр шаардлага, тухайн ажилд хувь нэмэр оруулах мэдлэг, ур чадвараар шалгуур болгон оруулахыг зөвлөдөг.¹³

Санал: ШТХ-ийн төслийн 78.3-ын "хууль зүйн өндөр мэргэшилтэй," гэсний дараа "шударга зан чанар, өндөр ёс зүй" гэж нэмэх.

Хэдийгээр ШТХ-ийн төслийн 78.3-т ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнд тавих чухал шаардлагуудыг тусгасан боловч эдгээр таван орон тоонд шүүгчээр ажиллаж байгаа болон шүүгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан хуульчид, мөн улс төрчид томилогдож болохоор байгааг анхаарах шаардлагатай.

Шүүхийн зөвлөлийг шүүгчид болон тэтгэвэрт гарсан шүүгчид дангаар эсхүл давамгайлж бүрдүүлэх нь "шүүх гаднын хэрэгцээ, шаардлагыг ойлгох болон нийтийн өмнө хариуцлага хүлээх чадваруудын аль алийг алдаж, өөрөө өөрийгөө л анхаардаг байдал руу амархан шилжих тул уг зөвлөлд шүүгчид төдийгүй өмгөөлөгч, иргэний нийгмийн төлөөлөл, эрдэмтэд зэрэг "шүүхийн тогтолцооны үйлчлүүлэгчид"-ийг гишүүнээр оруулах нь чухал."¹⁴ Бельги, Нидерланд, Болгар, Франц, Итали, Румын, Словени, Испани зэрэг улсад парламентаас сонгогдсон буюу томилогдсон шүүхийн зөвлөлийн

¹² European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 11.

¹³ Мөн тэнд, 9.

¹⁴ CDL-AD(2012)020, Opinion on the Cardinal Acts on the Judiciary that were amended following the adoption of Opinion CDL-AD(2012)001 on Hungary, §533, 34.

гишүүнд өмгөөлөгч, хуульч, профессор, иргэний нийгмийн төлөөллийн баланс хангасан байдаг.¹⁵ Жишээлбэл, Бельгийн шүүхийн зөвлөл нь 22 шүүгч гишүүн, 22 шүүгч биш гишүүнтэй. Шүүгч биш гишүүн нь 10-аас доошгүй жил практикт ажилласан 4 хуульч, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан 3 профессор, дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан дөрвөн иргэнийг наад зах нь оруулсан байхыг шаарддаг.¹⁶ Мөн, Нидерландад шүүгчийг сонгон шалгаруулах хороо нь тэргүүлэгчид (нэг шүүгч, хоёр нарийн бичгийн дарга), 12 гишүүн, 5 төлөөлөгчдөөс бүрддэг байна.¹⁷ Эдгээр 12 гишүүний зургаа нь шүүгч. Шүүгч биш зургаа нь прокурорын байгууллагын нэгээс доошгүй төлөөлөл, нэг хуульч, шүүх эрх мэдлийн гадна ажилласан дөрөв хүртэл гишүүнтэй байхаар хуульчилжээ. Тиймээс, шүүгч биш гишүүн нь иргэний нийгэмд нэр хүндтэй, хүлээн зөвшөөрөгдсөн, жирийн иргэдийг бүхэлд нь төлөөлж чадах байдалд үндэслэн томилогдвол зохилтой бөгөөд практикт хуульчаар ажилласан, академик (эрдмийн) эсхүл бусад хагас хууль зүйн шинжтэй ажил алба эрхэлсэн байвал шүүхийн зөвлөлийн үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэг, туршлагын хувь нэмэр оруулах баталгаа болно.¹⁸

ШЕЗ-д шүүгчдийн төлөөлөл тав, шүүгч бус гишүүдийн төлөөлөл тав байх тэнцвэртэй бүрэлдэхүүнийг Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан. ШЕЗ-д таваас дээш тооны шүүгч эсхүл шүүгчийн албан тушаал эрхэлж байсан хүн ШЕЗ-д орвол бүрэлдэхүүний энэ тэнцвэр алдагдана. Идэвхтэй ажиллаж буй шүүгчтэй адилхан шүүгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарах зэргээр чөлөөлөгдсөн хүн бол шүүгчийн өнцгөөс асуудалд хандах тул ШЕЗ дахь шүүгч биш таван гишүүнд эдгээр хүмүүсийг нэр дэвшихийг хаах хэрэгтэй. Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүнд шүүгч төдийгүй шүүгчээр

¹⁵ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 20.

¹⁶ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 17.

¹⁷ Мөн тэнд, 18.

¹⁸ Councils For The Judiciary – Report 2010-2011, paragraph 2.5, 2.6.

ажиллаж байсан иргэнийг томилохыг хориглох нь олон улсын сайн туршлага юм.¹⁹

Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүдийг парламент дийлэнх олонхоор томилох нь зүйтэй ч энэ нь тус зөвлөлд парламентын гишүүн зэрэг улс төрчдийг томилно гэсэн үг биш. ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнээр УИХ-ын гишүүн, сайд зэрэг улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж буй эсхүл ойрын жилүүдэд эрхэлж байсан хүмүүсийг томилох нь тус зөвлөлийн үйл ажиллагааг улс төржүүлж шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулах тул эдгээрийг шүүхийн зөвлөлд оруулахыг хориглох нь сайн туршлагад тооцогддог. Шүүхийн зөвлөлийг улс төрөөс тусгаарлах үүднээс түүний гишүүн нь парламентын гишүүн зэрэг идэвхтэй улс төрч байж болохгүй.²⁰ "Шүүхийн зөвлөл эсхүл бусад холбогдох байгууллагын гишүүн нь тухайн ажлыг эрхлэхийн өмнөх болон дараах үндэслэл бүхий хугацааны дотор улс төртэй холбоотой үйл ажиллагаа явуулж болохгүй"²¹ гэж илүү өргөнөөр харахыг бас чухалчилдаг. Тийм учраас, ШЕЗ-д нэр дэвшихээс тодорхой хугацааны өмнө улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхлээгүй байх шаардлагыг хуульчлах саналтай байна.

¹⁹ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 12.

²⁰ CCJE Opinion No. 10, Para 23; Goda Ambrasaite – Balyniene, Comparative analysis on the High Councils for Judiciary in the EU member states and judicial immunity, (European Commission, 2015), 11; CDL-AD(2007)028, Report on Judicial Appointments by the Venice Commission, §32

²¹ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 12.

Санал: ШТХ-ийн төслийн 78.10-д “Байнгын хороо болон Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь сүүлийн дөрвөн жилд шүүгч, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээр томилохыг хориглоно.” гэсэн шинэ заалт нэмэх.

1.3. ШЕЗ-ИЙН ШҮҮГЧ БУС ГИШҮҮНИЙГ ТОМИЛОХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭД

ШТХ-ийн төслийн 78.2-т ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд УИХ-ын “Хууль зүйн байнгын хорооноос гурав, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хоёрыг тус тус нээлттэйгээр зохих журмын дагуу нэр дэвшүүлж томилох...”-оор заажээ.

Хууль зүйн байнгын хороо ШЕЗ-ийн гурван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлэн сонгон шалгаруулалт явуулсны үндсэн дээр гуравны хоёрын саналаар томилохоор зохицуулах нь тус зөвлөлийг бүрдүүлэхэд ил тод байх, оролцоог хангах, парламент дахь олонх болон цөөнхийн зөвшилцлийг бий болгоход чухал алхам болно. Гэвч, Хууль зүйн байнгын хорооноос томилох гишүүний тоог гурав биш дөрөв болгох саналтай байна. Учир нь, Хууль зүйн байнгын хороо нээлттэйгээр нэр дэвшүүлж сонгон шалгаруулалт явуулж томилох агуулга ШТХ-ийн төсөлд туссан хэдий боловч ШЕЗ-ийн гишүүний томилгоог гуравны хоёрын саналаар шийдвэрлэж буй нөхцөлд санал хураалтын үр дүнд УИХ дахь олонхын дэмжсэн хоёр, цөөнхөөс дэмжсэн нэг гишүүнийг томилох магадлал бодитой. Үүн дээр нэмээд хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ШЕЗ-ийн хоёр гишүүнийг томилохоор байна. Үүний үр дагавар юу болох вэ гэвэл ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүний дөрвийг УИХ дахь олонх болсон нам, эвслээс шууд болон шууд бусаар бүрдүүлж улс төрийн нэг талын хэт хүчтэй нөлөөлөл ШЕЗ-д орж улс төржүүлэх эрсдэлтэй. ШЕЗ-ийн

шүүгч биш таван гишүүнийг томилоход УИХ-д олонх болсон нам, эвсэл, түүний байгуулсан Засгийн газрын гишүүн давамгайлахаар байгаа нь УИХ-аас 2020.01.09-ны өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” УИХ-ын 02 дугаар тогтоолын 3.1.1-д “Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний тавыг шүүгчид дотроосоо хувь тэнцүүлэн сонгож, бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох...” чиглэлийг баримталж хууль боловсруулах шаардлагатай зөрчилдөж байна.

Шүүхийн зөвлөлийг бүрдүүлэхэд парламентыг зохистой хэмжээнд оролцуулах нь ардчилсан улсын мөн чанарт тохирдог. “Ардчилсан зарчмаар зохион байгуулагдсан тогтолцоонд шүүхийн зөвлөл нь парламентаар дамжин илэрхийлэгддэг ард түмний хүсэл зоригийн төлөөлөлтэй холбогдсон байх хэрэгтэй.”²² Тиймээс, шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүдийг бүрдүүлэхэд парламент чухал үүрэгтэй оролцох нь зүй ёсны хэрэг. Шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахын тулд шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүний гол хэсгийг шүүгчид дотроосоо сонгох, шүүхийн зөвлөлийн ардчилсан легитим шинжийг хангахын тулд бусад гишүүдийг парламентаас сонгох ёстой гэж Венецийн комисс үзсэн.²³

ШЕЗ-ын шүүгч биш таван гишүүний 40 хувийг гүйцэтгэх эрх мэдлийн субъект дангаар томилох нь шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал эрсдэлд оруулах төдийгүй ардчилсан легитим шинжээр сул, нээлттэй, ил тод, оролцоог хангах тал дээр учир дутагдалтай болно. Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүний томилгоог гүйцэтгэх эрх мэдэлд өгөхөөс татгалзах саналыг Европын

²² CDL-INF(1998)009, Opinion on recent amendments to the law on major constitutional provisions of the Republic of Albania, §§9, 19; CDL-AD(2002)026, Opinion on the Draft Law on Judicial Power and Corresponding Constitutional Amendments of Latvia, §13; CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§43-45.

²³ European commission for democracy through law (the Venice Commission), “Judicial appointments” (Venice, 16-17 March 2007), 7.

шүүгчдийн зөвлөлдөх зөвлөл гаргасан.²⁴ Венецийн комисс ч мөн шүүгч биш гишүүдийг Ерөнхийлөгч эсхүл бусад гүйцэтгэх эрх мэдлийн институтээр томилуулахаас татгалзаж, харин эдгээрийг парламентаар томилуулах буюу сонгуулах хувилбарыг дэмжиж ирсэн.²⁵

Дээрх үндэслэлээр ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүний дөрвийг УИХ-ын Хууль зүйн байнгын хороо гуравны хоёрын саналаар томилох, нэгийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилохоор зохицуулах саналтай байна. Салбарын бодлого боловсруулж хэрэгжүүлдэг гол яамны сайдаас ШЕЗ-ийн шүүгч биш нэг гишүүнийг томилох нь зохистой хүрээнд тус яам болон ШЕЗ-ийн уялдааг хангах, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах тал дээр илүү сайн ойлголцож итгэлтэй хамтран ажиллахад тустай. ШЕЗ-ийн шүүгч таван гишүүнийг бүх шатны шүүгчдээс бүрдсэн бүрэлдэхүүн (Шүүгчдийн зөвлөл) сонгож, шүүгч биш тавин гишүүний дөрвийг УИХ дахь олонх цөөнхийн аль алины хүлээн зөвшөөрлөөр буюу дийлэнх олонхоор томилох, үлдсэн шүүгч биш нэг гишүүнийг хууль зүйн салбарын бодлогыг хариуцсан сайд томилох нь ШЕЗ-ийн бүрэлдэхүүнийг зохистой тэнцвэржүүлж улс төрийн аль нэг нам, эвсэл давамгайлахаас сэргийлж шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлын баталгаа болно.

²⁴ Goda Ambrasaite – Balyniene, Comparative analysis on the High Councils for Judiciary in the EU member states and judicial immunity, (European Commission, 2015), 11.

²⁵ CDL-AD(2004)044, Interim Opinion on Constitutional Reforms in the Republic of Armenia, §57; CDL-AD(2010)042, Interim Opinion on the Draft Law on the High Council for judges and Prosecutors (of 27 September 2010) of Turkey, §34.

Санал. ШТХ-ийн төслийн 78.2-ыг "Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос /цаашид "Байнгын хороо" гэх/ дөрөв, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс нэгийг тус тус нээлттэйгээр зохих журмын дагуу нэр дэвшүүлж томилох бөгөөд ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох таван шүүгчийг Шүүгчдийн зөвлөлөөс нууцаар санал хураан сонгосон Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн тус бүр нэг, анхан шатны шүүхийн гурван шүүгч тус тус орно" гэж өөрчлөх.

1.4. ШЕЗ-ИЙН ШҮҮГЧ БИШ ГИШҮҮНИЙГ НЭЭЛТТЭЙГЭЭР НЭР ДЭВШҮҮЛЖ ТОМИЛОХ ЖУРАМ

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлийн ...бусад таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилно" гэж заасан. Энэ заалт нь ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох ажиллагаа мерит зарчимд нийцсэн, ил тод, олон талын оролцоог хангасан байх замаар тус зөвлөлийн гишүүний үүргийг хараат бусаар, шударга, зарчимч гүйцэтгэх хүнийг томилуулах шаардлагыг илэрхийлдэг. ШЕЗ-ийн шүүгч биш гишүүдийн томилгоог УИХ-ын Хууль зүйн байнгын хороонд болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд өгч буй тохиолдолд эдгээрийн аль алины томилгоо нь энэ шаардлагыг бүрэн хангах ёстой юм. Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүдийн томилгоог парламент болон хууль зүйн сайдад хариуцуулж буй нь тэд үзэмжээрээ хүссэн хүнээ энэ албан тушаалд сонгоно гэсэн утгагүй. Энэ хэсэгт ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох процессыг ил тод байлгах, иргэний нийгмийн оролцоог хангуулахад ямар зохицуулалтыг хуульчилж болох вэ гэдгийг авч үзье.

УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос ШЕЗ-ийн гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж "Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар" томилохоор заасан нь ШЕЗ-ийн шүүгч

бус гурван гишүүнийг томилгоонд парламент дахь олонх, цөөнхийн аль аль оролцох, зөвшилцлийг хангах, ШЕЗ-ийг тэнцвэртэй бүрдүүлэх сайн талтай болсон тул энэ журмыг бүрэн дэмжиж байна. Байнгын хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар томилох нь УИХ дахь олонх цөөнхийн тэнцвэртэй оролцоог хангах тул УИХ-аас 2020.01.09-нд баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын 02 дугаар тогтоолын 3.1.1-д заасан "Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор түүний бүрэлдэхүүний ...бусад (шүүгч биш) таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох..." гэх чиглэлд нийцэж байна.

Парламент иргэдийг төлөөлж буйн хувьд шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүнийг томилж болох ч улстөржилтийг багасгахын тулд парламент дахь олонхын хэт нөлөөг сааруулж цөөнхийн бодит оролцоог хангадаг. Өөрөөр хэлбэл, шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүнийг томилоход цөөнхийн дэмжлэг авсан эсэх бүрэн биш юмаа гэхэд тодорхой хэмжээнд шийдвэрлэх үүрэгтэй байх процедурын баталгаагаар хангах хэрэгтэй. Энэ зорилгод хүрэхэд наад зах нь хоёр янзын арга байгаагаас нэгийг сонгох боломжтой. Нэг дэх арга нь шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүдийг парламентын дийлэнх олонхын санал (гуравны хоёр, дөрөвний гурав гэх мэт)-аар сонгох.²⁶ Хоёр дахь арга нь шүүгч биш гишүүдийн талыг парламентын олонхоор, үлдсэн талыг парламентын цөөнхөөр томилуулах.²⁷ Эхний арга буюу дийлэнх олонхын саналаар томилох нь хоёр дахь аргаасаа илүү түгээмэл төдийгүй олонх болон цөөнхийн бүтээлч оролцоог хангаж мерит зарчмыг хэрэгжүүлэх илүү боломжтой.

²⁶ European commission for democracy through law (the Venice Commission), "Judicial appointments" (Venice, 16-17 March 2007), 7; Venice Commission, Opinion on the Draft Law on Amendments to the Judicial System Act of Bulgaria, CDL-AD (2002) 015, para. 5; European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 11.

²⁷ CDL-INF(1998)009, Opinion on recent amendments to the law on major constitutional provisions of the Republic of Albania, §19.

Парламент иргэдийг төлөөлж буйн хувьд шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүнийг дийлэнх олонхын саналаар томилох нь парламент дахь зөвшилцлийг бүрдүүлэхэд цөөнхийг шийдвэрлэх үүрэгтэйгээр оролцуулахад болон улстөржилтийг багасгахад хэрэгтэй сайн туршлага гэж үздэг. Жишээлбэл: Испани (3/5), Итали (2/3)-д Шүүхийн зөвлөлийн гишүүдийг парламентын гишүүдийн дийлэнх олонхын саналаар томилдог. Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүний гол хэсгийг шүүгчид өөрсдөө дотроосоо сонгосон шүүгч гишүүдээр бүрдүүлэхийн зэрэгцээ бусад гишүүдийг парламент шаардлага хангасан иргэдээс дийлэнх олонхын саналаар томилох нь ардчилсан легитим шинжийг илүү сайн хангаж хүлээн зөвшөөрөгдөж, эдгээр шүүгч биш гишүүнийг тэнцвэртэй бүрдүүлэхэд парламент дахь цөөнхийн оролцоог хангана.²⁸ Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүдийг сонгохдоо парламентын дийлэнх олонхын санал авсан байх гэсэн өндөр босго тавьснаар парламент дахь улс төрийн хүчний харьцааг тусгахын зэрэгцээ парламент дахь олонх өөрийнхөө хүнийг түлхүү томилдог байдал үүсэхээс сэргийлнэ.²⁹

ШТХ-ийн төслийн 79.1.3-т "Байнгын хороо ажлын хэсэг байгуулж, 15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна" гэж сонгон шалгаруулалт явуулахаар заасан нь УИХ-аас 2020.01.09-нд баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" УИХ-ын 02 дугаар тогтоолын 3.1.1-д "Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, хараат бус, тогтвортой байдлыг хангах зорилгоор ...бусад таван гишүүнийг бусад институцээс тэнцвэртэй оролцооны үндсэн дээр нээлттэй нэр дэвшүүлэн, сонгон шалгаруулж томилох..." чиглэлийг баримталж хууль боловсруулах шаардлагад нийцэж байна. Байнгын хорооноос байгуулах энэхүү ажлын хэсэг нь нэр

²⁸ CCJE Opinion No. 10, Para 32; CDL-AD(2007)028, Report on Judicial Appointments by the Venice Commission, §29; CDL-AD(2008)006, Opinion on the Draft Law on the High Judicial Council of the Republic of Serbia, §76 .

²⁹ CDL-AD(2003)012, Memorandum: Reform of the Judicial System in Bulgaria, §15; CDL-AD(2003)016, Opinion on the Constitutional Amendments reforming the Judicial System in Bulgaria, §25; CDL-AD(2008)006, Opinion on the Draft Law on the High Judicial Council of the Republic of Serbia, §§19, 21; CDL-AD(2008)009, Opinion on the Constitution of Bulgaria, §25.

дэвшигчдээс ШЕЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хэн хамгийн сайн хангасан бэ гэдгийг гаргаж танилцуулах маш чухал үүрэг гүйцэтгэнэ. Иймээс, тус Ажлын хэсгийг мэргэжлийн, хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүсээс тэнцвэртэй бүрдүүлэх шаардлагатай. Үүний тулд ажлын хэсгийг байгуулах шийдвэрийг Байнгын хороо мөн гуравны хоёроос доошгүйн саналаар байгуулахаар хуульчлах хэрэгтэй. Байнгын хороо нь ердийн олонхын саналаар Ажлын хэсгийг байгуулбал тухайн ажлын хэсэгт УИХ дахь олонх суудал авсан нам, эвслийн нөлөөлөл давамгайлж, улмаар улс төрийн хувьд нэг талыг барьсан сонгон шалгаруулалт явагдах эрсдэлтэй. Тиймээс, УИХ-д суудал бүхий бүх нам, эвслийн оролцоог тэнцвэртэй хангаж хүлээн зөвшөөрсөн, хараат бус, шударга хүмүүсээр ажлын хэсгийг бүрдүүлэхийн тулд Ажлын хэсгийг бүрдүүлэхэд дийлэнх олонхын өндөр босго тавих хэрэгтэй.

Нэр дэвшигчийг сонгон шалгаруулах чиг үүрэгтэй ажлын хэсгээс ШЕЗ-ийн гишүүнд тавих шаардлагыг хамгийн сайн хангасан нэг хүнийг парламентад санал болгодог байх нь парламентын үзэмжийг хязгаарладаг. "Парламент нь олон нэр дэвшигчээс шууд сонгодог байж болохгүй бөгөөд "эрх бүхий нэр дэвшүүлэгчид" нь сул орон тоонд зөвхөн нэг нэр дэвшигчийг санал болгодог байх хэрэгтэй. Энэ нь Шүүхийн зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэхэд хэт улс төрийн шалгуураар хандахаас сэргийлэх ганц шийдэл гэж харагдаж байна."³⁰ ШТХ-ийн төслийн 79.1.4-т "Байнгын хороо 7 хоногийн дотор хэлэлцэж, Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилно" гэж заасан байх бөгөөд үүнд хэдэн нэр дэвшигчийг хэлэлцэх тухай тодорхой тусгагдаагүй байна. Харин, төслийн 79.1.5-т "Байнгын хороо нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнд томилохоос татгалзсан бол арван дөрвөн хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ," мөн 79.1.6-т "Байнгын хороо нэр дэвшигчийг татгалзсан тохиолдолд тухайн хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй" гэж бичсэн байгаагаас үзэхэд сонгон шалгаруулалтын дүнд хамгийн өндөр үнэлгээ авсан нэг хүнийг томилох эсэхийг Байнгын хороо хэлэлцэх агуулгатай байна.

³⁰ CDL-AD(2008)006, Opinion on the Draft Law on the High Judicial Council of the Republic of Serbia, §48.

Шүүхийн зөвлөл шүүхийн хараат бус байдал, хууль дээдлэх ёсыг хамгаалахын тулд үр нөлөөтэй ажиллах нь зөвхөн хуульчдын холбоо, эрдэм шинжилгээний байгууллага, шүүх эрх мэдлийн асуудал гэхээс илүүтэй нийт иргэний нийтлэг ашиг сонирхол учраас зөвлөлийн гишүүний томилгоог хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургуулиудын захирлуудын хуралдаанд шууд өгөх зүйтэй эсэх нь эргэлзээтэй.³¹ Гэхдээ, хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургуулиуд зэрэг мэргэжлийн хамт олон нь өөрийн удирдлагыг хэрэгжүүлж, бие даан ажилладаг төдийгүй шүүхийн хараат бус байдал, хууль дээдлэх ёсонд илүү санаа тавьж байдаг учраас эдгээрийг шүүхийн зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэх, томилоход бүтээлчээр үр нөлөөтэй оролцуулахаар хуульчлах нь чухал.

Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүний томилгоо дахь улс төржилтийг сааруулах өөр нэгэн арга бол тэдгээрийг нэр дэвшүүлэх ажиллагаа нээлттэй, ил тод байх, олон нийтийн байгууллагын оролцоог хангахаар хуульчлах явдал бөгөөд энэ нь "нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох" тухай Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтын үзэл баримтлалд нийцнэ. Жишээлбэл, шаардлага хангасан иргэн өөрөө нэр дэвших боломжтой байхаас гадна мэргэжлийн байгууллага, хамт олноос түүний зөвшөөрлийн үндсэн дээр нэр дэвшүүлэх боломжтой байх хэрэгтэй. Тодруулбал, шүүхийн зөвлөлд нэр дэвшүүлэхэд хуульчдын холбоо, өмгөөлөгчдийн холбоо, их сургууль, төрийн бус байгууллага зэрэг бие даасан байгууллагуудыг албан ёсоор татан оролцуулж сонгон шалгаруулалтыг тусгайлан байгуулсан Ажлын хэсгээр гүйцэтгүүлэх зөвлөмжийг Венецийн комиссоос удаа дараа гаргаж ирсэн.³² Мөн түүнчлэн, нэр дэвшигчдийн талаар олон нийтийн байгууллага санал, дүгнэлт гаргах, асуулт тавих боломжийг хуулиар баталгаатай олгох нь нэр дэвшигч ШЕЗ-д шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах зорилгоор чин шударгаар,

³¹ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §48.

³² European Commission For Democracy Through Law (Venice Commission) Bulgaria Opinion On The Judicial System Act, CDL-AD(2017)018, 7; European Commission For Democracy Through Law (Venice Commission), Final Opinion On The Revised Draft Constitutional Amendments On The Judiciary, CDL-AD(2016)009, 5.

хараат бусаар ажиллаж чадах эсэхийг үнэлэхэд чухал мэдээлэл авах суваг болно. Шүүхийн зөвлөлийн шүүгч биш гишүүнийг нэр дэвшүүлэх зэргээр сонгон шалгаруулах, томилох үе шатуудад иргэний нийгмийг оролцуулах хэрэгтэй гэж Шүүхийн зөвлөлүүдийн Европын сүлжээ байгууллага зөвлөжээ.³³

ШЕЗ-ийн гишүүнд нэр дэвших буюу дэвшүүлэх тухай хүсэлт, мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн талаарх намтар, хувийн ашиг сонирхлын мэдүүлэг, хөрөнгө орлогын мэдүүлгийн Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлж, хуульчид, судлаачид, иргэд болон олон нийтийн байгууллагаас санал, шүүмж, асуулт тавих боломжоор хангах нь "нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох" тухай Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн заалтын үзэл баримтлалд илүү нийцнэ, сонгон шалгаруулалт, томилгооны процессыг илүү мэдээлэлжүүлж зөв шийдвэр гарахад тусална. Шүүхийн зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн тухай болон сонгон шалгаруулахтай холбоотой бүхий л баримт бичиг нь олон нийтэд нээлттэй, ил тод байх хэрэгтэй гэж олон улсын сайн туршлага харуулдаг.³⁴

Ажлын хэсэг нэр дэвшигчийг бүртгэх, нийтэд танилцуулах, судалгаа, ярилцлага хийсний үндсэн дээр сонгон шалгаруулах, иргэний нийгмийн байгууллагуудаас асуулт, санал авах, томилгооны сонголт хийх гэх мэт ажиллагаа явуулахад 14 хоног арай богинодох тул уул хугацааг уртасгахын зэрэгцээ хэзээнээс эхэлж яаж тоолохыг тодорхой заах нь зүйтэй.

ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох талаар энд авч үзсэн үндэслэлүүдийг тооцож, олон улсын сайн туршлагад тооцогдсон Болгарын шүүхийн зөвлөлийн гишүүнийг парламентаас томилох зохицуулалт дээр тулгуурлан доорх саналыг боловсруулав.³⁵ Энэхүү санал болгож буй нарийвчилсан журмыг

³³ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 11.

³⁴ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 20.

³⁵ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 20-21.

Хууль зүйн байнгын хороо эсхүл сайдаас баталж болох боловч үүнийг зохистой агуулгаар батлахгүй байх магадлал бий. Мөн, ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг сонгон шалгаруулж томилох чиг үүрэгтэй Байнгын хороо болон сайд нь уг чиг үүргээ хэрэгжүүлэх журмыг өөрөө баталбал ашиг сонирхлын зөрчил үүсэж, явцуу сонирхлоор хандах эсхүл улс төржүүлэх эрсдэлтэй. Иймд ШЕЗ-ийн шүүгч биш таван гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлэх, сонгон шалгаруулах, томилох журмыг аль болох нарийвчлан, тодорхой байдлаар хуульчлах хэрэгтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 79-р зүйлийг дараах байдлаар өөрчлөх:

"79.1.Байнгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, томилно.

79.1.1.Ерөнхий зөвлөлийн дарга Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас далаас доошгүй хоногийн өмнө Байнгын хороонд энэ тухай мэдэгдэх бөгөөд уул хугацаа дуусахаас жараас доошгүй хоногийн өмнө Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

79.1.2.Сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш гуч хоногийн дотор энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн өөрөө нэр дэвших хүсэлтийг эсхүл түүний зөвшөөрснөөр нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн их, дээд сургууль нэр дэвшүүлэх тухай хүсэлтийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн талаарх намтар, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хамт Байнгын хороонд хүргүүлнэ. Эдгээр баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

79.1.3.Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг хараат бусаар, үнэнч шударгаар, төвийг сахиж явуулах нэр хүнд бүхий иргэдээс Ажлын хэсгийг бүрдүүлж байгуулна. Байнгын хороо ажлын хэсгийг гуравны хоёроос доошгүйн саналаар байгуулж, энэ зүйлийн 79.1.1-д заасны дагуу мэдээлснээс хойш 30 хоногийн дараа 45 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах бөгөөд ажлын хэсэг хамгийн өндөр үнэлгээ авсан нэр дэвшигчийн талаарх үндэслэл бүхий тайланг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

79.1.4.Энэ зүйлийн 79.1.3-т заасны дагуу тайланг нийтэлснээс хойш 7 хоногийн дотор нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн их, дээд сургууль, иргэд нэр дэвшигчийн талаарх асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд эдгээр асуулт, саналыг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

79.1.5.Байнгын хороо энэ зүйлийн 79.1.3-т заасны дагуу тайланг нийтэлснээс хойш 7 хоног өнгөрсний дараа 21 хоногийн дотор томилгооны сонголт явуулсны үндсэн дээр нээлтэй хэлэлцэж нууц санал хураалт явуулж Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилно.

79.1.6.Байнгын хороо нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнд томилохоос татгалзсан бол дахин сонгон шалгаруулалтыг нийтэд даруй мэдээлж, энэ зүйлд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлж томилно.

79.1.7.Байнгын хороо нэр дэвшигчийг татгалзсан тохиолдолд тухайн хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

79.2.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилохдоо энэ зүйлийн 79.1.1, 79.1.2, 79.1.3, 79.1.4, 79.1.5, 79.1.6, 79.1.7-д заасан журмыг баримтлах бөгөөд Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална."

1.5. ШЕЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН ДЭХ ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

Төрийн албаны тухай 2017 оны хуулийн 12.1.2-т зааснаар "шүүхийн захиргаа"-ны удирдах, гүйцэтгэх албан тушаалтны хувьд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн нь төрийн захиргааны албан тушаалтан гэж ойлгож байна. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай 2011 оны хуулийн 10.1.2-т төрийн захиргааны удирдах албан тушаалтнаас заримыг нь нэрлэн зааж хүйсийн квот тавих бодлогыг хэрэгжүүлэхээр заасан байх боловч үүнд шүүхийн захиргааны удирдах, гүйцэтгэх албан тушаалтыг багтаагаагүй байна. Гэхдээ, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10.2-т "Төрийн байгууллагын дэргэдэх болон үндэсний хэмжээний хороо, зөвлөл, комисс (цаашид "хороо" гэх) зэрэг зөвлөлдөх буюу хамтын удирдлагын байгууллагад аль нэгэн хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байна" гэсэн заалтын хүрээнд ШЕЗ-ийн бүрэлдэхүүн хамрахаар байх тул түүнд аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байна гэж ойлгох боломжтой. Уг хуулийн 10.1-д зааснаар төрөөс эрэгтэй, эмэгтэй хүний төрийн албанд орох, албан тушаал эрхлэх тэгш эрх бодитой хэрэгжих боломж, нөхцөлөөр хангахын тулд ШЕЗ-ийн бүрэлдэхүүн дэх аль нэг хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байх бодлогыг Монголын төр хэрэгжүүлэх үүрэгтэй.

Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүн нь нийгэм дэх олон талт байдлыг аль болох тусгасан байхаар зохицуулагдах нь зүйтэй.³⁶ Бүрэлдэхүүний олон талт байдал нь шүүгчийг шилж олох зэрэг үүргээ тал талын амьдралын туршлага, ертөнцийг үзэх үзлээр тугаан үзэж илүү бодитой, чанартай хэрэгжүүлэхэд тусална. Олон талт бүрэлдэхүүний нэг үндсэн шинж бол эрэгтэй болон эмэгтэй хүйсийн хүмүүсээс тэнцвэртэй бүрдүүлэх явдал юм. Олон улсын сайн туршлагаар нийтийн ашиг сонирхлын төлөө шийдвэр гаргах, удирдах чиг үүрэгтэй байгууллагад эмэгтэй эсхүл эрэгтэй аль нэг хүйсийн төлөөлөл 40 хувиас доошгүй байх шаардлага бий.³⁷ Шүүхийн зөвлөлийн бүрэлдэхүүнд жендэрийн

³⁶ 2007 CCJE Opinion No. 10 on the Council for the Judiciary at the Service of Society.

³⁷ The Preamble of the Appendix to the CoE Recommendation CM/Rec(2003)3 of the Committee of Ministers to CoE Member States on the Balanced Participation of Women and Men in Political and Public Decision-making, adopted on 30 April 2002.

тэгш төлөөллийг оруулах баталгааг хуульчлах хэрэгтэй гэж Венецийн комисс зөвлөдөг.³⁸

Санал: ШТХ-ийн 79.7-д "Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байх бөгөөд эрх бүхий этгээд Ерөнхий зөвлөлийн гишүүнийг сонгох, томилохдоо энэхүү шаардлагыг баримтална" гэж нэмэх.

1.6. ШЕЗ-ИЙН ГИШҮҮНЭЭР НӨХӨН СОНГОГДСОН, ТОМИЛОГДСОН ХҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

Нөхөн сонгогдсон буюу томилогдсон Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байхаар хуульчилбал ШЕЗ-ийн бүх гишүүний бүрэн эрх дандаа нэгэн зэрэг дуусаж, 100 хувь шинээр бүрдэх болно. Ингэснээр ШЕЗ-ийн ажлын залгамж чанар алдагдах, сүүлийн дөрвөн жилд тогтсон сайн практик огцом өөрчлөгдөх эрсдэлийг дагуулж, шүүхийн захиргааны хөгжилд саад болно. Жишээлбэл, ШЕЗ-ийн хуралдааны ирц дийлэнх олонхоор бүрдэхээр төсөлд заасан тул гишүүдийн бүрэн эрх нэгэн зэрэг дуусаж шүүгчид нэр дэвшүүлэх, шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хамгаалах зэрэг үүргээ гүйцэтгэх боломжгүй болж, ШЕЗ-ийн үйл ажиллагаа тасалдана. Мөн, нөхөн сонгогдсон буюу томилогдсон гишүүнийг дөрвөөс доош жилээр 1, 2, 3 жилээр ажиллуулах нь тухайн ажилтай танилцах, мэргэших боломжийг хязгаарлана. Польш улсад Шүүхийн зөвлөлийн гишүүдийн бүрэн эрх нэгэн зэрэг дуусгавар болох, нөхөн томилогдсон гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байх зохицуулалт нь дээрх шиг хүндрэл үүсэх учраас хасах, оронд нь гишүүний бүрэн эрх дараагийн гишүүн томилогдсоноор дуусгавар болохоор зааж

³⁸ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§32 and 35.

зөвлөлийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахыг зөвлөж байжээ.³⁹ Тиймээс, ШТХ-ийн төслийн 79.6-г хасах нь зүйтэй. Үүний оронд "Гишүүний бүрэн эрх сонгож, томилсноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно" гэж хуульчилбал орон гарсан гишүүний оронд томилогдсон гишүүн дөрвөн жилээр томилогдоно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар ШЕЗ-ийн гишүүний бүрэн эрх хугацаанаасаа өмнө дуусгавар болбол үүний оронд томилогдсон буюу сонгогдсон гишүүн дөрвөн жилийн хугацаагаар ажиллаж, улмаар бүрэлдэхүүний тодорхой хувь сөөлжлөн томилогдох байдал үүснэ (жишээлбэл, тодорхой хугацааны дараа Үндсэн хуулийн цэцийн бүрэлдэхүүн ийм зохицуулалтын үр дүнд тодорхой хэмжээнд сөөлжилдөг болсон).

ШЕЗ-ийн бүрэлдэхүүний залгамж чанарыг хангах илүү тодорхой арга замыг хуульчлах бас боломжтой. "Сөөлжсөн бүрэн эрхийн хугацаа зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтмол шинэчлэхийн зэрэгцээ залгамж чанарыг хангахад тусалж магадгүй."⁴⁰ Тухайлбал, ШЕЗ-ийн эхний бүрэлдэхүүн хоёр шүүгч гишүүнийг дөрвөн жилээр, нэг шүүгч гишүүнийг гурван жилээр, нэг шүүгч гишүүнийг хоёр жилээр, нэг шүүгч гишүүнийг нэг жилээр, шүүгч биш гишүүдээс хоёрыг нь дөрвөн жилээр, нэгийг нь гурван жилээр, нэгийг нь хоёр жилээр, нэгийг нь нэг жилээр тус тус томилоод, үүнээс хойш бүх томилгоог дөрвөн жилээр явуулах боломжтой. Ийм зохицуулалт хийвэл хоёр дахь бүрэлдэхүүнээс эхлээд ШЕЗ-ийн гишүүдийн дөрөвний нэг нь жил бүр шинэчлэгдэхийн зэрэгцээ үлдсэн гишүүд нь залгамж чанараа хадгална. Мөн, УИХ-ын Хууль зүйн байнгын хорооны нэг бүрэлдэхүүн эсхүл хууль зүйн сайд ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд хэт их нөлөөлөл орохуйц томилгоо хийх эрсдэлийг саармагжуулна.

³⁹ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 22.

⁴⁰ Violaine Autheman and Sandra Elena, "Global Best Practices: Judicial Council (Lessons Learned from Europe and Latin America)" (IFES Rule of Law White Paper Series, 2004), 18, <http://pdf.usaid.gov/pdfdocs/PBAAB591.pdf>.

Санал: ШТХ-ийн төслийн 79.6-д "Нөхөн сонгогдсон буюу томилогдсон Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна" гэж заасныг хасах эсхүл "Гишүүний бүрэн эрх сонгож, томилсноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно" гэж өөрчлөх.

1.7. ШЕЗ-ИЙН ГИШҮҮДИЙН БҮРЭН ЭРХ БА ЭРХ ТЭГШ БАЙДАЛ

ШЕЗ-ийн шүүгч болон шүүгч биш гишүүд, орон тооны болон орон тооны бус гишүүд өөр хоорондоо тэгш эрхтэй байх хэрэгтэй. Жишээлбэл, ШТХ-ийн төслийн 83.1.1-д "орон тооны гишүүний хувьд Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг хариуцах" гэж заасан нь Ерөнхий зөвлөлийн орон тооны гишүүн орон тооны бус гишүүнээсээ давуу эрх эдлэх мэтээр ойлгогдож хэрэгжихээс сэргийлэх нь зүйтэй болов уу.

ШЕЗ-ийн орон тооны болон орон тооны бус гишүүдийн тэгш эрхийг хангах нэг арга зам бол тэдгээрийг хуралдаанд бэлтгэх, оролцуулах, саналаа өгөх өргөн боломжоор хангах явдал юм. Жишээлбэл, шүүхийн зөвлөлийн хуралдаанаас өмнө холбогдох баримт бичигтэй танилцах замаар мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах, санал, байр сууриа бичгээр илэрхийлэх, мэдээлэл харилцааны технологи ашиглан хуралдаанд зайнаас оролцох зэрэг бүрэн эрхийг гишүүнд эдлүүлэхийг зөвлөдөг.⁴¹ Эдгээрийг ШЕЗ-ийн дотоод журмаар зохицуулах боломжтой ч алсдаа дарга эсхүл орон тооны гишүүд нь хэт нөлөөтэй болох зэргээс үүдэн орон тооны бус гишүүдийн эдгээр эрх хангагдахгүй байдал үүсэх эрсдэлтэй тул хуульд тодорхой заах нь чухал.

⁴¹ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 28.

ШЕЗ нь чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай тоогоор тогтмол хуралддаг байх хэрэгтэй.⁴² Үүнээс гадна Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хүрээний чухал асуудлыг хэлэлцэх үүднээс ээлжит бус хуралдаан зарлах боломжтой байх хэрэгтэй. ШТХ-ийн төслийн 81.4-т "Ерөнхий зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхий зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл гишүүдийн олонхын шаардсанаар зарлан хуралдуулна" гэж заажээ. Энэ зохицуулалт нь ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулахад ШЕЗ-ийн даргад хэт давуу эрх олгохын зэрэгцээ гишүүдийн санаачилгаар зарлан хуралдуулахад хэт хүндрэлтэй болгож байна. Өөрөөр хэлбэл, гишүүдийн олонх гэхээр 6-аас доошгүй гишүүн санаачилж байж ээлжит бус хуралдаан хийхээр байна. Ийм учраас ШЕЗ-ийн дөрвөөс доошгүй гишүүний санаачилгаар ээлжит бус хуралдааныг зарлах боломжтой болгох нь гишүүдийн тэгш эрхийг хангах, хойшлуулшгүй шаардлагатай асуудлыг яаралтай шийдвэрлэх боломжийг илүү бүрдүүлнэ.

Санал: ШТХ-ийн төслийн 83.1.6-д "Ерөнхий зөвлөлийн хуралдаан болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө холбогдох баримт бичгийг урьдчилан хүлээн авах, танилцах;" 83.1.7-д "Хүндэтгэн үзэх шалтгаантай бол Ерөнхий зөвлөлийн хуралдаанд цахим хэлбэрээр оролцох эсхүл саналаа бичгээр өгөх;" гэж нэмэх.

Санал: ШТХ-ийн төслийн 81.4-ийг "Ерөнхий зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхий зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл дөрвөөс доошгүй тооны гишүүний шаардсанаар зарлан хуралдуулна" гэж өөрчлөх.

⁴² OSCE and Max Planck, "Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability," (Kyiv, 23-25 June 2010) 4.

1.8. ШЕЗ-ИЙН ТАЙЛАН БА ИЛ ТОД БАЙДАЛ

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт “шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой ШЕЗ-ийн тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна” гэсэн заалт орсонтой холбоотойгоор ШЕЗ-ийг Улсын дээд шүүхийн дор өгч, ШЕЗ-ийн дотоод үйл ажиллагаанд нь оролцохоор байна гэж шүүмжлэл гарч байсан. Ийм болгоомжлолыг ойлгож хуваалцаж байгаа ч дээрх заалтад ийм утга огт байхгүй. Энэ заалтаар Улсын дээд шүүхээс ШЕЗ-ийг удирдана, чиглүүлнэ, дотоод ажилд нь орно гэсэн агуулга байхгүй гэж УИХ-ын нэгдсэн хуралдааны болон Төрийн байгуулалтын байнгын хорооны протокол, албан дүгнэлтэд хангалттай тодорхой тусгагдсан. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүхийн шүүгчид санал, даалгавар өгч ШЕЗ түүнийх нь мөрөөр ажиллах гэсэн утга уг заалтад байхгүй.

Венецийн комисс шүүхийн зөвлөлийн тайлантай холбогдуулан дараах зөвлөмжийг гаргажээ: “Шүүхийн зөвлөл үйл ажиллагаагаа нийтэд мэдээлэх үүрэг нь шүүхийн үйлчилгээний нөхцөл байдлын талаарх тайланг парламентад хүргүүлэх үүргийг багтааж болно. Гэвч, энэхүү тайлагнах үүрэг нь Шүүхийн дээд зөвлөлийг хууль тогтоох эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн өмнө албан ёсоор хариуцлага хүлээдэг нөхцөл рүү шилжүүлж болохгүй.”⁴³ Үүнтэй адилаар ШЕЗ-ийн зөвхөн “шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой үйл ажиллагааны тайланг” Улсын дээд шүүхэд танилцуулах бөгөөд энэ нь ШЕЗ-ийг Улсын дээд шүүхийн дор аваачиж түүний өмнө хариуцлага хүлээдэг байдал рүү аваачиж болохгүй юм.

ШЕЗ-ийн бүх үйл ажиллагааны тайланг бус, харин зөвхөн шүүгчийн хараат бус байдлыг хэрхэн хангаж буй тухай тайланг л Улсын дээд шүүхэд танилцуулахаар Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан. Улсын дээд шүүх болон ШЕЗ-ийн аль аль нь Үндсэн хуулийн байгууллага тул ШЕЗ-ийн дарга эсхүл гишүүн уг тайланг Улсын дээд шүүх дээр очоод танилцуулах нь зохисгүй тул уг

⁴³ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§71, 72; CDL-AD(2008)006, Opinion on the Draft Law on the High Judicial Council of the Republic of Serbia, §§35, 36.

тайланг бичгээр гаргаад хүргүүлэх, эсхүл ШЕЗ-ийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь танилцуулахаар хуулиар зохицуулах шаардлагатай. Тийм учраас Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт ШЕЗ-ийн тайланг хэн Улсын дээд шүүхэд танилцуулахыг заагаагүй. Гол санаа бол Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан чиг үүрэг буюу шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой хийж байгаа ажлынхаа тайланг Дээд шүүхэд явуулах, түүгээр дамжуулж нийт шүүгчид, хуульчид болон олон нийтэд хүргэх эргэх хариуцлагын нэг хэлбэр юм. Ийм үзэл баримтлалын хүрээнд дагалдах хууль нь гарч хэрэгжих хэрэгтэй.

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу "Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд танилцуулна." Үндсэн хуулийн энэхүү заалтыг хэрэгжүүлэх үүднээс ШТХ-ийн төслийн 82.1.10-д "Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд жил бүр танилцуулах"-аар тусгажээ. Гэвч, ШТХ-ийн төслийн 82.1.11-т "Ерөнхий зөвлөлийн ажлын тайланг Шүүгчдийн зөвлөлд танилцуулах"-аар заасан нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт "Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Зөвлөлийн үйл ажиллагааны тайлан" гэснийг өргөжүүлсэн шинжтэй болжээ. Иймээс, Үндсэн хуулийн уг заалтын хүрээгээр нь тусгах саналтай байна.

Санал: ШТХ-ийн төслийн 82.1.11-ийг бүхэлд нь хасах эсхүл "шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Ерөнхий зөвлөлийн тайланг Шүүгчдийн зөвлөлд танилцуулах" гэж өөрчлөх.

Ерөнхий зөвлөлийн ажил гэдэг бол зөвхөн шүүгчдэд хамаатай бус нийт иргэний хараат бус, шударга шүүхээр шүүлгэх эрхийн баталгааны тухай учраас Ерөнхий зөвлөл ажлын тайлангаа цахим хуудасдаа жил бүр хэвлэн нийтэлдэг байх, үүнтэй нь шүүгчид төдийгүй хуульчид, судлаачид, иргэд танилцах боломж бүрдэнэ. "Зөвлөл нь өөрийн үйл

ажиллагааны талаарх тайлан, мэдээллийг өргөн хүрээнд түгээх замаар олон нийтийн өмнө хариуцлага хүлээдэг байх хэрэгтэй."⁴⁴

ШЕЗ-ийн үйл ажиллагаа аль болох ил тод байх хэрэгтэй. Тус зөвлөл тайлангаа дээрх байдлаар шүүгчид болон олон нийтэд хүргэхээс гадна өдөр тутмын үйл ажиллагаа, ялангуяа шүүгчийн сонгон шалгаруулалттай холбоотой мэдээллээ өөрийн цахим хуудас болон бусад хэлбэрээр тогтмол нийтэд түгээж байх нь чухал.

Шүүгчээр томилуулахаар нэр дэвшүүлэх зэрэг гол чиг үүргээ гүйцэтгэхтэй холбоотой ШЕЗ-ийн хуралдаанд хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийг оролцох боломжоор хангах хэрэгтэй. Шүүгчийг нэр дэвшүүлэхтэй холбоотой зөвлөлийн хуралдаан нь олон нийтэд нээлттэй байх, хэвлэл мэдээлэл, иргэний нийгмийн байгууллага, олон нийт оролцох боломжоор хангахаар хуульчлах нь олон улсын сайн туршлага юм.⁴⁵ Жишээлбэл, Гүрж, Молдавт иргэний нийгмийн байгууллагууд шүүхийн зөвлөлийн хуралдааныг ажиглаж мониторинг хийх эрхтэй байдаг.⁴⁶

⁴⁴ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§71, 72; CDL-AD(2008)006, Opinion on the Draft Law on the High Judicial Council of the Republic of Serbia, §§35, 36.

⁴⁵ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 20, 28; OSCE and Max Planck, "Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability," (Kyiv, 23-25 June 2010)

⁴⁶ OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 28. <https://www.trends.mn/n/5512>

Санал: ШТХ-ийн төсөлд дараах заалтыг нэмж тусгах саналтай байна:

"81.7.Ерөнхий зөвлөлийн хуралдааныг нээлттэй явуулах бөгөөд хуралдааныхаа товыг 3-аас доошгүй хоногийн өмнө зарлаж хэвлэл, мэдээллийн хэрэгсэл, нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, сонирхсон иргэдийг танхимын багтаамжийн хүрээнд болон цахим хэлбэрээр оролцуулах боломжоор хангана.

81.8.Ерөнхий зөвлөл шийдвэрээ өөрийн цахим хуудсанд тогтмол нийтэлнэ."

81.9.Ерөнхий зөвлөл ажлын тайлангаа цахим хуудсанд жил бүр нийтэлнэ."

1.9. ШЕЗ-ИЙН ГИШҮҮНИЙ БАРИМТЛАХ ЗАРЧИМ, ХОРИГЛОХ ЗҮЙЛ

ШТХ-ийн төслийн 78.9-д "Ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг тус зөвлөл баталж, мөрдөнө" гэсэн заалт тусгасан нь ШЕЗ-ийн гишүүнийг ажилдаа хариуцлагатай хандах, шударга, ёс зүйтэй байлгахад чухал. ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмийг баталж мөрдүүлэх нь нэг талаас ШЕЗ-ийн гишүүний ёс зүйгүй, дур зоргын үйлдэл, эс үйлдэхүйг хязгаарлах, хянан шийдвэрлэх, нөгөө талаас ШЕЗ-ийн гишүүдээс ийм зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх ач холбогдолтой. Шүүхийн зөвлөлийн шүүгч гишүүн төдийгүй шүүгч биш гишүүн нь шүүх эрх мэдэлд тавих ёс зүйн өндөр шаардлагад захирагдахыг шаардах хэрэгтэй.

ШЕЗ-ийн гишүүн сахилгын зөрчил гарч байсан тохиолдол бий. Жишээлбэл, дүүргийн шүүхэд шүүгч, Ерөнхий шүүгчээр ажиллаж байгаад ШЕЗ-д 2013 онд ШЕЗ-ийн гишүүнээр томилогдсон нэгэн гишүүн 2016 онд ШЕЗ-ийн гишүүний бүрэн эрхээ дуусаагүй байхад Эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчид

нэр дэвшин, томилогдсон.⁴⁷ Монголын Улсын Үндсэн хууль болон Шүүхийн захиргааны тухай хуулиар Ерөнхий зөвлөлийн гишүүн шүүгчид нэр дэвших нь зарчмын хувьд байж боломгүй. Ерөнхий зөвлөлийн гишүүн нь шүүгчийн шалгаруулалт, томилгооны бараг бүх зүйлийг мэддэг, өөрөө оролцдог, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүд төдийгүй Мэргэшлийн хорооны гишүүдийг таньдаг, хамтран ажилладаг. Ийм хүн өөрөө шүүгчид нэр дэвших нь ашиг сонирхлын зөрчилтэй харагдах төдийгүй бусад нэр дэвшигчээс давуу байдал зүй бусаар олж авч, гарааны тэгш байдлыг зөрчинө. Ерөнхий зөвлөлийн гишүүн шүүгчид нэр дэвшиж байгаа тохиолдолд шүүгчийн шалгалт дээр үндэслэлгүй өндөр оноо авна, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүн нь бусад нэр дэвшигчээс илүүтэй өөрийн хамтран ажиллагчдаа тал засаж, Ерөнхийлөгч рүү явуулна гэж үндэслэлтэй хардах төдийгүй ийм зохисгүй зүйл гарах бодит боломжтой учраас энд шударга ёсны зарчим зөрчигдсөн юм. Үндсэн хуульд зааснаар шүүгчийг шилж олох ажил тэгш байдал, шударга ёсонд нийцсэн байх, Шүүхийн захиргааны хуульд зааснаар Ерөнхий зөвлөлийн гишүүн бүр шударга зан чанар, өндөр ёс зүйтэй байх ёстой гэсэн ерөнхий шаардлагууд нь Ерөнхий зөвлөлийн гишүүн өөрийн бүрэн эрхийн хугацаанд эсхүл бүрэн эрх нь дуусгавар болсноос хойш тодорхой хугацаанд шүүгчид нэр дэвшихийг хориотой. Гэвч, Ерөнхий зөвлөлийн гишүүн өөрөө нэр дэвшиж, Мэргэшлийн хороо түүнийг бүртгэж шалгалт авч, Ерөнхий зөвлөлийн бусад гишүүд нь шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид нэрийг нь явуулсан нь шүүхийн шинэчлэл, ялангуяа шүүгчийг шалгаруулах тогтолцооны шинэчлэлд итгэх олон нийтийн итгэлийг хөсөрдүүлсэн явдал болсон юм.

ШЕЗ-өөс хуульчдаас шүүгчийг шилж олох зэрэг чиг үүрэгтэй нь уялдуулан Монгол Улсын Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний ёс зүйн загвар дүрэм боловсруулж байв.⁴⁸ Олон улсын сайн туршлагаас харахад "Нууцлалыг хадгалах, үнэнч шударга байх, бодитой хандах, төвийг сахих зарчим, мөн хуралдаанд тасралтгүй

⁴⁷ О.Мөнхсайхан, "ШЕЗ-ийн гишүүн шүүгчид нэр дэвшсэн нь шалгаруулалтад итгэх итгэлийг хөсөрдүүлэв," Trends.mn Мэдээллийн цахим хуудас, 2016.04.14, <https://www.trends.mn/n/5512>

⁴⁸ О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (УБ, 2015), 98-104.

оролцох, албан үүргээ чандлан гүйцэтгэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн бол татгалзан гарах үүрэг"-ийг наад зах нь шүүхийн зөвлөлийн ёс зүйгээр шаардахыг зөвлөдөг.⁴⁹

ШЕЗ-ийн гишүүнээс өмнө нь гаргаж байсан зарим сахилгын зөрчил болон бусад орны туршлагад үндэслэн ШЕЗ-ийн гишүүнд хориглох зүйл, ёс зүйн ерөнхий зарчмыг хуульчлах нь уг асуудлыг илүү тодорхой болгох, ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмийн агуулгыг боловсруулахад хэрэгтэй. ШТХ-ийн төслийн 99.12-т Сахилгын хорооны дарга, гишүүний баримтлах зарчмыг, 102.1, 102.2-т гүйцэтгэх үүргийг нь заасантай төстэй тодорхой хуульчлаад, үлдсэн зохицуулалтыг ёс зүйн дүрэмд тусгах боломжийг үлдээх нь зохистой.

Санал:⁵⁰ ШТХ-ийн төслийн 78.10-т "Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, зарчимч, шударга, хараат бус байх, бодитой хандах, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, хичээл зүтгэл гаргах, гишүүний нэр хүндээ эрхэмлэх, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх буюу ийм нөхцөл үүссэн бол татгалзан гарах үүрэгтэй" гэж заах.

Санал: ШТХ-ийн 78.11-т ийнхүү заах хэрэгтэй: "Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнд дараах зүйлийг хориглоно:

78.11.1.Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаанд болон уул хугацаа дуусгавар болсноос хойш гурван жилийн дотор шүүгчид нэр дэвших;⁵¹

⁴⁹ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 11.

⁵⁰ Эдгээр зарчмын тайлбарыг дараах номоос үзэх боломжтой: О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (УБ, 2015), 61-77

⁵¹ Мөн тэнд, 67-69.

78.11.2.ашиг сонирхлын зөрчил үүссэн эсхүл өөрт хамаарал бүхий этгээдтэй холбоотой шийдвэр гаргахад оролцох;

78.11.3.албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн нууцыг задруулах, хувийн ашиг сонирхлыг хангах зорилгоор ашиглах;

78.11.4.Ерөнхий зөвлөлийн гишүүний нэр хүндэд сөрөг үйл ажиллагаа явуулах;

78.11.5.улс төрийн үйл ажиллагаа явуулах;

78.11.6.шүүн таслах ажилд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх;

78.11.7.Шүүхийн сахилгын хороо болон Шүүхийн мэргэшлийн хорооны дарга, гишүүнд нөлөөлөх;

78.11.8.Ерөнхий зөвлөлийн гишүүний албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах;

78.11.9.Ерөнхий зөвлөлийн гишүүний үүрэг гүйцэтгэхтэй холбогдуулан бэлэг, шан харамж авах;

78.11.10.Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрэмд заасан бусад."

1.10. ШЕЗ-ИЙН ДАРГА, ГИШҮҮНИЙ САХИАЛГЫН ЗӨРЧИЛ, САХИАЛГЫН ШИЙТГЭЛ

ШТХ-ийн төслийн 84.2-т Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулахаар заажээ: (1) гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон; (2) хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан; (3) ёс зүйн ноцтой алдаа гаргасан. Эдгээр үндэслэл тус бүрийг авч үзье.

ШТХ-ийн төслийн 84.2-т зааснаар “Гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон” бол ШЕЗ-ийн дарга, гишүүнийг огцруулах нь зүйн хэрэг юм. ШЕЗ-ийн дарга, гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдвол тэрээр тус зөвлөлийн дарга, гишүүний чиг үүргийг гүйцэтгэх нэр хүндээ алдана.⁵² Гэмт хэрэг үйлдсэн хүн шүүгчийг хуульчаас шилж олох зэрэг эрхэм чухал ажлыг үнэнч шударгаар хийнэ гэдэгт бодит эргэлзээ үүсэх буюу ийнхүү ойлгогдох нөхцөл үүснэ.

ШТХ-ийн төслийн 84.2-т “Хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан” бол огцруулах нь ч зохистой. “Удаа дараа” гэдгийг хуралдааныг гурав буюу түүнээс дээш удаа зөрчсөн гэж ойлгоно гэсэн тайлбар маргаангүй, тодорхой⁵³ бол энэ хэллэгээр нь хэрэглэхийг дэмжиж байна. Харин, ийм тайлбарлагдах эсэх нь маргаантай бол үүнийг тодорхой болгож “Хуралдааныг гурав буюу түүнээс дээш удаа хүндэтгэн үзэх шалтгаангүй тасалсан” гэж тодруулах нь уг асуудалд дур зоргоор хандах эрсдэлээс сэргийлнэ. Шүүхийн зөвлөлийн гишүүнийг хуралдаанд оролцоогүй гэсэн үндэслэлээр огцруулахаар зохицуулахдаа ийнхүү оролцоогүй хугацааны доод хязгаарыг тодорхой хуульчлах нь зүйтэй.⁵⁴

⁵² CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §53

⁵³ Жишээлбэл, Улсын дээд шүүх “хуулийг удаа дараа зөрчсөн” гэдгийг Монгол улсын хууль тогтоомжийг “гурав буюу түүнээс дээш зөрчсөнийг” ойлгоно гэж тайлбарлаж байжээ. “Хоршооны тухай Монгол Улсын хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай,” Улсын дээд шүүхийн 26 дугаар тогтоол, 2007.06.18. <https://www.legalinfo.mn/law/details/629>

⁵⁴ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§51-56.

ШТХ-ийн төслийн 84.2-т "Ёс зүйн ноцтой алдаа гаргасан" гэдгийг юу гэж ойлгох вэ гэдэг тодорхойгүй байна. Юуны өмнө нэр томъёоны хувьд ШЕЗ-ийн гишүүний ёс зүй бол шүүгчийн ёс зүйтэй адил хамгийн дээд идеалыг илэрхийлдэг тул ёс зүйг зөрчсөн болгон шийтгэл хүлээх, ялангуяа огцруулах үндэслэл болохгүй юм. Иймээс нэр томъёоны хувьд "сахилгын зөрчил" гэх нэр томъёо хэрэглэх саналтай байна (энэ саналын "Шүүгчийн ёс зүйн зөрчил ба сахилгын зөрчил" гэсэн 4.2 дахь хэсэгт ёс зүйн зөрчил эсхүл алдаа гэхээс илүү сахилгын зөрчил гэх нэр томъёо хэрэглэх нь зүйтэй талаарх үндэслэлийг арай дэлгэрэнгүйгээр бичсэн тул харна уу).

ШТХ-ийн төслийн 84.2-т зааснаар "огцруулах" шийтгэл ногдуулахаар хуульчлахтай холбоотой хэд хэдэн зүйл анхаарах нь зүйтэй. Юуны өмнө, ШТХ-ийн 84.2, 84.3-г зааснаар ШЕЗ-ийн гишүүнийг "ёс зүйн алдаа" гаргасан гэдгээр эгүүлэн татахаар байна. Нэг талаас, энэ нь зөрчилд тохирсон шийтгэлээр шийтгэх шударга ёсны зарчмыг зөрчинө. ШЕЗ-ийн гишүүний сахилгын зөрчилд тохирсон шийтгэлээр шийтгэх, ялангуяа ялимгүй зөрчлөөс эсхүл таалагдахгүй төдийгөөр эгүүлэн татах нь шударга биш талаар олон улсын сайн туршлага харуулж байна.⁵⁵ Харьцангуй хөнгөн зөрчил үйлдсэний төлөө эгүүлэн татах, огцруулах нь тохироогүй арга хэмжээ болно.⁵⁶ Нөгөө талаас, ёс зүйн алдаа гаргасан гэсэн хэт ерөнхий үндэслэлээр эрүүлэн татах нь шүүгчдийн эсхүл улс төрчдийн итгэлийг хүлээхгүй төдийгөөр ШЕЗ-ийн гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгодог нөхцөл үүсэж, Ерөнхий зөвлөлийн гишүүнийг тэдгээрээс хэт хараат болгоно. Энэ нь олон улсын сайн туршлагатай ноцтой зөрчилдөнө. Венецийн комисс шүүхийн зөвлөлийн шүүгч гишүүдийг сонгосон шүүгчид нь эргүүлж татах зохицуулалтыг хуульчлахыг эрс шүүмжилж, дараах үндэслэлийг бичжээ: "Шүүхийн зөвлөлийн гишүүн нь хараат бус байж, зарчмын үүднээс зөв ч шүүгчид үл таалагдах шийдвэр гаргах ёстой болдог. Шүүхийн зөвлөлийн гишүүнийг тэдгээрийг сонгосон шүүгчдийн итгэл даагаагүй бол эгүүлэн татдаг болбол хараат бус байдал нь

⁵⁵ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §§66-70

⁵⁶ CDL-AD(2014)038, Opinion on the Draft Laws on Courts And On Rights And Duties Of Judges and on the Judicial Council of Montenegro, §§45-48.

суларч, шүүгчдээс хэт хамааралтай болгон хараат бус, үр нөлөөтэй шүүх эрх мэдлийг бэхжүүлэх зорилгын төлөө ажиллах үүргийг нь үгүй болгоно."⁵⁷

ШТХ-ийн төслийн 78.11-д Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнд хориглох зүйлийг жагсаах нь зүйтэй гэж "ШЕЗ-ийн гишүүний баримтлах зарчим, хориглох зүйл" гэсэн 1.9 дэх хэсэгт дүгнэсэн билээ. Уг хориглох зүйлийг буюу ШТХ-ийн төслийн 78.11.1-78.11.9-д заасныг зөрчсөн бол огцруулахаар ШТХ-д шууд заах боломжтой. ШТХ-ийн төслийн 78.11.1-78.11.9-д жагсаасан хориглолт бол олон улсын сайн туршлага, Монголын практикт үндэслэн гарсан учраас эдгээр тодорхой зөрчлийг үйлдвэл огцруулахаар заах нь уг эрх мэдлийг хэрэгжүүлэх этгээд эрх мэдлээ урвуулан ашиглаж ШЕЗ-ийн гишүүний хараат бус байдалд халдахаас сэргийлнэ, ШЕЗ-ийн гишүүн юу хийж болох, болохгүйгээ урьдчилан мэдэж биеэ авч явах боломж олгоно, улмаар ШЕЗ-ийн үйл ажиллагаанд төдийгүй шүүх эрх мэдэлд итгэх олон нийтийн итгэлийг хадгалахад чухал үүрэгтэй. Шүүхийн ерөнхий зөвлөлийн бие даасан, түүний гишүүний хараат бус, төвийг сахисан байдлыг хуулиар баталгаажуулах нь шүүхийн хараат бус, хариуцлагатай байдлыг хамгаалахад чухал. Иймээс, "Зөвхөн хуульд тодорхой заасан үндэслэлээр шүүхийн зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болохоос нь өмнө огцруулахаар зохицуулах хэрэгтэй."⁵⁸ Шүүхийн зөвлөлийн гишүүнийг ёс зүйг зөрчсөн эсхүл үүргээ мэргэжлийн төвшинд гүйцэтгээгүй гэх зэрэг хэт ерөнхий үндэслэлээр эгүүлэн татах, огцруулах нь хууль зүйн стандартын шаардлагыг хангахгүй, хэтэрхий бүрхэг тул эгүүлэн татах, огцруулах асуудлыг гэмт хэрэг эсхүл сахилгын зөрчилтэй холбох, зөвлөлийн

⁵⁷ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §§66-70

⁵⁸ CDL-AD(2014)026, Opinion on the seven amendments to the Constitution of "the former Yugoslav Republic of Macedonia" concerning, in particular, the judicial Council, the competence of the Constitutional Court and special financial zones, §77.

гишүүд мэдэж байхуйцаар сахилгын зөрчлийн хэлбэрээр маш тодорхой хуульчлах хэрэгтэй.⁵⁹

ШЕЗ-ийн гишүүний сахилгын бүх зөрчлийг урьдчилан, нэг бүрчлэн, тодорхой хуульчлах боломж хязгаарлагдмал хэдий ч ШТХ-ийн ерөнхий үүрэг, зарчим тусгах, үүнийг ШЕЗ-ийн гишүүний ёс зүйн дүрмээр баяжуулах боломжийг хуульчлах нь чухал. Зөрчилд ногдуулах шийтгэл тохирсон байх зарчмыг баримтлах хэрэгтэй бөгөөд Шүүхийн зөвлөлийн гишүүнийг эгүүлэн татах, огцруулах нь хамгийн сүүлчийн арга хэмжээ байвал зохино.⁶⁰ ШТХ-ийн төсөлд "Энэ хуулийн 78.10 болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн" бол огцруулахаар заах саналтай байна. Харин, энэ хуулийн 78.10 болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг зөрчсөн бусад зөрчилд нээлттэй эсхүл хаалттай сануулах шийтгэл ногдуулж болох юм.

ШТХ-ийн төслийн 84.3-т "Шүүгчдийн зөвлөл энэ хуулийн 84.2-т заасан үндэслэлээр шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээс эгүүлэн татна" гэж заасан ч Ерөнхий зөвлөлийн шүүгч биш гишүүнийг хэн ямар үндэслэлээр огцруулах талаар төсөлд тусгаагүй байна. Шүүхийн зөвлөлийн сонгогдсон гишүүнийг эгүүлэх татахаар заачхаад томилогдсон гишүүнийг огцруулах заалт оруулахгүй байх нь учир дутагдалтай.⁶¹ ШЕЗ-ийн гишүүний сахилгын зөрчлийг хэн харьяалан шийдвэрлэх вэ гэдэг дээр хоёр янзын хувилбараас сонгох боломжтой байна.

⁵⁹ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§51-56; CDL-AD(2014)038, Opinion on the draft laws on courts and on rights and duties of judges and on the Judicial Council of Montenegro, §§45-48; CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §56

⁶⁰ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §58

⁶¹ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §§30 and 32

Хувилбар 1. Ерөнхий зөвлөлийн гишүүний сахилгын зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд нийцүүлэн нээлттэй, хаалттай сануулах, огцруулах шийтгэлийг аль тохирохыг нь Ерөнхий зөвлөл өөрөө шийдвэрлэдэг байж болох юм. Ерөнхий зөвлөл сахилгын зөрчил гаргасан гишүүндээ хариуцлага тооцохгүй бол тухайн институтийн нэр хүнд унах⁶² тул үүнд анхаарахаас аргагүй болно.

Хувилбар 2. ШТХ-ийн төслийн үзэл баримтлалыг хадгалж, ШТХ-ийн төслийн 84.2-т заасан үндэслэлээр Ерөнхий зөвлөлийн шүүгч таван гишүүнийг Шүүгчдийн зөвлөл, харин шүүгч биш таван гишүүнийг Хууль зүйн байнгын хороо тус тус нийт бүрэлдэхүүнийхээ дийлэнх олонхын саналаар эгүүлэн татахаар хуульчлах боломжтой. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ШЕЗ-д томилсон гишүүнээ огцруулах эсэхийг шийдэхээр хуульчилбал уг бүрэн эрхээ дангаар хэрэгжүүлэх учраас урвуулан ашиглах эрсдэл илүү их тул ШЕЗ-ийн шүүгч бус бүх гишүүнийг огцруулах эсэхийг Байнгын хороо шийдвэрлэх санал гаргаж байгаа юм. Харин, ШТХ-ийн төслийн 84.2-т зааснаас бусад сахилгын зөрчлийн хувьд ШЕЗ өөрөө хэлэлцэх, шаардлагатай бол хаалттай эсхүл нээлттэй сануулах боломжтой.

ШЕЗ-ийн гишүүнийг эгүүлэн татах, огцруулах шийдвэрийг ердийн олонхоор гаргавал таалагдаагүй төдийгөөр уг гишүүнийг зайлуулах эсхүл улс төржиж асуудалд хандах эрсдэл үүсэж, уг зөвлөлийн гишүүн УИХ эсхүл шүүгчдээс хараат бусаар ажиллах боломжгүй болно. Иймээс, тэдгээрийг эгүүлэн татах эсэхийг Шүүгчдийн зөвлөл эсхүл УИХ-ын Хууль зүйн байнгын хороо дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр тусгавал уг эрх мэдлийг урвуулан ашиглахаас сэргийлэхийн зэрэгцээ үнэхээр ноцтой зөрчил гаргасан Ерөнхий зөвлөлийн гишүүнд хариуцлага тооцох боломжтой болно. Шүүхийн зөвлөлийн гишүүн тодорхой хуульчилсан зөрчил үйлдсэн нь тогтоогдвол эгүүлэн татах эсэхийг парламентын гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхийг уг зөвлөлийн гишүүний хараат бус

⁶² CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §56

болон хариуцлагатай байдлын тэнцвэрийг хангасан сайн механизм гэж сайн туршлагаар үздэг.⁶³

ШЕЗ-ийн гишүүнд сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх, шийтгэл ногдуулах ажиллагааг урвуулан ашиглахаас сэргийлэх хэд хэдэн баталгааг хуульчлах нь зүйтэй. Нэгд, Шүүхийн зөвлөлийн гишүүний шийдвэрийн агуулгад үндэслэн огцруулах, эгүүлэн татахгүй гэдгийг тодорхой хуульчлах нь тус зөвлөлийн бие даасан, гишүүний хараат бус байдлыг хамгаалахад онцгой ач холбогдолтой.⁶⁴ Хоёрт, ШЕЗ-ийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх, огцруулах болон бусад шийтгэл ногдуулахад буруутгагдаж буй гишүүн нь сахилгын хэрэгт буруутгагдаж буй шүүгчтэй адил шударгаар шүүлгэх эрх эдлэхээр хуульчлах нь зүйтэй. Шүүхийн зөвлөлийн гишүүнд сахилгын хэргийг шударгаар хянан шийдвэрлэх баталгааг хуульд тусгадаг олон улсын сайн туршлага бий.⁶⁵

⁶³ CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §§51-56

⁶⁴ CDL-AD(2014)038, Opinion on the draft laws on courts and on rights and duties of judges and on the Judicial Council of Montenegro, §§45-48

⁶⁵ CDL-AD(2014)028, Opinion on the Draft Amendments to the Law on the High Judicial Council of Serbia, §§66-70

Санал. ШТХ-ийн төслийн дараах заалтыг өөрчлөх саналтай байна:

“84.2.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

84.2.1.хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдааныг гурав буюу түүнээс дээш удаа тасалсан;

84.2.2.энэ хуулийн 78.11.1-78.11.9-д заасныг зөрчсөн;

84.2.3.энэ хуулийн 78.10 болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн;

84.3.Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон бол түүнийг огцорсонд тооцно.

84.4.Энэ хуулийн 84.2-т заасан үндэслэлээр Ерөнхий зөвлөлийн шүүгч гишүүнийг эгүүлэн татах асуудлыг Ерөнхий зөвлөл, бусад гишүүнийг огцруулах асуудлыг Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо тус тус нээлттэйгээр хэлэлцэж нийт гишүүнийхээ гуравны хоёроос доошгүйн саналаар шийдвэрлэнэ. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн энэ хуулийн 78.10 болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг зөрчсөн бусад зөрчилд хаалттай эсхүл нээлттэй сануулах шийтгэлийг Ерөнхий зөвлөл ногдуулах бөгөөд уг асуудлыг шийдвэрлэхэд буруутгагдаж буй гишүүнийг саналын эрхтэйгээр оролцуулахгүй.

84.5.Сахилгын зөрчилд буруутгагдаж буй Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн нь энэ хуулийн 103.1.1-103.5-д заасан эрхийг эдэлнэ.

84.6.Шүүхийн зөвлөлийн гишүүнийг бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан эсхүл санал өгсөн шийдвэрийнх нь агуулгад үндэслэн огцруулах, эгүүлэн татах, бусад сахилгын шийтгэл ногдуулахыг хориглоно.

2. ШҮҮГЧИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТ, ТОМИЛГОО

Саналын энэ бүлэг нь (2.1) Шүүгчид тавих болзол, шаардлага; (2.2) Шүүхийг бүрдүүлэхэд олон талт байдлыг хангах; (2.3) Хуульчдаас шүүгчийг шилж олох ШЕЗ-ийн чиг үүрэг; (2.4) Шүүхийн мэргэшлийн хороо, түүний бүрэн эрх; (2.5) Шүүгчийн томилгоонд мерит зарчмыг хэрэгжүүлэх; (2.6) ШЕЗ-өөс шүүгчид нэр дэвшигчийг дахин санал болгох босгыг өндөрсгөх; (2.7) Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн томилгоо; (2.8) Улсын дээд шүүхээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийг томилох гэсэн хэсгээс бүрдэнэ.

2.1. ШҮҮГЧИД ТАВИХ БОЛЗОЛ, ШААРДЛАГА

Шүүгчид тавих болзол, шаардлагыг тодорхой хуульчлах нь чухал юм. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14-р зүйлийн талаарх НҮБ-ын Хүний эрхийн хорооны 32 дугаартай Ерөнхий тайлбарт гишүүн улсууд шүүгчийг томилоход баримтлах "объектив шалгуур, тодорхой журам"-ийг тогтоох арга хэмжээ авах хэрэгтэй гэжээ.⁶⁶ "Шүүгчийн томилгоо болон албан тушаал дэвшихтэй холбоотой бүх шийдвэр нь объектив шалгуурт үндэслэх бөгөөд уг шийдвэрийг бие даасан байгууллагад хариуцуулах эсхүл энэхүү шалгуураас өөр зүйлийг харгалзахгүй байх баталгаагаар хангах хэрэгтэй."⁶⁷

Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, зан төлөв, ёс зүй, мэргэшил гэсэн мерит зарчмын үндсэн шаардлагаа тодорхой хуульчлах хэрэгтэй. Европын зөвлөлийн сайд нарын хороо дараах зөвлөмж гаргажээ: "Шүүгчийн томилгоо болон албан тушаал дэвшихтэй холбоотой бүхий л шийдвэр нь хуулиар болон эрх бүхий этгээдээс урьдчилан тогтоосон объектив шаардлагад үндэслэх хэрэгтэй" бөгөөд шүүгчийг шилж олох, томилоход "хүний нэр төр (эрхэм чанар)-ийг хүндлэх" төдийгүй "шүүгчийн мэргэшсэн, үнэнч шударга, үр нөлөөтэй, үр

⁶⁶ UN Human Rights Committee, General Comment No. 32 on Article 14 of the ICCPR: Right to Equality before Courts and Tribunals and to Fair Trial, 23 August 2007.

⁶⁷ CCEJ Opinion No. 1 (2002).

чадвартай байдлыг шалгуур болгосон мерит зарчимд үндэслэх хэрэгтэй."⁶⁸ "Мерит зарчим нь хууль зүйн мэдлэг, аналитик чадвар, академик гоц байдал төдий биш, энэ дээр нэмээд шүүгчийн зан төлөв, шийдвэр гаргах чадвар, ойлгомжтойгоор илэрхийлэх чадвар, харилцааны чадвар, үр нөлөөтэй ажиллах чадвар зэрэг багтдаг."⁶⁹ Хэчнээн их мэдлэг, чадвартай байгаад ч өндөр ёс зүйгүй бол шүүх эрх мэдлийг хараат бусаар, шударгаар, мэргэжлийн төвшинд хэрэгжүүлэх боломжгүй.

ШТХ-ийн төслийн 88.2, 88.3-т зааснаар суурь болон тусгай шалгалтад шүүгчээр ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, ёс зүйн өргөн агуулгыг багтаасан нь шүүгчийн шалгалтыг мерит зарчмаар явуулахад ач холбогдолтой. Гэвч, эдгээрийг багтаасан ерөнхий шаардлагыг ШТХ-ийн төслийн 34.1-т заагаагүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно" гэж хууль зүйн дээд боловсрол, мэргэжлээрээ ажилласан жил, нас, иргэний харьяаллын дөрвөн болзлыг заасан. ШТХ-ийн төсөлд эдгээр болзлоос гадна цөөн тооны дараах тодорхой шаардлага хангасан байхаар тусгажээ: "Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:

34.1.1.эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

34.1.2.шүүгчид нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу эрүүгийн хэрэг үүсгэгдэж, яллагдагчаар татагдаагүй;

⁶⁸ Recommendation No. R (94)12 of the Committee of Ministers of the Council of Europe; Recommendation CM/Rec(2010)12 of the Committee of Ministers of the Council of Europe; OSCE/ODIHR, Final Opinion On Draft Amendments To The Act On The National Council Of The Judiciary And Certain Other Acts Of Poland, JUD-POL/305/2017, 27.

⁶⁹ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 6.

34.1.3.шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагаатай байх;

34.1.4.хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх."

Эндээс үзэхэд Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдээс ШЕЗ шүүгчээр томилуулахаар санал болгоход зөвхөн эдгээр тодорхой болзол, шаардлагыг баримтлахаар хязгаарлажээ.

ШТХ-ийн төслийн 36.1-т "Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ" гэж заажээ. Энэ заалт нь дараах хоёр янзаар ойлгогдох салаа утгатай байгааг нэг тийш нь шийдвэрлэх хэрэгтэй.

Нэг дэх утгаар ШТХ-ийн төслийн 36.1 нь зөвхөн ШТХ-ийн төслийн 34.2-т жагсаасан тодорхой болзол, шаардлагыг нэр дэвшигч хангасан эсэхийг нягтлаад Мэргэшлийн хорооноос хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг ШЕЗ санал болгох, Ерөнхийлөгч томилохоор ойлгогдож байна. Төслийн 36.1 ийм агуулгаар бичигдсэн бол "Энэ хуулийн 34.2-т заасан болзол, шаардлагыг хангасан нэр дэвшигчдээс Мэргэшлийн хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсан хүнийг шүүгчээр томилуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ" гэж тодорхой болгож хуульчлах хэрэгтэй болов уу.

Хоёр дахь утгаар бол ШЕЗ "олонхын санал авсан хүнийг" шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр заасан тул Мэргэшлийн хорооны үнэлгээгээр хамгийн сүүлд орсон хүнийг ч өргөн мэдүүлэх боломжтой. Энэ тохиолдолд ШЕЗ Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн хэд хэдэн нэр дэвшигчээс юуг шалгуур болгон шүүгчээр томилохоор Ерөнхийлөгчид санал болгох вэ гэдэг тодорхойгүй байх тул үзэмжээрээ хандах, эсхүл ийм хардлага, шүүмжээс салахгүй болно. Хэрэв ШТХ-ийн төслийн 36.1 нь энэхүү хоёр дахь утгаар бичигдсэн бол ШЕЗ Мэргэшлийн хорооны шалгалтад тэнцсэн нэр дэвшигчдээс юуг шалгуур болгон Ерөнхийлөгчид өргөн

мэдүүлэх вэ гэдгийг ШТХ-ийн төслийн 34.2-т тодорхой заах шаардлага үүснэ. Жишээлбэл, ШТХ-ийн төслийн 34.1-д жагсаасан шаардлага дээр нэмээд "шүүгчээр ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, өндөр ёс зүйтэй байх" гэж заах нь зүйтэй. ШТХ-ийн төслийн 34.1-д ингэж заавал Шүүхийн мэргэжлийн хороо дүгнэлтээ гаргахад төдийгүй ШЕЗ шүүгчид нэр дэвшигчийг өргөн мэдүүлэхэд, Ерөнхийлөгч томилгоо хийхэд тулгуур болж шүүгчийг шилж, олж, томилох бүх процесс мерит зарчимд илүү нийцнэ.

Санал. ШТХ-ийн төслийг сайжруулах дараах хоёр хувилбарын аль нэгийг сонгож тусгах саналтай байна:

Хувилбар 1. ШТХ-ийн төслийн 36.1-ийг "Энэ хуулийн 34.2-т заасан болзол, шаардлагыг хангасан нэр дэвшигчдээс Мэргэшлийн хорооноос хамгийн өндөр үнэлгээ авсныг нь шүүгчээр томилуулахаар Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчид ажлын таван өдрийн дотор өргөн мэдүүлнэ" гэж өөрчлөх.⁷⁰

Хувилбар 2. ШТХ-ийн төслийн 34.1.5-д "Шүүгчээр ажиллахад шаардлагатай мэдлэг, чадвар, өндөр ёс зүйтэй байх" гэж нэмэх, мөн төслийн 36.1-ийг "Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн энэ хуулийн 34.1-д заасан болзол, шаардлагыг хамгийн сайн хангасан нэр дэвшигчийг шүүгчийн албан тушаалд томилуулахаар илээр санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэн, ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ" гэж өөрчлөх.⁷¹

⁷⁰ Энэхүү хувилбарыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах номоос дэлгэрэнгүй үзнэ үү: О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (Содпресс 2015), 57-60.

⁷¹ Энэхүү хувилбарыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах номоос дэлгэрэнгүй үзнэ үү: О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (Содпресс 2015), 50-57.

2.2. ШҮҮХИЙГ БҮРДҮҮЛЭХЭД ОЛОН ТАЛТ БАЙДЛЫГ ХАНГАХ

Орчин үед шүүхийг бүрдүүлэхэд олон талт байдлыг хангахыг чухалчилж байна. Учир нь, шүүгчээр томилоход “мерит зарчмыг гол шалгуур болгохын зэрэгцээ шүүх дэх бүрэлдэхүүний олон талт байдал (diversity within the judiciary) нь олон нийтээс шүүх эрх мэдлийг бүхэлд нь хүлээн зөвшөөрөх, итгэх боломж олгодог. Шүүх эрх мэдэл нь төлөөллийн байгууллага биш боловч нээлттэй байж, нийгмийн бүх сектор дахь шаардлага хангасан хүмүүс орох боломжтой байх хэрэгтэй.”⁷²

Шүүн таслах ажлын туршлагатай хуульчаас гадна өмгөөлөгч, прокурор, төрийн болон бусад байгууллагад хуулийн зөвлөхөөр ажилласан туршлагатай хуульч, хууль зүйн сургуулийн багш зэрэг хүмүүс нэр дэвшиж шүүгчээр ажиллах болзол, шаардлага хангасан бол томилогдох боломж нээлттэй байх хэрэгтэй. Ингэснээр өөр өөр ажлын туршлага бүхий хүмүүс шүүх бүрэлдэхүүнд орж хэрэг, маргааныг тал талаас нь харж илүү зөв шийдвэрлэх боломж нээгдэнэ.

Шүүхийн тогтолцооны гаднаас шүүгчийн албан тушаалд нэрдэвших боломжийг нээх явдлыг Венецийн комисс дэмждэг. Жишээлбэл, шүүх эрх мэдлийн гадна ажилласан туршлагатай хуульчид (төрийн албанд ажилласан хуульч, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцдоггүй ч хуулийн зөвлөгөө өгдөг хуульч зэрэг)-ийг шүүгчийн сонгон шалгаруулалт орж өрсөлдөх боломж олгохыг эерэг өөрчлөлтөд тооцдог.⁷³

ШТХ-ийн төслийн 34.3-д “Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 34.1-д зааснаас гадна анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан” байна гэсэн учраас давж заалдах шатны шүүхэд зөвхөн анхан шатны шүүхэд шүүгчээр ажиллах хуульч томилогдохоор байна. Анхан шатны шүүх нотлох баримтыг буруу үнэлсэн эсэх, эсхүл хууль буруу хэрэглэсэн эсэхийг давж

⁷² European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 6.

⁷³ CDL-AD(2002)026, Opinion on the Draft Law on Judicial Power and Corresponding Constitutional Amendments of Latvia, §49.

заалдах шатны шүүх хянан шийдвэрлэдэг учраас давж заалдах шатны шүүхийн шүүгч анхан шатанд ажилласан туршлагатай байхыг шаардахаар заасан гэж ойлгож байна.

ШТХ-ийн төслийн 34.4-т зааснаар Улсын дээд шүүхийн шүүгч Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон уг хуулийн 34.1-д заасан шаардлагыг хангасан байхаас гадна (1) анхан шатны шүүхэд шүүгчээр арван жил, эсхүл давж заалдах шатны шүүхэд таваас доошгүй жил шүүгчээр ажилласан, эсхүл (2) өмгөөлөгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан байхыг шаардаж байна. Өөрөөр хэлбэл, энд дурдсан тодорхой хугацаагаар шүүгч, прокурор, өмгөөлөгчөөр ажилласан хуульчийг л Улсын дээд шүүхэд томилох боломжтой ч хууль зүйн сургуульд 10-аас доошгүй жил багшилсан хуульчийг томилох боломжгүй болгожээ.

Улсын дээд шүүх буюу хяналтын шатны шүүх зөвхөн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэх чиг үүрэгтэй тул уг шүүхийн бүрэлдэхүүний дийлэнхийг шүүгчийн ажлын туршлагатай хуульчид бүрдүүлэхийн зэрэгцээ өмгөөлөгч, прокурор, хууль зүйн сургуулийн багш зэрэг хууль зүйн ажлын тал талын туршлагатай хуульчдыг оруулах боломжтой байх нь хуулийг олон талаас харж илүү үндэслэлтэй тайлбарлах, эрх зүйг хөгжүүлэхэд чухал ач холбогдолтой. Зөвхөн шүүгчийн ажлын туршлагатай хүмүүсийг шүүгчээр томилох хязгаарлалтыг шууд зөвтгөх боломжгүй бөгөөд давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчид шүүхийн гаднаас нэр дэвшихийг дэмжих зөвлөмжийг Венецийн комисс гаргаж байв.⁷⁴ Эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудад Дээд шүүхэд ажиллах болзол, шаардлага хангасан бол олон талын ажлын туршлагатай хуульчид нэр дэвшиж томилогдох боломжтой байдаг. Жишээлбэл, Японы Дээд шүүх Ерөнхий шүүгч болон 12 шүүгчээс бүрдэх бөгөөд эдний 5 нь шүүгчийн, 4 нь өмгөөлөгчийн, 2 нь прокурорын, 1 нь их сургуулийн профессорын, 1 нь төрийн захиргааны албан хаагчийн ажлыг Дээд шүүхэд томилогдохоосоо өмнө хийж байжээ. Францын Дээд шүүхийн шүүгчдийн дийлэнх олонхыг шүүгчдээс бүрдүүлдэг

⁷⁴ CDL-AD(2014)038, Opinion on the draft laws on courts and on rights and duties of judges and on the Judicial Council of Montenegro, §53.

ч зарим нь хуулийн профессор, хуульчид байдаг.⁷⁵ Мөн, ХБНГУ-ийн Дээд шүүхүүдэд доктор, профессор шүүгч нар олон байгааг цахим хуудаснаас нь харж болно. Жишээлбэл, Дээд шүүхийн иргэний танхимд нийт 109 Ерөнхий шүүгч, шүүгчийн нэрс байх бөгөөд үүний 13 нь доктор, профессор, 57 нь доктор байна.⁷⁶

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан болзол, шаардлага хангасан бол Хуульчдын холбооноос магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн сургуульд арваас доошгүй жил багшилсан хуульч Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвших боломжтой (уг хуулийн 6.1.3). Хууль зүйн сургуульд багшилсан байх төдийгүй салбар эрх зүйгээр дагнан судалгаа хийж хүлээн зөвшөөрөгдсөн хуульч Улсын дээд шүүхийн шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд илүү хувь нэмэр оруулна. Тиймээс, тодорхой хугацаанд хууль зүйн сургуульд багшаар ажилласан, дэд профессор, профессорын албан тушаалд ажилласан эсхүл ийм цол авсан, хууль зүйн докторын зэрэг хамгаалсан хуульч Монгол Улсын дээд шүүхэд нэр дэвших боломжийг хэвээр үлдээх нь чухал юм.

Санал. ШТХ-ийн төслийн 34.4.3-т “хууль зүйн их, дээд сургуульд 10-аас доошгүй жил багшилсан, хууль зүйн докторын зэрэгтэй, дэд профессор эсхүл профессор цолтой” гэж нэмэх

ШТХ-ийн төслийн 34.5-т зааснаар “Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Дэд сайд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглоно” гэж заасан нь Улсын дээд шүүхийг улс төрийн нөлөөллөөс хөндийрүүлэх, мэргэжлийн байхад чухал заалт байна.

⁷⁵ “Cour de Cassation,” <https://www.courdecassation.fr/aboutthecourt9256.html>

⁷⁶ “Bundesgerichtshof,” <https://www.bundesgerichtshof.de/DE/DasGericht/Geschaeftsverteilung/BesetzungSenate/Zivilsenate/zivilsenatenode.html>

2.3. ХУУЛЬЧДААС ШҮҮГЧИЙГ ШИЛЖ ОЛОХ ШЕЗ-ИЙН ЧИГ ҮҮРЭГ

ШЕЗ болон Шүүхийн мэргэшлийн хорооны хоорондын харилцааг тодорхой болгох шаардлагатай байна. ШТХ-ийн төслийн 36.1-ын дагуу ШЕЗ нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгчид нэр дэвшигчээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр байна. Мэргэшлийн хорооны үнэлгээгээр тогтоосон эрэмбийг зүгээр л олонхын саналаар ямар ч үндэслэл хэлэхгүйгээр өөрчлөх нь мерит зарчимд харш юм. Жишээлбэл, Мэргэшлийн хорооны үнэлгээгээр 1-ээс 10 хүртэл дугаараар эрэмбэлэгдсэн нэр дэвшигчдээс 10 дахь буюу хамгийн сүүлийнхийг нь ямар ч үндэслэл хэлэхгүйгээр олонхын саналаар сонгох боломжтой нь мерит зарчим, түүний цаана буй хууль дээдлэх ёс болон ил тод байдлыг ноцтой зөрчинө. Урьд өмнө нь, ШЕЗ Мэргэшлийн хорооны үнэлгээний эрэмбийг ийм байдлаар өөрчилж шүүгчид нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгож ирсэн нь олон жил шүүмжлэгдэж шүүгчийг шилж олох, томилох процессод итгэх олон нийтийн итгэлийг алдах шалтгаан болсон. Үүнтэй төстэй зохицуулалтын талаар Венецийн комисс Украинд дараах зөвлөмжийг хүргүүлжээ: "Шүүхийн мэргэшлийн дээд комиссын зөвлөмж нь объектив шалгуурт үндэслэж байхад Шүүхийн дээд зөвлөл хуулиар тодорхойлоогүй үндэслэлээр уг зөвлөмжөөс татгалзаж болохоор байгаа нь хачирхалтай. Энэ нь дур зоргоор шийдвэр гаргах үүд хаалгыг нээнэ. Шүүхийн дээд зөвлөлийн оройл (role)-ыг илүү ил тод болгохыг хүчтэйгээр зөвлөж байна" гэжээ.⁷⁷

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу "хуульчдаас шүүгчийг шилж олох" үүргээ ШЕЗ хэрхэн биелүүлэх вэ гэдгийг дараах гурван хувилбарын аль нэгээр хуульчилж зохицуулах боломжтой:

Хувилбар 1. Шүүхийн ерөнхий зөвлөл нь нэгэнт 10 гишүүнтэй болсон учраас өөрөө сонгон шалгаруулалтаа хийгээд хамгийн өндөр

⁷⁷ CDL-AD(2010)026, Joint opinion on the law on the judicial system and the status of judges of Ukraine by the Venice Commission and the Directorate of Co-operation within the Directorate General of Human Rights and Legal Affairs of the Council of Europe, §50.

үнэлгээ авсан хүнийг шүүгчээр томилуулахаар Ерөнхийлөгчид нэр дэвшүүлэхээр хуульчлах бөгөөд Мэргэшлийн хороог татан буулгаж болно. Энэхүү хувилбар бол олон талын ач холбогдолтой тул үүнийг хамгийн сайн нь гэж үзэж дэмжих хэрэгтэй. Тухайлбал, Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасан "хуульчдаас шүүгчийг шилж олох" хамгийн гол чиг үүргээ ШЕЗ бүрэн утгаар нь хэрэгжүүлнэ. Мөн, Мэргэшлийн хороо бус ШЕЗ өөрөө сонгон шалгаруулалтаа хийж шүүгчид нэр дэвшүүлэх учраас ШЕЗ үзэмжээрээ сонголт хийсэн, шалгалтын онооны эрэмбийг баримталсангүй гэх мэт маргаан, хардлага гарахгүй болно, улмаар шүүгчийн сонгон шалгаруулалт болон шүүхэд итгэх олон нийтийн итгэл дээшилнэ. Түүнчлэн, шүүгчид тавих болзол, шаардлагыг хангасан эсэхийг зөвхөн нэг бүрэлдэхүүн (ШЕЗ) маш сайн шалгасны үндсэн дээр эдгээрийг хамгийн сайн хангаж өндөр үнэлгээ авсан хүнийг шүүгчээр томилуулахаар нэр дэвшүүлэх учраас уг чиг үүргийг хэрэгжүүлэх өөр илүү бүтэц, бүрэлдэхүүнийг давхардуулан байгуулах шаардлагагүй, илүү үр нөлөөтэй тогтолцоо бүрдэнэ. Үүнээс гадна, Мэргэшлийн хороог татан буулгаад Шүүхийн ерөнхий зөвлөл өөрөө сонгон шалгаруулалтаа хийх энэхүү хувилбарыг хуульчилбал ШЕЗ-ийн бүх гишүүнийг орон тооны болгон ажиллуулах боломжтой эсхүл ШТХ-ийн төсөлд байгаа шиг зохицуулалт хийсэн ч орон тооны болон орон тооны бус 10 гишүүний хүчээр сонгон шалгаруулалтыг сайн хийх бүрэн боломжтой (одоогийн хууль болон ШТХ-ийн төслөөр Мэргэшлийн хорооны гишүүн нь бүгдээрээ орон тооны бус). Шүүхийн зөвлөлийн бүх гишүүний орон тооны албан тушаал дээр ажиллуулахыг Венецийн комисс зөвлөдөг.⁷⁸ Эцэст нь, Шүүхийн зөвлөл болон Шүүхийн мэргэшлийн хороо гэсэн тусдаа байгууллагууд байх шаардлагагүй гэсэн байр суурийг Венецийн комисс илэрхийлжээ.⁷⁹ Киевийн зөвлөмжид ч үүнийг байж болох хувилбар хэмээн хүлээн зөвшөөрчээ.⁸⁰

⁷⁸ CDL-AD(2013)034, Opinion on proposals amending the draft law on the amendments to the constitution to strengthen the independence of judges of Ukraine, §43

⁷⁹ CDL-AD(2013)014, Opinion on the Draft Law on the amendments to the Constitution, Strengthening the Independence of Judges and on the Changes to the Constitution proposed by the Constitutional Assembly of Ukraine, §40.

⁸⁰ OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 2.

Хувилбар 2. ШЕЗ нь Мэргэшлийн хорооны үнэлгээ процессын хувьд зөв явагдсан эсэхийг нягталсны үндсэн дээр уг үнэлгээний эрэмбээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.⁸¹ Энэхүү хувилбар нь мерит зарчимд нийцэхийн зэрэгцээ ШЕЗ-ийн үзэмжээрээ сонголт хийх боломжийг хязгаарлаж буй ач холбогдолтой. Хуульчдаас шүүгчийг шилж олохтой холбогдсон үүргийг ШЕЗ хэрэгжүүлнэ гэж Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасантай нийцэх эсэх асуулт тавигдаж болох ч ШЕЗ Мэргэшлийн хороог байгуулж, ажиллах журмыг нь баталж, хяналт тавьж буй учраас уг үүргээ биелүүлсэн гэх үндэслэлтэй. Энэ хувилбар нь Киевийн зөвлөмжөөр бас дэмжигдсэн байдаг.⁸²

Хувилбар 3. Мэргэшлийн хорооны үнэлгээний эрэмбээс өөрөөр өргөн мэдүүлж буй бол түүнийхээ үндэслэлийг шийдвэртээ бичихийг ШЕЗ-д үүрэгжүүлэх.⁸³ Ийнхүү өөрчлөх болсон үндэслэл нь шүүгчид нэр дэвшигчийн ёс зүй, мэдлэг, ур чадвар, туршлага гэсэн шалгуурт үндэслэвэл зохилтой. ШЕЗ Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнийг томилж, холбогдох журмыг нь баталж өгч буй тул хуульд тодорхой заасан болзол, шаардлагыг хангаагүй гэх үндэслэлээр л уг хорооны шалгалтын эрэмбийг өөрчилж болох бөгөөд энэ тохиолдолд заавал үндэслэл бүхий шийдвэр гаргадаг байх ёстой. Үгүй бол өмнөхтэй адил ШЕЗ-ийн нэр дэвшүүлж буй шийдвэрт олон нийт эргэлзэж шүүгчийн сонгон шалгаруулалтад итгэх олон нийтийн итгэл дээшлэхгүй.

Дээрх 3 хувилбарын аль аль нь тухайн нэр дэвшигчид тавих шалгуурыг хангасан эсэхээр үнэлгээ хийж өргөн мэдүүлж буй учраас

⁸¹ Энэхүү хувилбарыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах номоос дэлгэрэнгүй үзнэ үү: О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (Содпресс 2015), 57-60; Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо (УБ, 2015), 68-74.

⁸² OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 2.

⁸³ Энэхүү хувилбарыг хэрхэн хэрэгжүүлэх талаар дараах номоос дэлгэрэнгүй үзнэ үү: О.Мөнхсайхан, Монгол Улс дахь шүүгчийн сонгон шалгаруулалт: шүүгчид нэр дэвшигчийг үнэлэх ажиллагааг сайжруулах нь (Содпресс 2015), 50-57; Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо (УБ, 2015), 68-74.

мерит зарчимд нийцнэ. Гэхдээ, дээр дурдсан үндэслэлүүдээс үзэхэд Хувилбар 1 нь хамгийн сайн учраас түүнийг хуульчлахыг санал болгож байна. Гагцхүү энэ хувилбарыг төсөлд тусгах боломжгүй бол Хувилбар 2 эсхүл ядаж Хувилбар 3-ыг хуульчлах нь зүйтэй.

Санал: ШЕЗ-өөс хуульчдаас шүүгчийг шилж олох чиг үүргээ хэрэгжүүлэх дараах хувилбарын аль нэгийг сонгох:

Хувилбар 1. Шүүхийн мэргэшлийн хороог татан буулгаж, ШЕЗ-ийн гишүүд өөрсдөө шүүгчийн шалгалтыг авах замаар сонгон шалгаруулж, хамгийн өндөр оноо авсан (эсхүл хамгийн олон саналаар дэмжигдсэн) нэр дэвшигчийг Ерөнхийлөгчид санал болгохоор хуульчлах.

Хувилбар 2. ШЕЗ нь Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээ процессын хувьд зөв явагдсан эсэхийг нягталсны үндсэн дээр уг үнэлгээний эрэмбээр хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх.

Хувилбар 3. ШЕЗ зөвхөн хуульд тодорхой заасан болзол, шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр Шүүхийн мэргэшлийн хорооны үнэлгээний эрэмбийг өөрчилөн өргөн мэдүүлж болох ч энэ тохиолдолд түүнийхээ үндэслэлийг шийдвэртээ бичихийг ШЕЗ-д үүрэгжүүлэх.

ШЕЗ-өөс сонгон шалгаруулалтыг үндэслэн зөвхөн нэг хүнийг шүүгчийн албан тушаалд томилуулахаар Ерөнхийлөгчид өргөн мэдүүлж ирснийг хэвээр хадгалах хэрэгтэй. ШЕЗ-өөс зөвхөн ийнхүү нэг хүнийг нэр дэвшүүлэх нь олон хүнийг нэр дэвшүүлснээс илүүтэйгээр шүүгчийн томилгоо дахь улс төржилт, үзэмжээрээ шийддэг байдлыг хумьдаг.

2.4. ШҮҮХИЙН МЭРГЭШЛИЙН ХОРОО, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ

Шүүхийн мэргэшлийн хороо улсын хэмжээнд нэг байж, таван жилийн хугацаагаар томилогдсон есөн орон тооны бус гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулахаар төсөлд тусгажээ (ШТХ-ийн төсөл, 86.1, 86.2). Тус хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, эрдэмтэн, хуульчаас бүрдэх (ШТХ-ийн төсөл, 86.1, 86.3)-ээр заасан. Энэ заалт нь олон улсын сайн туршлагад нийцэж байна. Шүүгчийг сонгон шалгаруулах байгууллагад шүүгчийн бодит төлөөлөл байхаас гадна хуулийн профессор, хуульчийг хууль зүйн соёл, туршлагаа харгалзан оруулах боломжтой.⁸⁴

Мэргэшлийн хороог бүрдүүлэх бүрэн эрхийг ШЕЗ хэрэгжүүлэхээр төсөлд тусгажээ. Тус хорооны зургаан гишүүн нь Улсын дээд шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгч байх бөгөөд тэдгээрийг Шүүгчдийн зөвлөлөөс сонгож, Ерөнхий зөвлөлд санал болгох (ШТХ-ийн төсөл, 86.4) бол бусад гишүүдийг Ерөнхий зөвлөл нэр дэвшүүлж, томилно (ШТХ-ийн төсөл, 86.4, 86.5). Тус хорооны даргыг гишүүдийн санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө гэж заажээ (ШТХ-ийн төсөл, 86.7).

Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглох (ШТХ-ийн төсөл, 86.6)-оор заажээ. Сахилгын хорооны гишүүн Мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллахыг хориглох заалт нэмж өгөхгүй бол нэг хүн шүүхтэй холбоотой хэт олон эрх мэдэл хэрэгжүүлэх, ашиг сонирхлын зөрчил үүсэх, мөн ачаалал нэмэгдэж аль нэг албан үүрэг цалгардах магадлалтай.

⁸⁴ OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 3.

Санал: ШТХ-ийн төслийн 86.6-г "Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, мөн шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно." гэж өөрчлөх.

Ерөнхий зөвлөл Мэргэшлийн хороог бүрдүүлэхийн зэрэгцээ түүнийг бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг хангаж, Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны болон гишүүний ёс зүйн дүрмийг батална (ШТХ-ийн төсөл, 86.10, 86.12) гэжээ. Тус хорооны гишүүнд дараахыг хориглохоор байна (ШТХ-ийн төсөл, 86.11):

- шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох;
- шүүгчийн хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөх;
- нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;
- нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх.

Мэргэшлийн хорооны гишүүн ёс зүйн өндөр стандартыг сахих нь уг тогтолцоонд итгэх итгэлийг хадгалахад чухал учраас үүнтэй холбоотой хоёр санал байна.

Нэгд, ШТХ-ийн төслийн 86.11.5-д "Мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллаж байхдаа болон бүрэн эрх дуусгавар болсноос хойш гурван жилийн дотор дээд шатны шүүхийн шүүгчийн эсхүл ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвших"-ийг хориглоно гэж нэмж заах. Ийм хориглолтыг хуульчлах зайлшгүй шаардлага бий. Жишээлбэл, 2014-2015 онд нэр бүхий шүүгч Шүүхийн мэргэшлийн хороонд гишүүнээр ажиллаж байхдаа давж заалдах шатны шүүхийнхээ ерөнхий шүүгчид нэр дэвшиж томилогдсон, дараа нь Дээд шүүхийн шүүгчийн орон тоо зарлагдмагц Мэргэшлийн хорооныхоо ажлыг өгч нэр дэвшээд Дээд шүүхэд хэдхэн сарын өмнө томилогдсон тохиолдол бий. Энэ нэр дэвшигчийн талаар тухайн үед нэр дэвшигчдийн болон

хуульчдын дунд яригдаад л өнгөрсөн байдаг.⁸⁵ Түүнчлэн, хуулийн засаглал төлөвшсөн орон (жишээлбэл, АНУ-ын Индиана, Оклахома зэрэг муж)-д шүүгчийг сонгон шалгаруулах хорооны гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд аливаа шүүгч эсхүл Ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвшдэггүй бөгөөд бүрэн эрх нь дууссаны дараа 3-5 жилдээ ч нэр дэвшдэггүй. Учир нь, сонгон шалгаруулах хорооны гишүүн хорооныхоо шалгалт, сонгон шалгаруулалтын бүх нарийн ширийн зүйлийг мэддэг, бусад гишүүдийг нь таньдаг болсон байдаг. Ийм хүн шүүгчид нэр дэвших нь ашиг сонирхлын зөрчилтэй харагдаж, бусад нэр дэвшигчээс шударга бус давуу байдал олж авдаг учраас нэр дэвшихийг нь хориглодог.

Хоёрт, ШТХ-ийн төслийн 86.11.6-д "Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны болон гишүүний ёс зүйн дүрэмд заасан бусад" гэж нэмэх. Учир нь тус хорооны гишүүнд хориглох, хязгаарлах хэм хэмжээг энд дурдсан цөөн агуулгаар хязгаарлах боломжгүй өргөн бөгөөд цаг хугацааны шаардлагаар хөгжин өөрчлөгдөх шаардлагатай байдаг.

Санал: ШТХ-ийн төслийн 86.11.5-д "Мэргэшлийн хорооны гишүүнээр ажиллаж байхдаа болон бүрэн эрх дуусгавар болсноос хойш гурван жилийн дотор дээд шатны шүүхийн шүүгчийн эсхүл ерөнхий шүүгчийн албан тушаалд нэр дэвших," мөн 86.11.6-д "Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны болон гишүүний ёс зүйн дүрэмд заасан бусад" гэж тус тус нэмэх.

ШТХ-ийн төслийн 86.8-т заасны дагуу Шүүхийн мэргэшлийн хороо (1) шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс энэ хуульд заасан шалгалт авч, үнэлгээ өгөх, (2) давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт гаргах гэсэн хоёр төрлийн бүрэн

⁸⁵ О.Мөнхсайхан, "ШЕЗ-ийн гишүүн шүүгчид нэр дэвшсэн нь шалгаруулалтад итгэх итгэлийг хөсөрдүүлэв," Trends.mn Мэдээллийн цахим хуудас, 2016.04.14, <https://www.trends.mn/n/5512>

эрх хэрэгжүүлнэ гэжээ. Мөн төслийн 86.9-т зааснаар "Мэргэшлийн хороо шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ." ШТХ-ийн төслийн 41.2.10-т "ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингээр шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй талаар Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан" гэсэн үндэслэлээр Ерөнхий зөвлөл шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгохоор байна.

Энэхүү саналын "Хуульчдаас шүүгчийг шилж олох ШЕЗ-ийн чиг үүрэг" гэсэн 2.3 дахь хэсэгт шүүгчийн сонгон шалгаруулалтыг ШЕЗ өөрөө бүрэн хариуцаж Мэргэшлийн хороог татан буулгах нь хамгийн сайн хувилбар гэсэн дүгнэлт хийсэн билээ. Үүнээс гадна ШТХ-ийн төслөөс Мэргэшлийн хороонд "шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт" гаргах, үүний мөрөөр шүүгчийг чөлөөлөх зохицуулалтаас татгалзах саналтай байна.

Нэгд, Мэргэшлийн хороонд энэхүү бүрэн эрх олгосон зохицуулалт нь доод шатны шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулахаар байна. ШТХ-ийн төслийн 58.1-т зааснаар "Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ." Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн зүгээс доод шатны шүүхэд энэхүү бүрэн эрхийг ашиглан нөлөөлөх эсхүл тийнхүү ойлгогдох байдал үүсэх эрсдэлтэй байна.

Хоёрт, Улсын дээд шүүхийн эсхүл давж заалдах шатны шүүхийн шүүгчийн мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадвар ноцтой алдагдсан асуудлыг шийдвэрлэх боломжгүй болохоор байна. ШТХ-ийн төслийн 58.1-т "...шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ" гэж зааснаас үзэхэд уг зохицуулалт зөвхөн анхан эсхүл давж заалдах шатны шүүхийн шүүгчид хамаарахаар байна.

Гуравт, шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлтийг гаргах чиг үүргийг Мэргэшлийн хороонд өгч

шийдвэрлүүлдэг бусад улсын сайн туршлага олдохгүй байна. Үүний оронд шүүхийн тухай хуульд "шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшил"-тэй холбоотой тодорхой зөрчлийг хуульчилж заагаад эдгээр зөрчлийг Сахилгын хороо (комисс, зөвлөл гэх мэт өөр өөр нэрлэгддэг)-нд харьяалуулж, бусад сахилгын зөрчилтэй нэгэн адил процессоор шийдвэрлүүлдэг. Жишээлбэл, хэрэг хуваарилах журмыг зөрчих; шүүгчийн албан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу зохисгүйгээр биелүүлэх; хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа эсхүл олон хоногоор таслах; шүүн таслах үүргийнхээ дагуу шийдвэр гаргах эсхүл бусад ажиллагаатай холбоотой хуулиар тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа эсхүл ноцтой зөрчих; харьяаллын дагуу явуулах үүрэгтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах; шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг нийтэд зарласан ажиллагааны товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих, эсхүл товлосон цагтаа ирэхгүй байх; хэрэг хянан шийдвэрлэх тухай эсхүл бусад хуулийн заавал биелүүлэх шинжтэй, илэрхий, тодорхой заалтыг шууд санаатай эсхүл хэт болгоомжгүйгээр зөрчих, хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад шүүхийн шийдвэрт шаардагдах үндэслэлийг огт бичээгүй нь шүүхийн эцсийн шийдвэрээр тогтоогдсон; шүүгчийн үүргээ гүйцэтгэх явцад мэргэжлийн наад захын мэдлэг, ур чадваргүйг нотолсон үйлдэл, эс үйлдэхүй гаргасан; Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан хүний үндсэн эрх, эрх чөлөөний маргаангүй, тодорхой утгыг шууд санаатай эсхүл хэт болгоомжгүйгээр зөрчсөн гэх мэтийг Эх газрын төдийгүй Англи Америкийн тогтолцоотой улсуудад шүүгчийн сахилгын зөрчилд тооцож тогтоогдвол сахилгын шийтгэл хүлээлгэдэг байна. Энэхүү саналын "Сахилгын тодорхой зөрчлийн жагсаалтыг хуульчлах" гэсэн гарчигтай 4.4 дэх хэсгээс ийм төрлийн сахилгын зөрчлийн талаар үзнэ үү.

Дөрөвт, Мэргэшлийн хороо нь зөвхөн шүүгчийн сонгон шалгаруулалт хийх зориулалтаар байгуулагдсан тул түүнд "шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт" гаргахад зайлшгүй шаардлагатай процесс хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд энэ талаарх хуулийн зохицуулалт төсөлд алга. Өөрөөр хэлбэл, буруутгагдаж буй шүүгч тайлбар, нотлох баримт гаргаж өгөх, үг хэлэх, өмгөөлөгч авах, өөрийнх нь асуудлыг шийдвэрлэх хуралдаанд

биеэр оролцох гэх мэт өөрийн буруутгагдаж буй асуудлаа шударгаар шүүлгэх эрхийг эдлэх боломжгүй байна. Шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшилтэй холбоотой зөрчлийг хуульд тодорхой заагаад Шүүхийн сахилгын хороонд харьяалуулбал сахилгын бусад зөрчилд буруутгагдаж буй шүүгчидтэй адил процессын эрхүүдээ бүрэн эдлэх боломжтой. Сахилгын хорооны шийдвэрт гаргасан гомдлыг Улсын дээд шүүхээр хянан шийдвэрлүүлэхээр төсөлд тусгасан учраас сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулахаас сэргийлнэ.

ШТХ-ийн төслийн 41.2.10-т "ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингээр шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй талаар Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан" гэсэн үндэслэлээр Ерөнхий зөвлөл шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгосон бол тухайн шүүгч чөлөөлөгдсөнийхөө дараа уг шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргах боломжтой. Шүүгчийг чөлөөлсөн үндэслэл хууль бус байсан нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол шүүгчийн бүрэн эрхийг сэргээж цалин хөлсийг нөхөн олгох (ШТХ-ийн төсөл, 41.3)-оор заасан нь шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах нэгэн баталгаа мөн. Гэхдээ, ШТХ-ийн төслийн 41.2.10-т заасан үндэслэлээр уг шийдвэр гарахын өмнө холбогдох шүүгч өөрийн тайлбар, үндэслэл, нотлох баримтыг гаргаж өгөх, өөрийнхөө эсрэг үндэслэл, баримтыг няцаах, уг асуудлыг шийдвэрлэх хуралдаанд оролцох зэрэг шударга процессын эрхүүдийг эдэлдэг байх хэрэгтэй бөгөөд уг асуудлыг сахилгын зөрчил болгон хуульчилж Сахилгын хороонд харьяалуулснаар эдгээр эрхийг шүүгчид эдлүүлэх боломж бүрдэж, урвуулан ашиглагдахаас урьдчилан сэргийлнэ. Шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингээр тэнцэхгүй гэсэн шийдвэр гарсны дараа л шүүхэд гомдол гаргах агуулгатай төстэй зохицуулалтыг шударгаар шүүлгэх эрхэд нийцэхгүй гэж Венецийн комисс үзэж байжээ.⁸⁶

⁸⁶ European Commission For Democracy Through Law (Venice Commission), Opinion On Act CLXII Of 2011 On The Legal Status And Remuneration Of Judges And Act CLXI Of 2011 On The Organisation And Administration Of Courts Of Hungary, CDL-AD(2012)001, 22.

Санал. ШТХ-ийн төслийн 41.2.10-т "ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингээр шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй талаар Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан," 86.8-т "давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт гаргах," 58.1-т "Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ," 86.9-т "Мэргэшлийн хороо шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингийн хувьд албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ." заасныг тус тус хасах.

2.5. ШҮҮГЧИЙН ТОМИЛГООНД МЕРИТ ЗАРЧМЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

ШТХ-ийн төсөлд ШЕЗ-өөс санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгч томилох харилцааг дараах байдлаар зохицуулжээ.

37.1. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно.

37.2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч нь шүүгчид тавигдах болзол, хангаагүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд албан ёсоор мэдэгдэнэ.

37.3. Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг

дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.

Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012 оны хуулийн 15.2-аар Ерөнхийлөгч ШЕЗ-өөс санал болгосон нэр дэвшигчийг ямар хугацаанд томилох вэ гэдгийг заагаагүй байснаас шийдвэр гаргалгүй удах тохиолдол олон гарч байсан. Мөн, Ерөнхийлөгч нэр дэвшигчийг томилохоос ямар үндэслэлээр татгалзаж болохыг заагаагүйн дээр томилохоос татгалзсан тохиолдолд үндэслэлээ бичихийг шаардаагүйгээс үзэмжээрээ татгалзсан гэж шүүмжлэгдэж ирсэн юм.⁸⁷ Учир нь, Ерөнхийлөгч шүүгчийг томилох эсэхийг шийдвэрлэхэд баримтлах тодорхой шалгуурыг хуульчлаагүй байсан учраас зөвхөн өөрийн байр суурийг дэмждэг үү гэх мэтээр үзэмжээрээ шийдвэрлэх буюу тэгж ойлгогдох эрсдэл өндөр байлаа. ШТХ-ийн төслөөр эдгээр дутагдалтай байдлыг засаж залруулах алхам хийсэн нь сайшаалтай. Тодруулбал, ШТХ-ийн төслийн 37 дугаар зүйлд Ерөнхийлөгч шүүгчид нэр дэвшигчийг томилох хугацааг тогтоогоод зогсохгүй зөвхөн шүүгчид тавих болзол, шаардлагыг хангаагүй гэсэн үндэслэлээр татгалзах, ийнхүү татгалзсан нь үндэслэлтэй эсэхийг ШЕЗ дахин нягталж үзэх байдлаар зохицуулсан нь Үндсэн хуулийн үзэл баримтлалд бүрнээ нийцжээ.

Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно." гэж заасан. Хууль дахь "тэгнэ," "ингэнэ" гэсэн хэллэг үүрэгжүүлсэн утгатай

⁸⁷ Энэ талаар дараах ном, өгүүллээс үзнэ үү: Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо (УБ, 2015), 74-77; О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам (Нээлттэй нийгэм форум 2015), 65-69; О.Мөнхсайхан, "Монгол Улсын шүүх эрх мэдлийн талаарх хөндлөнгийн судалгаа, дүн шинжилгээ" илтгэл, "Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар" олон улсын бага хурлын эмтхэтгэл дотор (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018), 41-71.

хэрэглэгддэг ёс бий. Энэ ёсоор уншвал "...Ерөнхийлөгч томилно" гэсэн Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн заалт нь Ерөнхийлөгч томилохоос үзэмжээрээ татгалзаж болохгүй утгатай. Өөрөөр хэлбэл, шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэсэн ноцтой үндэслэл байгааг бичгээр илэрхийлснээс бусад тохиолдолд ШЕЗ-өөс танилцуулсан эсхүл санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхийлөгч заавал томилох үүрэгтэй. Хэрэв шүүгчид тавих болзол, шаардлага хангаагүй гэсэн үндэслэл харуулахгүйгээр ШЕЗ-өөс санал болгосон нэр дэвшигчийг томилохоос Ерөнхийлөгч үзэмжээрээ татгалздаг байвал Ерөнхийлөгч болон ШЕЗ-ийн хооронд зөрчил үүсэж, шүүгчийг шилж олох, томилох ажиллагааг бэрхшээлтэй болгоод зогсохгүй шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд итгэх олон нийтийн итгэлийг унагана. Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн дагуу хуульчдаас шүүгчийг шилж олох ажлыг зөвхөн ШЕЗ-д хариуцуулсан учраас ШЕЗ-ийн санал шийдвэрлэх үүртэй байх хэрэгтэй бөгөөд үүнд Ерөнхийлөгчийн зүгээс хутгалдан орж болохгүй.

Олон улсын сайн туршлагаар мөн шүүгчид нэр дэвшигчийг шилж олохоос томилох хүртэлх бүх шийдвэр объектив шалгуурт үндэслэх, аль болох улс төрийн байгууллага бус харин бие даасан байгууллага (шүүхийн зөвлөл)-өөр шийдвэрлүүлж байхыг илүүд үздэг. Жишээлбэл, Венецийн комисс ингэж үзжээ: "Энэ процессод голлох үүргийг бие даасан байгууллага-шүүхийн зөвлөл гүйцэтгэх баталгааг хангах хэрэгтэй. Энэхүү зөвлөлийн шийдвэрийг зөвхөн онцгой үндэслэл бүхий тохиолдолд татгалзаж болох ч зөвлөлийн санал болгосон жагсаалтад байхгүй нэр дэвшигчийг томилохыг Ерөнхийлөгчид хэрхэвч зөвшөөрч болохгүй. Бие даасан, хараат бус шүүхийн зөвлөлийн саналд Ерөнхийлөгч захирагдаж буй тохиолдолд Ерөнхийлөгчийн томилгоо асуудал үүсгэхгүй."⁸⁸ Жишээлбэл, Ирланд, Грек, Литви, Люксембург, Словак зэрэг улсад шүүгчийг шилж олох чиг үүрэгтэй байгууллага (шүүхийн зөвлөл, комисс зэрэг)-ын шүүгчээр томилуулах саналыг гүйцэтгэх эрх мэдлийн албан тушаалтан хэлбэрийн хувьд ёсчилж

⁸⁸ European Commission For Democracy Through Law (Venice Commission), Judicial Appointments, CDL-AD(2007)028, 4; European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 6.

томилдог бөгөөд практикт уг байгууллагын саналыг байнга дагадаг.⁸⁹ Хууль тогтоох эсхүл гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүгчийг томилох зохицуулалттай улсын хувьд ч шүүх эрх мэдлээс голлон бүрдсэн, бие даасан, мэргэжлийн чадамж бүхий байгууллагын саналыг томилох эрх бүхий этгээд дагадаг байх хэрэгтэй.⁹⁰

ШТХ-ийн төслийн 37.2-ын агуулгыг бүрэн дэмжиж буй ч уг заалтад "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч нь шүүгчид тавигдах болзол, хангаагүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд албан ёсоор мэдэгдэнэ" гэж бичсэн байх бөгөөд үүнд "шаардлага" гэдэг үг орхигдсон техникийн алдаа гарсан бололтойг анхаарна уу. Мөн, Үндсэн хуульд албан тушаалд "тавих шаардлага" гэсэн үг хэрэглэдэг учраас ШТХ-ийн төсөл дахь "тавигдах" гэдэг үгийг "тавих" гэж өөрчлөх нь зүйтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 37.2-д "болзол," гэсний дараа "шаардлага" гэж нэмэх

2.6. ШЕЗ-ӨӨС ШҮҮГЧИД НЭР ДЭВШИГЧИЙГ ДАХИН САНАЛ БОЛГОХ БОСГЫГ ӨНДӨРСГӨХ

ШТХ-ийн төслийн 37.3-т "Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно" гэж заажээ. Шүүгчээр томилуулахаар нэр дэвшүүлэх шийдвэрийг ШЕЗ нь хуралдаанд сууж буй гишүүдийнхээ олонхын саналаар гаргахаар төсөлд тусжээ. Ерөнхийлөгчөөс үндэслэл бүхий татгалзлыг

⁸⁹ EU Justice Scoreboard(2017), 41, <http://ec.europa.eu/justice/effective-justice/scoreboard/indexen.htm>

⁹⁰ Recommendation No. R (94)12 of the Committee of Ministers of the Council of Europe, para. 47.

ирүүлчхээд байхад түүнийг хүлээн авах эсэхийг дахин хуралдаанд сууж буй гишүүдийнхээ олонхоор гаргахаар зохицуулбал өмнөх саналаа хамгаалж тухайн нэр дэвшигчийг дахин санал болгоход амархан. Тиймээс, ШЕЗ-ийн хуралдаанд сууж буй гишүүний дийлэнх олонхын саналаар татгалзсан шалтгаан тогтоогдоогүй гэж үзсэн бол дахин санал болгохоор зохицуулах нь зүйтэй. Энэ талаар Киевийн зөвлөмжид ингэж зөвлөжээ: "Ерөнхийлөгч Шүүхийн зөвлөлийн нэр дэвшүүлсэн хүнийг томилохоос татгалзсан шийдвэр нь зөвхөн процедурын шалтгаантай байж болох бөгөөд заавал үндэслэгдсэн байх хэрэгтэй. Энэ тохиолдолд сонгон шалгаруулах байгууллага шийдвэрээ дахин хянан үзнэ. Уг байгууллага гуравны хоёрын саналаар Ерөнхийлөгчийн хоригийг давах бүрэн эрхтэй байхаар зохицуулах нь нэг хувилбар. Бүхий л шийдвэр хуулиар тогтоосон, үндэслэл бүхий богино хугацааны дотор гардаг байх ёстой."⁹¹ Тиймээс, Ерөнхийлөгчийн хоригийг үндэслэлгүй гэсэн шийдвэрийг ШЕЗ-ийн хуралдаанд сууж буй гишүүдийн дийлэнх олонхын саналаар гаргахаар зохицуулах нь зүйтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 37.3-ыг "Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүний дийлэнх олонхын саналаар тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно" гэж гэж өөрчлөх.

⁹¹ OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 6.

2.7. УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙН ТОМИЛГОО

ШТХ-ийн төслийн 37.4-т "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно" гэж заажээ. Энэ заалтаар Улсын дээд шүүхийн шүүгчийн нэр дэвшүүлсэн шүүгчийг Ерөнхий шүүгчээр томилохоор Ерөнхийлөгч үзэмжээрээ татгалзаж болохоор байгаа нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлд буй шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлын зарчим үл нийцнэ. Одоо хүчин төгөлдөр үйлчилж буй 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль болон үүнээс өмнөх хуулийн зохицуулалтын ийм дутагдалтай байдлаас болж Ерөнхийлөгч Улсын дээд шүүхийн санал болгосон шүүгчийг томилохоос үзэмжээрээ татгалзаж ирсэн байдаг. Мөн, Ерөнхий шүүгчийг гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс томилж буй тохиолдолд зөвхөн үндэслэл бүхий татгалзал хийхийг Киевийн зөвлөмжид тусгажээ.⁹² Тиймээс, Ерөнхийлөгч зөвхөн үндэслэл бүхий тохиолдолд Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгчийг томилохоос татгалзах, уг үндэслэлээ шийдвэртээ бичгээр тусгах, улмаар Улсын дээд шүүх Ерөнхийлөгчийн татгалзлыг үндэслэлгүй гэж үзвэл хуралдаанд оролцсон гишүүний дийлэнх олонхын саналаар дахин нэр дэвшүүлэх, үндэслэлтэй гэж үзвэл өөр шүүгчийг томилуулахаар нэр дэвшүүлэхээр хуульчлах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, Дээд шүүхийн ерөнхий шүүгчийн томилгоог шүүгчид нэр дэвшүүлж томилох процесстой адилхан (ШТХ-ийн төслийн 37.1-37.3) зохицуулах нь зүйтэй.

⁹² Мөн тэнд, 5.

Санал: ШТХ-ийн төслийн 37.4-т "Улсын дээд шүүхийн санал болгосон нэр дэвшигчийг Ерөнхий шүүгчээр татгалзсан бол үндэслэлээ албан ёсоор бичгээр мэдэгдэнэ. Улсын дээд шүүх Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүний дийлэнх олонхын саналаар тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно." гэж нэмэх.

2.8. УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭЭС БУСАД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧИЙГ СОНГОХ

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт "Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно" гэж заасан байсан бол 2019.11.14-нд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр уг заалтыг "Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн энэ зүйлд заасан хүрээнд хуулиар олгож болно" гэж өөрчилсөн. Энэ өөрчлөлт нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлд заасан хүрээнээс гадуур Ерөнхийлөгчид хуулиар ямар ч бүрэн эрх олгож болохгүй гэх үзэл баримтлалаар орсон. Тийм ч учраас, энэхүү үзэл баримтлалыг тодотгох үүднээс УИХ-аас 2020.01.09-нд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай УИХ-ын 02 дугаар тогтоолын 2.3.2-т "Монгол Улсын Ерөнхийлөгчид зөвхөн Монгол Улсын Үндсэн хуульд заасан үндсэн бүрэн эрхийнх нь хүрээнд тодорхой бүрэн эрх олгож байхаар зохицуулах," "Ерөнхийлөгчид хуулиар олгосон бүрэн эрх Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин гуравдугаар зүйлд заасан хүрээнд байх нэмэлт, өөрчлөлтийг холбогдох хууль тогтоомжид оруулах" гэж бичжээ.⁹³

⁹³ Төрийн мэдээлэл, 2020 он №03 /1105/, 110-111.

Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох, шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид өгсөн агуулгатай заалтууд ШТХ-ийн төсөлд байх бөгөөд эдгээр нь Үндсэн хуулийн 33 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт байхгүй учраас хасах саналтай байна.

ШТХ-ийн төслийн 37.5-т "Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс, Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар тус тус томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно" гэж зааснаас үзэхэд Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс томилохоор уншигдаж байна. Гэтэл, ШТХ-ийн төслийн 36.1-д "Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах нэр дэвшигчээс илээр санал хурааж, олонхын санал авсан хүнийг шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ" гэж заасан нь уг төслийн 37.5-ийн дээрх заалттай зөрчилдөж байна. ШТХ-ийн төслийн 36.1-ийн дагуу ШЕЗ Улсын дээд шүүхээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийг томилуулах саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэхээр ойлгогдож байх тул тус заалтаас "Ерөнхий шүүгчээр" гэдгийг хасах нь зүйтэй. Учир нь, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг томилох бүрэн эрхийг Ерөнхийлөгчид Үндсэн хуулийн 33 болон бусад зүйл, заалтаар олгоогүй.⁹⁴

Улсын дээд шүүхээс бусад шүүхийн ерөнхий шүүгчийн орон тоог нээлттэйгээр зарлах, нэр дэвшүүлэх замаар тухайн шүүхийн шүүгчид дотроосоо сонгодог байх нь олон улсын сайн туршлага юм. Киевийн зөвлөмжид "Тухайн шүүхийн шүүгчид дотроосоо ерөнхий шүүгчээ сонгодог байх нь сайн хувилбар"⁹⁵ гэж заасан. Венецийн комисс мөн

⁹⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар "Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно."

⁹⁵ OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 5.

тухайн шүүхийн шүүгчид дотроосоо ерөнхий шүүгчээ сонгохыг дэмжиж ирсэн.⁹⁶ Түүнчлэн, ШТХ-ийн төслийн 37.5-д шүүгчдийн зөвлөгөөнөөс ерөнхий шүүгчийг "томилох" бус харин "сонгох" гэсэн нэр томъёо хэрэглэвэл агуулгад нь нийцнэ.

Санал: ШТХ-ийн төслийн 36.1-ээс "Ерөнхий шүүгчээр" гэдгийг хасах.

Санал: ШТХ-ийн төслийн 37.5-ийг "Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс тус тус гурван жилийн хугацаагаар сонгох бөгөөд эдгээрийг нэг удаа улируулан сонгож болно" гэж өөрчлөх.

⁹⁶ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Bulgaria Opinion On The Judicial System Act, CDL-AD(2017)018, 7.

3. ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС, ШҮҮХИЙН БИЕ ДААСАН БАЙДАЛ

Энэ бүлэг нь (3.1) Шүүгчийн дотоод хараат бус байдал ба Улсын дээд шүүх; (3.2) Шүүгчийг шилжүүлэн болон сэлгэн ажиллуулах; (3.3) Шүүгчийг чөлөөлөх, түдгэлзүүлэх, огцруулах; (3.4) Шүүгчийн урамшуулал ба хараат бус байдал; (3.5) ШЕЗ-өөс шүүхийн төсвийн төслийг УИХ-д шууд өргөн мэдүүлэх; (3.6) Шүүхийн төсвийн төслийг хэлэлцэх явцад саналаа хэлэх боломжийг ШЕЗ-д олгох; (3.7) Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх; (3.8) Шүүгчийн тусгай саналыг хэвлэн нийтлэх; (3.9) Шүүгчдийн зөвлөл гэсэн есөн хэсгээр бүрдэнэ.

3.1. ШҮҮГЧИЙН ДОТООД ХАРААТ БУС БАЙДАЛ БА УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана," 49 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт "Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй," 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана" гэж заасан нь нэг талаас шүүх эрх мэдлийн бие даасан, нөгөө талаас шүүгчийн хараат бус байдлыг хамгаалдаг.

Шүүгчийн хараат бус байдал нь гадаад болон дотоод талтай. Хараат бус байдлын гадаад тал нь бусад эрх мэдлийн салаанаас шүүх болон шүүгчид зүй бусаар нөлөөлөхийг хориглодог бол түүний дотоод тал нь шүүгч зөвхөн Үндсэн хууль болон хуульд захирагдах, бусад хүчин зүйл, ялангуяа дээд шатны шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн удирдлага, нөлөөллөөс ангид байх баталгааг шаарддаг. "Шүүхийн хараат бус байдал гэдэг бол шүүх эрх мэдэл бүхэлдээ бусад эрх мэдлүүдээс хараат бус байх утгаас гадна энэ нь "дотоод" талтай юм. Шүүхийн тогтолцоонд байгаа шүүгч бүр бусад шүүгчтэй

адил эрх мэдэл хэрэгжүүлдэг. Шүүн таслах ажлаа хийх явцад тэрээр бусад шүүгчид төдийгүй шүүхийнхээ ерөнхий шүүгч, бусад шүүх (давж заалдах, хяналтын шатны зэрэг)-ийн шүүгчдээс хараат бус байх хэрэгтэй.⁹⁷ Шүүгчийн шийдвэр гаргах ажиллагааг ерөнхий шүүгч эсхүл дээд шатны шүүхэд захируулах байдлаар шүүхийг шатлан зохион байгуулах нь шүүгчийн дотоод хараат бус байдлыг илэрхий зөрчдөг гэж Венецийн комисс үздэг.⁹⁸

Улсын дээд шүүх нь хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан, давж заалдах, хяналтын журмаар хянан шийдвэрлэх болон Үндсэн хуулиар олгосон тодорхой бүрэн эрхийг хэрэгжүүлэх чиг үүрэгтэй (Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 65 дугаар зүйлийн 1 дэх хэсэг). Үүний дагуу Улсын дээд шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр ШТХ-ийн төсөлд заажээ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх (ШТХ-ийн төсөл, 25.6.1);
2. хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянах (ШТХ-ийн төсөл, 25.6.2);
3. Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах (ШТХ-ийн төсөл, 25.6.4);
4. хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх (ШТХ-ийн төсөл, 25.6.5);
5. ШТХ-ийн төслийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах (ШТХ-ийн төсөл, 25.6.7);

⁹⁷ European Commission For Democracy Through Law (Venice Commission), Opinion On The Draft Law On The Judiciary And The Draft Law On The Status Of Judges Of Ukraine, CDL-AD(2007)003, 61.

⁹⁸ The Venice Commission, Report on the Independence of the Judicial System Part I: the Independence of Judges, CDL-AD(2010)004, 18.

6. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах тухай санал гаргах (ШТХ-ийн төсөл, 25.6.8);
7. Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг хянан шийдвэрлэх (ШТХ-ийн төсөл, 25.6.9);
8. бүх насаар нь хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хянан шийдвэрлэх (ШТХ-ийн төсөл, 25.6.10);
9. Шүүхийн шийдвэр, практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах (ШТХ-ийн төсөл, 25.6.3);

Үндсэн хуулиар Улсын дээд шүүхэд хүлээлгэсэн чиг үүрэгт нь төдийлөн хамааралгүй, түүнээс нь хальсан шинжтэй дараах бүрэн эрхийг өгөхөөр төсөлд тусгажээ:

1. Шүүхийн шийдвэр, практикт үндэслэн зөвлөмж гаргах (ШТХ-ийн төсөл, 25.6.3);
2. Шүүхийн шийдвэрийг бичих аргачлал, журмыг Улсын дээд шүүх тогтооно (ШТХ-ийн төсөл, 22.2);
3. Шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг зохион байгуулах (ШТХ-ийн төсөл, 25.6.3, 50.3). [Шүүхийн ерөнхий зөвлөл] шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Улсын дээд шүүх болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах (ШТХ-ийн төсөл, 74.1.6);
4. Шүүхийн судалгаа, шинжилгээ, тоон болон бусад мэдээлэл, сургалтын асуудлыг хариуцсан Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана (ШТХ-ийн төсөл, 24.1);
5. Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд

буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ (ШТХ-ийн төсөл, 58.1);

6. Шүүхийн мэргэшлийн хорооны зургаан гишүүн нь Улсын дээд шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгч байх бөгөөд тэдгээрийг Шүүгчдийн зөвлөлөөс сонгож, Ерөнхий зөвлөлд санал болгоно (ШТХ-ийн төсөл, 86.4).;
7. Хуульд зааснаар танхим байгуулах (ШТХ-ийн төсөл, 25.6.6). Аймаг, нийслэлийн шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэний хэргийн танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална (ШТХ-ийн төсөл, 29.3). Мөн, анхан шатны шүүхэд тодорхой хэрэг, маргааны төрлөөрх танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална. (ШТХ-ийн төсөл, 32.3, 32.4).

Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5-д заасны дагуу бусад асуудал шийдвэрлэх бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд олгож болох боловч энэ нь Үндсэн хуулийн суурь зарчимд нийцсэн байх хэрэгтэй. Гэтэл, ШТХ-ийн төслөөр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх зэрэг Үндсэн хуулийн бүрэн эрхээс нь гадуур олон бүрэн эрхийг өгсөн байна. Эдгээр бүрэн эрх нь хамтдаа доод шатны шүүх болон түүний шүүгчдийг шатлан захирах, хянах үр дагавартай байна. Тодруулбал, доод шатны шүүхийн шийдсэн хэрэг, маргааныг давж заалдах эсхүл хяналтын журмаар шийдвэрлэхээс гадна Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах, зөвлөмж гаргах, шүүхийн шийдвэр бичих аргачлал, журмыг тогтоох, сургалт явуулах, шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулах (чөлөөлөх хүртэл үр дагавартай)-аар Мэргэшлийн хороонд хүргүүлэх, Мэргэшлийн хорооны 9 гишүүний гуравны хоёр буюу 6 нь Дээд шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгчээс бүрдүүлэх, шүүгчдийн зөвлөлд бүрэн бүрэлдэхүүнээрээ орох (анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид уг зөвлөлд төлөөллөө оролцуулах

бол Улсын дээд шүүхийн бүх шүүгчид орох бөгөөд Шүүгчдийн зөвлөл нь Мэргэшлийн хорооны 8 гишүүний зургааг, ШЕЗ-ийн 10 гишүүний тавыг, Сахилгын хорооны 9 гишүүний 3-ыг тус тус сонгоно) зэрэг өргөн эрх мэдэлтэй байна. Эдгээр эрх мэдэл нь хувь шүүгч хуулийг хэрхэн хэрэглэж хэрэг, маргааныг яаж шийдвэрлэх, шийдвэрээ яаж бичих гээд бараг бүх зүйл рүү нь Улсын дээд шүүхээс орох эрсдэл үүсгэнэ. Ийм өргөн бүрэн эрх бүхий Улсын дээд шүүхийн гаргасан тайлбар, зөвлөмж, сургалтын агуулга, шийдвэр бичих аргачлалд ягштал захирагдахгүй бол анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчид чөлөөлөгдөх эсхүл ийм айдастайгаар ажиллах болно. Энэ бол шүүгчийн дотоод хараат бус байдлын ноцтой зөрчил болно.

Англи-Америкийн тогтолцоо дахь *stare decisis* номлол болон Эх газрын тогтолцоо дахь давж заалдах буюу хяналтын журмаар гомдол гаргах зохицуулалт нь шүүх эрх мэдэл дэх хууль хэрэглээний нэгдмэл, зарчимч байдлыг хангах чиг үүргийг бүрэн гүйцэтгэдэг. Үүнээс илүү эрх мэдлийг ШТХ-ийн төсөлд байгаа шигээр Дээд шүүхэд төвлөрүүлэх нь анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийн хараат бус байдлыг аюулд оруулна. Бүх шатны шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтлэх замаар нийтэд хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нь хангах болон дээд шатны шүүхэд гомдол гаргах тодорхой журамтай байх нь шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулахгүйгээр хуулийг нэг мөр тайлбарлаж, хэрэгжүүлэх нөхцөл болно.⁹⁹

Улсын дээд шүүх эсхүл давж заалдах шатны шүүхээс доод шатны шүүхэд заавал биелүүлэх шинжтэй тайлбар гаргах, зөвлөмж өгөх практик шүүгчийн дотоод хараат бус байдалд төдийлөн нийцдэггүй. Доод шатны шүүхдээ зориулан хууль хэрэглээний асуудлаарх тайлбар, зөвлөмж гаргах бүрэн эрхийг Дээд шүүхэд өгөх агуулгатай хуулийн төсөл шүүгчийн дотоод хараат бус байдалд халдах тул түүнээсээ татгалзах саналыг Венецийн комисс Украинд ийнхүү өгч байжээ:

⁹⁹ European Commission For Democracy Through Law (Venice Commission), Opinion On Act CLXII Of 2011 On The Legal Status And Remuneration Of Judges And Act CLXI Of 2011 On The Organisation And Administration Of Courts Of Hungary, CDL-AD(2012)001, 21.

Хараат бус шүүх тогтолцоонд дээд шатны шүүх нь өөрийн гаргасан шийдвэрээрээ дамжуулж нэг мөр жишиг тогтоож байдаг. Шүүхийн жишигт албан ёсоор захирагддаг нийтлэг эрх зүйн уламжлалаас ялгаагүйгээр иргэнлэг эрх зүйн доод шатны шүүхүүд нь давж заалдах журмаар шийдвэрээ хүчингүй болгуулахгүйн тулд дээд шатны шүүхийн шийдвэрүүдийн хөгжүүлсэн зарчмуудыг баримтлах хандлагатай байдаг. Мөн, шүүхийн өөр өөр салбар хоорондын уялдааг процессын хэм хэмжээгээр хангадаг. Одоогийн төсөл нь энэхүү зарчмаас хэт их зөрж байна. Хууль хэрэглээний асуудлаарх зөвлөмж/ тайлбарыг доод шатны шүүхэд өгөх боломжийг Дээд шүүхэд... өгч байна. Энэ тогтолцоо нь Украинд хараат бус шүүх эрх мэдлийн төлөвшүүлэхийг бодитоор дэмжихгүй, харин ч шүүгчийг дээд албан тушаалтнаас өгсөн тушаал зааварт захирагдах төрийн захиргааны албан хаагч шиг ажиллуулдаг болгох эрсдэлтэй.¹⁰⁰

Дээд шүүх нь шүүхийн жишгийн эрх зүйн нэг мөр байдлыг хангахдаа хууль хэрэглээний асуудлаар ерөнхий зөвлөмж, тайлбарыг доод шатны шүүхэд хүргүүлэх замыг бус, харин хяналтын журмаар хэрэг, маргаан шийдвэрлэх замыг хэрэглэхээр хуульчлах тухай адил зөвлөмжийг Гүржид өгч байжээ.¹⁰¹ Хуулийн тайлбарын нэг мөр байдал нь заавал биелэгдэх шинжгүй шүүхийн практикийг судлах замаар хангагдах боломжтой.¹⁰² "Дээд шатны шүүхээс тайлбар, зөвлөмж, тогтоол гаргах явдлаас зайлсхийвэл зохих бөгөөд гаргаж байгаа

¹⁰⁰ European Commission For Democracy Through Law (Venice Commission), Opinion On The Draft Law Of Ukraine On The Judicial System, CDL-INF(2000)5, 4.

¹⁰¹ CDL-AD(2014)030, Joint Opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate of Human Rights and Rule of Law (DGI) of the Council of Europe, on the draft Laws amending the Administrative, Civil and Criminal Codes of Georgia, §§ 33, 34

¹⁰² OSCE ODIHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 8.

нөхцөлд доод шатны шүүх заавал биелүүлэх шинжгүй байх ёстой. Үгүй бол энэ нь хувь шүүгчийн хараат бус байдалд халдана."¹⁰³

"Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах" бүрэн эрхийг Улсын дээд шүүхэд Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4-өөр олгосон учраас ШТХ-ийн төслийн 25.6.4-д тусгахыг үгүйсгэхэд хэцүү. Үндсэн хуулийн энэ заалтад "хуулийн тайлбар гаргах" гэж бичээгүй, харин "хуулийг зөв хэрэглэх талаар" тайлбар гаргах гэж бичсэн нь уг тайлбар "шүүхийн шийдвэр, практикт үндэслэн" хуулийг зөв хэрэглэх тухай байх агуулга илэрхийлдэг. Монгол улсын эрх зүйн уламжлал ч бас ийм явж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Улсын дээд шүүх нь шүүхийн шийдвэр, практикт үндэслэхгүйгээр хуулийн заалтын талаарх хийсвэр тайлбар гаргахгүй. Нэгэнт ийм агуулгаар тайлбар гаргах боломж бүрдэх учраас Улсын дээд шүүхэд "зөвлөмж гаргах" бүрэн эрх нэмж өгөх шаардлагагүй юм.

Шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтны мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах сургалтыг ШЕЗ зохион байгуулахад Улсын дээд шүүхтэй хамтрах байдлаар төсөл бичигдсэн боловч бодит байдалд шүүгчийн сургалтад Улсын дээд шүүх ноёлохоор байна. Нэгд, шүүхийн сургалтын асуудал хариуцсан хүрээлэн ШЕЗ-ийн дэргэд биш Улсын дээд шүүхийн дэргэд байх учраас Улсын дээд шүүх сургалтын хөтөлбөр, багшлах бүрэлдэхүүн гэх мэтийг шийдвэрлэхэд давамгайлна. Улсын дээд шүүхийн дэргэд судалгааны асуудал хариуцсан хүрээлэн ажиллах нь уг шүүхээс судалгаанд үндэслэсэн шийдвэр гаргахад тустай байх талтай. Гэвч, ШТХ-ийн төслийн 24.1-т зааснаар Шүүхийн судалгаа, шинжилгээ, тоон болон бусад мэдээлэл, сургалтын асуудлыг хариуцсан Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллах бөгөөд адил чиг үүрэгтэй бүтэц ШЕЗ дотор байхгүй байхаар байна. Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн чиг үүрэг, ажиллах журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батлах боловч уг хүрээлэнгийн хүрээлэнгийн бүтэц, орон тоог Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална (24.2, 24.3). Хоёрт, Улсын дээд шүүх

¹⁰³ Мөн тэнд.

хяналтын шатны шүүхийн чиг үүргээсээ гадна хуулийн тайлбар, зөвлөмж, шүүхийн шийдвэр бичих аргачлал, журам гаргах эрх мэдлээ хэрэгжүүлж эдгээр нь шүүгчийн сургалтын агуулгыг тодорхойлох магадлалтай. Улсын дээд шүүх сургалтаар дамжуулан доод шатны шүүхийн шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй. Улсын дээд шүүхийн шүүгчийн сургалтаар заасны дагуу шийдэхгүй эсхүл ажиллахгүй бол болохгүй гэсэн айдас үүсэхээс сэргийлэх үүднээс ШЕЗ уг сургалтыг зохион байгуулах нь зүйтэй.

Шүүгчийн болон шүүхийн захиргааны ажилтны мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах сургалтыг ШЕЗ зохион байгуулахад Улсын дээд шүүх хамтрах шаардлага байхгүй. Мэдээж ШЕЗ нь шүүгчийн сургалтад Дээд шүүхийн шийдвэрийг ашиглах, шаардлагатай тохиолдолд Дээд шүүхийн шүүгчийг сургагч багшаар ажиллуулах боломжтой. Шүүхийн зөвлөлтэй улсын хувьд тус зөвлөлд сургалтыг хариуцуулах нь элбэг. "Шүүхийн зөвлөлтэй улсад тус зөвлөл шүүгчийн хууль зүйн боловсролд зориулсан зөвлөмж гаргаж болно. Энэ нь шүүгчийн үргэлжилсэн сургалтын талаарх зөвлөгөө, холбогдох ур чадварын талаар агуулна."¹⁰⁴

"Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ" гэсэн ШТХ-ийн төслийн 58.1-д буй заалтыг хасах шаардлагатай. Энэхүү саналын "Шүүхийн мэргэшлийн хороо, түүний бүрэн эрх" гэсэн гарчигтай 2.4 дэх хэсэгт уг заалт болон холбогдох бусад заалтыг төслөөс хасах үндэслэлийг авч үзсэнтэй танилцана уу.

Давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг давж заалдах журмаар хянан шийдвэрлэх, хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэхээс гадна "шүүн таслах ажиллагааны практикийг судалж мэдээлэл хийх, зөвлөмж гаргах, хууль тогтоомжийг боловсронгуй

¹⁰⁴ Мөн тэнд, 5.

болгох тухай саналаа Улсын дээд шүүхэд уламжлах" бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр ШТХ-ийн төслийн 29.4.3-т заасан нь салаа утгатай ойлгогдож байна. Уг заалт нь давж заалдах шатны шүүх өөрөө бие даагаад "шүүн таслах ажиллагааны практикийг судалж мэдээлэл хийх, зөвлөмж гаргах" уу, эсвэл ийм мэдээлэл хийх, зөвлөмж гаргах саналаа "хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай санал"-тай адилаар Улсын дээд шүүхэд уламжлах уу гэдэг тодорхойгүй байна. Хэрэв эхнийхээр буюу бие даагаад зөвлөмж гаргахаар ойлгогдвол давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэл үүсгэнэ. Иймээс, давж заалдах шатны шүүхэд ч, Дээд шүүхэд ч зөвлөмж гаргах эрх мэдлийг өгөх шаардлагагүй.

Санал: ШТХ-ийн төлөөс дараах заалтыг хасах, өөрчлөх саналтай байна:

1. ШТХ-ийн төслийн 22.2-д "Шүүхийн шийдвэрийг бичих аргачлал, журмыг Улсын дээд шүүх тогтооно." гэснийг хасах;
2. ШТХ-ийн төслийн 25.6.3-аас "шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран сургалт зохион байгуулах, зөвлөмж гаргах," ШТХ-ийн төслийн 29.4.3-ээс "зөвлөмж гаргах," 50.3-аас "Улсын дээд шүүхтэй хамтран," 74.1.6-аас "Улсын дээд шүүх болон" гэснийг тус тус хасах;
3. ШТХ-ийн төслийн 58.1-т "Шүүгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ." гэснийг хасах;

4. ШТХ-ийн төслийн 86.4-д "Мэргэшлийн хорооны зургаан гишүүн нь Улсын дээд шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгч байх бөгөөд тэдгээрийг Шүүгчдийн зөвлөлөөс сонгож, Ерөнхий зөвлөлд санал болгоно." гэснийг хасах;
5. ШТХ-ийн төслийн 25.6.6-аас "Хуульд зааснаар танхим байгуулах" гэснийг хасах. Үүнтэй холбогдуулан ШТХ-ийн төслийн 29.3-ийг "Аймаг, нийслэлийн шүүхэд шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэний хэргийн танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална," мөн төслийн 32.4-ийг "Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална" гэж тус тус өөрчлөх.

3.2. ШҮҮГЧИЙГ ШИЛЖҮҮЛЭН БОЛОН СЭЛГЭН АЖИЛЛУУЛАХ

2013, 2015 онд шүүхийг өөрчлөн зохион байгуулж анхан болон давж заалдах шатны шүүхийн бүх шүүгчийг чөлөөлж, өөрчлөн байгуулагдсан шүүхэд нь буцаан томилсон. Энэ үед өөрчлөн байгуулагдсан шүүхэд нь буцаан томилох боломжтой орон тоо байсаар байхад зарим шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр шүүх рүү шилжүүлсэн, 13 шүүгчийг огт буцаан томилоогүй.¹⁰⁵ Ийм замаар шүүгчийн хараат бус байдалд ноцтой халдсан тохиолдол дахин гарахаас сэргийлэх үүднээс зөвхөн шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлөөр шилжүүлэн томилох, ийнхүү томилохоос Ерөнхийлөгч татгалзахгүй байх зохицуулалтыг ШТХ-ийн төсөлд тусгаж өгчээ.

¹⁰⁵ Ж.Хунан, П.Баттулга, М.Мөнхжаргал, Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлын баталгаа: шүүгчийн томилгоо (УБ, 2015), 81-94; О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, Монгол Улс дахь Шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам (УБ: Нээлттэй нийгэм форум, 2015), 65–69.

ШТХ-ийн төслийн 3.1.6-д "шүүгчийг шилжүүлэн ажиллуулах" гэж "шүүхийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах болон энэ хуульд заасан бусад тохиолдолд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн адил шатны шүүхэд шилжүүлэн ажиллуулахыг" ойлгоно гэжээ. Татан буулгасан, өөрчлөн байгуулсан тохиолдолд шүүгчийг шилжүүлэн ажиллуулах нарийвчилсан зохицуулалтыг мөн тусгажээ. ШТХ-ийн төслийн 43.3.5-д "шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, аль нэг шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилуулах," мөн төслийн 43.4-д "шүүгчийн орон тоо цөөрсөн, шүүхийг татан буулгах болон өөрчлөн зохион байгуулахтай холбоотойгоор шүүгчийг өөрчлөн зохион байгуулагдсан шүүх, эсхүл өөр шүүхэд шилжүүлэн томилохоос Ерөнхийлөгч татгалзаж болохгүй" гэж тус тус заасан байна.

Шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөл авахгүйгээр өөр шүүхэд шилжүүлэхийг хориглож буй нь шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах сайн туршлагад нийцэж байна. "Шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан эсхүл шүүхийн бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлийн онцгой нөхцөлөөс бусад тохиолдолд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр шүүхэд шинээр томилох, шилжүүлэх ёсгүй."¹⁰⁶ Онцгой шалтгаантайгаас бусад тохиолдолд шүүгчийн хүсэл зоригийнх нь эсрэг шилжүүлж болохгүй гэсэн байр суурийг Венецийн комисс мөн баримталдаг.¹⁰⁷

ШТХ-ийн төслийн 43.5-д "Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүх хооронд сэлгэх буюу шилжүүлэн ажиллуулж болно" гэжээ. Уг төслийн 3.1.5-д "шүүгчийг сэлгэн

¹⁰⁶ Recommendation CM/Rec(2010)12 of the Committee Of Ministers To Member States On Judges: Independence, Efficiency And Responsibilities, 6.

¹⁰⁷ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 9.

ажиллуулах" гэж "шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны өөр шүүхэд ажиллуулахыг" хэлнэ гэжээ. Харин, ШТХ-ийн төслийн 43.5-д буй "шилжүүлэн ажиллуулах" гэдэг ойлголт нь ШТХ-ийн төслийн 3.1.6-д "шүүхийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах болон энэ хуульд заасан бусад тохиолдолд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн адил шатны шүүхэд шилжүүлэн ажиллуулахыг" хэлнэ гэсний "энэ хуульд заасан бусад тохиолдол" гэдэгт хамаарч байна.

ШТХ-ийн төслийн 16.5-д "Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолтоор ажиллаж болно. Томилолтоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална" гэж заажээ. Энд заасан "томилолтоор ажиллаж болох" зохицуулалт нь ШТХ-ийн төслийн 3.1.5-д "шүүгчийг сэлгэн ажиллуулах" ажиллуулахтай адил агуулгатай эсэх тодорхойгүй байна. Адил агуулгатай гэж үзвэл "Сэлгэн ажиллуулах" гэсэн адил хэллэгээр бичих нь дээр болов уу. Учир нь, "сэлгэн ажиллуулах"-д заавал шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэхээр заасан байх тул шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэл бага байна. Харин, "томилолтоор ажиллах" болон "сэлгэн ажиллуулах" нь ялгаатай агуулгатай бол түүнийг заах, мөн аль алинд нь шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг авсан байхаар тусгаж шүүгчийн хараат бус байдлын баталгааг хангах хэрэгтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 16.5-д "Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд өөрийн хүсэлтээр сэлгэн ажиллаж болно. Сэлгэн ажиллуулах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална" гэж өөрчлөх.

3.3. ШҮҮГЧИЙГ ЧӨЛӨӨЛӨХ, ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, ОГЦРУУЛАХ

Шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгох үндэслэлийг ШТХ-ийн төслийн 41.2-т бичжээ. Эдгээр үндэслэлийн дийлэнх нь шүүгч өөрөө хүсэлтээ бичгээр гаргасан, өөр ажилд томилогдсон, сонгогдсон, нас барсан зэрэг тодорхой үйл явдал болсон, эсхүл шүүхийн шийдвэр гарсантай холбоотой шүүгчийн бүрэн эрхийг дуусгавар болгож чөлөөлөх агуулгатай байх тул эдгээр үйл явдлыг нягтлаад бүрэн эрхийг нь дуусгавар болгох нь нэг талаар шүүгчийн хараат бус байдлын баталгаа болохоор байна. ШТХ-ийн төслийн 41.2.2-д "эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон" бол мөн бүрэн эрхийг нь дуусгавар болохоор заажээ.

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх, чөлөөлөх, огцруулах бүрэн эрхийг Ерөнхийлөгчид Үндсэн хуулийн 33 болон бусад зүйлээр олгоогүй. Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор шүүгч болон шүүгч бус гишүүдийн тэнцвэртэй төлөөлөөс бүрдэж ажилладгийн хувьд ШЕЗ нь шүүгчийн буруутай үйл ажиллагаатай холбоогүй үндэслэл (жишээлбэл, ШЕЗ-ийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгогдсон, сураггүй алга болсонд тооцогдсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон зэрэг)-ээр шүүгчийг түдгэлзүүлэх, уул үндэслэл арилсан тохиолдолд шүүгчийн бүрэн эрхийг сэргээх, харин шүүгчийн буруутай үйл ажиллагаатай холбоогүй үндэслэл (жишээлбэл, чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан, өөр албан тушаалд шилжсэн, томилогдсон, сонгогдсон зэрэг)-ээр шүүгчийг чөлөөлөх бүрэн эрхийг шууд хэрэгжүүлэх боломжтой.

Санал: ШТХ-ийн төслийн 40.1-ээс "саналыг үндэслэн Ерөнхийлөгч," мөн төслийн 41.2-оос "ийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч," 74.1.3-аас "албан тушаалаас нь чөлөөлүүлэх, түдгэлзүүлэх, огцруулах" гэдгийг тус тус хасах.

3.4. ШҮҮГЧИЙН УРАМШУУЛАЛ БА ХАРААТ БУС БАЙДАЛ

2012 оны Шүүхийн тухай багц хууль Үндсэн хуулийн 48.3-д "Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэж зарчмыг олон улсын сайн туршлагын дагуу тодотгосон хэд хэдэн заалтыг хуульчилсан байсан. Тодруулбал, ШТХ-ийн 28.5-д "Шүүхийн үйл ажиллагааны төсвийг өмнөх жилийнхээс бууруулахыг хориглоно," ШЭЗБТХ-ийн 23.5-д "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэж заасан. Шүүгчийн цалин хөлсийг бууруулахгүй байх баталгааны цаад зорилго бол хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагаас шүүхийн төсөв, шүүгчийн цалингаар дамжуулан шүүгчдийг шийтгэх явдал гаргуулахгүй байхад чиглэдэг.¹⁰⁸ Гэтэл, УИХ ШТХ-ийн 28.5, ШЭЗБТХ, 23.5 дахь хэсгүүдийг 2015 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн хуулиар хүчингүй болсон. Үүний дараа Засгийн газар шүүгчийн цалинг 61-66 хувиар бууруулах саналыг 2016 онд гаргаж хэлэлцүүлж байсан, мөн шүүхийн төсвийн улсын төсөвт эзлэх хувь 0.82 хүрсэн байсныг 0.66 болгон бууруулсан. Шүүхийн төсвийг 2015-2017 онуудад жил бүр бууруулан баталжээ.¹⁰⁹

ШТХ-ийн төсөлд шүүгчийн эдийн засгийн баталгаа буюу эдийн засгийн хараат бус байдлыг хангах сайн зохицуулалтыг тусгажээ. Жишээлбэл: ШТХ-ийн төслөөр шүүгчийн цалингийн хэмжээг тогтоох, нэмэгдүүлэх шалгууруудаас гадна түүний бүрдүүлбэрийг тодорхой хуульчилжээ: ШТХ-ийн төслийн 47.1-т "Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна," 47.2-т "Тухайн шүүгчийн үндсэн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар

¹⁰⁸ Мөн тэнд., 37.

¹⁰⁹ Энэ талаарх дэлгэрэнгүйг дараах эх сурвалжаас үзнэ үү: О.Мөнхсайхан, "Шүүх эрх мэдэл дэх шүүхийн захиргаа," Монгол Улс дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019) дотор, (Конрад-Аденауэр Сан, 2019), 71-107; О.Мөнхсайхан, "Монгол Улсын шүүх эрх мэдлийн талаарх хөндлөнгийн судалгаа, дүн шинжилгээ" илтгэл, "Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар" олон улсын бага хурлын эмтхэтгэл дотор (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018), 41-71.

нэмэгдэнэ," 47.3-т "Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон шүүн таслах ажиллагааны, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, докторын зэрэг, цол зэрэг нэмэгдлээс бүрдэнэ" гэжээ. Үүнээс гадна шүүгчийн цалин, нэмэгдлийг батлах процедурын баталгааг хангаж өгчээ. Тодруулбал, ШТХ-ийн төслийн 47.4-т "Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ, шүүгчийн орон тоог Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно," 47.5-д "Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй" гэж заасан. Эдгээр заалт нь 2016 онд шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулах саналыг гаргаж шүүгчийн эдийн засгийн хараат бус байдлыг эрсдэлд оруулж байсан шиг тохиолдол гаргахаас сэргийлнэ.

Пост коммунист улсуудад хувь шүүгчдийн нийгмийн хэрэгцээ, ялгаатай байдлаас хамаараад санхүүгийн бус урамшуулал, хангамжийн тогтолцоо нь амархан урвуулан ашиглагдах, субъектив шалгуурт өртөх магадлалтайг Венецийн комисс анхааруулжээ.¹¹⁰ Пост-коммунист улсуудын туршлагаас харахад урт хугацаандаа урамшууллын тогтолцоог халах, тухайн нөхцөлд аль хэдийнэ хэрэгжүүлж байгаа бол аль болох урьдчилан тогтоосон, тодорхой шалгуураар ил тодоор олгох хэрэгтэй гэжээ. Киевийн зөвлөмжид урамшуулал, давуу эрхийг үзэмжээр хуваарилах зохицуулалтаас татгалзахыг дараах байдлаар уриалжээ: "Урт хугацаандаа урамшуулал, давуу эрхийг халж, шүүгчийн мэргэжлийн хариуцлага болон амьдралын стандартад нийцүүлэн шүүгчийн хэрэгцээг хангахуйц түвшинд шүүгчийн цалинг нэмэгдүүлэх хэрэгтэй. Урамшуулал, давуу эрх хэрэгжиж байгаа тохиолдолд тэдгээрийг урьдчилан тогтоосон шалгуураар, ил тод журмаар олгох нь зүйтэй. Урамшуулал эсхүл давуу эрхийг эдлүүлэхэд ерөнхий шүүгчийг оролцуулах хэрэггүй."¹¹¹

¹¹⁰ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 6.

¹¹¹ OSCE and Max Planck, "Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability," (Kyiv, 23-25 June 2010) 4.

ШТХ-ийн төсөл шүүгчийн эдлэх давуу эрх болон урамшууллын талаар тусгажээ. Жишээлбэл, ШТХ-ийн төслийн 47.6-т "Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ," 47.7-т "Шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд түүний очих, ирэх замын зардлыг хоёр жилд нэг удаа шүүхийн төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгоно" гэж шүүгчийн эдлэх давуу эрхийн тухай тодорхой заасан учраас энэ нь урьдчилан тогтоосон, тодорхой байх шалгуурыг хангаж байна.

Харин шүүгчид олгох урамшууллын зохицуулалт нь урьдчилан тогтоосон, тодорхой байх шалгуурыг хангахгүй байна. Тодруулбал, ШТХ-ийн төслийн 47.8-д "Шүүгчид ногдох хэргийн ачааллын шалгуур үзүүлэлт, шүүгчид урамшуулал олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална" гэж заасан. Ийм урамшууллыг олгох шалгуур үзүүлэлт, журмыг баталж мөрдсөн ч гэсэн ШЕЗ-ийн зүгээс шүүгчийг сайн эсхүл муу ажилласан гэдгээр нь үнэлэх, ингэхдээ үзэмжээр буюу хэт субъектив хандах, үүгээр дамжуулан шүүгчийн шүүн таслах ажилд нөлөөлөх эрсдэл үүсгэхээр байна. ШТХ-ийн төсөлд шүүгчид урамшуулал олгох шалгуур, журмыг огт хуульчлаагүй харин ШЕЗ-ийн үзэмжид орхисон нь Киевийн зөвлөмжийн дээрх шаардлагыг хангахгүй байна. Нөгөө талаар, одоогийн хуулиар урамшууллын тогтолцоо угаасаа байхгүй учраас шүүгчийн хараат бус байдалд халтай уг тогтолцоог шинээр бий болгох шаардлагагүй.

ШТХ-ийн төслийн 47.8 нь Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012 оны хуулийн 8.3-т "Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагааны түвшинг гурваас таван жилд дүгнэх шалгуур үзүүлэлт, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл Шүүхийн мэргэшлийн хороотой хамтран боловсруулж, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална," 23.3-т "Шүүгч нь ажлын ачаалал, бүтээмж, шийдвэрийн чанар зэрэгтэй уялдсан нэмэгдэл авах бөгөөд уг нэмэгдэл нь энэ хуулийн 8.3-т заасан мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс хамаарах ба нэмэгдлийн хэмжээ үндсэн цалингийн 50 хувь хүртэл байна" гэж заасны "...уг нэмэгдэл нь энэ хуулийн 8.3-т заасан мэргэшлийн үнэлгээний үр дүнгээс

хамаарах ..." гэсэн нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана" зэрэг заалтыг зөрчсөн гэж шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2015 оны 5 дугаар дүгнэлттэй зөрчилдөх магадлалтай. Цэц энэ дүгнэлтээрээ шүүгчийн мэргэшлийн үнэлгээнээс хамаарсан нэмэгдэл олгох нь уг үнэлгээг хийж буй этгээдээс үзэмжээрээ хандах эрсдэлийг үүсгэж буй тул шүүгчийн хараат бус байдалд нийцэхгүй гэж үзсэн.

Иймд, ШТХ-ийн төсөлд шүүгчийн эдийн засгийн баталгааг тодорхой хуульчилсан тул урамшууллын тухай ийм тодорхойгүй зохицуулалт байх шаардлагагүй.

Санал. ШТХ-ийн төслийн 47.8-т "Шүүгчид ногдох хэргийн ачааллын шалгуур үзүүлэлт, шүүгчид урамшуулал олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална" гэж заасныг хасах.

3.5. ШЕЗ-ӨӨС ШҮҮХИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ УИХ-Д ШУУД ӨРГӨН МЭДҮҮЛЭХ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт хууль дээдлэх зарчим, 49 дугаар зүйлд шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ 48 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт "Шүүх улсын төсвөөс санхүүжнэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана" гэж заасан. Тийм учраас, Засгийн газар болон УИХ-ын зүгээс шүүхийн төсвийг батлахад шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдал ямагт хүндэтгэлтэй хандах үүрэгтэй.

ШТХ-ийн төслийн 47.9.2-д "Засгийн газар жилийн төсвийн төслийг шүүхийн төсвийн саналыг өөрчлөхгүйгээр холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх"-ээр заасан нь гүйцэтгэх эрх мэдлийн зүгээс шүүхийн төсвийн төслийг бууруулж өргөн мэдүүлэх замаар

шүүхийн бие даасан байдалд халддаг явдлыг эцэслэхэд тустай.¹¹² Гэвч, ШТХ-ийн төслийн 76.1.1-т ШЕЗ “бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төсвийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” бүрэн эрхийг хэрэгжүүлэх гэж заасан нь уг төслийн 47.9.2-т заасантай зөрчилдөж, Засгийн газрын зүгээс шүүхийн төслийн төслийн хэмжээг танаж УИХ-д өргөн мэдүүлдэг байдал үүсэх эрсдэлтэй.

Засгийн газартай зөвшилцөнө гэдэг бол Сангийн яам эсхүл сайдтай зөвшилцөнө гэсэн үг бөгөөд энэ зүгээс санхүү, төсвийн эрх мэдэлдээ дулдуйдан шүүхийн төсвийн төслийг үзэмжээрээ бууруулах, үүгээр дамжуулан шүүхэд нөлөөлөх эрсдэлтэй. “Шүүхийн төсөв нь албан байгууллагын үзэмжийн шийдвэрээс хамаарч бус харин урьдчилан тогтоосон, объектив шалгуурт үндэслэсэн тогтвортой байдлаар санхүүждэг байх хэрэгтэй.”¹¹³ Шүүхийн захиргааг хариуцсан бие даасан байгууллага шүүхийн төсвийн төслийг шүүхүүдийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулж парламент буюу түүний холбогдох хороонд шууд өргөн мэдүүлдэг байх нь зохимжтой¹¹⁴ (гэхдээ үүнээс өөр байр суурьтай зөвлөмж бас бий).¹¹⁵

¹¹² Энэ талаарх дэлгэрэнгүйг дараах эх сурвалжаас үзнэ үү: О.Мөнхсайхан, Г.Цагаанбаяр, Ж.Алтансүх, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам (Нээлттэй нийгэм форум 2015); О.Мөнхсайхан, “Шүүх эрх мэдэл дэх шүүхийн захиргаа,” Монгол Улс дахь ардчиллын хөгжил, бэхжилт, асуудал, сорилт (1990-2019) дотор, (Конрад-Аденауэр Сан, 2019), 71-107; О.Мөнхсайхан, “Монгол Улсын шүүх эрх мэдлийн талаарх хөндлөнгийн судалгаа, дүн шинжилгээ” илтгэл, “Шүүхийн захиргааны хөгжлийн чиг хандлага: чиг үүрэг ба загвар” олон улсын бага хурлын эмтхэтгэл дотор (Шүүхийн ерөнхий зөвлөл, 2018), 41-71; Ж.Алтансүх, Шүүхийн эдийн засгийн баталгаа, харьцуулсан судалгаа (УБ, 2016).

¹¹³ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 11.

¹¹⁴ Мөн тэнд, 11.

¹¹⁵ “[...] [T]he parliamentary budget battles [...] are undoubtedly of a political nature. [...] While wanting to ensure greater independence of judges and courts, and thus to bring about their de-politicization, [by involving the Council of Justice into this battles] it may turn out that they will, quite to the contrary, be engulfed in the political debate. Without deviating from the principle of having a separate budget for the judiciary and, in order to allow for a de facto judicial independence, these of powers and budgetary struggles could rather be left with Minister of Justice or the Cabinet as a whole which will feel politically responsible for the treatment eventually accorded to the judiciary in the matters of proper funding.” CDL-AD(2002)026, Opinion on the Draft Law on Judicial Power and Corresponding Constitutional Amendments of Latvia, §48

Санал: ШТХ-ийн төслийн 76.1.1-өөс "Засгийн газартай зөвшилцөн" гэдгийг хасах.

3.6. ШҮҮХИЙН ТӨСВИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЯВЦАД САНАЛАА ХЭЛЭХ БОЛОМЖИЙГ ШЕЗ-Д ОЛГОХ

ШЕЗ шүүхийн төсвийн төслийг УИХ-д шууд өргөн мэдүүлээд зогсохгүй төсөлтэй холбоотой асуулт гарвал хариулах, саналаа хэлэх боломжоор хангагдаж байж шүүхийн төсөв шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангахад шаардлагатай, үндэслэл бүхий хэмжээтэй батлагдана. "Шүүхэд төсөв хуваарилах шийдвэр шүүхийн хараат бус байдлын зарчимд чанд нийцэх бөгөөд шүүх эрх мэдэл шүүхийн зөвлөлөөр дамжуулан парламентад өргөн мэдүүлсэн төсвийн төсөлтэй холбоотой байр сууриа илэрхийлэх боломжоор хангагдах хэрэгтэй."¹¹⁶ Мөн, шүүхийн төсвийг хэлэлцэх явцад шүүхийн зөвлөл эсхүл түүнтэй адил байгууллагын байр суурийг парламентад сонсох боломжоор хангахыг Киевийн зөвлөмжид тусгасан байдаг.¹¹⁷

Санал: ШТХ-ийн төслийн 47.9.2-т "бөгөөд улсын төсвийг хэлэлцэн батлах явцад шүүхийн төсөвтэй холбоотой саналаа хэлэх боломжийг Шүүхийн ерөнхий зөвлөлд олгоно" гэж нэмэх.

3.7. ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЭЭЛТТЭЙ, ИЛ ТОД БАЙХ

ШТХ-ийн 13.1-т "Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна," 13.2-т "Шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна" гэж шүүхийн үйл ажиллагааны

¹¹⁶ European Commission For Democracy Through Law (Venice Commission) Report On The Independence Of The Judicial System Part I: The Independence Of Judges, CDL-AD(2010)004, 11.

¹¹⁷ OSCE ODHR and Max Planck, Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Kyiv, 23-25 June 2010), 3.

нээлтэй, ил тод байдлын ерөнхий нөхцөлийг заажээ. ШТХ-ийн төслийн 13.4-т "Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа нийтэд тогтмол мэдээлж" байхыг үүрэгжүүлэхийн зэрэгцээ 13.5-т "Шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай төрийн болон албаны, хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлж болно" гэж заажээ.

ШТХ-ийн төслийн 22.7-т "Бүх шатны шүүх шийдвэрээ өөрийн цахим хуудсанд байршуулж, хэвлэн нийтэлнэ" гэж заасан нь шүүхийн шийдвэрийг заавал цахим хуудсанд байршуулах, хэвлэн нийтлэхийг үүрэгжүүлсэн шинжтэй, олон улсын сайн туршлагад нийцсэн сайн зохицуулалт болжээ (гэхдээ байршуулах, хэвлэн нийтлэхийг тогтмол хийх, хугацаажуулах хэрэгтэй). "Мэргэжил нэгтнүүд болон олон нийтийн өмнө шүүгчийн хүлээх хариуцлагыг дээшлүүлэх үүднээс шүүхийн шийдвэр нь үнэ төлбөргүй, хялбархан авч ашиглах боломжтой байдлаар өгөгдлийн санд байршиж, цахим хуудаст хэвлэн нийтлэгддэг байх нь зохимжтой. Шүүхийн шийдвэр нь маргааны төрөл, хууль зүйн асуудал, бичсэн шүүгчийн нэрээр индекслэгддэг байх хэрэгтэй."¹¹⁸

ШТХ-ийн төслийн 22.7-т шүүхийн шийдвэрийг хэзээ цахим хуудаст байршуулах, хэвлэн нийтлэх хугацааг тодорхой болгоогүй байх тул энэхүү заалт хэрэгжихгүй байх эрсдэл байна.

Санал. ШТХ-ийн төслийн 22.7-ийг "Бүх шатны шүүх шийдвэрээ хүчинтэй болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор өөрийн цахим хуудсанд тогтмол байршуулж, хэвлэн нийтэлнэ" гэж өөрчлөх.

ШТХ-ийн төслийн 13.3-т "Шүүх хуралдааны явцын дуу, эсхүл дуу-дүрсний бичлэгийг шүүгч, шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн эсхүл хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэн зохих журмын дагуу баталгаажуулж, архивт хадгална" гэжээ. Энэ нь дуу эсхүл дуу-

¹¹⁸ Мөн тэнд, 7.

дүрсний бичлэгийг заавал хийх бус харин шүүгч, шүүх бүрэлдэхүүний үзэмжээрээ буюу хэргийн оролцогчийн хүсэлтээр шийдвэрлэх агуулгатай болжээ. Өөрөөр хэлбэл, хэргийн оролцогч хүсэлт гаргахгүй бол эсхүл шүүгч, шүүх бүрэлдэхүүн шийдэхгүй бол шүүх хуралдааны явцыг дуу, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бичихгүй байхаар ойлгогдож байна. Ийм агуулгатай бол энэ нь шүүх хуралдааны ил тод байдлыг дордуулсан ухралт болно. Мөн, шүүгч биеэ зөв авч явсан эсэх, шүүх хуралдааны тэмдэглэл үнэн зөв буусан эсэх дээр шүүхийн дуу эсхүл дуу-дүрсний бичлэг гол баримт болдог. Энэхүү бичлэг нь Шүүхийн ёс зүйн хорооны сахилгын хэрэг хянан шийдвэрлэх процессод түгээмэл ашиглагдаж ирсэнтэй адил Шүүхийн сахилгын хороо байгуулагдахаар хэрэглэгдэнэ. Киевийн зөвлөмжөөр "шүүх танхим дахь шүүгчийн зан үйл болон шүүх хуралдааны тэмдэглэлийг үнэн зөв байдлыг нотлох харуулах үүднээс шүүх хуралдааны бүхий л процессыг электрон хэрэгслээр бичих шаардлагатай. Бичгээр үйлдсэн буюу гараар бичсэн протокол хангалтгүй."¹¹⁹ Тиймээс, Шүүхийн тухай 2012 оны хуулийн 8.5-т буй "Шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж архивт хадгална" заалтыг хэвээр үлдээх саналтай байна.

Санал: ШТХ-ийн 13.3-ийг "Хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдааны явцыг дуу болон дүрс бичлэгээр баталгаажуулж архивт хадгална" гэж өөрчлөх саналтай байна.

¹¹⁹ Мөн тэнд, 7.

3.8. ШҮҮГЧИЙН ТУСГАЙ САНАЛЫГ ХЭВЛЭН НИЙТЛЭХ¹²⁰

Олон ардчилсан улсад шүүх, ялангуяа үндсэн хуулийн шүүх болон дээд шүүхийн шүүгчид тусгай санал нийтлүүлэх эрх эдэлдэг. Эдгээр улсад шүүгч нар заримдаа үндсэн хуулийн эсхүл хуулийн заалтыг хэрхэн тайлбарлах вэ гэдэг дээр санал зөрж, олонхоороо шийдвэрээ гаргадаг ч цөөнх болсон шүүгч тусгай саналаа нийтлүүлж болдог.

Үндсэн хууль дахь хууль дээдлэх ёс, түүний нэг хэлбэр болох хуульд захирагдах зарчим нь шүүгчээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хуулийг ягштал баримтлахаас гадна маргаан шийдвэрлэхдээ хуулийг хэрэглэхийг шаарддаг. Тусгай саналыг хэвлэх боломжгүй үед цөөнх болсон Дээд шүүхийн шүүгч хуулийг хэрхэн хэрэглэж байгаагаа тайлбарлах, Үндсэн хууль эсхүл хуульд үнэнч гэдгээ илэрхийлж чаддаггүй. Тусгай санал бичиж буй шүүгч олонхи алдаатай шийдвэр гарсан бол түүнийг энэ удаа биш ч хожим засхад чухал үүрэгтэй. Түүнчлэн, тусгай санал нь хувь шүүгч хуулийг хэрэглэхдээ хэр зарчимч ханддаг вэ гэдгийг олон нийтэд харуулдаг. Дээд шүүхээс заримдаа өөрийн өмнөх шийдвэрийг үгүйсгэсэн шийдвэр гаргах тохиолдол бий. Зарим шүүгчид адил асуудлаар ялгаатай шийдвэр гаргасан бүрэлдхүүнд аль алинд нь орсон байдаг. Тусгай санал хэвлүүлэх эрхгүй тохиолдолд олон нийт эдгээр шүүгч өөрийн өмнөх шийдвэрийн тулгуурласан зарчмаа дэмжсэн үү, эсхүл эсрэг санал өгсөн үү, тийм бол өөрөөр шийдвэрлэх хангалттай үндэслэл гаргасан уу гэдгийг мэдэх ямар ч боломжгүй учраас зарчимгүй шүүгчид далдлагдаад өнгөрдөг.

Ардчилсан ёс шүүх дээр наанадаж дөрвөн утгаар хэрэгждэг. Юуны өмнө, шүүх бүрэлдэхүүн маргааны талаарх шийдвэрээ олонхын саналаар гаргадаг. Хоёрт, шүүгч олонхоос өөр байр суурь, үндэслэлтэй байгаагаа илэрхийлэхийг хориглох нь түүний итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг ноцтой хязгаарладаг. Ардчилсан нийгмийн мөн чанарт олонхын эсрэг

¹²⁰ Энэхүү саналын үндэслэлийг дараах өгүүллээс авсан тул уг өгүүллээс дэлгэрүүлэн уншина уу: О.Мөнхсайхан, "Цэцийн гишүүн болон дээд шүүхийн шүүгчийн тусгай саналыг нийтлэх нь Үндсэн хууль зөрчөөгүй," Эрх зүй 35, Дугаар 3 (2016), 1-30.

шүүгчийн саналаа хэвлүүлэх эрх чөлөө зайлшгүй агуулагдах ёстой. Гуравт, ардчилсан ёс шүүхийн шийдвэрийг хэвлэн нийтэлдэг байх төдийгүй шүүх өөрөө шийдвэрийнхээ үндэслэлийг ил тод бичихийг шаарддаг. Шүүгч хуулийн дагуу хуулийг хэрэглэж маргааныг шийдвэрлэх, ийнхүү хэрэглэж байгаагаа шийдвэртээ бичиж харуулах ёстой. Үндэслэлтэй шийдвэр бичих нь заавал мөрдөх зарчим болсон цагт дур зорго хумигддаг. Дөрөвт, тусгай санал хэвлэгдсэнээр тухайн маргааны ээдрээ төвөгтэй байдлыг ойлгоод зогсохгүй олонх болон цөөнхийн хүлээн зөвшөөрсөн хуулийн тайлбаруудыг харьцуулах, тэдгээрийн үндэслэлийг хэлэлцэх боломжийг хуульчид, судлаачид, олон нийтэд өгдөг. Энэ хэлэлцүүлэг нь хууль тогтоомжийн шинэчлэл эсхүл адил төстэй дараагийн маргааныг шүүх өөрөөр шийдвэрлэхэд хүргэж болно. Түүнчлэн, хуулийн оюутнууд шүүхийн шийдвэр болон тусгай саналыг харьцуулан судалж анализ хийх, хууль тайлбарлах ур чадвараа хөгжүүлдэг, хуулийн мөн чанарыг илүү сайн ойлгож авдаг. Цөөнх болсон шүүгч нь бусад шүүгчдийн үндэслэлийг шүүмжлэхийн хажуугаар өөрийн үндэслэлийг ил хэлдэг учраас шүүхийн шийдвэрийн үндэслэл сайжирдаг, чанарждаг.

Тусгай саналаа нийтлэх нь хуулийг хамгийн үндэслэлтэйгээр ойлгож хэрэглэх, бичиж илэрхийлэх боломжийг шүүгчид өгдөг. Тусгай саналаа нийтлэх эрхгүй бол шүүгч хуулийн тухай энэ ойлголтоо илэрхийлэх боломжгүй болдог. Тиймээс, шүүгч тусгай саналаа хэвлэх эрхтэй байх нь тухайн шүүгч хуулийг хэрэглэх, шийдвэр гаргах тал дээр бүрэлдэхүүний бусад шүүгчээс хараат бус байгааг харуулдаг. Тусгай санал хэвлүүлэх нь шүүгчид бие биенээсээ харилцан хараат бус байгаа, тухайн шүүгч бие даан боддог, ухамсраа сонсдог гэдгийг илтгэдэг.

Нийтлэг эрх зүйн бүл эсхүл Иргэнлэг эрх зүйн бүлтэй эсэхээс үл хамааран улсууд үндсэн хуулийн болон дээд шүүхийн шүүгчид тусгай санал нийтлэх эрхийг өгч байна. АНУ, Канад, Австрали, Шинэ Зеланд, Энэтхэг, Пакистан, Израилийн шүүхэд тусгай санал хэвлүүлж болдог. Түүнчлэн, Японы Дээд шүүх, Өмнөд Солонгосын Үндсэн хуулийн шүүх болон Дээд шүүхийн шүүгчид тусгай санал хэвлүүлдэг. Мөн, Европын холбооны 27 улсаас Португали, Финланд, ХБНГУ, Эстон, зэрэг 20 улсад тусгай саналыг хэвлүүлэхийг бүх маргаан дээр эсхүл

зөвхөн үндсэн хуулийн маргаан дээр зөвшөөрдөг. Монголтой адилхан социализмаас ардчилал руу харьцангуй амжилттай шилжсэн Төв болон Зүүн Европын бараг бүх улс үүнийг зөвшөөрсөн байна.

Монгол Улсад Үндсэн хуулийн цэцийн гишүүн болон ердийн шүүхийн шүүгчид тусгай саналаа бичгээр гаргаж хэрэгт хавсаргах боломжтой байсан ч шүүхийн шийдвэрийн хамт нийтлүүлэх эрхгүй явж ирсэн. Тусгай саналаа нийтлүүлэх эрхийг 2012 онд Улсын дээд шүүхийн шүүгчид өгөхөөр хуульчилсан. 2012 оны Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31.6 дахь хэсэгт "Хяналтын шатны шүүх шийдвэрээ энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт, бусад шүүх шийдвэрээ өөрийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтэлнэ" гэж заасан байсан. Гэвч, уг заалтад "энэ хуулийн 31.5-д заасан тусгай саналын хамт..." хэмээн Улсын дээд шүүхийн шүүгчийн тусгай саналыг заавал хэвлэн нийтлэхээр хуульчилсан нь Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана," 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн "Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ," гэсэн заалтыг тус тус зөрчсөн гэж Үндсэн хуулийн цэцийн 2016 оны 5 дугаар дугаар тогтоолоор дүгнэж, уг заалтыг хүчингүй болгосон. Цэцийн энэхүү шийдвэр нь Улсын дээд шүүхийн шүүгчийн тусгай саналыг заавал хэвлэн нийтлэх нь Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн гэсэн утгатай. Тиймээс, Улсын дээд шүүхийн шүүгч тусгай саналаа хэвлэн нийтлэх эрх эдлэх байдлаар хууль батлах нь Үндсэн хууль зөрчихгүй юм.

ШТХ-ийн төслийн 22.5-т "Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхын саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж, хавтаст хэрэгт хавсаргана" гэж бичжээ. Дээр дурдсан үндэслэлээр Улсын дээд шүүхийн шүүгчид тусгай саналаа хэвлэн нийтлэх эрх олгосон байдлаар хуульчлах саналтай байна.

Санал. ШТХ-ийн төслийн 22.5-т “Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхын саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж, хавтаст хэрэгт хавсаргана.” гэсний дараа “Хяналтын шатны шүүхийн шүүгч нь тусгай саналаа уг шүүхийн цахим хуудсанд байрлуулж, хэвлэн нийтлэх эрхтэй” гэж нэмэх.

3.9. ШҮҮГЧДИЙН ЗӨВЛӨЛ

Шат шатны шүүхийн шүүгчээс бүрдсэн шүүгчдийн зөвлөл ажиллах нь шүүгчийн өөрийн удирдлагыг хангахад чухал ач холбогдолтой. Шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий Шүүгчдийн зөвлөл ажиллахаар төсөлд тусгасан байна. Шүүгчдийн зөвлөл нь үйл ажиллагааны журмыг батлах; Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, эгүүлэн татах; Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах; шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах; Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох; шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заажээ (ШТХ-ийн төсөл, 20.3).

Шүүгчдийн зөвлөл үйл ажиллагааныхаа журмыг өөрөө батлах боловч үүний үндсэн зарчмыг хуульчлахаар төсөлд заажээ. Уг зөвлөл хоёр жил тутам хуралдах бөгөөд дараагийн хурлын товоо өөрөө тогтооно (ШТХ-ийн төсөл, 20.1). ШТХ-ийн төсөлд Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд сонгогдсон нийт шүүгчдийн талаас илүү нь оролцвол хүчинтэйд тооцох бөгөөд шүүгч биеэр оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана (ШТХ-ийн төсөл, 20.4), хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана (ШТХ-ийн төсөл, 20.7), хуралдааны зохион байгуулалтын асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцна (ШТХ-ийн төсөл, 20.8) гэж заажээ. Мөн, Шүүхийн

ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно (ШТХ-ийн төсөл, 20.5, 20.6) гэжээ. Нууц санал хураалтын зарчмыг хуульчлах нь шүүгч бүр саналаа чөлөөтэй гаргах баталгаа болно. Венецийн комисс мөн Шүүхийн сахилгын хороо, Шүүхийн зөвлөлийн гишүүнийг шүүгчид дотроосоо нууц санал хураалтаар сонгох талаар тодорхой хуульчлахыг зөвлөжээ.¹²¹

Шүүгчдийн зөвлөлтэй холбоотой хоёр асуудлыг эргэн харах хэрэгтэй байж магадгүй. Эхнийх нь Шүүгчдийн зөвлөлийг бүрдүүлэхтэй холбоотой, удаах нь Шүүгчдийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулахтай холбоотой.

ШТХ-ийн төслийн 20.1-т "Шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонх, Улсын дээд шүүхийн шүүгчдээс бүрдсэн шүүгчдийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана" гэж заажээ. ШТХ-ийн төсөл, 20.1-т "Зөвлөлийн хуралдаанд сонгогдсон нийт шүүгчдийн талаас илүү нь оролцвол хүчинтэйд тооцох..." гэж зааснаас үзвэл Зөвлөлийн хуралдаан хуралдах тутам төлөөлөгчдийг сонгож бүрдүүлэхээр ойлгогдож байна. Гэвч, ШТХ-ийн төсөлд "анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонх"-ыг яаж бүрдүүлэн Шүүгчдийн зөвлөлд оруулах талаар төдийлөн тодорхой тусгаагүй байна. Хэдийгээр Шүүгчдийн зөвлөлийн "үйл ажиллагааны журмыг батлах" чиг үүргийн хүрээнд "анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонх"-ыг хэрхэн бүрдүүлэхээ шийдвэрлэнэ гэж ойлгож болох боловч шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх чухал институтийн хувьд эдгээр шүүхийн шүүгчдийн төлөөллийг бүрдүүлэх тодорхой журмыг хуульчлах нь зүйтэй. Энэ тал дээр хоёр хувилбар байж болохоор байна.

Хувилбар 1. Анхан болон давж заалдах шатны шүүх тус бүр нийт шүүгчийнхээ тавин хувьтай тэнцүү тооны төлөөлөгчийг дотроосоо

¹²¹ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §52.

нууц санал хураалтаар сонгон Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд илгээж болох юм. Шүүх бүрийн хувь тэнцүүлсэн, шударга төлөөллийг Шүүгчдийн зөвлөлд оруулах нь энэ хувилбарын давуу тал юм. Ийм зохицуулалт хийхгүй орхивол зарим шүүхээс шүүгчдийнх нь тоотой дүйцэхгүй тооны хэт цөөн төлөөлөл Шүүгчдийн зөвлөлд орох байдал үүсэх эрсдэлтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 20.1-т “Анхан болон давж заалдах шатны шүүх тус бүр нийт шүүгчийнхээ тавин хувьтай тэнцүү тооны төлөөлөгчийг дотроосоо нууц санал хураалтаар сонгон Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд илгээнэ.” гэсэн өгүүлбэр нэмэх.

Хувилбар 2. Анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн бүх шүүгчид Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд оролцох боломжтой байдлаар зохицуулах боломжтой. Ингэснээр Дээд шүүхийн бүх шүүгчийг оролцуулчхаад бусад шүүхийн шүүгчдийн талаас доошгүй оролцуулах мэтээр ялгавартай байдал үүсгэхгүй. Монгол Улсын шүүхийн бүх шүүгчид Шүүгчдийн зөвлөлийн хуралдаанд оролцох нь нээлттэй байх учраас шүүгчдийн тэгш эрхийг хангасан, илүү ардчилсан байж, өөрөө удирдах ёсыг илүү сайн хэрэгжүүлнэ. Монгол Улсад өнөөдөр 550 орчим шүүгчид байна. Улаанбаатар хотод 1000 хүртэл хүн хуралдах боломжтой танхим олноор бий болсон нь шүүгчдийн шууд ардчиллыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

Санал: ШТХ-ийн төслийн 20.1-ыг “Шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий анхан, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчдийн зөвлөл /цаашид “Зөвлөл” гэх/ ажиллана” гэж өөрчлөх.

Энд авч үзсэн хоёр хувилбарын аль боломжтойг нь, эсхүл анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонхыг зохистойгоор, шударга, тэнцвэртэй бүрдүүлэх өөр илүү дээр хувилбар байвал түүнийг ШТХ-ийн төсөлд тусгавал зохилтой.

ШТХ-ийн төслийн 20.3-т "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонхын саналд үндэслэн Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болно" гэж заажээ. Шүүгч бүр тэгш эрхтэй учраас Шүүгчдийн зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхий шүүгч нарын олонхын саналаар хуралдуулахыг хасах эсхүл үүний зэрэгцээ нийт шүүгчдийн 10 хувиас доошгүйн саналд үндэслэн зохион байгуулж болохоор хуульчлах нь зүйтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 20.3-т "Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонх эсхүл нийт шүүгчийн 10 хувиас доошгүй тооны шүүгчид гаргасан санал гаргасан бол Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулна." гэж өөрчлөх.

4. ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ЗӨРЧИЛ БА ШИЙТГЭЛ

Энэ бүлэг нь (4.1) Шүүгчийн ёс зүйн дүрмийг иргэний нийгмийн оролцоотой, нээлттэйгээр боловсруулах; (4.2) Шүүгчийн ёс зүйн зөрчил ба сахилгын зөрчил; (4.3) Шүүгчийн ёс зүйн тайлбар ба зөвлөгөө; (4.4) Сахилгын тодорхой зөрчлийн жагсаалтыг хуульчлах; (4.5) Сахилгын шийтгэлийн төрлийг олшруулах; (4.6) Шүүгчийг огцруулах үндэслэлийг тодруулах; (4.7) Тохирсон байх зарчмыг хуульчлах; (4.8) Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгчийг түр түдгэлзүүлэх гэсэн найман хэсгээс бүрдэнэ.

4.1. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ДҮРМИЙГ ИРГЭНИЙ НИЙГМИЙН ОРОЛЦООТОЙ, НЭЭЛТТЭЙГЭЭР БОЛОВСРУУЛАХ¹²²

Шүүгч албан үүргээ хэрэгжүүлэхдээ болон хувийн амьдралдаа баримтлах хэм хэмжээг урьдчилан, ойлгомжтой, зөрчилдөөнгүй тодорхойлсон байх нь сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны урьдач нөхцөл. Монгол Улс 1997 онд анх удаа Шүүгчийн ёс зүйн дүрэмтэй болсноос хойш энэ дүрэм хэд хэдэн удаа шинэчлэн найруулагдаад байна. 2010 онд шүүгчийн ёс зүйн дүрмийн хэт ерөнхийлсөн зохицуулалт, ёс зүйн алдаа ба ашиг сонирхлын зөрчлийг зохицуулаагүй, ганцаарчилсан уулзалт, сахилгын шийтгэлийн зохицуулалт учир дутагдалтай байгаа талаар дурдаж байв.¹²³

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (ШЭЗБТХ)-ийн 32 дугаар зүйлийн 32.1-т "Шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана," 32.2-д "Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн шүүгчид сахилгын хариуцлага хүлээлгэнэ"

¹²² Энэ хэсэгт дэвшүүлсэн саналын үндэслэлийг доорх судалгаанаас авч баяжуулан бичив: О.Мөнхсайхан, Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага (АНУ-ын Азийн сан 2019); О.Мөнхсайхан, "Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процедур: амжилт ба сорилт," "Шүүгчийн ёс зүй ба сахилга" Олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор, (УБ 2017) 41-87.

¹²³ Н.Лүндэндорж нар, Монгол Улсад шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх нь, 60-77.

гэж заасан. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.2-д “Хуульчдын холбооны шүүгчдийн хороо шүүгчийн ёс зүйн дүрмийг” батлахаар заасан. Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооноос Шүүгчийн ёс зүйн дүрэм (ШЁЗД)-ийг 2014 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн 1/08 дугаар тогтоолоор баталсан. Энэ ёс зүйн дүрмээр шүүгчийн нийгмийн харилцаанд баримтлах зарчим, шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, нийтийн алба ба хувийн амьдралд шүүгчийн баримтлах ёс зүйг тодорхойлж, ерөнхий зохицуулалтыг нарийвчлахын зэрэгцээ нийгмийн хөгжилтэй уялдуулан шинэлэг зохицуулалтыг тусгасан. Тухайлбал, шүүгч олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим сүлжээ ашиглах, хэргийн оролцогчтой харилцах, зохисгүй байдал гаргахгүй байх гэх мэт.

2014 оны ШЁЗД-ын агуулгатай холбоотой хоёр асуудал үүссэнийг авч үзье. Юуны өмнө, 2014 оны ШЁЗД-д олон чухал зарчим, зохицуулалт орхигдсон. Жишээлбэл, шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах, татгалзлыг шийдвэрлэх, хичээл зүтгэл гаргах, мэргэжлийн үүргээ чухалчлах, мэргэжлийн шаардлага хангасан байх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалах, хэлэлцүүлэх эрхийг хангах, хэрэг, маргааныг заавал шийдвэрлэх, биеэ зөв авч явах үүргүүд зэрэг маш олон чухал асуудлыг ШЁЗД-д огт тусгаагүй. ШЁЗД-д орхигдсон эдгээр асуудал нь Шүүгчийн ёс зүйн талаарх Банглорын зарчмууд,¹²⁴ Америк,¹²⁵ Канад¹²⁶ зэрэг улсын шүүгчийн ёс зүйн дүрэм, үндсэн зарчмуудад тусгалаа олсон байдаг. Жишээлбэл, НҮБ-ын Гэмт хэрэг, хар тамхитай тэмцэх байгууллага (UNODC)-ын хүрээнд 75 улсын шүүгч нар оролцож баталсан Шүүгчийн зан үйлийн Банглорын зарчмууд Шүүгчийн ёс зүйн дүрмийг улс орнууд батлах, хэрэгжүүлэхэд тулгуур болж ирсэн. Уг зарчмууд нь хараат бус байдал, төвийг сахисан байдал, зарчимч байдал (integrity), зохистой байдал, тэгш байдал, мэргэжлийн шаардлага хангасан байдал ба хичээл

¹²⁴ The Judicial Integrity Group, “The Bangalore Principles of Judicial Conduct,” 2007, <http://www.coe.int/t/dghl/cooperation/cje/textes/BangalorePrinciplesComment.PDF>.

¹²⁵ ABA, “Model Code of Judicial Conduct,” 1990, <http://www.americanbar.org/groups/professionalresponsibility/publications/modelcodeofjudicialconduct.html>.

¹²⁶ Candian Judicial Council, “Ethical Principles for Judges,” 2004, <http://www.cjc-ccm.gc.ca/cmslib/general/newspubjudicialconductPrinciplesen.pdf>.

зүтгэл гэсэн үнэт зүйлүүд, тэдгээрийн тодорхойлолт, тус бүрийг нь хэрэгжүүлэхэд баримтлах зан үйлийн жагсаалтыг багтаадаг байна. Эдгээр нийтлэг зарчим, үүргийг ШЁЗД боловсруулахад харгалзах нь чухал.

ШЁЗД-д шүүгчийн ёс зүйн олон улсын стандартад төдийлөн нийцэхгүй заалтууд оржээ. Жишээлбэл, шүүгчийн ёс зүйн материаллаг харилцааг зохицуулсан дүрэмд шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх хөөн хэлэлцэх хугацааг тусгадаггүй. Гэтэл, хуульд байхгүй хөөн хэлэлцэх хугацааг ШЁЗД-ээр тогтоосон бөгөөд ингэхдээ 6 сар гэсэн хэт богино хугацаа тавьсан нь маргаантай. Ийм заалт ШЁЗД-д орсон нь хууль зүйн техник талаасаа мэргэжлийн бус төдийгүй шүүгчийн ёс зүйн олон улсын сайн туршлагад нийцэхгүй, олон нийтийн шүүхэд итгэх итгэлд халтай гэдгийг энэ саналын "Шүүгчийн сахилгын хэргийн хөөн хэлэлцэх хугацаа" гэсэн гарчигтай 6.3 дахь хэсэгт дэлгэрэнгүй өгүүлнэ. 2002 оны Шүүхийн тухай хуульд байсан хөөн хэлэлцэх хугацааны заалтыг 2012 оны Шүүхийн тухай багц хуулиас хасчихаад байхад буцаан ШЁЗД-ээр сэргээсэн нь хууль тогтоогчийн санаа зоригт үл нийцсэн.

ШЁЗД-д хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийг зөрчсөн шинжтэй заалтууд мөн туссан. Жишээлбэл, шүүгч маргааны нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулзахыг хатуу хориглодог нь хууль дээдлэх ёс төлөвшсөн олон улсад тогтсон зарчим.¹²⁷ 2008 онд Шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг сэргээхийн тулд авах арга хэмжээ дотор Шүүгчийн ёс зүйн дүрмийг шинэчлэх, ингэхдээ "маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай шүүгч уулзахыг хориглох"-ыг судлаачид зөвлөж байсан юм.¹²⁸ Тиймээс, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль (ШЭЗБТХ)-ийн 27.1.17-д "хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах"-ыг шууд хориглосон. Гэтэл, 2014 оны ШЁЗД-ийн 3.2-р зүйлийн 4-т "Шүүгч хэргийн оролцогчтой ганцаарчлан уулзаж хэргийн нөхцөл байдал, гэм буруугийн талаар

¹²⁷ ABA, "Model Code of Judicial Conduct," Rule 2.9; The Judicial Integrity Group, Commentary on the Bangalore Principles of Judicial Conduct, 2007, 62, <https://www.unodc.org/documents/congress//background-information/Corruption/BangaloreprinciplesEN.pdf>.

¹²⁸ White, Report on the Status of the Court Reform in Mongolia, 30.

ярилцаж болохгүй бөгөөд хэрэв албан ажлын зайлшгүй шаардлагын улмаас хэргийн нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах бол шүүхийн туслах ажилтан байлцуулах бөгөөд уулзалтын агуулгын талаар тэмдэглэл хөтлөн хэрэгт хавсаргана" гэж зааж хуучин зохицуулалтаа сэргээсэн нь хуулийн дээрх заалттай зөрчилддөг. Шүүхийн ёс зүйн хороонд ирж буй гомдлоос харахад шүүгч нар маргааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай уулзах тохиолдолд гарсаар байгаа бөгөөд үүнийг ШЕЗД-ийн 3.2-р зүйлийн 4-өөр зөвтгөх нь элбэг.¹²⁹ Шүүгчийн туслах байсаар байхад шүүгчийг маргааны нэг талтай уулзахыг зөвшөөрч байгааг зөвтгөхөд хэцүү. Учир нь, шүүгч хэргийн нэг талтай нөгөө талыг байлцуулалгүйгээр харилцсанаар зөвхөн нэг талын үндэслэлийг сонсох бөгөөд уг үндэслэлийг няцаах боломжийг нөгөө талд олгодоггүй. Зөвхөн нэг талын үндэслэлийг сонссоноор шүүгч хууль зүйн болон фактын асуудал дээр алдаатай шийдвэр гаргах эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн, шүүгч нь авлига эсхүл бусад зүй бус нөлөөнд автах, эсхүл тийнхүү ойлгогдох үүд хаалгыг нээдэг. Шүүгчид заримдаа маргааны аль нэг талтай нөгөө талыг байлцуулахгүйгээр уулздаг байсан хуучин практикийг¹³⁰ үргэлжлүүлэх боломжийг ШЕЗД-ээр олгож байгаа нь шүүгчид итгэх олон нийтийн итгэлийг унагах нэг хүчин зүйл болж байна.

Хуульч, эрдэмтэн, холбогдох иргэний нийгмийн байгууллага зэрэг шүүхийн биш төлөөллийг Шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулахад оролцуулах нь эдгээр ёс зүйн заримд шүүхийн "үйлчлүүлэгчийн өнцөг"-ийг тусгахад тустай.¹³¹ Эсвэл зарим улсын жишгээр шүүгчдийн

¹²⁹ Жишээлбэл, эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч нь прокурорыг байлцуулахгүйгээр яллагдагч нартай уулзаж хэргийн агуулгын талаар ярьсан гэдгийг тогтоосон Шүүхийн ёс зүйн хороо (ШЕЗХ)-ны 2014.07.22-ны өдрийн тогтоол, Захиргааны хэргийн шүүхийн шүүгч шүүх хуралдаан болохоос өмнө хэргийн нэг тал болох төрийн захиргааны байгууллагын дарга уу утсаар ярьсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн шүүгчийн тайлбар бүхий ШЕЗХ-ны 2016.08.30-ны өдрийн 107-р тогтоолыг тус тус үзнэ үү. Мөн, Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч аймгийнхаа орлогч прокурортой олон нийтийн газар шөнө дунд хүртэл хамт байж согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн болон бусад зөрчил гаргасан шүүгчид цалин бууруулах сахилгын шийтгэлийг оногдуулж байсан (ШЕЗХ-ны 2017.06.09-ний өдрийн магадлал).

¹³⁰ Уайт, Монгол Улсын шүүхийн шинэтгэлийн өнөөгийн байдалд хийсэн судалгааны тайлан, 20.

¹³¹ UNODC, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, 134.

жинтэй төлөөлөл болон хуульчид, эрдэмтэд, иргэний нийгмийн төлөөлөөс тэнцвэртэй бүрдсэн Шүүхийн ерөнхий зөвлөл олон талын оролцоотой боловсруулж, нээлтэй хэлэлцэж Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах боломжтой.

Санал: ШТХ-ийн төслийн 20.9-д "Шүүгчдийн зөвлөл нь Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийг боловсруулахдаа олон улсын сайн туршлага, шүүгчийн хараат бус болон хариуцлагатай байдлын зарчимд тулгуурлаж, хуульчид, эрдэмтэд, хууль зүйн чиглэлийн төрийн бус байгууллагуудын төлөөллийг оролцуулна. Шүүгчийн ёс зүйн дүрмийн болон түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст байрлуулснаас хойш 21 хоногийн дараа олон нийтэд нээлтэй хэлэлцүүлж, саналаа илэрхийлэх боломж олгосны үндсэн дээр Шүүгчдийн зөвлөл батална. Шүүгчийн ёс зүйн дүрэм нь Үндсэн хууль болон бусад хуульд нийцсэн байна." гэж заах.

4.2. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ БА САХИЛГЫН ЗӨРЧИЛ

Шүүгчийн сахилгын тогтолцоо болон шүүгчийн ёс зүйн дүрмийн аль нь хувь шүүгчийн үйл ажиллагааг мэргэжлийн, зарчимч байлгах замаар шүүх эрх мэдлийн хараат бус, шударга, төвийг сахисан байдалд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалах зорилготой. Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчийн баримтлах ёстой зарчим, үзэл санааг багтааж хараат бус, төвийг сахисан байх этгээдийн хувьд биеэ яаж авч явах хамгийн өндөр стандартыг тогтоодог учраас уг дүрмийн зөрчил бүр сахилгын зөрчил биш тул түүнд заавал сахилгын шийтгэл хүлээлгэх нь тохиромжгүй.

Шүүгчийн ёс зүйн дүрмийг сахилгын шийтгэл хүлээлгэх хэрэгсэл болгон ашиглавал шүүгчийн хараат бус байдал эрсдэлд орох хэдий ч ёс зүйн хэм хэмжээний ноцтой зөрчил нь хуулийн дагуу сахилгын

шийтгэл хүлээх үндэслэл болно.¹³² Шүүгчийн ёс зүйн дүрмийн зөрчил нь гагцхүү шүүхийн хараат бус, шударга, төвийг сахисан байдалд итгэх итгэлийг эвдэж шүүхийн нэр хүндийг унагасан бол сахилгын зөрчил болдог. "Шүүх эрх мэдлийг үл хүндэтгэхэд хүргэх буруутай үйл ажиллагааны ноцтой, уучилж үл болох хэргүүдийг сахилгын журмаар шийдвэрлэх хэрэгтэй."¹³³

Шүүгчийн ёс зүйн дүрэм болон сахилгын журам нь зорилгоороо ялгаатай гэж үзэх хандлага бий. Шүүгчийн ёс зүйн дүрэм нь шүүгчийн үйл ажиллагааг чиглүүлж, буруутай үйл ажиллагаа гаргахаас сэргийлэхийг зорьдог бол сахилгын хэм хэмжээ нь аль хэдийнэ болоод өнгөрсөн буруутай үйл ажиллагаанд шийтгэл хүлээлгэх зорилготой.¹³⁴ Шүүгчийн ёс зүйн дүрэмд шүүгч өдөр тутмын ажлаа эрхлэх явцад гарч ирж болох тодорхой асуудлыг хэрхэн авч үзэх вэ гэдгийг үнэлж шийдвэрлэхэд туслах зарчмуудыг багтаадаг бол сахилгын журам нь сахилгын шийтгэл зайлшгүй хүлээхүйц буруу эсхүл зохисгүй үйл ажиллагааг журамлахад зориулан бүтээгдсэн.¹³⁵ Гэвч, шүүгчийн ёс зүйн дүрэм нь сахилгын шийтгэл хүлээхүйц ёс зүйгүй, мэргэжлийн биш үйл ажиллагааг тодорхойлоход хэрэглэх албан ёсны эх сурвалжийн үүрэг гүйцэтгэж болно.¹³⁶

Шүүгчийн ёс зүйн дүрмийг сахилгын шийтгэл шууд хүлээлгэх үндэслэл шууд болохоор хэрэглэхэд тохиромжгүй. Учир нь, уг дүрмийн зарим заалт тодорхой, нарийвчилсан байж болох ч ихэнх заалт нь ерөнхий, бүрхэг хэллэгээр бичигддэг тул юуг зөвшөөрч, юуг хориглож буйг урьдчилан таамаглаж болохуйц байх гэсэн шаардлагыг бүрэн

¹³² CDL-AD(2013)035, Opinion on the draft Code on Judicial Ethics of the Republic of Tajikistan, §§8, 12-13, 15 and 16, 30-31.

¹³³ CDL-AD(2014)018, Joint opinion of the Venice Commission and OSCE/ODIHR on the draft amendments to the legal framework on the disciplinary responsibility of judges in the Kyrgyz Republic, §32

¹³⁴ OSCE, ODIHR, "Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges" (Warsaw, 27 December 2018), 9.

¹³⁵ CDL-AD(2013)035, Opinion on the draft Code on Judicial Ethics of the Republic of Tajikistan, §§8, 12-13, 15 and 16, 30-31.

¹³⁶ Acquaviva Nans, Castagnet Florence and Evanghelou Morgane: A Comparative Analysis of Disciplinary Systems for European Judges and Prosecutors, prepared for the 7th edition of the European Judicial Training Network's THEMIS Competition, 2012, pp. 2-3.

хангадаггүй гэх шүүмж байдаг. Шүүгчийн ёс дүрэм дэх ерөнхий, бүрхэг заалтуудад үндэслэн тодорхой шүүгчийн хараат бус байдалд халдахаас сэргийлэхийн тулд сахилгын шийтгэл нь аль болох хуулийн тодорхой заалтад үндэслэсэн, зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон байх бөгөөд удаа дараа гарсан эсхүл ноцтой ёс зүйгүй практикт хариу үзүүлэх эцсийн найдвар болж байх хэрэгтэй.¹³⁷

2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр байгуулсан хороо нь "Шүүхийн ёс зүйн хороо," биш харин "Шүүхийн сахилгын хороо" гэж нэрлэгдсэн нь тохиолдлын зүйл биш бөгөөд агуулгын шинжтэй чухал өөрчлөлт. Шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх чиг үүрэгтэй хороог Монгол Улсад эхлээд Шүүгчийн сахилгын хороо, дараа нь Шүүхийн сахилгын хороо гэж зөв нэрлэж байсан ч 2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын хуулиар Шүүхийн ёс зүйн хороо болгон өөрчилсөн нь агуулгаасаа зөрсөн шинжтэй болсон. Бусад дийлэнх улсад Шүүхийн сахилгын хороо хэсэн нэр хэрэглэдэг.

Шүүгчийн ёс зүйн зөрчил нь шүүгчийн сахилгын зөрчлөөс өргөн хүрээтэй. Өөрөөр хэлбэл, шүүгчийн ёс зүйн зөрчил бүхэн сахилгын зөрчил биш харин сахилгын зөрчил бүхэн шүүгчийн ёс зүйн зөрчил болдог. Иймд, ШТХ-ийн төсөл дэх "ёс зүйн зөрчил" гэдэг нэр томъёог "сахилгын зөрчил" гэж өөрчлөх нь зүйтэй юм.

Санал: ШТХ-ийн төсөл дэх "шүүгчийн ёс зүйн зөрчил" гэсэн нэр томъёог "шүүгчийн сахилгын зөрчил" гэж өөрчлөх.

¹³⁷ CDL-AD(2013)035, Opinion on the draft Code on Judicial Ethics of the Republic of Tajikistan, §§8, 12-13, 15 and 16, 30-31.

4.3. ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙН ТАЙЛБАР БА ЗӨВЛӨГӨӨ¹³⁸

Хэдий хуульд зөрчлийн тодорхой жагсаалтыг зааж болох ч урьдчилан харах боломжгүй ёс зүйн болон сахилгын олон асуудал гарч ирэх учраас хууль болон шүүгчийн ёс зүйн дүрэмд ерөнхий зарчим, үнэт зүйлийн шинжтэй заалт орохоос аргагүй юм. Эдгээр ерөнхий, бүрхэг заалтыг урвуулан ашиглах, дур зоргоор тайлбарлах эрсдэлийг бууруулахын тулд шүүгчийн ёс зүйн стандартын болон сахилгын хэм хэмжээний тайлбар гаргах, шүүгчийн ёс зүйн асуудлаар зөвлөгөө авах механизмыг бий болгохыг олон улсад зөвлөдөг¹³⁹ (эдгээр заалтыг урвуулан ашиглаж шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлийг бууруулах өөр нэг арга зам бол сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг гомдлоор Дээд шүүхээр хянуулах явдал. Үүний талаар энэ саналын “Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг Улсын дээд шүүхэд давж заалдах” гэсэн гарчигтай 6.6 дахь хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ).

Шүүхийн ёс зүйн хорооны захиалгаар Шүүхийн судалгаа, мэдээлэл сургалтын хүрээлэн, Азийн сан хамтран шүүгчийн ёс зүйн сургагч багш нарыг сургалтаар бэлтгэж, тэдний тусламжтайгаар сургалтын гарын авлагыг Шүүгчийн ёс зүйн олон улсын зарчим, бодит кейсэд тулгуурлан боловсруулсан юм. 2018 оны 11 дүгээр сарын 01-ээс 07-ны өдрүүдэд орон нутгийн 9 бүс, нийслэл дэх нийт 484 шүүгчийг 5 ээлжээр хамруулан ёс зүйн сургалтыг амжилттай зохион байгуулаад байна. Уг сургалтын үеэр сургагч багш нарын шинээр боловсруулсан Шүүгчийн ёс зүйн сургалтын гарын авлага, мөн Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчим, түүний тайлбар-ыг шинээр орчуулан хэвлүүлж, нийт шүүгчдэд гарын авлага болгон хүргэсэн. Шүүхийн ёс зүйн хороо өөрийн шийдвэрүүдээс цахим хуудаст байршуулж, хоёр удаа эмхэтгэн хэвлүүлээд байгаа нь ШЁЗД-ийн утгыг тайлбарлан

¹³⁸ Энэ хэсэгт холбогдох саналын үндэслэлийг доорх судалгаанаас авч баяжуулан бичив: О.Мөнхсайхан, Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага (АНУ-ын Азийн сан 2019); О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процедур: амжилт ба сорилт,” “Шүүгчийн ёс зүй ба сахилга” Олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор, (УБ 2017) 41-87.

¹³⁹ OSCE, ODHR, “Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges” (Warsaw, 27 December 2018), 16.

хөгжүүлэхэд чухал үүрэгтэй. Гэвч, Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн цогц тайлбар гараагүй байна.

Шүүгчийн ёс зүйг төлөвшүүлэхэд нэг талаар Монгол Улсын Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалт бүрийн дэлгэрэнгүй тайлбарыг онолын үндэслэл, бодит болон хийсвэр жишээгээр баяжуулан боловсруулах, хэвлэх шаардлагатай байна. Шүүгчийн ёс зүйн дүрэмтэй улсуудад уг дүрмийг зөрчсөн эсэх талаарх маргааныг шийдвэрлэсэн шүүхийн сахилгын хорооны болон шүүхийн шийдвэрүүд, онолын бүтээлүүдэд үндэслэсэн тайлбарыг боловсруулж хэвлэдэг. Жишээлбэл, Америкийн Хуульчдын холбоо нь Шүүгчийн ёс зүйн загвар дүрмийн тайлбарыг 640 хуудастайгаар 2011 онд хоёр дахь удаагаа хэвлэжээ.¹⁴⁰ Мөн, Канад улсад шүүгчийн ёс зүйн дүрэм байхгүй боловч шүүгчийн ёс зүйн зарчмууд байдаг бөгөөд эдгээр зарчмуудын тайлбарыг хэвлэж өргөнөөр ашигладаг.¹⁴¹

Олон улсын сайн туршлагын дагуу шүүгч өөрт тулгарсан ёс зүйн тодорхой асуудлаар хандаж зөвлөгөө авдаг тогтолцоо (шүүгчийн ёс зүйн зөвлөгөө өгөх хороо)-г бий болгох нь зүйтэй. 2017 оны 10-р сарын 09-ний өдөр Шүүхийн ёс зүйн хорооноос зохион байгуулсан "Шүүгчийн ёс зүй ба сахилга" олон улсын бага хурлын илтгэлдээ Канадын Нова Скота мужийн Дээд шүүхийн шүүгч Роберт Врайт Канадад Шүүхийн зөвлөх хороо хэрхэн ажилладаг талаар танилцуулсныг энд товчлон хүргэе. Анх 1998 онд байгуулагдсан Ёс зүйн зөвлөх хороо нь ёс зүйн зарчмуудыг боловсруулан нийтэлж, шүүгчдээс ирэх ёс зүйн шинжтэй төрөл бүрийн асуултад хариу, тодруулгч өгч ажилладаг. Тус хорооны бүрэлдэхүүн чиг үүргийг дараах байдлаар тайлбарлажээ:

Тус хороо нь Канадын мужууд, түвшин түвшний шүүхийн төлөөлөл буюу анхан болон давж заалдах шатны нийт 12 шүүгчээс бүрддэг. Хорооны үндсэн үүрэг нь Холбооны засгийн газраас томилогдсон шүүгчдэд аливаа ёс зүйн холбогдолтой асуудал тулгарсан тохиолдолд тэдэнд албан бус зөвлөгөөг нууцыг чандлах байдлаар

¹⁴⁰ Arthur Garwin, Eileen Libby, Kathleen Maher, Dennis Rendleman, Annotated Model Code of Judicial Conduct, Second Edition (ABA 2011).

¹⁴¹ Ethical Principles For Judges (Canadian Judicial Council 2004).

өгөх явдал юм. Холбогдох хүсэлтийг ихэвчлэн бичгээр гарган ирүүлдэг ба Хороо тухайн асуудлыг хэлэлцэн зөвшилцөж санал дүгнэлтээ нууцлалыг хадгалах замаар хариу болгон хүргүүлдэг. Хорооны ирүүлсэн санал нь зөвхөн зөвлөх шинжтэй. Хороо нь ямар нэгэн шийдвэр, тогтоол гаргадаггүй. Харин тухайн хүсэлт гаргасан шүүгч нь Ёс зүйн зөвлөх хорооны өгсөн зөвлөгөө дээр үндэслэн өөрийн шийдвэрийг гаргадаг. Хороо нь Канадын шүүхийн зөвлөлийн авч хэрэгжүүлдэг сахилгын арга хэмжээтэй ямар нэгэн байдлаар холбоогүй байдгаараа Монгол дахь Шүүхийн ёс зүйн хорооноос ялгаатай юм. Өөрийн эрхэлсэн ажил болон хувийн амьдрал дээрээ ёс зүйн асуудлуудтай нүүр тулсан шүүгч нарын хувьд Ёс зүйн зөвлөх хороо нь маш чухал эх сурвалж байдгийг дурдах ёстой. Уг хороо нь ёс зүйн ээдрээтэй асуудлууд үүсэн гарах тохиолдол бүрд хариулт өгөх боломжгүйн зэрэгцээ хуулийн талаарх асуулт дээр ямар нэгэн байдлаар санал бодол илэрхийлдэггүй. Гэхдээ хороо нь хүсэлт гаргасан шүүгчдэд Канад улсын хэмжээнд цуглуулсан, үр дүнтэй нь батлагдсан туршлагаууд дээр үндэслэн нууцыг чандлан зөвлөгөө, чиглэл өгөх боломж/чадамжтай байдаг. Хорооны гаргасан нэр дурдагдаагүй санал дүгнэлтийг зөвхөн шүүгч нарт зориулсан хаалттай цахим хуудас дээрээс бусад шүүгчид үзэж, судалж болдог.¹⁴²

Шүүгчийн ёс зүйн дүрмийн заалтууд ерөнхий, бүрхэг байдаг тул төлөвлөж буй үйл ажиллагаа нь уг дүрэмд нийцсэн эсэх дээр эргэлзэж буй шүүгчид зөвлөгөө өгөх чиг үүрэгтэй хороог АНУ-д холбооны болон мужийн төвшин байгуулж ажиллуулдаг. АНУ-ын 50 муж улсын дийлэнхэд нь шүүгчид ёс зүйн зөвлөгөө өгөх хороо (комисс) ажилладаг байна.¹⁴³ Уг хороо нь шүүгч, хуульч болон хуульч биш гишүүдийн тэнцвэртэй төлөөллөөс бүрдэх (өөр нэгэн эх сурвалжид уг хороонд

¹⁴² Роберт Врайт, “Шүүгчийн ёс зүй, сахилга: Канадын туршлага,” Шүүгчийн ёс зүй ба сахилга: олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор (Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо, 2017), 25.

¹⁴³ Judicial Ethics Advisory Committees by State, www.ajs.org/ethics/ethadviscommlinks.asp

ихэнхдээ шүүгч биш хүмүүсийг оруулдаг гэжээ¹⁴⁴) бөгөөд шүүгчид тулгамдсан ёс зүйн асуудлаар үндэслэл бүхий зөвлөгөө өгч туслах чиг үүрэгтэй. Шүүгчид ёс зүйн зөвлөгөө өгөх хорооноос өгсөн зөвлөгөө нь ихэнхдээ зөвлөх шинжтэй ч зарим тохиолдолд зөвлөмжийг дагаж хэрэгжүүлэх нь шүүгчийн сахилгын зөрчлийг үгүйсгэх үндэслэл болох боломжтой. АНУ-аас гадна Словен зэрэг Европын улсуудад ийм зөвлөмжийн чиг үүрэгтэй бүтцийг бий болгох болсон.¹⁴⁵

Санал: ШТХ-ийн төсийн 20.10-д “Шүүгчдийн зөвлөл шүүгчид тулгарч буй ёс зүйн асуудлаар зөвлөгөөг өгөх чиг үүрэгтэй хороог байгуулах бөгөөд тус хорооны бүрэлдэхүүн, журмыг батална. Шүүгчид зөвлөгөө өгөх хорооны зөвлөгөө нь нууцлалтай байж, зөвхөн тухайн шүүгчид очих бөгөөд тухайн зөвлөгөөг шүүгчийн нэр, хувийн мэдээлэлгүйгээр нийтэлж болно.” мөн төслийн 20.11-т “Шүүгчид ёс зүйн зөвлөгөө өгөх хороо нь энэ хуулийн 20.10-д зааснаас гадна Шүүгчийн ёс зүйн дүрмийн тайлбарыг боловсруулж хэвлэн нийтлэх ажлыг хариуцна.” гэж заах

4.4. САХИЛГЫН ТОДОРХОЙ ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТЫГ ХУУЛЬЧЛАХ

Хэтэрхий бүрхэг агуулгатай ерөнхий тодорхойлолт өгөхөөс илүү сахилгын тодорхой зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах нь олон улсын стандартад нийцсэн сайн туршлага юм.¹⁴⁶ “Сахилгын зөрчил болохуйц үйл ажиллагаа аль болох хангалттай тодорхой болговол

¹⁴⁴ Russel Wheeler, “Judicial Independence in the United States of America,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 563.

¹⁴⁵ Goda Ambrasaite – Balyniene, *Comparative analysis on the High Councils for Judiciary in the EU member states and judicial immunity*, (European Commission, 2015), 19.

¹⁴⁶ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §15

шүүгч өөрийнхөө үйл ажиллагааны үр дагаврыг урьдчилан таамаглаж зохицуулна. Мөн, сахилгын шийтгэл хүлээлгэх үндэслэлийг илүү тодорхой, нарийвчлан тодорхойлох нь тэдгээрийг хэрэглэхтэй холбоотой үзэмж, субъектив байдлыг хязгаарлахад тусалдаг.¹⁴⁷

Нөгөө талаар, шүүгчийн сахилгын зөрчлийг бүгдийг нь зөвхөн хуульд нарийвчлан, тодорхой заах гэж оролдох нь бодитой биш төдийгүй зарим сөрөг үр дагавартай. Жишээлбэл, Италид нарийвчлан тодорхой хуульчилснаас бусад шүүгчийн үйлдэл, эс үйлдэхүйд сахилгын шийтгэл ногдуулж болохгүй байх хуулийг 2006 онд баталсан бөгөөд уг хуульд нийт 37 зөрчлийг тодорхойлжээ.¹⁴⁸ Италид шүүгчийн сахилгын зөрчлийн “бүрэн” жагсаалтыг хуульчилсан нь уг зөрчлийг хянан шийдвэрлэхэд үзэмжээр хандах явдлыг бууруулах, шүүгчид урьдчилан таамаглах боломж олгож буй ч хэд хэдэн асуудал үүсгэж байна. Юуны өмнө, сахилгын шийтгэл хүлээлгэх бүх үндэслэлийг нарийвчлан тодорхойлж жагсаах гэж оролдох нь сахилгын зөрчлийн хүрээг хэт явцууруулж, урьдчилан харж чадаагүй ч сахилгын шийтгэл заавал хүлээлгэх нөхцөлийг хамруулах боломжгүй болгоно.¹⁴⁹ Өөрөөр хэлбэл, Италид нийгмийн болон шүүх эрх мэдлийн хүрээнд төлөвшсөн ёс зүйн мэдрэмжтэй илт зөрчилдсөн ч тухайн зөрчил нь хуульд тодорхой, илэрхий тусгагдаагүй төдийгөөр ямар ч шийтгэл хүлээхгүй өнгөрөх “хийдэл” үүсгэжээ.¹⁵⁰ Шүүгчийн ёс зүйг ноцтой зөрчсөн сахилгын зөрчилд хариуцлага хүлээлгэхгүй байх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд ноцтой хохирол учруулдаг. Мөн, Италид сахилгын зөрчлийг бүгдийг нь жагсааж буй нь шүүгчийн үйл ажиллагаанд

¹⁴⁷ CDL-AD(2014)018, Joint opinion of the Venice Commission and OSCE/ODIHR on the draft amendments to the legal framework on the disciplinary responsibility of judges in the Kyrgyz Republic, § 24; CDL-AD(2014)008, Opinion on the draft Law on the High Judicial and Prosecutorial Council of Bosnia and Herzegovina, §90.

¹⁴⁸ Giuseppe Di Federico, “Judicial Independence in Italy,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 380.

¹⁴⁹ OSCE ODIHR and Max Planck, *Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability*, (Expert Meeting in Kyiv, 23-25 June 2010), 13.

¹⁵⁰ Luigi D’Alessandro, Matteo Marini, Roberta Mariscotti, “The Transition From Case Law To The Codification Of Disciplinary Violations In The Italian Reform Of The Judicial System: Effects On Freedom Of Expression And Association,” THEMIS 2011 (BORDEAUX 25TH – 27TH MAY 2011), 4.

тавигдах стандартыг өсгөх биш харин ч хэт доош буулгасан гэж шүүмжлэгддэг.¹⁵¹

Шүүхийн тухай хуульд шүүгчийн сахилгын зөрчлийн тодорхой жагсаалтыг дэлгэрэнгүй заахын зэрэгцээ уг жагсаалтад багтахгүй зөрчлийг шийдвэрлэх боломжийг олгох хоёр янзын туршлага байна. Нэг дэх арга нь шүүхийн тухай хуульд тодорхой зөрчлийг жагсаахын зэрэгцээ түүнд дурдагдаагүй зөрчлийг багтаахуйц ерөнхий хэллэгтэй зөрчлийг заах зохицуулалт. Жишээлбэл, Нидерландын Шүүхийн албан хаагчийн тухай хуулийн аль нэг заалтыг зөрчсөн эсхүл сайн шүүгчид зохихгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргасан бол сахилгын шийтгэл ногдуулахаар хуульчилсан.¹⁵² Хоёр дахь арга нь хуульд сахилгын тодорхой зөрчлийг боломжит хэмжээнд жагсаахын зэрэгцээ шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөнийг сахилгын зөрчилд тооцож шийтгэхээр хуульчлах зохицуулалт. Жишээлбэл, Гүрж, Хорват, Болгар, Латви, Литви, Монгол.¹⁵³ Эдгээр хоёр аргын аль нэгийг эсхүл аль алийг нь зэрэг хэрэглэсэн улсууд бий.

ШТХ-ийн төслийн 52 дугаар зүйлд шүүгчид хориглох зүйлийг жагсаагаад эдгээрээс зөрчвөл сахилгын шийтгэл хүлээлгэхээр заах аргыг хэрэглэсэн нь сайн туршлагад нийцэж байна. Сахилгын зөрчлийг ийнхүү тодорхой жагсаах нь Сахилгын хорооны бүрэлдэхүүн болон түүний шийдвэрийг гомдлоор хянах Улсын дээд шүүхийн шүүгчдийн үзэмжээрээ хандах байдлыг хязгаарлах, юу хориглогдож, ямар үүрэг хүлээж буйг шүүгч урьдчилан мэдэж биелүүлэх, сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой юм. Монгол Улсад гарч байсан шүүгчийн сахилгын зөрчил болон олон улсын харьцуулалтад үндэслэн ШТХ-ийн төслийн 52-р зүйлээр шүүгчид хориглох зүйлийг илүү олон тооны тодорхой, нарийвчилсан хориглолтоор баяжуулан хуульчилбал маргаантай гэсэн шалтгаанаар хариуцлагаас зайлсхийхээс

¹⁵¹ Мөн тэнд.

¹⁵² Нидерландын Шүүгчийн албан хаагчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1.

¹⁵³ Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.i; Хорват Улсын Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн (2)1; Болгарын Шүүхийн тогтолцооны тухай хуулийн 307(4)3.

Латвийн Шүүгчийн сахилгын хариуцлагын хуулийн 1(1)3; Литвийн шүүхийн тухай хуулийн 83.1.1).

сэргийлэхийн зэрэгцээ шүүгчид урьдчилан харж үйл ажиллагаа зохицуулах боломж олгож шүүгчийн хараат бус байдлыг хамгаалах, улмаар шүүхэд итгэх итгэлийг хамгаалах ач холбогдолтой юм.

Санал: ШТХ-ийн төслийн 52 дугаар зүйлд жагсаасан хориглох зүйл дээр дараахыг нэмж хуульчлах саналтай байна:

1. шүүгч, прокурор, хуульч, өмгөөлөгч, цагдаагийн албан хаагчтай эсхүл шүүн таслах ажлын явцад хуулийн этгээд, иргэнтэй доромжилсон эсхүл үл хүндэтгэсэн байдлаар харьцах;¹⁵⁴
2. хэрэг хуваарилах журмыг зөрчих;¹⁵⁵

¹⁵⁴ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 419.2; Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)к, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)к; "The Italian Judicial system," 42. Мөн, ХБНГУ-д шүүгчийн чиг үүргээ гүйцэтгэж буй арга хэлбэр, жишээлбэл хэргийн талуудтай харьцаж буй байдал, хянан шийдвэрлэх ажиллагааны дэгтэй байдал сахилгын процедураар хянаж болдог байна. Seibert-Fohr, "Judicial Independence in Germany," 487.

¹⁵⁵ Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)н;

3. шүүгчийн албан үүргээ хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй буюу зохисгүйгээр биелүүлэх;¹⁵⁶
4. хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр албан ажлаа удаа дараа эсхүл олон хоногоор таслах;¹⁵⁷
5. шүүн таслах үүргийнхээ дагуу шийдвэр гаргах эсхүл бусад ажиллагаатай холбоотой хуулиар тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа эсхүл ноцтой зөрчих;¹⁵⁸
6. харьяаллын дагуу явуулах үүрэгтэй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах;¹⁵⁹

¹⁵⁶ Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.f, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)g, Болгарын Шүүхийн тогтолцооны тухай хуулийн 307(4)5, Латвийн Шүүгчийн сахилгын хариуцлагын хуулийн 1(1)2; Литвийн шүүхийн тухай хуулийн 83.3); Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)j, Zoltan Fleck, "Judicial Independence in Hungary," in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 814.

¹⁵⁷ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 419.4, 418.9, 417.19, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)j;

¹⁵⁸ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 419.3; Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)e; Мөн, Бельгид шүүхийн шийдвэрээ гаргахгүй бол сахилгын шийтгэл хүлээлгэдэг байна; Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)g, Benoit Allemeersch, Andre Alen and Benjamin Dalle, "Judicial Independence in Belgium," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 332; Мөн, ХБНГУ-д шүүгчийн чиг үүргээ гүйцэтгэж буй арга хэлбэр, жишээлбэл шүүх хуралдааны товыг цагтаа эхлүүлж буй байдал, цаг барьж буй байдал сахилгын процедураар хянаж болдог байна. Seibert-Fohr, "Judicial Independence in Germany," 487.

¹⁵⁹ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 418.11, 417.9, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)i; Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.e, Болгарын Шүүхийн тогтолцооны тухай хуулийн 307(4)2.

7. шүүх хуралдаан, урьдчилсан хэлэлцүүлэг зэрэг нийтэд зарласан ажиллагааны товыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа зөрчих, эсхүл товлосон цагтаа ирэхгүй байх;¹⁶⁰
8. хэрэг хянан шийдвэрлэх тухай эсхүл бусад хуулийн заавал биелүүлэх шинжтэй, илэрхий, тодорхой заалтыг шууд санаатай эсхүл хэт болгоомжгүйгээр зөрчих,¹⁶¹
9. хүндэтгэн үзэх шалтгаангүй байхад шүүхийн шийдвэрт шаардагдах үндэслэлийг огт бичээгүй нь шүүхийн эцсийн шийдвэрээр тогтоогдсон;¹⁶²

¹⁶⁰ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 418.10, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)h;

¹⁶¹ Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)i. Ийм үйлдэл, эс үйлдэхгүйг АНУ-д мөн шүүгчийн сахилгын зөрчилд тооцон шийтгэдэг байна. Cynthia Gray, "The Line Between Legal Error and Judicial Misconduct: Balancing Judicial Independence and Accountability," *Hofstra Law Review* 32, no. 4 (2004). ХБНГУ-д мөн хуулийг илэрхий зөрчсөн шүүгчийн алдаатай шийдвэрийг шүүх хянаж байсан бөгөөд энэ нь хууль дээдлэх ёсыг сахиулахад зайлшгүй гэж үздэг байна. Жишээлбэл, Шүүхийн тухай хуулийг зөрчиж шүүхийн танхимаас өмгөөлөгчийг албадан гаргахыг тушаасан шүүгч дээр ийм хяналт хэрэгжүүлсэн гэж бичжээ. Seibert-Fohr, "Judicial Independence in Germany," 487-488.

¹⁶² Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.15; Benoit Allemeersch, Andre Alen and Benjamin Dalle, "Judicial Independence in Begium," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 354;

10. шүүгчийн үүргээ гүйцэтгэх явцад мэргэжлийн наад захын мэдлэг, ур чадваргүйг нотолсон үйлдэл, эс үйлдэхүй гаргасан;¹⁶³
11. Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалсан хүний үндсэн эрх, эрх чөлөөний маргаангүй, тодорхой утгыг шууд санаатай эсхүл хэт болгоомжгүйгээр зөрчсөн,¹⁶⁴
12. Ерөнхий зөвлөл эсхүл шүүхээс хууль ёсны чиг үүргээ хэрэгжүүлэх явцад хүргүүлсэн мэдэгдлийг зөрчих, үл тоох,¹⁶⁵
13. сахилгын зөрчлийн талаарх гомдол шалгах, хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах,¹⁶⁶
14. шүүгчийн албан тушаал хашдаг гэж дурдагдсан арга хэмжээ дээр төрийн болон орон нутгийн байгууллага, алба тушаалтныг сайшаах, эсхүл зэмлэх,¹⁶⁷
15. өөрийн гаргасан шүүхийн шийдвэрт зохисгүй, үл хүндэтгэсэн, доромжилсон хэллэг хэрэглэх (энэ тохиолдолд тухайн шийдвэрийг хуульд заасны дагуу хянасан шүүхийн шийдвэрт үндэслэн шийдвэрлэнэ),¹⁶⁸

¹⁶³ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.14, Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)с; "The Italian Judicial system," 42.

¹⁶⁴ Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)b. Түүнчлэн, АНУ-д мужийн шүүхийн сахилгын хороо үндсэн эрхийг зөрчсөн бол тухайн шүүгчид сахилгын хэрэг үүсгэн хянаж шийдвэрлэж болдог. Cynthia Gray, "The Line Between Legal Error and Judicial Misconduct: Balancing Judicial Independence and Accountability," Hofstra Law Review 32, no. 4 (2004).

¹⁶⁵ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 419.5, 418.12,

¹⁶⁶ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 419.5, 418.17; Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)n, Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.g,

¹⁶⁷ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 418.3

¹⁶⁸ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 418.6

16. шүүн таслах үүргээ гүйцэтгэх явцад шууд санаатай эсхүл хэт болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүй гаргасны улмаар иргэн, хуулийн этгээдэд гэм хор учруулсан;¹⁶⁹
17. хууль заасны дагуу татгалзан гарах үүрэгтэйгээ мэдсээр байж татгалзан гараагүй;¹⁷⁰
18. өөрийн, гэр бүлийн гишүүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх, хууль зүйн зөвлөгөө өгөх;¹⁷¹
19. хуульд заасны дагуу зөвшөөрөл авах, татгалзан гарах, нэмэгдэл, урамшуулал, тэтгэлэг авах зорилгоор худал мэдээлэх эсхүл төөрөгдүүлэх;¹⁷²
20. өөрийн эсхүл бусдын хувийн ашиг сонирхлыг хангах, давуу байдал олж авахын тулд шүүгчийн албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, бусад этгээдэд тийнхүү ашиглахыг зөвшөөрөх;¹⁷³

¹⁶⁹ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.5. Мөн, тус хуулийн 296 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт шүүгчийн хэт болгоомжгүй эсхүл санаатайгаар гаргасан алдаа, зөрчлийн улмаас хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг төр хариуцан арилгах боловч буруутай шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэсэн эсэхээс үл хамааран төрд учирсан төрд үүссэн хохирлыг буруутай шүүгчээр нөхөн төлүүлэхээр заажээ. Монгол Улсын Иргэний хуульд “шууд санаатай буюу хэт болгоомжгүй” гэх нэр томъёог хэрэглэсэн байдаг: Иргэний хуулийн 384.4-т “Тээвэрлэгчийн шууд санаатай буюу хэт болгоомжгүй үйл ажиллагаанаас шалтгаалаагүй болон гэрээнд өөрөөр заагаагүй бол тээвэрлэгч нь хугацаа хожимдсоноос учирсан хохирлыг хариуцахгүй” гэж заажээ. Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(7)-д заасны дагуу шүүгчийн шууд санаатай эсхүл хэт болгоомжгүйгээр учруулсан хохирлыг төр тухайн шүүгчээр нөхөн төлүүлэх боломжтой ажээ.

¹⁷⁰ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.8, Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)а; “The Italian Judicial system,” 42.

¹⁷¹ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.6.

¹⁷² Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.11.

¹⁷³ “The Italian Judicial system,” 42; Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417.13; Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)е.

21. шүүн таслах үүргээ гүйцэтгэх явцад эсхүл бусад үед шүүхийн нэр хүнд болон шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг унагасан үйлдэл, эс үйлдэхүй гаргасан.¹⁷⁴

2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх" гэж илэрхийлсэн нь дээрх шиг байдлаар шүүгчийн сахилгын тодорхой зөрчлийг жагсаан хуульчилж, хүлээх хариуцлагыг зайлшгүй болгохыг дэмжинэ. Шүүгчийн сахилгын тодорхой зөрчлийн дэлгэрэнгүй жагсаалтыг ШТХ-ийн төслийн 52 дугаар зүйлд тусгасан тохиолдолд Мэргэшлийн хороо нь давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшинг тогтоож дүгнэлт гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлэх шаардлагагүй. Мэргэшлийн хороонд ийм дүгнэлт гаргах бүрэн эрх өгөхийг дэмжихгүй байгаа үндэслэлийг энэ саналын "Шүүхийн мэргэшлийн хороо, түүний бүрэн эрх" гэсэн гарчигтай 2.4 дэх хэсэгт тайлбарласан.

Мөн түүнчлэн, ШТХ-ийн төслийн 53-55 дугаар зүйлд буй хориглолт, үүргийг зөрчвөл сахилгын шийтгэл хүлээхээр заах нь чухал. Жишээлбэл, хуульд заасны дагуу хөрөнгө, орлого болон ашиг

¹⁷⁴ Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.d; Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 4(1)р, Болгарын Шүүхийн тогтолцооны тухай хуулийн 307(4)4; Литвийн шүүхийн тухай хуулийн 83.1.1); Antoine Garapon, "Judicial Independence in France," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 290; Benoit Allemeersch, Andre Alen and Benjamin Dalle, "Judicial Independence in Belgium," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 332; Adam Bodnar and Lukasz Bojarski, "Judicial Independence in Poland," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 714; Zoltan Fleck, "Judicial Independence in Hungary," in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 814.

сонирхлын зөрчлийн мэдүүлэг мэдүүлээгүй эсхүл худал мэдээлэх¹⁷⁵ үүргээ биелүүлээгүй бол олон улсад сахилгын зөрчилд тооцдог төдийгүй Монгол Улсын хууль тогтоомжоор¹⁷⁶ төрийн албан хаагч сахилгын шийтгэл хүлээхээр заасан байдаг. Мөн, Испани, Итали, Румын зэрэг улсад улс төрийн намд харьяалагдах зэрэгтэй холбоотой хориглолтыг зөрчвөл сахилгын шийтгэл хүлээлгэдэг.

Санал: ШТХ-ийн төслийн 57.1.1-ийг “энэ хуулийн 52-55 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг зөрчсөн,” гэж өөрчлөх.

ШТХ-ийн 52.1.15-т “оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр хууль зүйн чиглэлээр багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах” гэж заажээ. Энэ заалтын дагуу шүүгч багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх бараг боломжгүй болох нь. Учир нь, Монгол Улсын хууль зүйн их, дээд сургуулиудад “үнэлгээ тавих эрхгүйгээр” багшлах боломж тун хязгаарлагдмал бөгөөд ийм практик ховор. Хууль зүйн сургуульд хууль зүйн магистрын зэргээ дөнгөж хамгаалсан шинэ залуу багш “үнэлгээ тавих эрхгүйгээр” багшлах тохиолдол гарч болох ч энэ түвшинд хичээл заах нь шүүгч шиг өндөр мэдлэг, чадвар, туршлагатай мэргэжилтэнд үл тохирно. Нөгөө талаар, хууль зүйн их, дээд сургуульд хичээл заах цагийн үнэлэмж маш бага байдгаас шүүгч цагаар хичээл зааж тийм их орлого олоод байх боломжгүй. Эцэст нь, шүүн таслах албан үүргээ цалгардуулахгүйгээр багшлах, эрдэм шинжилгээний ажил хийх нь олон улсад шүүгчид зөвшөөрдөг цөөн ажлын нэг билээ.

¹⁷⁵ Нидерландын Шүүгчийн албан хаагчийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 1, Румын Улсын Шүүгч болон прокурорын эрх зүйн байдлын тухай хуулийн 99(1)а; Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 2.2.b, Хорват Улсын Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн (2)8; Латвийн Шүүгчийн сахилгын хариуцлагын хуулийн 1(1)б.

¹⁷⁶ Авилгын эсрэг Монгол Улсын хуулийн 1.8.

Санал: ШТХ-ийн 52.1.15-т "оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр хууль зүйн чиглэлээр багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах" гэсний "оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр хууль зүйн чиглэлээр" гэдгийг хасах.

4.5. САХИЛГЫН ШИЙТГЭЛИЙН ТӨРЛИЙГ ОЛШРУУЛАХ

Олон төрлийн сахилгын шийтгэлээс онгох боломжтой байх нь тухайн зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон шийтгэл ногдуулахад тусалдаг. Ийм үндэслэлээр Венецийн комисс дараах сахилгын шийтгэлүүдийг хуульчлахыг зөвлөжээ: хаалттай сануулах, нээлттэй сануулах, цалин бууруулах, түдгэлзүүлэх, огцруулах.¹⁷⁷ Тодруулбал, зарим улсын хуулиудыг уншиж үзэхэд шүүгчийн сахилгын зөрчилд дараах төрлийн сахилгын шийтгэл ногдуулж байна:

1. Хаалттай сануулах: Итали, Гүрж, Молдав, Болгар;
2. Нээлттэй сануулах: Итали, Гүрж, Румын, Нидерланд, Хорват, Болгар;
3. Зэрэг дэвийг бууруулах: Итали (2 сараас 2 жилийн хугацаанд);
4. Торгох: Нидерланд, Хорват;
5. Цалин бууруулах: Румын, Молдав, Болгар;
6. Түдгэлзүүлэх: Нидерланд (1 жил хүртэл хугацаагаар), Итали;
7. Өөр шүүх рүү шилжүүлэн томилох: Румын (1-3 сарын хугацаагаар);
8. Огцруулах: Нидерланд, Итали, Гүрж, Румын, Молдав, Хорват, Болгар.

¹⁷⁷ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §§37-38; CDL-AD(2011)004, Opinion on the Draft Law on Judges and Prosecutors of Turkey, §63

ШТХ-ийн төслийн 59.1-д “Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан бол Сахилгын хороо доор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг оногдуулна” гэж заажээ: сануулах /хаалттай, нээлттэй/; тодорхой хугацаагаар шүүгчийн ёс зүйн сургалтад суухыг даалгах; зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах; огцруулах. Сануулах, сургалтад суухыг даалгах, зэрэг дэвийг бууруулах шийтгэл бол харьцангуй хөнгөн шийтгэлд тооцогдох бол огцруулах нь хамгийн хүнд шийтгэл юм. Хөнгөн болон хамгийн хүнд шийтгэлүүдийн дундын хувилбар буюу хүнд шийтгэлийг хуульчлахгүй бол хүнд зөрчилд нэг бол хэт хөнгөн эсхүл хэт хүнд шийтгэл ногдуулж тохирсон, шударга байх зарчим зөрчигдөхөд хүрнэ.

Тодорхой хугацаагаар цалин бууруулах шийтгэл нь Монголын хуулиудад тусаж олон жил хэрэглэгдэж ирсэн. Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012 оны хуулийн 37.1.2-т “зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах” шийтгэлийг шүүгчид ногдуулж болохоор заасан бол “албан тушаалын цалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах” шийтгэлийг төрийн жинхэнэ албан хаагчид ногдуулж болохоор Төрийн албаны тухай 2017 оны хуулийн 48.1.2-т заажээ. Торгох эсхүл цалин бууруулах шийтгэл нь олон улсад хамгийн түгээмэл (Нидерланд, Хорват зэрэгт торгох, Румын, Молдав, Болгар зэрэгт цалин бууруулах шийтгэл хэрэглэдэг), үр нөлөөтэй шийтгэлүүдийн нэгд тооцогддог. Уг шийтгэлийг ШТХ-ийн төслөөс хасах үндэслэл харагдахгүй байна. Зэрэг дэвийг бууруулах шийтгэл байж болох ч энэ нь цалин бууруулах шийтгэлээс хөнгөн учраас үр нөлөө муутай. Учир нь, зэрэг дэвийг бууруулах шийтгэл хүлээсэн шүүгч нь тухайн зэрэг дэвийн нэмэгдлээ л авахгүй байх бөгөөд албан тушаалын цалингаа бүхэлд нь авна.

2019 онд Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр “түдгэлзүүлэх”-ийг сахилгын шийтгэлийн төрөл байхаар заасан бөгөөд энэ нь мөн л олон улсад хэрэглэгддэг шийтгэл (жишээлбэл, Итали, Нидерланд, АНУ-ийн зарим муж). Гийм ч учраас, 2019.11.14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, түүнийг товч илэрхийлэл болсон УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т шүүгчийн хариуцлагын талаарх Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан хуулийн төсөл

боловсруулахдаа "шүүгчийг сахилгын шийтгэлийн журмаар албан тушаалаас нь түдгэлзүүлэх" чиглэл баримтлахыг тодорхой заасан байна.

Цалин бууруулах болон түдгэлзүүлэх гэсэн хоёр төрлийн шийтгэлийг нэмж хуульчлахаар хэт олон төрлийн шийтгэл болчихно гэж үзвэл харьцангуй ховор хэрэглэгддэг "ёс зүйн сургалтад суухыг даалгах" шийтгэлийг ШТХ-ийн төслөөс хасах боломжтой юм.

Санал: ШТХ-ийн төслийн 59.1-ийг дараах байдлаар өөрчлөх:
"59.1.Шүүгч сахилгын зөрчил гаргасан бол Сахилгын хороо доор дурдсан сахилгын шийтгэлийн аль нэгийг оногдуулна:

59.1.1.хаалттай сануулах;

59.1.2.нээлттэй сануулах;

59.1.3.зэрэг дэвийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар бууруулах;

59.1.4.зургаан сар хүртэл хугацаагаар 30 хүртэл хувиар цалинг бууруулах;

59.1.5.нэг жил хүртэл хугацаагаар шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх;

59.1.6.огцруулах."

4.6. ШҮҮГЧИЙГ ОГЦРУУЛАХ ҮНДЭСЛЭЛИЙГ ТОДРУУЛАХ

ШТХ-ийн төслийн 114.1-д Сахилгын хороо дараах дөрвөн үндэслэлээр шүүгчийг огцруулахаар заажээ:

1. Шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн;
2. огцруулахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн;

3. Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн;
4. гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

“Шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн,” “огцруулахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн” зэрэг сахилгын зөрчил гаргасан бол ШЕЗ огцруулдаг байсныг халж, эдгээрийг Сахилгын хороонд харьяалуулсан нь 2019 онд Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтөд бүрнээ нийцэж байна. Гэвч, ШТХ-ийн төслийн 52-55 дугаар зүйлд заасан хориглолт, үүргийг ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн бол шүүгчийг огцруулах үндэслэл болохоор ШТХ-ийн төслийн 114.1-д заах саналтай байна. Учир нь, ШТХ-ийн төслийн 52-55-д заасан хориглолт, үүргийг удаа дараа эсхүл ноцтой зөрчих нь шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн зөрчлөөс дутахгүй ноцтой бөгөөд шүүхэд итгэлийг унагах боломжтой юм.

Шүүгчийн ёс зүйн дүрэм эсхүл ШТХ-ийн 52-55 дугаар зүйлд заасныг удаа дараа эсхүл ноцтой зөрчсөн бол огцруулна гэж заахдаа илүү тодруулах боломжийг эрэлхийлэх нь зүйтэй. Шүүгчийг огцруулах заалтын томъёолол бусад улсад ямар байдаг талаар авч үзье. Шведэд шүүгчийн үүргээ ноцтой буюу удаа дараа зөрчсөн нь шүүгчийн албан тушаалыг эрхлэхэд тохирохгүйг харуулсан бол огцруулахаар зохицуулсан байдаг.¹⁷⁸ Нидерландад “хүнд гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон,” “дампуурах буюу зээлээ төлж чадахгүй болох зэргээр санхүүгийн чадамжгүй болсон”, “шүүн таслах ажлын зохистой хэрэгжилт эсхүл түүнд итгэх итгэлд ноцтой хохирол учруулсан үйлдэл, үйлдэхүй” гаргасан эсхүл “хуульд заасан тодорхой үүргийг удаа дараа биелүүлээгүй” бол шүүгчийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд тохирохгүй гэж үзэн огцруулдаг.¹⁷⁹ ХБНГУ-д шүүгч санаатай гэмт хэрэг үйлдэж

¹⁷⁸ Chapter 11 Article 5, Sweden -- Instrument of Government (1957)

¹⁷⁹ Roel de Lange, “Judicial Independence in Netherlands,” in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 258; “Securing Justice: The Disiplinary System For Judges in the Russian Federation” (ICJ, December 2012), 28.

нэгээс доошгүй жилийн хорих ялаар шийтгүүлсэн, эх орноосоо урвах гэмт хэрэг үйлдсэн, Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг урвуулан ашигласныг Үндсэн хуулийн шүүх тогтоосон эсхүл нийтийн албыг хаших мэргэжлийн чадваргүйг харуулсан шийдвэр гаргасан бол шүүгчийг огцруулах үндэслэл болдог байна.¹⁸⁰

Санал: ШТХ-ийн төслийн 114.1.3-ыг “энэ хуулийн 52-55 дугаар эсхүл Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой буюу удаа дараа зөрчиж шүүгчийн албан тушаал эрхлэхэд тохирохгүй нь илэрхий болсон” гэж заах.

4.7. ТОХИРСОН БАЙХ ЗАРЧМЫГ ХУУЛЬЧЛАХ

Шүүхийн сахилгын процессод хууль ёсны байх, шүүгчийн хараат бус байдлыг хүндэтгэх, шударгаар хянан шийдвэрлэх, үйлдсэн зөрчилд тохирсон шийтгэл ногдуулах зарчмуудыг баримтлах нь түгээмэл.¹⁸¹ Шүүгчийн гаргасан зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон шийтгэлээр шийтгэх нь шударга ёсны наад захын шаардлага. Тийм ч учраас, 2019.11.14-ний өдөр Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, түүнийг товч илэрхийлэл болсон УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т шүүгчид ногдуулах сахилгын шийтгэл “зөрчлийн шинж байдалдаа тохирсон байх” зарчмыг үндэслэн тодорхойлох чиглэлийг барьж хууль боловсруулахыг заасан. Энэхүү зарчим нь Монгол Улсын үе үеийн Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай 2017 оны хууль (1.3 дугаар зүйл)-д туссан байдаг бөгөөд шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад ч баримтлах зарчим болгон хуульчлах

¹⁸⁰ Anja Seibert-Fohr, “Judicial Independence in Germany,” in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 490.

¹⁸¹ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §12

нь олон улсын сайн туршлагад тооцогддог. Жишээлбэл, Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 7(2)-т "Шүүгчийн хувийн байдал болон түүний үйлдсэн сахилгын зөрчлийн хүнд, хөнгөн байдалд тохирсон сахилгын шийтгэлийг хэрэглэнэ" гэж заажээ.

Сахилгын зөрчилд тохирсон шийтгэл ногдуулах тухай зарчмыг дурдаад зогсохгүй түүнийг хэрэгжүүлэх илүү нарийвчилсан зохицуулалтыг хуульчлах болжээ. Үүнд хоёр янзын туршлага байна. Нэгд, зарим улсын хувьд сахилгын зөрчлийг ангилахгүйгээр тодорхой зөрчлүүдийг ерөнхийд нь жагсаан, тухайн зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон шийтгэлийг ямар хүчин зүйлд үндэслэн сонгож ногдуулахыг заах байдлаар хуульчилдаг. Жишээлбэл, Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 7(2)-т "Шүүгчийн хувийн байдал болон түүний үйлдсэн сахилгын зөрчлийн хүнд, хөнгөн байдалд тохирсон сахилгын шийтгэлийг хэрэглэнэ. Сахилгын зөрчлийн хүнд, хөнгөн байдал нь тухайн үйлдэл, эс үйлдэхүй болон түүнээс гарсан үр дагавраар тодорхойлогдоно. Зөрчил үйлдэгдэх үед шүүхийн процессод оролцож байсан хүмүүст болон шударга ёсны нэр хүндэд үзүүлсэн нөлөөгөөр үр дагаврыг үнэлнэ" гэж заажээ. Мөн, Эстонийн Шүүхийн тухай хуулийн 88(4)-т "Сахилгын шийтгэл ногдуулахад сахилгын зөрчлийн шинж чанар, хүнд хөнгөн байдал, үр дагавар, шүүгчийн хувийн зан байдал зэрэг зөрчилд холбогдох нөхцөл байдлыг анхаарч үзнэ" гэж заасан бол Хорват Улсын Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн 63(б)-д сахилгын шийтгэл ногдуулахад зөрчлийн хүнд хөнгөн, үүсгэсэн үр дагавар, хариуцлагын төвшин, зөрчил гарсан нөхцөл байдал, шүүгчийн зан байдал, шийтгэлийг сонгох нөлөөлөх бусад нөхцөл байдлыг харгалзан үзнэ гэжээ.

Хоёрт, бусад улсад зөрчлийг хүнд болон хөнгөн¹⁸² (Испанид хөнгөн, хүнд, онц хүнд¹⁸³) гэж ангилан ногдуулж болох шийтгэлийн

¹⁸² Хорват Улсын Шүүхийн зөвлөлийн тухай хуулийн 20 дугаар зүйл. Үндсэн хуульд үнэнч байх үүргээ зөрчих, ашиг сонирхлын зөрчилтэй хэргээс татгалзах гараагүй, хөрөнгө, орлогоо мэдүүлээгүй, албан үүрэгт нь харшилсан албан тушаал, ажил эрхлэх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр урт хугацаагаар ажилдаа ирэхгүй байх, хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг уртаар хэтрүүлэх, эрх мэдлийг урвуулан ашиглах, мэргэжлийн үйл ажиллагааны нууц эсхүл итгэмжлэн мэдсэн мэдээллийг задруулах нь илүү ноцтой зөрчилд тооцогдож шийтгэл хүлээдэг.

¹⁸³ Испани Улсын Шүүхийн тухай органик хуулийн 417, 418, 419 дүгээр зүйл.

сонголтыг нь заадаг. Тухайн зөрчил хүнд эсхүл хөнгөн байна уу гэдгээс хамаараад хүнд эсхүл хөнгөн шийтгэлээс ногдуулах эрх бүхий этгээдийн сонголтын хүрээг хумьсан байдаг. Сахилгын зөрчлийг хүнд болон хөнгөн хэмээн ангилж ногдуулж болох шийтгэлийг ялгаатай хуульчлах нь урьдчилан таамаглахуйц байдлыг бий болгоход илүү тустай бол тулгуурлах хүчин зүйлийг жагсаах нь илүү уян хатан байж тухайн зөрчилд хамгийн тохирсныг нь сонгох илүү боломж олгоно.

Санал: ШТХ-ийн төслийн 59.5-д "Сахилгын зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохирсон сахилгын шийтгэл ногдуулна. Зөрчлийн шинж чанар, хэр хэмжээг тодорхойлоход зөрчлийн хүнд хөнгөн байдал, үр дагавар, зөрчил гарсан нөхцөл байдал, шүүгчийн хувийн зан байдал болон зөрчилд холбогдох бусад нөхцөл байдалд тулгуурлана." гэж заах.

4.8. САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ЯВЦАД ШҮҮГЧИЙГ ТҮР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх нь сахилгын шийтгэлийн хэлбэрээр хэрэглэгдэхээс (энэ саналын "Сахилгын шийтгэлийн төрлийг олшруулах" гэсэн гарчигтай 4.5 дахь хэсгээс үүний үндэслэлтэй танилцана уу) гадна гэмт хэрэгт ялагдсан эсхүл хангалтай үндэслэлээр сахилгын зөрчилд буруутгагдаж буй тохиолдолд шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалах зорилгоор хэрэглэдэг түр арга хэмжээ юм. Жишээлбэл, Нидерландад шүүгч сахилгын зөрчил үйлдсэн гэх хангалттай үндэслэл байвал шүүгчийн бүрэн эрхийг 6 сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлж болдог бөгөөд түдгэлзүүлсэн хугацааг дахин нэг удаа зургаан сар эсхүл тухайн хэргийг эцэслэн хянан шийдвэрлэх хүртэл сунгаж болдог.¹⁸⁴ Мөн энэ улсад эрүүгийн хэрэгт ялагдсан бол шүүгчийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авдаг. Түүнчлэн, Бельгид эрүүгийн хэрэгт эсхүл сахилгын хэрэгт буруутгагдаж

¹⁸⁴ Нидерландын Шүүгчийн албан хаагчийн тухай хуулийн 38 дугаар зүйл.

буй шүүгчийг тухайн хэргийг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл түр түдгэлзүүлж болдог.¹⁸⁵ Мөн, АНУ-д хүнд гэмт хэрэгт ялагдсан бол түр түдгэлзүүлэхээс гадна сахилгын зөрчилд буруутгагдаж буй шүүгчийн түр түдгэлзүүлэхгүй бол олон нийтэд эсхүл шударга шүүхийн тогтолцоонд ноцтой аюул учруулах хангалттай үндэслэл байвал тухайн шүүгчийг түр түдгэлзүүлэх арга хэмжээ авдаг.¹⁸⁶

ШТХ-ийн төслийн 40.3-т "Сахилгын хороо шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг хянан үзээд түдгэлзүүлсэн бол шийдвэрээ Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулна" гэж заасан байна. Харин, сахилгын хэрэг үүсгэсний дараа сахилгын зөрчил үйлдсэн байх хангалттай үндэслэл байгаа бол шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалах үүднээс шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх зохицуулалт төсөлд тусгагдаагүй байна.

Санал. ШТХ-ийн 40.5-д "Сахилгын хэрэгт буруутгагдаж буй шүүгчийн бүрэн эрхийг түр түдгэлзүүлэхгүй бол олон нийтэд эсхүл шударга шүүхийн тогтолцоонд ноцтой хохирол учруулах үндэслэл, нотлох баримт байгаа бол Шүүхийн сахилгын хороо тухайн шүүгчийн бүрэн эрхийг 6 сар хүртэл хугацаагаар түр түдгэлзүүлж энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд мэдэгдэнэ. Сахилгын хороо шүүгчийн бүрэн эрхийг түр түдгэлзүүлсэн хугацааг дахин нэг удаа зургаан сар хүртэл эсхүл сахилгын хэргийг эцэслэн хянан шийдвэрлэх хүртэл сунгаж болно." гэж заах.

¹⁸⁵ Benoit Allemeersch, Andre Alen and Benjamin Dalle, "Judicial Independence in Belgium," in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 333;

¹⁸⁶ ABA Model Rules for Judicial Disciplinary Enforcement, Rule 15. Interim Suspension.

5. ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО

Сахилгын хорооны бие даасан байдал, үйл ажиллагааны баталгааг хангах чухал зохицуулалтыг ШТХ-ийн төсөлд тусгажээ. Тухайлбал, Ажлын алба нь Сахилгын хорооны дарга, гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх бөгөөд түүний бүтэц, бүрэлдэхүүн, төсөв, ажлын албаны ажиллах журмыг Сахилгын хороо зөвлөгөөнөөрөө хэлэлцэж батлахаар заажээ (99.20, 104.2, 104.4). Ажлын албаны дарга нь Ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах, ажилтныг томилж, чөлөөлөх, төсвийг захиран зарцуулах, ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнахаар заасан (104.3) нь ажлын албаны хариуцлагыг дээшлүүлэх ач холбогдолтой. Мөн, Сахилгын хорооны бие даан ажиллах, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх санхүүгийн баталгааг төр хангахаар тусгажээ (99.21). Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна (99.22) гэжээ. Сахилгын хорооны дарга, гишүүний баримтлах зарчим (99.12), хүлээх үүрэг (102.1), татгалзан зарах нөхцөл (102.2)-ийг заахын зэрэгцээ "Сахилгын хорооны гишүүний ёс зүйн дүрмийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр батална" гэж заасан (102.3) нь тус хорооны бүрэлдэхүүнийг хариуцлагажуулах шинэлэг зохицуулалт болжээ. ШТХ-ийн төсөлд Сахилгын хороотой холбоотой энэ мэт олон чухал заалт байх боловч төслийг сайжруулах үүднээс тус хорооны бүрэлдэхүүнд тавих шаардлага, уг хороонд томилогдож болохгүй этгээд, бүрэн эрхийн хугацаа, хорооны дарга, гишүүнийг сонгох, томилох журмыг авч үзэж саналаа өгөхийг зорилоо.

Энэ бүлэг нь (5.1) Шүүхийн сахилгын хорооны гишүүнд тавих шаардлага; (5.2) Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орохыг хориглох этгээд; (5.3) Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа; (5.4) Сахилгын хорооны дарга, гишүүнийг сонгох, томилох; (5.5) Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах гэсэн таван хэсэгтэй.

5.1. ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ГИШҮҮНД ТАВИХ ШААРДЛАГА

Сайн туршлага¹⁸⁷

Франц, Швед зэрэг бусад улсад шүүхийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэдэг бүрэлдэхүүний олонх шүүгч биш буюу шүүгчийн ажлын туршлагагүй хүмүүс байна.¹⁸⁸ АНУ-ын 50 муж улсад байдаг шүүхийн сахилгын хороодын олонхынх нь бүрэлдэхүүн шүүгч, хуульч, иргэдийн төлөөллийг багтаадаг бөгөөд ихэнхдээ шүүгчид цөөнх байдаг (California, Hawaii, Iowa, New Jersey, New Mexico, North Dakota, Washington, Wisconsin зэргийг харна уу).¹⁸⁹ Жишээлбэл, Невада мужийн шүүгчийн сахилгын комисс 7 гишүүнтэй бөгөөд Дээд шүүхээс томилсон 2 шүүгч, Мужийн Хуульчдын холбооноос томилсон 2 хуульч, Амбан захирагчаас томилсон 3 иргэн багтдаг.¹⁹⁰

Пост коммунист улсуудад мөн шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд шүүгчдийг олонх болгохоос татгалзаж

¹⁸⁷ Шүүхийн сахилгын хорооны гишүүнд тавих сайн туршлагыг доорх судалгаанаас хэсэгчлэн авав: О.Мөнхсайхан, Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага (АНУ-ын Азийн сан 2019); О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процедур: амжилт ба сорилт,” “Шүүгчийн ёс зүй ба сахилга” Олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор, (УБ 2017) 41-87.

¹⁸⁸ Giuseppe Di Federico, “Judicial Accountability and Conduct: An Overview,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 112; Antoine Garapon, “Judicial Independence in France,” in *Judicial Independence in Transition*, ed. Harold Epineuse and Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 278; Joakim Nergelius and Dominik Zimmermann, “Judicial Independence in Sweden,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 210. Францад Шүүхийн дээд зөвлөлийн 17 гишүүний 4 нь иргэн байсан бол одоо 6 гишүүн нь иргэн байхаар болсон. Эдгээр иргэдийн хоёрыг Ерөнхийлөгч, хоёрыг Сенатын танхим, хоёрыг Төрийн зөвлөлөөс тус бүр томилдог.

¹⁸⁹ Russel Wheeler, “Judicial Independence in the United States of America,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 549; Mark Tushnet, “Judicial Selection, Removal and Discipline in the US,” in *Judiciaries in Comparative Perspective*, ed. H. P. Lee (Cambridge Univ Press, 2011), 148.

¹⁹⁰ Allison Combs, “Judicial Discipline Commissions” (Legislative Counsel Bureau, Nevada Legislature, Background Paper 95-5), 3, <https://www.leg.state.nv.us/Division/Research/Publications/Bkground/BP95-05.pdf>.

эхэлсэн. Жишээлбэл, 2008 оноос өмнө Чехэд шүүгчид сахилгын арга хэмжээ авах асуудлыг зөвхөн шүүгчид шийдвэрлэдэг байсан нь зохимжгүй, хангалтгүй байсан гэж буруутгагдаж байв. Шүүгч нар бусад шүүгчээ сахилгажуулахад хэтэрхий зөөлөн ханддаг гэсэн шүүмжлэлээс урьдчилан сэргийлэхийн тулд шүүгчид сахилгын арга хэмжээ авах эрх мэдлийг Чехийн Захиргааны дээд шүүхийн тусгай танхимд шилжүүлсэн бөгөөд уг танхим гурван шүүгч болон гурван шүүгч биш гишүүд (нэг прокурор, нэг хуульч-Хуульчдын холбооны гишүүн, нэг хууль зүйн эрдэмтэн)-ээс бүрддэг болжээ.¹⁹¹ Энэ танхимын дөрвөөс доошгүй гишүүд санал нэгдэж шийдвэр гаргах учраас шүүгчид сахилгын шийдвэр дээр хориг тавих боломж хэвээр үлдсэн боловч сахилгын шүүхийн шийдвэрт давж заалдах гомдол гаргах боломжгүй ажээ.¹⁹²

Монгол Улс

Сахилгын хороо есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар ШТХ-ийн төслийн 99.2-д заасан нь одоогийн Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүний тоотой ижил байна. ШТХ-ийн төслийн "99.4-т заасан байгууллагаас томилогдсон тус бүр нэг гишүүн орон тооны, бусад нь орон тооны бус байна" гэснээс үзэхэд есөн гишүүний гурав нь орон тооны байхаар байна. 550 орчим шүүгчтэй Монгол улсын хувьд Сахилгын хороо есөн гишүүнтэй, үүний гурав нь орон тооны байхад ачааллыг хэт ихсэхгүй, тохиромжтой тоо гэж үзэж байна.

ШТХ-ийн төслийн 99.3-т зааснаар Сахилгын хорооны гишүүн "хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан" байхаар заасан нь гишүүнд тавигдах шаардлагыг өндөрсгөсөн ач холбогдолтой болжээ. Гэвч, гишүүнд тавигдах шаардлагыг сайжруулах хэд хэдэн санал байна.

¹⁹¹ Tomas Friedel and Michel Urban, "What Czech Judges Can and Cannot Do? Practice of Judicial Disciplinary Authorities in the Czech Republic: Empirical Analyses of All Disciplinary Decisions between 2008-2014," *Asian Journal of Legal Education* 3, no. 1 (2016): 26.

¹⁹² Friedel and Urban, 26.

Нэгд, Сахилгын хороонд шүүгч, хуульчаас гадна хууль зүйн эрдэмтнийг оруулахаар заах. ШТХ-ийн төслийн 99.3-т зааснаар "Сахилгын хорооны гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, шүүгч, хуульчаас бүрдэнэ" гэж зааснаас үзэхэд Сахилгын хорооны бүрэлдэхүүнд зөвхөн хуульч болон шүүгч орохоор заажээ.

Хууль зүйн эрдэмтэн нь иргэдийг төлөөлөх боломжтой тултэдгээрийг Шүүхийн сахилгын хороонд орох боломжийг хаах нь төдийлөн оновчтой биш юм. Учир нь, хууль зүйн эрдэмтэн нь заавал хуульч байх шаардлагагүй бөгөөд амьдрал дээр ч хуульчийн зөвшөөрөлгүй, шүүхийн практикт оролцохгүйгээр судалгааны ажил хийдэг эрдэмтэд олон байдаг. Тиймээс, олон улсад хууль зүйн эрдэмтдийг хагас хууль зүйн ажил эрхэлдэг гэж үзэх хандлага бий. Хууль, шүүхийн практикаас гадуур ажилладаг ийм иргэдийн төлөөллийг оролцуулах нь ардчилсан нийгэмд төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж байгаа субъект олон нийтийн өмнө хариуцлага хүлээх зарчмыг хэрэгжүүлэх,¹⁹³ шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд тавих иргэдийн хяналтыг дээшлүүлэх, эцсийн дүндээ шүүхэд итгэх иргэдийн итгэлд эерэг нөлөө үзүүлэх ач холбогдолтой. Ийм олон талын төлөөлөл орсноор ашиг сонирхлын зөрчил үүсэхээс сэргийлэх, асуудлыг тал талаас нь харж илүү үндэслэлтэй, зөв шийдвэрлэхэд эерэгээр нөлөөлнө. Тийм ч учраас, 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2.3-аар илэрхийлэхдээ Шүүхийн сахилгын хорооны гишүүдийн тодорхой хэсэг нь хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтэн байхаар заасан.

Олон улсын сайн туршлага шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд шүүгч, эрдэмтэн, хуульч зэрэг хууль зүйн өндөр мэргэжилтэн төдийгүй иргэний нийгмийн төлөөллөөс нь ёс зүйн өндөр шаардлага, тухайн ажилд хувь нэмэр оруулах мэдлэг, ур

¹⁹³ Anja Seibert-Fohr, ed., *Judicial Independence in Transition*, 277.

чадвараар шалгуур болгон оруулах хэрэгтэй гэж үздэг.¹⁹⁴ Венецийн комисс ч мөн шүүхийн сахилгын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүнд шүүгч, хуульч, эрдэмтдийн төлөөллийг оролцуулахыг зөвлөдөг.¹⁹⁵ Жишээлбэл, Болгар, Хорват, Франц зэрэг улсад ийм олон талын төлөөллийг хангаж бүрдүүлдэг.

Хоёрт, Сахилгын хорооны есөн гишүүний гурав нь шүүгч, гурав нь хуульч, гурав нь эрдэмтэн байхаар тодорхой заах. ШТХ-ийн төслийн 99.3-т Сахилгын хорооны бүрэлдэхүүний хэд нь шүүгч, хэд нь хуульч байхыг заагаагүй учраас аль нэг нь давамгайлах эрсдэлтэй. Жишээлбэл, тус хороонд шүүгчид эсхүл шүүгээр ажиллаж байгаад тэдгээрт гарсан хүмүүс давамгайлбал шүүгчийн явцуу ашиг сонирхлыг хамгаалах, олон нийтийн төлөөлөл оролцох боломж хумигдах эрсдэлтэй. Жишээлбэл, 2013-2019 онд Шүүхийн ёс зүйн хорооны бүрэлдэхүүнд нийт 16 хүн ажиллажээ. Тус хорооны гишүүнээр томилогдож ажиллахдаа эдгээрийн 6 нь төрийн захиргааны албан хаагч (үүний 4 нь ХЗДХЯ-ны газрын дарга, 1 нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, 1 нь Оюуны өмчийн газрын дарга), 5 нь шүүгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан хуульч, 3 нь их, дээд сургуулийн багш, 1 нь судлаач, 1 нь ХЭҮК-ийн гишүүнээр тус тус ажиллаж байжээ. Шүүхийн ёс зүйн хороонд нэр дэвшиж байсан хүмүүсээс харахад шүүгчээр ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан хуульчид олон байсан нь тус хорооны хэрэг хянан шийдвэрлэх явцад шүүгчийн ажлын онцлогийг ойлгоход тустай байсан ч хэт давамгайлбал олон нийтийн төлөөлөл алдагдах нөхцөл үүсгэх эрсдэлтэй. Шүүгчид сахилгын арга хэмжээ авах тогтолцоог шүүх эрх мэдэл өөрөө голлон хянах шүүгчийн хариуцлагатай байдлыг хангахад тохиромжгүй.¹⁹⁶ Иймээс, сахилгын хороог шүүгч, хуульч, эрдэмтдийн тэнцүү тооны төлөөллийг оролцуулан бүрдүүлэх нь зүйтэй.

¹⁹⁴ European Network of Councils for the Judiciary (ENCJ), Project on Non Judicial Members in Judicial Governance 2015-2016, 9.

¹⁹⁵ OSCE, ODIHR, "Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges" (Warsaw, 27 December 2018), 9.

¹⁹⁶ Sarkar Ali Akkas, "Judicial Independence and Accountability: A Comparative Study of Contemporary Bangladesh Experience" (University of Wollongong, 2002), 223.

Сахилгын хорооны есөн гишүүний гурав нь шүүгч, гурав нь хуульч, гурав нь эрдэмтэн байхаар тодорхой заах нь 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2.3-т "Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институцээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах" гэж заасанд бүрнээ нийцнэ.

Санал: ШТХ-ийн төслийн 99.3-ыг "Сахилгын хороо нь шүүгч, хуульч, эрдэмтдийн тэнцүү төлөөлөөс бүрдэх бөгөөд эдгээр нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байна" гэж өөрчлөх.

5.2. САХИЛГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ОРОХЫГ ХОРИГЛОХ ЭТГЭЭД

ШТХ-ийн төсөлд "Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно" гэж заасан (99.7). Тус хороонд өмгөөлөгч, прокурор орохыг хориглож буй нь шүүгчийн хараат бус байдлыг хамгаалахад чухал ач холбогдолтой юм. "Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан" төдийгүй Ерөнхий зөвлөлийн гишүүн, Мэргэшлийн хорооны гишүүн Сахилгын хороонд орохыг хориглох замаар шүүхийн захиргаатай холбоотой эрх мэдэл цөөн хүнд төвлөрөхөөс сэргийлнэ. Шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэхэд оролцсон этгээд нь шүүгчийн сонгон шалгаруулалт, томилгоо, захиргаа, төсвийн чиг үүрэг хэрэгжүүлж болохгүй гэж Киевийн зөвлөмжид заажээ.¹⁹⁷ 2019 онд Үндсэн хуульд оруулсан нэмэлт,

¹⁹⁷ "Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia," par. 9.

өөрчлөлтөөр Шүүхийн сахилгын хороог бие даалган байгуулсан нь ШЕЗ дээр төвлөрүүлсэн шүүхийн захиргааны эрх мэдлийг задалж, шүүгчийг шилж олох болон шүүгчид сахилгын шийтгэл ногдуулах чиг үүргийг тусдаа, харилцан бие даасан байгууллагуудаар хэрэгжүүлэхэд чиглэсэн.

Хараат бусаар, төвийг сахиж ажиллах эсэхэд үндэслэл бүхий эргэлзээ үүсгэх ажил эрхэлж буй хүмүүсийг шүүхийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд оруулахаас татгалздаг. Жишээлбэл, "гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн гишүүд"-ийг уг бүрэлдэхүүнд томилох, сонгохыг хориглодог.¹⁹⁸ Энэ мэт улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаа болон тодорхой хугацаанд эрхэлж байсан иргэдийг Шүүхийн сахилгын хороонд оруулахыг хориглож буйн дэлгэрэнгүйгээр үндэслэлийг энэхүү саналын "ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнд тавих шаардлага" гэсэн 1.2 дахь хэсгээс үзнэ үү.

Санал: ШТХ-ийн төслийн 99.7-ыг "Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн болон Мэргэшлийн хорооны гишүүн, шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор, мөн сүүлийн дөрвөн жилд шүүгч, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, дэд сайд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглоно" гэж өөрчлөх.

¹⁹⁸ OSCE, ODIHR, "Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges" (Warsaw, 27 December 2018), 9.

5.3. САХИЛГЫН ХОРООНЫ ГИШҮҮНИЙ БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА¹⁹⁹

Шүүгчийн сахилгын зөрчлийг шалгах, шийдвэрлэх чиг үүрэгтэй субъектийн бүрэн эрхийн хугацаа нь тухайн улс орны шүүхийн болон эрх зүйн тогтолцооны онцлогт нийцсэн байхын зэрэгцээ бие даасан, хараат бус байдлыг нь хангахуйц байх ёстой. Шүүхийн захиргааны тухай 2012 оны хуулийн 32.5-д заасны дагуу Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийг 3 жилийн хугацаатай томилдог. ШТХ-ийн төслийн 99.8-д энэ зохицуулалтыг залгамжлан авч, Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд түүнийг 1 удаа улируулан сонгож, томилж болохоор заажээ.

Монгол Улсын хувьд Шүүхийн сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа гурван жил байх нь олон улсын нийтлэг жишигт нийцэж байна. Сахилгын хэрэг шийдвэрлэх бүрэлдэхүүний бүрэн эрхийн хугацааг 3-4 жилээр тогтоох хандлага байна. Тухайлбал, Францад Шүүхийн дээд зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа 4 жил (улирахгүй), Польшид сахилгын төлөөлөгчийн бүрэн эрхийн хугацаа 4 жил (шийдвэрлэх чиг үүргийг шүүх хэрэгжүүлдэг учир бүрэн эрхийн хугацаа яригдахгүй), АНУ-ын Канзас, Баруун Виржиниа мужид 3 жил байна.

ШТХ-ийн төсөлд “Гишүүний бүрэн эрх сонгож, томилсноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно (99.8) гэж заасан нь тус хорооны залгамж чанарыг хадгалах, шийдвэрийн үндэслэл тогтвортой, тууштай гардаг болоход тустай болжээ. Одоогийн хууль, дүрмээр Шүүхийн ёс зүйн хорооны 9 гишүүний бүрэн эрхийн хугацаа нэгэн зэрэг дуусах бөгөөд Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 2.8-д “Ёс зүйн хорооны дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарвал Шүүхийн захиргааны тухай хууль, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хууль, энэ дүрэмд заасны дагуу тухайн гишүүнийг нэр дэвшүүлсэн субъект нь 14 хоногийн дотор

¹⁹⁹ Энэ хэсгийг доорх судалгаанаас хэсэгчлэн авав: О.Мөнхсайхан, Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага (АНУ-ын Азийн сан 2019); О.Мөнхсайхан, “Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процедур: амжилт ба сорилт,” “Шүүгчийн ёс зүй ба сахилга” Олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор, (УБ 2017) 41-87.

нөхөн нэр дэвшүүлнэ. Гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна" гэж заасан. Жишээлбэл, тус хорооны нэг гишүүн нөхөн нэр дэвшиж томилогдоод 8 сарын хугацаанд л ажиллаж байв. Тиймээс, гишүүдийн бүрэн эрхийн хугацаа дууссаны дараа нь өөр шинэ 9 гишүүн томилогдож боломжтой. Энэ нь Шүүхийн ёс зүйн хорооны ажлын залгамж чанар алдагдах, сүүлийн гурван жилд тогтсон сайн жишиг тасрах, алдагдах эрсдэлийг дагуулж, шүүгчийн ёс зүйн хөгжилд саад болж байв.

Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг сөөлжүүлэн томилж, шинэчилдэг болох хувилбарыг хуульчилж болно. "Сөөлжсөн бүрэн эрхийн хугацаа зөвлөлийн бүрэлдэхүүнийг тогтмол шинэчлэхийн зэрэгцээ залгамж чанарыг хангахад тусалж магадгүй."²⁰⁰ Тухайлбал, Шүүхийн сахилгын хорооны дараагийн бүрэлдэхүүний 9 гишүүний 3 нь нэг жил, 3 нь хоёр жил, 3 нь гурван жилийн хугацаатай томилогдох, эдгээр гишүүдийн бүрэн эрх дуусгавар болсны дараа томилогдсон гишүүд тус бүр гурван жилээр томилогдоно гэж хуульчлах хувилбарыг бодож үзэх хэрэгтэй. Ийм өөрчлөлт хийсний дараа томилогдох хоёр дахь бүрэлдэхүүнээс эхлээд Шүүхийн ёс зүйн хорооны гишүүдийн гуравны нэг жил бүр шинэчлэгдэхийн зэрэгцээ үлдсэн гишүүд нь залгамж чанараа хадгална. Мөн хорооны бие даасан байдлыг дээшлүүлэх нэг нөхцөл болно. Ингэснээр гишүүдийн бүрэлдэхүүнийг тогтмол шинэчилж байх, нэг бүрэлдэхүүн удаан хугацаагаар ажиллаж "дасал" болохоос сэргийлэх ач холбогдолтой.

Сөөлжих аргаар бүрэлдэхүүнийг томилдог туршлага зарим улсад бий. Тухайлбал, Америкийн Хуульчдын холбооноос гаргасан загвар дүрэмд хорооны нийт 12 гишүүдийг анхан болон давж заалдах шатны шүүхээс томилогдсон, хуульч, иргэн гэсэн 3 бүлэгт хувааж, бүлэг тус бүрээс нэг гишүүний бүрэн эрхийн хугацаа жил бүр дуусч байхаар зохицуулсан байна.²⁰¹ Ийнхүү гишүүдийн бүрэн эрхийн хугацааг сөөлжин тогтоох нь хорооны үйл ажиллагааны залгамж холбоог

²⁰⁰ Violaine Autheman and Sandra Elena, "Global Best Practices: Judicial Council (Lessons Learned from Europe and Latin America)" (IFES Rule of Law White Paper Series, 2004), 18, <http://pdf.usaid.gov/pdfdocs/PBAAB591.pdf>.

²⁰¹ Model Rules for Judicial Disciplinary Enforcement, Rule No. 2, Terms 4 (ABA,1994).

хадгалах болон бүрэлдэхүүнийг тогтмол шинэчлэх зорилгын аль алиныг хангах оновчтой хувилбар юм.

5.4. САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА, ГИШҮҮНИЙГ СОНГОХ, ТОМИЛОХ

ШТХ-ийн төслийн 99.4-т “Сахилгын хорооны гишүүнд Шүүгчдийн зөвлөлөөс гурав, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос гурав, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүнийг тус тус сонгож, томилно” гэж заажээ. Уг төслийн 99.5-т “Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдээс тус бүр нэг шүүгчийг болон орон тооны гишүүнийг шүүгчдийн зөвлөл нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхын саналаар сонгоно” гэж зааж, шүүгчдийн зөвлөлөөс Сахилгын хороонд орох гурван шүүгчийг сонгох зарчмыг тусгасан нь ач холбогдолтой. Ингэснээр ерөнхий зөвлөлийн гишүүнийг нэр дэвшүүлэхэд илээр санал хурааж хувь шүүгчийн саналд нөлөөлж байсан шиг бурангуй явдал Сахилгын хорооны гишүүнийг сонгоход гарах эрсдэл нь хязгаарлагдана. Мөн, ШТХ-ийн төслийн 99.17-т “Сахилгын хорооны даргыг зөвлөгөөнөөс гишүүдийн олонхын саналаар сонгоно” гэж заасан нь тус хорооны бие даасан байдлыг хангахад чухал юм.

Сахилгын хорооны гишүүнийг сонгох, томилохтой холбоотой ажиллагааг олон улсын сайн туршлага болон шүүгчийн хараат бус, хариуцлагатай байдлын зарчимд нийцүүлэн сайжруулах шаардлага байна. Тухайлбал, ШТХ-ийн төслийн 99.4, 99.6-д заасны дагуу Сахилгын хорооны есөн гишүүний гурвыг нь УИХ-ын Хууль зүйн байнгын хорооноос, гурвыг нь Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас томилох бөгөөд Хууль зүйн байнгын хорооны томилгоо хуралдаанд оролцсон гишүүний олонхоор шийдвэрлэхээр ойлгогдож байна (дийлэнх олонхын саналаар шийдвэрлэхээр заагаагүй). Энэхүү зохицуулалт нь шүүгчийн хараат бус байдлыг эрсдэлд оруулахаар байна. Учир нь, УИХ-ын сонгуулиар олонх болсон нам, эвсэл нь Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний гуравны хоёрыг дангаар томилох буюу томилоход нөлөөтэй байхаар байна.

Ингэснээр Сахилгын хорооны шийдвэр улс төрийн хувьд олонхын талд тал засах эрсдэл нэмэгдэнэ. Сахилгын хороог бүрдүүлэхэд шүүгчдийг хэт нөлөөтэй болгож шүүгчийн явцуу сонирхлыг хамгаалдаг болгож болохгүй төдийгүй гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийн хэт нөлөө оруулж хараат бус байдлыг нь алдагдуулж болохгүй. Тиймээс, ШТХ-ийн төслийн 99.4, 99.6 нь 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2.3-т "Шүүхийн сахилгын хорооны гишүүдийг шүүн таслах ажлын туршлагатай хуульчид, нэр хүндтэй иргэд, хууль зүйн өндөр мэргэшилтэй эрдэмтдээс нээлттэй нэр дэвшүүлэх замаар холбогдох институцээс тэнцвэртэйгээр бүрдүүлэх зарчмыг хуульчлах" гэж заасан шаардлагыг хангахгүй байна. Мөн, олон улсын жишгийн дагуу Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг томилох, сонгоход гүйцэтгэх болон хууль тогтоох эрх мэдлийг хэт давамгайлж оролцуулахаас татгалзахыг зөвлөдөг.²⁰²

Санал: ШТХ-ийн төслийн 99.4-ийг "Сахилгын хорооны гишүүнд Шүүгчдийн зөвлөлөөс гурав, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос тав, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас нэг хүнийг тус тус сонгож, томилно" гэж өөрчлөх.

Шүүхийн сахилгын хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнийг шүүгчдийн өөрийн удирдлагын байгууллага болон парламент хамтран бүрдүүлэх зохицуулалт Франц, Гүрж, Литви, Болгар, Хорват зэрэг улсад түгээмэл бөгөөд энэ нь сайн туршлагад тооцогддог.²⁰³ Эдгээр улсад ихэнхдээ парламент дийлэнх олонхын саналаар уг бүрэлдэхүүний зарим гишүүнийг томилохоор зохицуулдаг нь парламент дахь олонх

²⁰² OSCE, ODIHR, "Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges" (Warsaw, 27 December 2018), 4.

²⁰³ Мөн тэнд, 10.

дангаар хүч түрэн томилохоос сэргийлэх, уг томилгоонд цөөнхийг бодитойгоор оролцуулах, улмаар улс төрийн бус мерит томилгоо хийхэд хувь нэмэр оруулах шалтгаантай.

Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүнийг сонгох, томилох ажиллагаа нь ил тод, шударга, иргэний нийгмийн оролцоог хангасан байх шаардлагатай.²⁰⁴ ШЕЗ-ийн гишүүнийг иргэний нийгмийн оролцоог ханган нээлттэйгээр нэр дэвшүүлэн парламентаас дийлэнх олонхоор томилох үндэслэл, сайн туршлага нь Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний гол хэсгийг парламентаас томилоход адил үйлчлэх учраас энэ саналын "ШЕЗ-ийн шүүгч биш гишүүнийг нээлттэйгээр нэр дэвшүүлж томилох журам" гэсэн 1.4 дэх хэсгээс эдгээр үндэслэлийг харна уу.

Санал: ШТХ-ийн төслийн 99.6-г тус төслийн 79.1 (ШЕЗ-ийн гишүүний томилгоо)-тэй төстэйгээр дараах байдлаар өөрчлөх саналтай байна:

99.6.Байнгын хороо Сахилгын хорооны гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, томилно.

99.6.1.Сахилгын хорооны дарга Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас далаас доошгүй хоногийн өмнө Байнгын хороонд энэ тухай мэдэгдэх бөгөөд уул хугацаа дуусахаас жараас доошгүй доошгүй хоногийн өмнө Байнгын хорооноос Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

²⁰⁴ Мөн тэнд.

99.6.2. Сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш гуч хоногийн дотор энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн өөрөө нэр дэвших хүсэлтийг эсхүл түүний зөвшөөрснөөр нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн сургууль нэр дэвшүүлэх тухай хүсэлтийг мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлсэн талаарх намтар, хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө орлогын мэдүүлгийн хамт Байнгын хороонд хүргүүлнэ. Эдгээр баримт бичгийг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

99.6.3. Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтыг хараат бус, үнэнч шударгаар, төвийг сахиж явуулах хүмүүсээс Ажлын хэсгийг бүрдүүлэн байгуулна. Байнгын хороо ажлын хэсгийг гуравны хоёроос доошгүйн саналаар байгуулж, энэ зүйлийн 99.6.1-д заасны дагуу мэдээлснээс хойш 30 хоногийн дараа 45 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулах бөгөөд ажлын хэсэг хамгийн өндөр үнэлгээ авч шалгарсан нэр дэвшигчийн талаарх үндэслэл бүхий тайланг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

99.6.4. Энэ хуулийн 99.6.3-т заасны дагуу тайланг нийтэлснээс хойш 7 хоногийн дотор нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага, Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн их, дээд сургууль, иргэд нэр дэвшигчийн талаарх асуулт, саналаа Байнгын хороонд ирүүлж болох бөгөөд эдгээр асуулт, саналыг Монгол Улсын Их Хурлын цахим хуудаст даруй нийтэлнэ.

99.6.5. Байнгын хороо энэ зүйлийн 99.6.3-т заасны дагуу тайланг нийтэлснээс хойш 7 хоног өнгөрсний дараа 21 хоногийн дотор томилгооны сонсгол явуулсны үндсэн дээр хэлэлцэж Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Сахилгын хорооны гишүүнийг томилно.

99.6.6.Байнгын хороо нэр дэвшигчийг Сахилгын хорооны гишүүнд томилохоос татгалзсан бол дахин сонгон шалгаруулалтыг нийтэд даруй мэдээлж, энэ зүйлд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлж томилно.

99.6.7.Байнгын хороо нэр дэвшигчийг татгалзсан тохиолдолд тухайн хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

99.7.Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшүүлэх, томилохдоо энэ зүйлийн 99.6.1, 99.6.2, 99.6.3, 99.6.4, 99.6.5, 99.6.6, 99.6.7-д заасан журмыг баримтлах бөгөөд Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.5. ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮНД ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ

Шүүхийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх бүрэлдэхүүнд эмэгтэй болон эрэгтэй хүйсийн тэнцвэртэй төлөөллийг хангахыг олон улсын сайн туршлагаар чухалчилдаг.²⁰⁵ Жишээлбэл, энэ талаар Францын Магистратын дээд зөвлөлийн тухай органик хуулийн 5.2-т заажээ. ШЕЗ-ийн бүрэлдэхүүнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэслэл нь Сахилгын хорооны бүрэлдэхүүнд нэгэн адил үйлчлэх тул энэхүү саналын 1.5 дахь хэсгээс харна уу:

Санал. 99.2-т "Сахилгын хороо есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 99.4-т заасан байгууллагаас томилогдсон тус бүр нэг гишүүн орон тооны, бусад нь орон тооны бус байна" гэж заасны дараа "Сахилгын хорооны бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөлөл нийт гишүүний 40 хувиас доошгүй байх бөгөөд эрх бүхий этгээд Сахилгын хорооны гишүүнийг сонгох, томилохдоо энэхүү шаардлагыг баримтална" гэсэн өгүүлбэр нэмэх.

²⁰⁵ Мөн тэнд, 10.

6. ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА²⁰⁶

Энэ хэсэг нь (6.1) Шүүгчийн албан тушаал эрхлэхээс өмнөх болон дараах зөрчил; (6.2) Гомдлын хүрээгээр хязгаарлагдах эсэх; (6.3) Шүүгчийн сахилгын хэргийн хөөн хэлэлцэх хугацаа; (6.4) Мөрдөн шалгах чиг үүрэг ба бүрэн эрх; (6.5) Шалгах, нотлох болон шийдвэрлэх чиг үүргийг тусгаарлах; (6.6) Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг Улсын дээд шүүхэд давж заалдах; (6.7) Ил тод байдал гэсэн нийт долоон хэсгээс бүрдэнэ.

6.1. ШҮҮГЧИЙН АЛБАН ТУШААЛ ЭРХЛЭХЭЭС ӨМНӨХ БОЛОН ДАРААХ ЗӨРЧИЛ

Сайн туршлага

Шүүхийн сахилгын хорооны эрх хэмжээ нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг алдагдуулсан аливаа сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэж чадахуйц байх ёстой. Тийм учраас шүүгч байх үеийн төдийгүй шүүгч болохоос өмнө үеийн сахилгын зөрчлийг хамарч хэрэгждэг. Жишээлбэл, Канадын Нова Скота мужийн Дээд шүүхийн шүүгч Роберт "...Канадын Шүүхийн зөвлөлийн зүгээс гомдол хүлээн авч, хянан үзэх үндсэн 5 шат бий. Эдгээр гомдолд шүүгчээр томилогдохоос өмнөх хугацааны асуудлаарх гомдол ч багтаж болно," "Шүүгч болохоос өмнө зөрчил гаргасан явдал ч байдаг, байнга шалгаад л яваад байна. Нотлогдсон үед шийдвэрлэнэ. Энд хугацаа байхгүй"

²⁰⁶ Энэ бүлэгт дэвшүүлсэн саналын үндэслэл, сайн туршлагыг доорх судалгаанаас хэсэгчлэн авав: О.Мөнхсайхан, Шүүгчийн ёс зүй, сахилгатай холбоотой хууль тогтоомжийн төсөл боловсруулах хэрэгцээ, шаардлага (АНУ-ын Азийн сан 2019); О.Мөнхсайхан, "Монгол Улс дахь шүүгчийн сахилгын процедур: амжилт ба сорилт," "Шүүгчийн ёс зүй ба сахилга" Олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор, (УБ 2017) 41-87.

гэжээ.²⁰⁷ Түүнчлэн, шүүгчийн шүүгч болохоос нь өмнөх зан үйл одоо шүүгчээр ажиллах шаардлага хангасан эсэхэд нөлөөтэй байгаа бол уг зан үйлийнх нь төлөө тухайн шүүгчид сахилгын арга хэмжээ авах эрх хэмжээ Шүүхийн сахилгын хороонд бий гэж Небраск мужийн Дээд шүүх шийдэж байжээ.²⁰⁸ Энэ сахилгын хэрэгт шүүгч нь орон нутгийн прокуророор ажиллаж байхдаа эрүүгийн хэрэг дээр цагдаагийн тайлангийн хуулбарыг өөрчилж, эх тайлангаа өөрчлөх эсхүл ялах дүгнэлтэд нийцүүлэн мэдүүлгээ өөрчлөхийг уг тайланг бичсэн цагдаагийн албан хаагчаас хүссэн байна.

Европын зарим улсад тэтгэвэрт гарсан шүүгчид сахилгын арга хэмжээ авдаг байна. Жишээлбэл, Эстонд тэтгэвэрт гарсан шүүгч мэдээллийн нууцлал хадгалах үүргээ зөрчвөл тэтгэврийг нь нэг жил хүртэл хугацаагаар 25 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэл ногдуулдаг байна.²⁰⁹ Мөн, Молдавт шүүгчийн албан тушаал эрхэлж байхдаа сахилгын зөрчил гаргасан ч уг албан тушаалаас чөлөөлөгдсөн этгээдэд тэтгэврийн хэмжээг нь бууруулах сахилгын шийтгэл ногдуулдаг.²¹⁰

АНУ-ын ихэнх мужид шүүхийн сахилгын хороо нь шүүгч албан тушаалаа хашихаа больсон хүнд хаалттай эсхүл нээлттэй сануулах зэрэг хариуцлага тооцох боломжтой. Шүүгчийн ёс зүй, сахилгын асуудлаар мэргэшсэн профессор Синтий Грэй үүний цаад шалтгааныг ингэж бичсэн:

...Хэдийгээр шүүгч нь албан тушаалаа хашихаа больсон боловч "тухайн сахилгын зөрчил нь шүүхийн тогтолцооны зарчимч байдалд ноцтой халдсан бол уг зарчимч байдлыг хамгаалахын тулд хариуцлага хүлээлгэх нь чухал. Учир нь, дуугүй байх нь ийм зөрчлийг өөгшүүлдэг гэсэн

²⁰⁷ Роберт Врайт, "Шүүгчийн ёс зүй, сахилга: Канадын туршлага," Шүүгчийн ёс зүй ба сахилга: олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор (Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо, 2017), 26, 107.

²⁰⁸ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 408–9.

²⁰⁹ Эстонийн шүүхийн тухай хуулийн 88(2). Мөн дараахыг харна уу: Timo Ligi, "Judicial Independence in Estonia," in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 739–93.

²¹⁰ Молдавын Шүүгчийн сахилгын хариуцлагын тухай хуулийн 7(1), 7(6).

ойлголтыг олон нийтэд төрүүлдэг" (Probert, 1981, at 776) ... "Албан тушаалаа орхисны дараа урьдын шүүгч нь өөрийн намтартаа шүүгчийн албан тушаалын статусыг хадгалдаг. Энэхүү албан тушаалын протокол сэвтсэн гэдгийг олон нийт мэдэх эрхтэй" (In re Steady, 1994, at 118). "Шүүгчийн зан үйл бол олон нийтийн ашиг сонирхлын чухал асуудал бөгөөд урьдын шүүгчтэй холбоотой хэргүүд нь шүүх эрх мэдэл бүхэлдээ яаж ажиллахыг тодорхойлж, шаардлагатай жишгийг тогтоож байдаг" (Commission v. Dodds, 1996, at 182).²¹¹

Эндээс харахад шүүгчийг тэтгэвэрт гарсан, чөлөөлөгдсөн зэргээр түүний шүүгч байхдаа үйлдсэн сахилгын зөрчлийг шалгахгүй, тогтоохгүй, хариуцлага хүлээлгэхгүй байх нь шүүхийн нэр хүндэд хортой хохирол учруулдаг байна.

Монгол Улс

Шүүгчээр томилогдохоос өмнөх зан үйлтэй нь холбогдуулж шүүгчид хариуцлага хүлээлгэх эсэх асуудлыг Шүүхийн ёс зүйн хорооны нийт гишүүдийн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэсэн тохиолдол гараагүй боловч ийм зөрчил гарах боломжтой. Тухайлбал, Үндсэн хуулийн цэцийн гишүүн ийм сахилгын зөрчил гаргаж байв. Д.Сугар нь Цэцийн гишүүнээр томилогдохоосоо өмнө Төрийн өмчийн хорооны дарга байхдаа Цэцийн гишүүний цалингаасаа 40.5 дахин их хөрөнгө, орлогыг Хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ мэдүүлээгүй. Энэхүү сахилгын зөрчилтэй нь холбогдуулан Д.Сугарт Цэцийн даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулж байсан.²¹²

Шүүхийн ёс зүйн хорооны шалгаж байсан гомдолд буруутай гэж дурдагдаж байсан шүүгч нь тухайн асуудлыг шийдвэрлэхээс өмнө тэтгэвэрт гарсан буюу чөлөөлөгдсөн тохиолдол хэд хэд гарсан. Шүүхийн

²¹¹ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 409.

²¹² Энэ шийдвэрт хийсэн анализыг дараах өгүүллээс уншина уу. О.Мөнхсайхан, "Цэцийн гишүүнд хариуцлага хүлээлгэх асуудалд хийсэн дүн шинжилгээ," Хууль дээдлэх ёс Цуврал 2 (48) (2014): 7–22.

ёс зүйн хороо тэтгэвэрт гарсан эсхүл чөлөөлөгдсөн шүүгчийн үйлдсэн сахилгын зөрчил гарсныг тогтоосон боловч хариуцлага хүлээлгээгүй орхиж шийдвэрлэсэн. Жишээлбэл, нэгэн шүүгч нь нэхэмжлэлийн шаардлагыг биелүүлсэн тухай зөвхөн хариуцагч талын тайлбарт тулгуурлан маргааныг хариуцагчийн талд хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн төдийгүй хөрөнгө, орлогын мэдүүлгээ үнэн зөв гаргаагүй нь тогтоогдсон. Шүүхийн ёс зүйн хороо үүнийг сахилгын зөрчил гэж үзсэн боловч уг шүүгч шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тул түүнд үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон.²¹³ Мөн, өөр нэгэн шүүгч шүүгдэгчид хандан "Чи ганцаараа энхийн цагаан тагтаа, бусад нь хар хэрээ юм биз дээ. Дугуй дугуйгаа олдог юм. Охиноо яагаад ааваараа овоглосон юм бэ? Аавтайгаа гэр бүлийн харьцаатай байдаг уу..." зэргээр хэлснийг сахилгын зөрчил гэж Шүүхийн ёс зүйн хороо үзсэн боловч уг шүүгч шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн тул түүнд үүсгэсэн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон.²¹⁴

2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх" гэж илэрхийлсэн. Энэ нь шүүгчийн уг албан тушаал эрхлэхээс өмнө гаргасан сахилгын зөрчил төдийгүй шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн хүний уг албан тушаалыг эхэлж байхдаа гаргасан зөрчлийг хянан шийдвэрлэхээр хуульчлахыг шаардана.

²¹³ Шүүхийн ёс зүйн хорооны 2015.12.17-ны өдрийн магадлал.

²¹⁴ Шүүхийн ёс зүйн хорооны 2016.10.27-ны өдрийн магадлал.

Санал: ШТХ-ийн төслийн 59.5-д “Шүүгчийн албан тушаалд томилогдохоос өмнө гаргасан үйлдэл, эс үйлдэхүй нь шүүгчийн сахилгын ноцтой зөрчилд тооцогдохоор бол тухайн шүүгчид энэ хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.”, 59.6-д “Шүүгч байхдаа шүүгчийн сахилгын зөрчил гаргасан боловч тухайн зөрчлийг хянан шийдвэрлэхээс өмнө тэтгэвэрт гарсан бол түүний зөрчлийн шинж чанар, хэр хэмжээнд тохируулан хаалттай, нээлттэй сануулах эсхүл нэг жил хүртэл хугацаагаар тэтгэврийн хэмжээг нь 30 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэлийн аль нэгийг ногдуулна. Тэтгэвэрт гарахаас бусад байдлаар шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн бол тухайн зөрчлийн үйл баримт болон ногдуулах сахилгын шийтгэлийг тогтооно” гэж нэмэх.

6.2. ГОМДЛЫН ХҮРЭЭГЭЭР ХЯЗГААРЛАГДАХ ЭСЭХ

Сайн туршлага

Польш, Франц, АНУ, Канад зэрэг улсад гомдлын хүрээгээр хязгаарлах зохицуулалт байхгүй. Эдгээр улсад шалгалт явуулж буй албан тушаалтан сахилгын хэргийг өөрийн санаачилгаар үүсгэх боломжийг олгосон нь шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь талуудын санаачилгаар үүсдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин түүнийг нийтийн эрх ашгийн өмнөөс шалгадаг, шийдвэрлэдэг гэсэн үзэл баримтлалыг харуулдаг. Тухайлбал, Канадын Нова Скота мужийн Дээд шүүхийн шүүгч Роберт Врайт “Гомдлын дагуу шалгаж байтал өөр зөрчил гарсан нь илэрвэл анхны гаргасан гомдлыг шалгаж дуусаад дахиад шинэ зөрчил болгон шалгадаг” хэмээн Канадын туршлагыг хуваалцсан юм.²¹⁵

²¹⁵ “Шүүгчийн ёс зүй ба сахилга” олон улсын бага хурлын тэмдэглэл,” Шүүгчийн ёс зүй ба сахилга: олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа (Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо, 2017), 107.

Польшийн Шүүхийн тухай хуулийн 117 дугаар зүйлд “Сахилгын хэргийг шийдэх явцад өөр сахилгын зөрчил илэрвэл Сахилгын шүүх сахилгын төлөөлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр тухайн хэргийг шийдвэрлэх бөгөөд шинээр илэрсэн зөрчилд тусад нь сахилгын хэрэг үүсгэн шалгана” гэж заасан. Өөрөөр хэлбэл, сахилгын хэргийг шийдвэрлэх явцад шинэ зөрчил илэрвэл түүнд холбогдуулан сахилгын хэрэг шинээр үүсгэн шалгах эрх хэмжээтэй. Учир нь шүүгчийн сахилгын зөрчлийн объект нь хувийн ашиг сонирхол гэхээс илүүтэй нийтийн ашиг сонирхол, түүний дотор олон нийтийн шүүхэд итгэх итгэл байдаг тул маргааны хүрээ нь гомдлын хүрээгээр хязгаарлагддаггүй.

Монгол Улс

Шүүхийн ёс зүйн хорооны эрх хэмжээ зөвхөн гомдлын хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд гомдлыг шалгах явцад илэрсэн шүүгчийн сахилгын ноцтой зөрчлийг хянан шийдвэрлэх шаардлагатай гэж тус хороо үзэж шийдвэрлэсэн ч уг байр суурийг шүүх хүлээн зөвшөөрөөгүй. Жишээлбэл, Шүүгч Р нь А аймаг дахь Б банканд холбогдох хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх явцад түүний нөхөр хугацаа хэтэрсэн /2010-2014 онд/ зээлийн үлдэгдэл болох нийт 66,713,790.23 төгрөгийг тухайн Б банканд төлсөн. Шүүгч Р 2014 оны хөрөнгө, орлогын их хэмжээний өөрчлөлтөд өөрийн нөхрийнхөө 66,713,790.23 төгрөгийн зээл төлөлтийн талаар бүртгүүлээгүй байх бөгөөд ийнхүү бүртгүүлээгүй гэдгээ тайлбартаа хүлээн зөвшөөрсөн. Шүүгч Р-ийн нөхөр Б банканд 66,713,790 төгрөгийн зээлийг төлж хаалгасан нь 2010-2014 оны хооронд ийм хэмжээний зээлтэй байсан гэдгийг харуулсан гэж тус хороо үзжээ. Энэхүү зээлийн хэмжээ нь шүүгч Р-ийн 2011 оны бүрэн жилийн цалин (9,726,918 төгрөг)-аас даруй 6.8 дахин их, 2012 оны бүтэн жилийн цалин (12,890,539 төгрөг)-аас 5.1 дахин их байжээ. Тиймээс, шүүгч Р нь өөрийн нэг жилийн цалингаас их хэмжээний хөрөнгө, орлого буюу зээлийг мэдүүлээгүй байх тул Авилгын эсрэг хуулийн 13.8.4-т²¹⁶ заасны дагуу

²¹⁶ Авлигын эсрэг хуулийн 13.8.4.-д “нэг жилийн цалинтай тэнцэх буюу түүнээс их хэмжээний хөрөнгө, орлогыг мэдүүлээгүй, худал мэдүүлсэн, эсхүл хөрөнгө, орлогын мэдүүлгийг гаргаж өгөөгүй, гаргахаас татгалзсан бол албан тушаалаас нь огцруулах буюу ажлаас халах” тухай заасан.

түүнд огцруулах шийтгэлийг Шүүхийн ёс зүйн хороо ногдуулжээ.²¹⁷ Гэвч, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх болон Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас гомдолд дурдагдаагүй асуудлаар шүүгчийг шалгаж, зөрчил илрүүлэн сахилгын хэрэг үүсгэж, улмаар сахилгын арга хэмжээ ногдуулсан гэх болон бусад үндэслэлээр уг сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгосон.²¹⁸ Энэ маргааны агуулга нь анх гомдолд дурдсанаар шүүгч хэргийг үндэслэлгүйгээр түдгэлзүүлж, энэ хугацаанд өөрийн нөхрийн зээлийг хаалгасан тухай байсан боловч сахилгын хэргийг хянан шийдвэрлэх явцад шүүгч Р нь нөхрийнхөө зээлийн талаар хөрөнгө, орлогын мэдүүлэгтээ тусгаагүй тухай шинэ зөрчил илэрсэн байна. Шүүгчийн сахилгын зөрчлийг зөвхөн гомдлын дагуу шалгадаг, ийм гомдол хэн нэгэн гаргаагүй гэж шүүх үзээд шүүгч Р-ийн ШЭЗБТХ, Авлигын эсрэг хууль, ШЁЗД-ийг зөрчсөн эс үйлдэхүйд хариуцлага хүлээлгээгүй.

Манай хууль болон дүрмийн зохицуулалтаар хуульд хариуцлага хүлээлгэхээр заасан зохицуулалт, ШЁЗД-ийг ноцтой зөрчсөн нь нотлох баримтаар бүрэн нотлогдсон байхад "гомдолд дурдаагүй" гэсэн үндэслэлээр сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож, зөрчил гаргасан шүүгчид хариуцлага хүлээлгэхгүй байгаа нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд халтай. Цаашлаад сахилгын хэргийг шалгах явцад өөр ноцтой зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг шалгах эрх хэмжээ байхгүй нь хэн нэгэн гомдол гаргахыг хүлээх үү гэсэн асуулт тавихад хүргэнэ. Эндээс үзвэл Шүүхийн ёс зүйн хорооны шалгах ажиллагаа хувийн эрх зүйн маргаан шиг гомдлын хүрээгээр хязгаарлагдахгүй байх нь зүйтэй. Мөн одоогийн тогтолцоонд нэг талаас Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн шалгах чиг үүрэгтэй боловч нөгөө талаас гомдлоо тодорхой хэмжээнд нотлохыг гомдол гаргагчид шууд бусаар үүрэгжүүлдэг. Гэвч, шүүгчийн ёс зүйн маргаан нь маргааны талуудад нотлох үүрэг хүлээлгэдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин нийтийн ашиг сонирхол хөнддөг нийтийн эрх зүйн маргаан²¹⁹, гомдол гаргагч,

²¹⁷ ШЁЗХ-ны 2014.9.05-ны өдрийн 45 дугаар магадлал.

²¹⁸ ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар Ш/14, 2014.11.12; УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 11, 2015.01.12.

²¹⁹ О.Мөнхсайхан нар, Монгол Улс дахь шүүхийн захиргааны загвар: Тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, 124.

шүүгч хоёр нь зөрчил гаргасан эсэх талаар маргалдахаас илүү, төрийн тусгай албан тушаалтан болох шүүгчийн зөрчил гаргасныг шалгахыг шаардаж буй харилцаа юм.

ШТХ-ийн төслийн 105.4-т “Сахилгын хороо гомдол, мэдээлэл шалгах явцад гомдол мэдээлэлд дурдагдаагүй боловч Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн байж болзошгүй үйл баримт илэрвэл хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна” гэж заасан нь Сахилгын хорооны шалгах ажиллагаа зөвхөн гомдол, мэдээллийн агуулгаар хязгаарлагдахгүй байх чухал алхам болж, 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн “шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх” гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т “Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх” гэж илэрхийлсэнтэй нийцэж байна. Сахилгын зөрчил нь зөвхөн Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн зөрчлөөс хязгаарлагдахгүй тул энэ агуулгаар хэллэгийг сайжруулах саналтай байна.

Санал. ШТХ-ийн төслийн 105.4-ийг “Сахилгын хороо гомдол, мэдээллийг шалгах явцад гомдолд дурдагдаагүй боловч шүүгчийн сахилгын зөрчилд хамаарч болзошгүй үйлдэл, эс үйлдэхүйн талаарх үйл баримт илэрвэл тусгаарлан шалгана” гэж өөрчлөх.

6.3. ШҮҮГЧИЙН САХИЛГЫН ХЭРГИЙН ХӨӨН ХЭЛЭЛЦЭХ ХУГАЦАА

Сайн туршлага

Бусад улсын туршлагаас үзэхэд шүүгчийн сахилгын зөрчилд хөөн хэлэлцэх хугацааг үйлчилдэг болон үйлчилдэггүй гэсэн хоёр хэлбэр байдаг. Хүний амьдралын, бизнесийн, улс орны хамгийн чухал маргаантай асуудлыг шийдвэрлэх эрх мэдлийг хэрэгжүүлж буй шүүгч нар олон нийтийн итгэлийг хүлээхүйц өндөр ёс зүйтэй байх үүрэгтэй. Шүүгчийн энэ үүргээ ноцтой эсхүл удаа дараа зөрчсөн сахилгын зөрчил олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг хамгийн ихээр унагадаг учраас тэвчишгүй байх ёстой. Ямар нэг хөөн хэлэлцэх хугацаа тогтоосон үед уг хугацааны дотор сахилгын хэрэг үүсгээгүй эсхүл сахилгын шийтгэл хүлээлгэж чадаагүй бол ямар ч ноцтой зөрчил гаргасан шүүгч хариуцлагаас мултрах боломжтой. Тиймээс, хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэх ёсгүй гэж үздэг. Жишээлбэл, Америкийн хуульчдын холбооноос зөвлөсөн Шүүгчийн сахилгыг сахиулах загвар дүрмийн 18-р дүрмийн 10-т шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд хөөн хэлэлцэх хугацаа үйлчлэхгүй хэмээн заасан.²²⁰ АНУ-ын муж улсуудын шүүгчийн сахилгын тогтолцоонд мөн хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэггүй. Мөн, Канадад шүүгчид сахилгын шийтгэл ногдуулахад хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэггүй. Канадын Нова Скота мужийн Дээд шүүхийн шүүгч Роберт Вraith “Канад улсад хөөн хэлэлцэх хугацааг энэ тохиолдолд тооцохгүй. Миний үзэж буйгаар Монголд байдгийн адил богино хугацаатай байх нь шүүхэд итгэх олон нийтийн итгэлд сөргөөр нөлөөлнө хэмээн үзэж байна” гэжээ.²²¹

Хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэг улсууд “гомдол мэдээлэл гаргах эрх бүхий субъектүүд тухайн цаг үед нь мэдээлэл гаргаснаар фактыг үнэн зөв шийдвэрлэх боломжтойн дээр зарим сахилгын

²²⁰ “Model Rules for Judicial Disciplinary Enforcement.”

²²¹ Роберт Вraith, “Шүүгчийн ёс зүй, сахилга: Канадын туршлага,” Шүүгчийн ёс зүй ба сахилга: олон улсын бага хурал: илтгэл, зөвлөмж, судалгаа дотор (Монгол Улсын Шүүхийн ёс зүйн хороо, 2017), 26.

зөрчил тодорхой хугацааны дараа өөрөө арилах боломжтой"²²² гэж тайлбарладаг. Гэхдээ, хөөн хэлэлцэх хугацааг олон жилээр уртаар тогтоож өгдөг. Жишээлбэл, Италид сахилгын зөрчлийг мөрдөн шалгах ажиллагаа 2 жилээс урт хугацаанд үргэлжилсэн, Шүүхийн дээд зөвлөл 2 жилийн дотор шийдвэрээ гараагүй, эсхүл сахилгын зөрчил гарснаас хойш 10 жилийн дараа мэдсэн бол сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгодог.²²³ Бельгид сахилгын асуудал хариуцсан этгээд зөрчлийн үйл баримтын талаар мэдсэнээс хойш 6 сарын дотор уг зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх ёстой ажээ.²²⁴ Францад гомдол гаргагч тухайн хэрэгт холбогдох эцсийн шийдвэр гарснаас хойш 1 жилийн дотор гомдол гаргаж болох боловч Хууль зүйн сайд, Давж заалдах шатны шүүхийн тэргүүн зэрэг эрх бүхий этгээдээс Шүүхийн зөвлөлд хүсэлт гаргахад ийм хугацаа үйлчилдэггүй.²²⁵ Хууль зүйн сайд нь иргэний гомдол, мэдээллийг шалгасны үндсэн дээр хүсэлт гаргах боломжтой учраас Хууль зүйн сайдад шүүгчийн сахилгын зөрчлийн талаар гомдол, мэдээлэл гаргахад хугацаа байхгүй ажээ.

ХБНГУ-ын Бавари мужид төрийн жинхэнэ албан хаагчийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгахад шалгахад хөөн хэлэлцэх хугацаа тогтоодоггүй бөгөөд шийтгэл оногдуулахад тухайн зөрчлийн шинж байдлаас хамааруулан ялгамжтай хугацаа тогтоодог гэж Улсын дээд шүүхийн шүүгч П.Соёл-Эрдэнэ бичжээ:

[ХБНГУ-ын] сахилгын зөрчлийн хуульд "хөөн хэлэлцэх хугацаа" гэсэн ойлголт байдаггүй. Энэ ойлголтыг зөвхөн эрүүгийн эрх зүйн ойлголт гэж үздэг... Иймээс сахилгын зөрчил үйлдэгдсэнээс хойш урт удаан хугацаа өнгөрсний дараа ч мөрдөн шалгаж болно. ...Сахилгын зөрчил үйлдэгдсэнээс хойш 2-оос дээш жил өнгөрсөн бол сануулга өгөх, мөнгөн торгууль оногдуулах арга хэмжээ

²²² Д.Баттулга, "Шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд үйлчлэх хөөн хэлэлцэх хугацаа," 40.

²²³ Di Federico, "Judicial Independence in Italy," 381.

²²⁴ "Securing Justice: The Disiplinary System For Judges in the Russian Federation" (ICJ, December 2012), 31.

²²⁵ "Securing Justice: The Disiplinary System For Judges in the Russian Federation," 31.

авч болохгүй, ...3-аас дээш жил өнгөрсөн бол цалин хасах арга хэмжээ авч болохгүй, ...7-оос дээш жил өнгөрсөн бол албан тушаал бууруулах арга хэмжээ авч болохгүй. Харин төрийн албанаас халах хэмжээний зөрчил үйлдсэн бол сахилгын шийтгэлд ямар нэг хугацааны хязгаарлалт тавиагүй. Өөрөөр хэлбэл ажлаас халагдах шийтгэл хүлээх хэмжээний хүнд, ноцтой сахилгын зөрчилд үйлдсэн төрийн жинхэнэ албан хаагчийн үйлдсэн хэрэг 10 жилийн хойш илэрсэн байсан ч ажлаас халах сахилгын шийтгэл оногдуулж болно.²²⁶

Эндээс үзэхэд Бавари мужид төрийн жинхэнэ албан хаагчид шүүгч хамаарах бөгөөд эдгээрийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгахад хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэггүй байна. Мөн, зөрчлийн шинж чанараас хамааруулан хөөн хэлэлцэх хугацааг 2, 3, 7 жил гэсэн урт хугацаагаар тогтоосон байх ч ажлаас халах хэмжээний ноцтой зөрчилд хөөн хэлэлцэх хугацаа тавьдаггүй ажээ.

Шилжилтийн улсуудын хувьд ч харьцангуй урт хөөн хэлэлцэх хугацаа тавьж өгч байна. Польшийн хувьд сахилгын зөрчил гаргаснаас хойш 3 жилийн дотор сахилгын хэрэг үүсгэх бөгөөд зөрчил гарснаас хойш 5 жил өнгөрсөн бол хариуцлага хүлээлгэдэггүй, Босни-Герцеговин, Гүржид сахилгын зөрчил гарснаас хойш 5 болон түүнээс дээш жил өнгөрсөн бол шүүгч, прокурорын эсрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй ажээ.²²⁷ ОХУ-д шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхэд хөөн хэлэлцэх хугацаа үйлчилдэггүй бөгөөд ОХУ-ын Дээд шүүх Хөдөлмөрийн тухай хуульд буй хөөн хэлэлцэх хугацаа шүүгчийн сахилгын зөрчлийн талаар гомдол гаргахад үйлчлэхгүй гэж шийдсэн.²²⁸

²²⁶ П.Соёл-Эрдэнэ, "Төрийн жинхэнэ албан хаагчийн үйлдсэн сахилгын зөрчил ба хөөн хэлэлцэх хугацаа."

²²⁷ Д.Баттулга, "шүүгчийн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэхэд үйлчлэх хөөн хэлэлцэх хугацаа," 40. Гүржийн Шүүгчийн сахилгын хариуцлагын болон сахилгын процессын тухай хуулийг 3.

²²⁸ "Securing Justice: The Disiplinary System For Judges in the Russian Federation," 29.

Монгол Улс

1993 оны ШТХ-ийн 45-р зүйл, 2002 оны ШТХ-ийн 54, 56-р зүйлд шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх маш богино хугацаа зааж байсан. Тухайлбал, 2002 оны хуулийн 54.2-т "Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл оногдуулахгүй" гэж байсан. Гэвч, 2012 оны Шүүхийн тухай багц хуулийн шинэчлэлийн хүрээнд энэхүү хөөн хэлэлцэх хугацаанаас татгалзаж, өмнөх хуулийн энэ талаарх зохицуулалтыг хассан.

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуульд шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхэд баримтлах хөөн хэлэлцэх хугацааны талаар тодорхой тусгаагүй байхад Хуульчдын холбооны Шүүгчдийн хороо Шүүгчийн ёс зүйн дүрмээр ийм хугацааг 2014 онд тогтоосон. Ийнхүү тогтоохдоо 1993, 2002 оны ШТХ-иудад байсан шиг маш богинохон хугацаа тавьсан. Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийг Монгол Улсын Ерөнхийлөгч батлах бөгөөд тус хороо нь Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн хурлаар батлагдсан Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн эсэх асуудлыг хянан шийдвэрлэдэг. Энэ хоёр дүрмийн аль алинд нь шүүгчийн сахилгын зөрчил хянан шийдвэрлэх хөөн хэлэлцэх хугацааг зааж өгчээ. Гэтэл, хоёр дүрмийн хөөн хэлэлцэх хугацаа нь өөр өөр байх бөгөөд сонголттой хувилбар үүсэж, тодорхойгүй байдал үүсгэжээ. Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 5.1.7-д "Шүүгчид холбогдох сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш зургаан сар, зөрчил гаргаснаас хойш нэг жил өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй" гэж заасан бол ШЁЗД-ийн 5.1.3-д "Ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар, зөрчил гаргаснаас хойш 6 сараас илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй" гэж заасан.

Дээрх хугацаанд шинжилгээ хийж үзэхэд ШЭЗБТХ-ийн 34.1-т "Ёс зүйн хорооны гишүүн гомдол, хүсэлтийг хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгана," 35.1-т зааснаар "Ёс зүйн хороо сахилгын хэргийг 30 хоногийн дотор нийт гишүүний олонхын ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ," Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3.3.2 дахь хэсэгт "Ёс зүйн хорооны дарга шаардлагатай тохиолдолд гомдол

шалгах хугацааг 30 хоногоор нэг удаа сунгаж болно" зэргээс үзэхэд сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхэд дор хаяж 1-3 сарын хугацаа зарцуулахаар байна. Гэтэл, шүүгчийн сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 1 сар өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулж болохгүй гэсэн заалт хэрэгжих боломжгүй шахуу болж байна. Үүнээс гадна хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг тасалдах (зогсоох) зохицуулалт байхгүй тул зөрчил гарснаас хойш тухайн шүүгчид хөөн хэлэлцэх хугацаанд багтааж сахилгын шийтгэл хүлээлгэж чадах эсэх нь хууль зүйн хувьд тодорхойгүй. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх (цаашид "ЗХДЗШШ" гэх) хэд хэдэн сахилгын хэрэг дээр хөөн хэлэлцэх хугацааг тасалдуулахгүйгээр үргэлжлүүлэн тоолж байсан бол УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол "шүүгчийн ёс зүйн зөрчилд оногдуулсан сахилгын шийтгэлийн хууль зүйн үндэслэлийг хянан шалгасан хугацаа нь Иргэний хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1 дэх хэсэгт зааснаар хөөн хэлэлцэх хугацаа тасалдсан" байна гэж дүгнэсэн.²²⁹

Хууль дээдлэх ёс хэрэгждэг бусад улсад шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэхэд хөөн хэлэлцэх хугацааг тогтоодоггүй эсхүл хэдэн жилээр тогтоодог. Гэтэл, Монгол Улсын хувьд шүүгчийн сахилгын зөрчилд хөөн хэлэлцэх хугацаагч 6 сар, 1 жил гэж хэт богино тогтоосон нь шүүгчид хариуцлага тооцох механизмыг сулруулж, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг унагах нэг шалтгаан болж байна. Жишээлбэл, ЗХДЗШШ болон УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаан дараах шүүгчийн сахилгын зөрчил гарсныг хүлээн зөвшөөрсөн боловч хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэсэн үндэслэлээр тухайн сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгож байсан:²³⁰

²²⁹ УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 297, 2016.10.12.

²³⁰ ЗХДЗШШ болон УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаан нь ШЁЗХ-ны бусад магадлалыг хүчингүй болгоход баримталсан үндэслэлүүдэд хөөн хэлэлцэх хугацаа дууссаныг мөн дурдсан байдаг. Жишээлбэл, ШЁЗХ-ны магадлал, Дугаар 45, 2014.09.05; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар ш/14, 2014.11.12; УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 11, 2015.01.12; ШЁЗХ-ны магадлал, Дугаар 62, 2015.10.22; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар 579, 2015.12.16; УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 51, 2016.02.22.

- "...2009 оны 3 сарын 25-ны ...өдөр иргэн Ц.Т шүүгч Р.А-гийн ажлын өрөөнд цүнх барьж ороод шүүгч Р.А-тай уулзан уг цүнхийг түүнд өгсөн нь камерын бичлэг (CD) болон түүнийг буулгасан зургаар нотлогдож байна" гээд "...дүүргийн шүүхэд шийдвэрлэгдэхээр хэрэг нь хянагдаж байсан "BBB" ХХК-ий захирал С.Э-ийн нөхөр Ц.Т шүүгч Р.А-тай уулзан цүнхтэй зүйл өгснийг шүүгч Р.А хүлээн авсан" нь шүүгчийн сахилгын зөрчил хэмээн Шүүхийн ёс зүйн хороо үзэж шүүгч Р.А-д цалин бууруулах сахилгын шийтгэл ногдуулсан магадлал гаргасан. ЗХДЗШШ болон УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдаан тус магадлалыг хянахдаа шүүгч Р.А-гийн үйлдлийг шүүгчийн сахилгын зөрчил байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн боловч "уг үйлдлээс хойш 4 жил гаруй хугацаа өнгөрсөн, өөрөөр хэлбэл сахилгын шийтгэл ногдуулж болох хугацаа өнгөрсөн" гэх үндэслэлээр хорооны уг магадлалыг хүчингүй болгож шийдвэрлэсэн.²³¹
- Шүүх хуралдааны тэмдэглэл хуульд заасан хугацаанд бүрэн гүйцэд бичигдсэн эсэхэд шүүх хуралдаан даргалагчийн хувиар хяналт тавиагүйгээс хуулийн хугацаанд бүрэн гараагүй, мөн, шүүхийн шийдвэрийг хууль заасан хугацаанд бичиж гаргаагүй зөрчил гаргасан гэж Шүүхийн ёс зүйн хороо үзсэнийг хүлээн зөвшөөрсөн боловч уг зөрчил гарснаас хойш ШЁЗД-ийн 5.1.3-д заасан 6 сарын хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн гэсэн үндэслэлээр тухайн шүүгчид сануулах шийтгэл ногдуулсан хорооны магадлалыг хүчингүй болгосон²³²
- Шүүгч "...эрүүгийн хэргийг давж заалдах журмаар хянан хэлэлцэхдээ хохирогч гэх хүмүүсээс үүнээс өмнө "гичий" гэж хэлүүлж байсан эсэх, өөрийн байгууллагын үйлчлэгч ажилтанд ингэж хэлүүлснээр та бүгдийн нэр хүнд хир унасныг болон учирсан хор уршиг, үр дагаврыг нотолсон

²³¹ ШЁЗХ-ны магадлал, Дугаар 32, 2014.07.03; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар ш/07, 2014.10.08; УДШ-ийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоол, Дугаар 279, 2014.12.01.

²³² ШЁЗХ-ны магадлал, Дугаар 63, 2016.12.08; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар 221/МА2017/0141, 2017.02.15.

баримт бичиг хэрэгт байхгүй байна, хүнийг эрүүгийн ялаар шийтгэнэ гэдэг хариуцлагатай зүйл шүү, ноцтой аюультай биш асуудлыг эрүүгийн гэм бурууд тооцоод байвал зөв биш байх шүү гэж прокурор, хэргийн оролцогчоос асуусан"-ыг шүүгчийн сахилгын зөрчил гэж Шүүхийн ёс зүйн хороо үзээд цалин бууруулах шийтгэл ногдуулсан магадлал гаргасан. Гэвч, ЗХДЗШШ-ээс уг магадлалыг дараах үндэслэлээр хүчингүй болгосон: "...шүүгчийн ёс зүйгүй авирласан гэж гомдол гаргасныг 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдөр Шүүхийн сахилгын хороо /хуучин нэрээр/ хүлээн авсан байх ба... Иймд сахилгын зөрчил илэрсэн 2013 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс хойш Шүүгчийн ёс зүйн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.17-д заасан шийтгэл ногдуулах хугацааг хэтрүүлэн 6 сар 25 хоногийн дараа буюу 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр шүүгч Д.М-д сахилгын шийтгэл ногдуулсан нь ...Шүүгчийн ёс зүйн дүрмийн... 5.1 дүгээр зүйлийн 3 дахь заалтыг зөрчсөн байна."²³³

- "1465 дугаар шийдвэрийг гүйцэтгэх ажиллагаа 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр эхэлснээс хойш 8 сар орчмын дараа буюу 2012 оны 07 дугаар сарын 09-ний өдөр шүүгч Д.У уг шийдвэрийг тайлбарлах тухай 1352 дугаар албан тоотыг гаргасан... нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 121.1-д заасан "гагцхүү уг шийдвэрийг биелүүлж эхлэхээс өмнө түүнийг хууль зүйн үндэслэлийг... тайлбарлаж болно" гэснийг илт зөрчсөн шүүгчид сануулах сахилгын шийтгэл ногдуулсан магадлалыг Шүүхийн ёс зүйн хороо гарсан. Хэдийгээр ЗХДЗШШ нь "шүүгч Д.У сахилгын зөрчил гаргасан тухай Шүүхийн ёс зүйн хорооны 82 дугаар магадлалын дүгнэлт зөв байна" гэсэн боловч Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн хэмээн тус хорооны магадлалын холбогдох хэсгийг хүчингүй болгосон."²³⁴

²³³ ШЁЗХ-ны магадлал, Дугаар 01, 2014.01.25; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар ш/4, 2014.06.25.

²³⁴ ШЁЗХ-ны магадлал, Дугаар 82, 2015.12.17; ЗХДЗШШ-ийн магадлал, Дугаар 06, 2016.02.25.

2012 оны Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу байгуулагдсан Хуульчдын холбооны Мэргэжлийн хариуцлагын хорооны маргаан шийдвэрлэх журмын 1.7-р зүйлд "Хөөн хэлэлцэх хугацаа зөрчил гарсан өдрөөс хойш гурван жил байна. Маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно" гэж заасан. Энэ журамд шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх хөөн хэлэлцэх хугацаанаас харьцангуй урт хугацаа тогтоож өгсний дээр хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсоох зохицуулалтыг оруулж, зөрчил гаргасан хуульчдад хариуцлага тооцох, хуульчдын нэр хүндийг хамгаалах боломжийг нэмэгдүүлж өгсөн. Мөн түүнчлэн, 2019 онд батлагдсан Өмгөөллийн тухай хуулийн 31.8-т "Өмгөөлөгч ёс зүйн зөрчил гаргаснаас хойш гурван жилийн хугацаа өнгөрсөн бол хариуцлага хүлээлгэхгүй" гэж харьцангуй уртаар заасан байна.

ШТХ-ийн төслийн 59.2-д "Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй" гэж заасан нь 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх" гэж илэрхийлсэнтэй ноцтой зөрчилдөнө. Учир нь, шүүгчийн сахилгын зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараар тогтооно гэдэг бол Монгол Улсад хуульчийн болон өмгөөлөгчийн сахилгын зөрчилд хэрэгжиж байгаа хөөн хэлэлцэх хугацаанаас даруй гурав дахин богино төдийгүй олон улсын жишгээс хэт богино байна. Ийм хэт богино хөөн хэлэлцэх хугацаа зааснаар шүүгчийн сахилгын олон ноцтой зөрчилд сахилгын зөрчилд шийтгэл хүлээлгэх боломжгүй болно.

Ийм учраас уул хугацааг шүүгчид тавигдах өндөр шаардлагад нийцүүлэн уртасгах, хугацаа тоолохыг зогсоох зохицуулалтыг хуульчлах нь зүйтэй.

Санал: ШТХ-ийн төслийн 59.2-ийг "Шүүгчийн сахилгын зөрчил гарснаас хойш 5 жилээс илүү хугацаа өнгөрсөн бол сахилгын шийтгэл ногдуулахгүй бөгөөд гомдол, мэдээллийг Хороонд гаргаснаар хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг зогсооно. Энэ хуулийн 59.1.4-т заасан огцруулах шийтгэл ногдуулахаар зөрчил гаргасан бол хөөн хэлэлцэх хугацаа хэрэглэхгүй.

6.4. МӨРДӨН ШАЛГАХ ЧИГ ҮҮРЭГ БА БҮРЭН ЭРХ

Сайн туршлага

Хэрэгт хамааралтай нотлох баримтыг цуглуулах, хууль сануулж гэрчээс мэдүүлэг авах зэрэг ажиллагааг мөрдөн шалгах ажиллагаанд багтаадаг. Шүүгчийн ёс зүйн талаарх Бангалорын зарчмыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тунхаглалын 2.2-т "...Хороо зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаагаа хэвийн явуулахын тулд хуулиар тодорхой албадлагын эрх хэмжээгээр хангагдсан байна" гэж заасан.²³⁵ Европын шүүхийн зөвлөлүүдийн сүлжээнээс гаргасан баримт бичигт "шүүгчийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгах чиг үүрэгтэй субъект нь бичгийн болон аман нотлох баримт цуглуулж хэрэгт авах зэрэг боломжтой байх ёстой"²³⁶ гэжээ.

Хууль дээдлэх ёс төлөвшсөн орнуудын туршлагыг судалж үзэхэд шүүгчийн сахилгын асуудлыг хянан шалгаж байгаа субъектүүд мөрдөн шалгах бүрэн эрхтэй. Шүүгч сахилгын зөрчил гаргасан гэх гомдол ирсэн бол түүнийг мөрдөн шалгадаг. Гэмт хэргийн тухай гомдол мэдээлэл цагдаад ирэхэд гомдлыг заавал хүлээн авч шалгадаг шиг шүүгчийн сахилгын зөрчлийн талаарх гомдлыг ч заавал хүлээн авч шалгах ижил зарчим үйлчилдэг. Олон улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх институтэд нотлох баримт цуглуулах, гэрчээс мэдүүлэг авах зэрэг ажиллагаанд албадлага хэрэглэх боломжийг бүрдүүлэх ёстой гэж үздэг. Жишээ нь, Итали, Франц зэрэг улсад мөрдөн шалгах чиг үүргийг илтгэгч шүүгч, прокурор хэрэгжүүлдэг учраас угаас мөрдөн шалгах эрх мэдэлтэй байдаг. Франц, Польш зэрэг оронд шүүгчийн сахилгын хэргийг шалгахад эрүүгийн процессын хэм хэмжээ үйлчилдэг, АНУ-д шаардлагатай нотлох баримтыг гарган өгөөгүй, эсхүл гэрч худал мэдүүлэг өгсөн бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулдаг.²³⁷

²³⁵ П.Баярцэцэг, Монгол улс дахь шүүгчийн сахилгын процесс: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, Магистрын дипломын ажил, (УБ 2016), 28.

²³⁶ Мөн тэнд. European Network of Councils for the Judiciary, Minimum Judicial Standards V: Disciplinary Proceedings and Liability of Judges, 28.

²³⁷ Мөн тэнд, 28.

АНУ-ын олон мужид шүүхийн сахилгын хороо бий бөгөөд энэ хороо нь шүүгч, хуульч, иргэдээс бүрддэг. Иргэн, хуулийн этгээдийн гаргасан шүүгчид холбогдох гомдлын талаар мөрдөн шалгах бүрэн эрхийг шүүхийн сахилгын хороонд олгож хэрэгжүүлдэг.²³⁸ Америкийн хуульчдын холбооны Шүүгчийн сахилгыг сахиулах загвар дүрмийн 14-р зүйлийн 2-т "Энэ дүрмийн 17 дугаар зүйлийн 3-т заасан бүрэн мөрдөн шалгах ажиллагаагаар Сахилгын мэргэжилтэн мөрдөн шалгах чиг үүргээ гүйцэтгэх зорилгоор шүүгч болон гэрчийг зарлан дуудах хуудсаар дуудан ирүүлэх, шаардлагатай бичиг баримт болон нотлох баримтыг гаргуулах ажиллагааг албадан хийлгэж болно. Сахилгын мэргэжилтэн нь шалгах ажиллагааны хүрээнд шүүгчийн хүсэлтээр гэрчийг албадан ирүүлэх болон нотлох баримт гаргуулах бүрэн эрхтэй"²³⁹, 14-р зүйлийн 3-т "Албадан мэдүүлэг өгөх болон хуралдаанд оролцуулах бүрэн эрхийн хүрээнд Сахилгын мэргэжилтэн болон хариуцагч нь ёс зүйн асуудал шийдвэрлэх хуралдаан болон мэдүүлгийн үед гэрчийг албадан ирүүлэх болон холбогдох баримт бичгийг гаргуулахыг шаардаж болно", 14-р зүйлийн 4 буюу Албадан ажиллагааны хэрэгжилт хэсэгт "Мөрдөн шалгах үед албадан ирүүлэх, баримт бичиг албадан гаргуулах, гэрчээс мэдүүлэг авах шаардлагатай бол эдгээр ажиллагааг албадан гүйцэтгэнэ"²⁴⁰ гэж тус тус заасан. Дээрхээс үзэхэд АНУ-д шүүгчийн сахилгын зөрчлийг шалгахад мөрдөн шалгах чиг үүрэг төдийгүй бүрэн эрх нь хангалттай олгогдсон байх бөгөөд гэрчээс мэдүүлэг авах, гэрчийг хуралдаанд ирүүлэх, гэрчээс холбогдох баримт бичгийг гаргуулах, холбогдох нотлох баримтыг байгаа газраас нь гаргуулах бүрэн эрхтэй төдийгүй хэрэв шаардлагыг биелүүлээгүй бол албадан гүйцэтгүүлэх эрх мэдэлтэй. Үүний үр дүнд сахилгын зөрчлийг шалгахад ямар нэгэн хүндрэл үүсэхгүй ба бүрэн шалгаж, шүүгчийг сахилгын зөрчил гаргасан эсэхийг хангалттай нотлох боломжтой байдаг.

²³⁸ UNODC, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity, 12.

²³⁹ "Model Rules for Judicial Disciplinary Enforcement" (American Bar Association, 1994), <http://americanbar.org/groups/professionalresponsibility/modelrulesjudicialdisciplinaryenforcement.html>.

²⁴⁰ Мөн тэнд.

Монгол Улс

Шүүгчийн эрх зүйн байдлын тухай 2012 оны хуулийн 34.1-д Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн гомдол, хүсэлтийг шалгана гэж заасан. Мөн, Шүүхийн ёс зүйн хорооны дүрмийн 3.3.3-т дараах заалт бий: "гишүүн шаардлагатай гэж үзвэл Ажлын албаны ажилтнаар баримт, мэдээлэл бүрдүүлэх даалгавар өгч болно. Энэ тохиолдолд гишүүн захирамж гаргана. Захирамжид ажилтны хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон байна." Гишүүнд шалгах чиг үүрэг өгсөн эдгээр заалтаас өөр зохицуулалт хууль болон дүрэмд байхгүй. Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн шалгах чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлэх, ямар бүрэн эрх эдлэх талаар хуульчлаагүй.

Шүүхийн ёс зүйн хороонд сахилгын зөрчлийг шалгах чиг үүрэг байгаа боловч шалгах бүрэн эрх байхгүй. Шүүгчийн сахилгын зөрчил гаргасан эсэх нь шалгаж нотлоход төвөгтэй асуудал. Гэвч, гэрчээс хууль сануулж тайлбар авах, аливаа этгээдээс нотлох баримт гаргуулах, шинжээч томилох зэрэг бүрэн эрх Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн эсхүл Ажлын албанд өгөөгүй учраас шүүгчийн эсрэг гарсан гомдлыг бүрэн шалгах боломж хязгаарлагдмал. Шүүгчийн сахилгын зөрчлийн талаарх гомдлыг шалгах явцад ийм хүндрэл, бэрхшээлүүд тулгардаг гэж Шүүхийн ёс зүйн хорооны гишүүд үзэж байжээ:

"Хороонд гомдлыг бүрэн шалгах эрх мэдэл байхгүйгээс шүүгчийн ёс зүйн зөрчил гарсан эсэхийг нотолж чадахгүй хэрэгсэхгүй болж байна. Жишээ нь Мобикомоос шүүгч хэргийн нэг тал руу утсаар ярьсан эсэх мэдээллийг авч чадахгүйгээс энэ асуудал бүрэн шалгагдалгүй хэрэгсэхгүй болсон."

"Шүүгчийн ёс зүй зөрчсөн эсэх асуудлыг нотлох баримтаар хөдөлбөргүй тогтоох асуудал манай хорооны ажил. Гэтэл нотлох баримтыг гаргуулж авах, цуглуулах эрх мэдэлгүй байна. Иймд нотлох баримт цуглуулж чаддаг, шударгаар үнэлж чаддаг байх ёстой."

"Шүүгчдээс гаргаж буй зарим зөрчил нь шууд өөрсдөөс нь бус, шүүхийн ажилтнууд, өмгөөлөгчдөөс шууд хамаарах зүйл байна. Иймд Ёс зүйн хорооны хуралд гаргасан алдаа

нь шүүхийн нэр хүндэд нөлөөлдгийг ойлгуулахын тулд эдгээрийг дуудан оруулах бүрэн эрхийг Шүүхийн ёс зүйн хороонд өгөх [хэрэгтэй]."

"Шүүгчийн ёс зүйн зарим гомдлыг шалгахын тулд прокурор, мөрдөн байцаагч, шүүхийн ажилтнаас тайлбар авах шаардлага гарч байна. Гэтэл прокурор, мөрдөн байцаагч нар тайлбар өгөхөөс татгалзаж байгааг зогсоох, үндэслэлгүйгээр татгалзсан бол хариуцлага тооцдог болох хэрэгтэй."²⁴¹

Шалгах чиг үүрэгтэй боловч шалгах бүрэн эрхгүй байгаа нь үндэслэлтэй байж болох гомдлоос татгалзах, сахилгын хэргийг хэрэгсэхгүй болгох, улмаар шүүгчийн сахилгын хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоо төдийгүй шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг унагах үр дагавартай.

Шүүгчийн сахилгын хэргийг шалгаж, хангалттай нотлохгүйгээр буруутгах эсхүл нотлох баримт цуглуулж чадахгүй үндэслэлээр хариуцлагаас бултуулахын аль аль нь байж таарахгүй. Иймд ШТХ болон бусад хуулиар Шүүхийн сахилгын хороо нотлох баримт гаргуулан авах, гэрчээс хууль сануулж мэдүүлэг авах зэрэг зохицуулалтыг тусгах зайлшгүй шаардлагатай.

ШТХ-ийн төслийн 101.1.1-т Сахилгын хорооны гишүүн "гомдол, мэдээллийг шалгахтай холбогдуулан оролцогчийг дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах, хууль сануулж тайлбар авах" эрхийг хэрэгжүүлнэ гэсэн зохицуулалт орсон нь шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэж бодит үнэнийг тогтоодог болоход чухал алхам болно. Гэвч, уг төслөөр Сахилгын хорооны гишүүн "дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах" бүрэн эрхээ хэрэгжүүлтэл холбогдох этгээд ирэхгүй, нотлох баримт гаргаж өгөхгүй бол яах вэ, ямар хууль сануулж тайлбар авах вэ гэдэг тодорхойгүй байх бөгөөд буруутай этгээдэд хүлээлгэх санкцыг ШТХ болон түүнийг дагалдаж холбогдох хуулиудад оруулах нэмэлт, өөрчлөлтөд тусгаагүй байна. Тэгэхээр сахилгын зөрчлийг шалгахтай холбоотой эдгээр

²⁴¹ Мөн тэнд.

бүрэн эрх хэрэгжих баталгаагүй тунхаг төдий болж, шүүгч сахилгын зөрчил гаргасан эсэхийг бүрэн тогтоох боломж хязгаарлагдана, улмаар 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх" гэж илэрхийлсэн шаардлага зөрчигдөхөөр байна.

Сахилгын зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг бүрэн шалгаж тогтоох боломжыг Шүүхийн сахилгын хороонд олгож болох хоёр янзын хувилбар байна.

Хувилбар 1. Сахилгын зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн талаар шалгалт хийж буй Сахилгын хорооны шүүгч биш гишүүн нь Сахилгын хорооныхоо шүүгч гишүүнд хандаж хүсэлт тавих замаар "гомдол, мэдээллийг шалгахтай холбогдуулан оролцогчийг дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах, хууль сануулж тайлбар авах" ажиллагааг хийлгэж болох юм. Тангараг өргөсөн шүүгч гишүүн эдгээр ажиллагааг хийх бүрэн боломжтой. Энэ хувилбарыг сонгосон тохиолдолд Эрүүгийн хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага үүснэ.

Санал. Эрүүгийн хуулийн 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах), 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Худал мэдүүлэх), 21.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг (Худал орчуулах, хэлмэрчлэх), 21.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг (Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах)-т тус тус "шүүхэд" гэдгийг дараа "эсхүл Шүүхийн сахилгын хороонд" гэж нэмэх.

Хувилбар 2. Зөрчлийн тухай хуульд Сахилгын хорооны гишүүн "гомдол, мэдээллийг шалгахтай холбогдуулан оролцогчийг дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах" бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломж олгоогүй эсхүл "худал мэдүүлэг" өгсөн бол торгох шийтгэл ногдуулахаар зааж Зөрчил шалган шийдвэрлэх хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах боломжтой. Энэ тохиолдолд Сахилгын хорооны гишүүн уг асуудлаар татварын байцаагчтай төстэй бүрэн эрх эдэлж хэрэгжүүлнэ гэсэн үг (Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлийн 13 дахь хэсгийг харна уу). Энэхүү хоёр дахь хувилбар нь гомдол, мэдээллийг шалгах ажиллагааг шууд бие даан хэрэгжүүлэх бүрэн эрхийг Шүүхийн сахилгын гишүүн бүрт олгох учраас илүү үр нөлөөтэй төдийгүй гишүүдийн тэгш байдлыг хангах учраас нэг дэх хувилбараас давуу талтай.

Санал. Зөрчлийн тухай хуульд "15.71 дугаар зүйл. Шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах" гэсэн шинэ зүйл нэмж "Шүүхийн сахилгын хорооны гишүүн дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, шаардсан мэдээлэл, нотлох баримтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирүүлээгүй, гаргаж өгөөгүй, худал мэдүүлэг өгсөн, мэдээлэл, нотлох баримтыг устгасан, өөрчилсөн бол хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно" гэж заах, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт "6.32.Шүүхийн сахилгын хорооны гишүүн Зөрчлийн тухай хуулийн 15.71 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчил." гэж нэмэх.

6.5. ШАЛГАХ, НОТЛОХ БОЛОН ШИЙДВЭРЛЭХ ЧИГ ҮҮРГИЙГ ТУСГААРЛАХ

Сайн туршлага

Шүүгчийн сахилгын зөрчил гарсан тухай гомдлыг шалгах, нотлох чиг үүрэг болон үүсгэсэн сахилгын хэргийг шийдвэрлэх чиг үүргийг тус тус салгах нь олон улсын сайн туршлагад тооцогдож хүлээн зөвшөөрөгдсөн. Шүүгчдийн явцуу сонирхлоор ханддаг гэсэн буруутгалаас сэргийлэх, сахилгын процедурын шударга байдлыг хангах үүднээс шүүгчийн сахилгын хороо нь гомдол хүлээн авч мөрдөн шалгах ажиллагаа явуулах болон сахилгын хэргийг сонсож сахилгын арга хэмжээ ногдуулах эрх хэмжээнүүдийг давхардуулан хэрэгжүүлэх ёсгүй гэсэн санаа Киевийн зөвлөмжид тусгагдсан байдаг.²⁴² “Шүүхийн сахилгын хэргийг шийдвэрлэдэг байгууллага нь эдгээр хэргийг үүсгэх ёсгүй бөгөөд эдгээр хэргийг үүсгэж эрх хэмжээтэй хүнийг гишүүнээр байлгах ёсгүй”²⁴³ гэж Киевийн зөвлөмжид мөн бичжээ. Түүнчлэн, сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үүсгэж явуулах (прокурорын ялах чиг үүрэгтэй төстэй) эрх мэдэл болон уг хэргийг шийдвэрлэх эрх мэдлийг нэг гарт төвлөрүүлэх нь уг ажиллагаа төвийг сахисан, шударга байх шаардлагыг зөрчинө гэсэн олон зөвлөмжийг Венецийн комисс гаргаж байв.²⁴⁴ Үүнээс гадна, шүүгчийн сахилгын хэргийг шалгасан байгууллага тухайн шүүгчийг огцруулах шийдвэр гаргасан нь түүний төвийг сахисан байдлыг эргэлзээнд оруулсан тул Хүний эрхийн Европын конвенцын 6-р зүйлд заасан шударгаар шүүлгэх эрхийг зөрчсөн гэж Хүний эрхийн Европын шүүх шийдвэрлэж

²⁴² “Kyiv Recommendations On Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia,” 2.

²⁴³ Мөн тэнд, 6.

²⁴⁴ CDL-AD(2014)032, Joint Opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate of Human Rights and the Rule of Law (DGI) of the Council of Europe, on the draft Law on making changes to the Law on disciplinary Liability and disciplinary Proceedings of Judges of General Courts of Georgia, §16; CDL-AD(2010)026, Joint opinion on the law on the judicial system and the status of judges of Ukraine by the Venice Commission and the Directorate of Co-operation within the Directorate General of Human Rights and Legal Affairs of the Council of Europe, §74; CDL-AD(2002)015, Opinion on the Draft Law on Amendments to the Judicial System Act of Bulgaria, §5

байжээ.²⁴⁵ Тиймээс, мөрдөн шалгах чиг үүрэг болон нотлох баримтыг үнэлж шийдвэрлэх чиг үүргийг салгадаг.

Дэлхийн улсуудад шүүгчийн сахилгын хэргийг шалгах нотлох болон шийдвэрлэх чиг үүргийг салгаж буй туршлагыг хоёр ангилж болохоор байна. Нэг дэх хувилбар нь сахилгын хэргийг үүсгэх, шалгах, нотлох ажиллагааг бие даасан байгууллагад хариуцуулах бөгөөд энэ байгууллага нь сахилгын хэргийг эцэслэн шийдвэрлэх байгууллагаас тусдаа байдаг.²⁴⁶ Жишээлбэл, Албани, Болгар, Хорват, Франц, Испани, Гүрж зэрэг улсад шүүхийн зөвлөл дотор сахилгын хэргийг шалгах, нотлох чиг үүрэгтэй тусдаа нэгж байх бөгөөд энэ нэгж нь уг хэргийг шийдвэрлэдэггүй байна. Шүүгчдээс тохиолдлын журмаар аль нэгийг нь сонгож сахилгын хэргийг шалгах, нотлох ажиллагааг хийлгүүлэх зохицуулалт ч байдаг.²⁴⁷ Шүүхийн зөвлөл эсхүл сахилгын хороо нь сахилгын хэргийг мөрдөн шалгах болон шийдвэрлэх чиг үүргийг хоёуланг нь хэрэгжүүлж болохгүй²⁴⁸ гэсэн шалтгаанаар эдгээр чиг үүргийг өөр өөр байгууллагад хариуцуулдаг. Хоёр дахь хувилбар нь шүүгчийн сахилгын хэргийг шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүрэгтэй нэг бүрэлдэхүүн байх бөгөөд уг бүрэлдэхүүний аль нэг гишүүн сахилгын хэргийг шалгасан бол уг хэргийг шийдвэрлэхэд оролцдоггүй байна. Энэ тохиолдолд сахилгын хэргийг шалгах, нотлох чиг үүрэгтэй тусдаа байгууллага байхгүй гэсэн үг.²⁴⁹ Венецийн комисс “шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх явцад мөрдөн шалгах

²⁴⁵ ECtHR, *Kamenos v. Cyprus*, application no. 147/07, judgment of 31 October 2017, pars 102-110.

²⁴⁶ CDL-AD(2010)042, Interim Opinion on the Draft Law on the High Council for judges and Prosecutors (of 27 September 2010) of Turkey, §§50, 51.

²⁴⁷ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §§64, 68, 69 and 71

²⁴⁸ Lydia F. Muller, “Judicial Administration in Transitional Eastern Countries,” in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 946.

²⁴⁹ CDL-AD(2010)042, Interim Opinion on the Draft Law on the High Council for judges and Prosecutors (of 27 September 2010) of Turkey, §§50, 51.

эсхүл нотлох байдлаар оролцсон гишүүн нь тухайн сахилгын хэргийг шийдвэрлэхэд оролцож болохгүй" гэж үзсэн.²⁵⁰

Шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргүүдийг нэг субъектэд төвлөрүүлэхээс татгалзаж, өөр өөр этгээдэд хуваарилж хэрэгжүүлэхийг хууль дээдлэх ёсны үүднээс сайшаадаг. АНУ-д эдгээр эрх мэдлийг төвлөрүүлсэн болон хуваарилсан хоёр янзын загвар хэрэгжиж байна. Сахилгын хорооны шийдвэрийг Дээд шүүх хянах боломжтой тохиолдолд уг хороо мөрдөн шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргийг хэрэгжүүлэхэд шударгаар шүүлгэх эрх зөрчигдөхгүй гэж 20 мужийн дээд шүүхүүд шийдвэрлэсэн байна.²⁵¹ Гэвч, эдгээр мужуудыг судалж үзвэл хэдийгээр сахилгын хороо нь эдгээр чиг үүргийг хамтад нь хэрэгжүүлдэг боловч тусдаа сахилгын хуульчийг томилж шалгах, нотлох чиг үүрэг хэрэгжүүлэх хандлагатай байна. Жишээлбэл, Невада мужид аливаа этгээд мужийн эсхүл орон нутгийн шүүгчийн эсрэг гомдлоо Шүүгчийн сахилгын комиссоод гаргаж болох бөгөөд комисс эхний шалгалт хийсний дараа сахилгын хэрэг үүсгэхээс татгалзах эсхүл үүсгэж хуралдаанаар хэлэлцүүлэх шийдвэр гаргадаг. Үүний тулд Комисс хуралдаан бүрдээ сахилгын хуульчийг томилж шалгах, нотлох ажиллагаа хийлгэдэг²⁵² бөгөөд ихэнхдээ Ерөнхий прокурорын газар ажиллаж буй хуульчийг сонгодог. Комисс нь сахилгын зөрчлийг нотлох илэрхий, итгэл үнэмшил төрүүлэхүйц үндэслэл байгаа гэж үзвэл комиссоос томилогдож нотлох ажиллагаа хийж буй сахилгын хуульч энэ тухай дүгнэлт үйлдэж гарын үсэг зурдаг. Уг дүгнэлтийг шүүгчид хүргүүлэх бөгөөд шүүгч 20 хоногт тайлбар гаргах эрхтэй. Комиссын хуралдаанд нэг талаас уг сахилгын хуульч, нөгөө талаас шүүгч ордог бөгөөд сахилгын хуульч эсхүл шүүгч комиссын шийдвэрийн талаарх гомдлоо Дээд шүүхэд гаргах эрхтэй.

АНУ дахь эрх мэдлийг хуваарилсан загвар нь хос байгууллага бүхий бүтэц болон хос танхим бүхий бүтэц гэсэн хоёр хэлбэртэй. Хос байгууллага бүхий бүтцийн дагуу шүүгчийн эсрэг гомдлыг нэг

²⁵⁰ Venice Commission Opinion on the Laws on Disciplinary Liability and Evaluation of Judges of the Former Yugoslav Republic of Macedonia, CDL-AD(2015)042, 21 December 2015, par 78.

²⁵¹ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 414.

²⁵² Combs, "Judicial Discipline Commissions," 3.

байгууллага хүлээн авч шалгах, улмаар зөрчлийг нотолсон дүгнэлт үйлдэх чиг үүрэгтэй бол өөр нэг байгууллага уг дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх чиг үүрэгтэй байдаг (Alabama, Delaware, Illinois, Ohio, Oklahoma, Pennsylvania, West Virginia, Wisconsin гэсэн 8 мужид байна) бөгөөд хоёр дахь байгууллагын шийдвэр нь ихэнхдээ Дээд шүүхээр хянагддаг эсхүл хянагдах боломжтой байна.²⁵³ Хос бүрэлдэхүүн бүхий бүтэц нь шүүхийн сахилгын хороо гэсэн нэг байгууллагатай байх бөгөөд гишүүд нь мөрдөн шалгах болон шийдвэрлэх чиг үүргийг ээлжлэн гүйцэтгэдэг. Шүүгчийн эсрэг гомдлыг шалгаж, зөрчлийг нотолсон дүгнэлт гаргах чиг үүрэгтэй мөрдөн шалгах бүрэлдэхүүнд суусан гишүүн нь тухайн дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх бүрэлдэхүүнд орох ёсгүй бөгөөд хэлэлцэж шийдвэрлэх чиг үүрэгтэй бүрэлдэхүүний шийдвэрийн талаар Дээд шүүхэд гомдол гаргах боломжтой байдаг (Arizona, Florida, Kansas, North Carolina, South Carolina, Tennessee, Vermont, Wyoming гэсэн 8 мужид байна).²⁵⁴

Канад улсын холбооны шүүхийн шүүгчийн сахилгын асуудлыг шалгах болон шийдвэрлэх чиг үүргүүдийг салгаж өгсөн ажээ. Холбооны шүүхийн шүүгчийн эсрэг гомдлыг аливаа этгээд Канадын шүүхийн зөвлөлд гаргаж болдог бөгөөд нэргүй гомдол гаргахыг ч зөвшөөрдөг байна. Тус зөвлөлийн Шүүхийн ёс зүйн хороо (Judicial conduct committee)-ны дарга эсхүл дэд дарга нарын нэг нь уг гомдлыг авч үздэг бөгөөд энэ эхний шатанд ихэнх гомдол хэрэгсэхгүй болдог. Энэ эхний шатанд заримдаа шүүгчийн сахилгын зөрчил гаргасан гэх асуудлыг мөрдөн шалгуулахад гаднаас хуульч томилж оролцуулдаг байна.²⁵⁵ Энэ шатанд гомдол хэрэгсэхгүй болоогүй бол гурваас таван шүүгчийн бүрэлдэхүүн албан ёсны шалгах ажиллагаа явуулах эсэхийг шийдвэрлэдэг байна. Мужийн ерөнхий прокурор эсхүл холбооны Хууль зүйн сайд Канадын шүүхийн зөвлөлд гомдол гаргасан бол албан ёсны шалгах ажиллагаа шууд явуулдаг байна. Шүүхийн зөвлөлийн гишүүн мөрдөн шалгах болон албан ёсны шалгах ажиллагаа явуулахад оролцсон бол шүүхийн зөвлөл уг асуудлыг шийдвэрлэхэд оролцдоггүй талаар Мартин Л. Фридланд ингэж бичжээ:

²⁵³ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 414.

²⁵⁴ Gray, 415.

²⁵⁵ Friedland, "Appointment, Discipline and Removal of Judges in Canada," 60.

Мөрдөн шалгах ажиллагаа (investigation)-нд оролцсон Зөвлөлийн гишүүн – шүүгч нь шалгах ажиллагаа (inquiry)-нд оролцдоггүй. Шалгах ажиллагаанд оролцсон шүүгч Зөвлөлийн нийт гишүүдийн хуралдаанаар зөвлөлдөхөд оролцдоггүй. Тиймээс, мөрдөн шалгах болон шийдвэрлэх ажиллагааг хооронд нь зааглахад анхаарсан гэсэн үг. Миний бодлоор бол, АНУ-ын зарим мужид байдаг шиг мөрдөн шалгах болон шийдвэрлэх ажиллагааг ажлын байр болон хүний нөөцийн хувьд бүрэн тусгаарласан бүтэц илүү дээр юм.²⁵⁶

Фридландын бичсэнээр 5-7 гишүүдээр бүрдсэн Шалгах хороо (Inquiry Committee) албан ёсны шалгах ажиллагааг хэрэгжүүлдэг бөгөөд уг хорооны гишүүдийн олонхыг Шүүхийн зөвлөлийн гишүүд бүрдүүлэх боловч туршлагатай хуульчид болон шүүгчид тэнцвэртэйгээр бүрэлдэхүүнд багтдаг. Сахилгын хэргийг Шалгах хороонд танилцуулах үүрэг бүхий бие даасан зөвлөх (хуульч)-ийг томилдог. Шалгах хороо хаалттай явуулахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд хуралдаан нээлттэй явагддаг. Шүүхийн зөвлөл Шалгах хорооны дүгнэлтийг хүлээн авч Хууль зүйн сайдад зөвлөмж хүргүүлдэг.

Европын улсуудад мөрдөн шалгах, нотлох чиг үүрэг болон шийдвэрлэх чиг үүргийг ихэвчлэн салгасан байдаг. Эдгээр улсаас Австри, Франц болон Италийг авч үзье. Австрид хамтын удирдлагын нэг байгууллага сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, мөрдөн шалгаж, шийдвэрлэдэг боловч мөрдөн шалгасан гишүүд уг хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд ордоггүй.²⁵⁷

Мөрдөн шалгах ажиллагааг Франц зэрэг улсад Хууль зүйн яамны Шүүхийн үйлчилгээний ерөнхий хянан шалгагч нь Хууль зүйн сайдын даалгаснаар шүүгч (болон прокурор)-ийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгадаг бөгөөд Дээд шүүхийн ерөнхий шүүгч нь Сахилгын зөвлөл (Шүүхийн дээд зөвлөлийн Шүүгчийн сахилгын хэргийн бүрэлдэхүүн)-

²⁵⁶ Friedland, 61.

²⁵⁷ UNODC, Resource Guide on Strengthening Judicial Integrity and Capacity (New York: United Nations, 2011), 133; OSCE, ODIHR, “Note On International Standards And Good Practices Of Disciplinary Proceedings Against Judges” (Warsaw, 27 December 2018), 13.

ийн даргын хувьд гишүүдээсээ мөрдөн шалгагчийг томилж болдог.²⁵⁸ Хууль зүйн сайдын хяналт дор явагдсан Шүүхийн үйлчилгээний хянан шалгагчийн явуулсан мөрдөн шалгах ажиллагааны дараа Дээд шүүхийн Ерөнхий шүүгч эсхүл Хууль зүйн сайд фактын асуудлыг Сахилгын зөвлөлд танилцуулдаг бөгөөд Сахилгын зөвлөл нэг гишүүнээ мөрдөн шалгалт явуулж илтгэх үүрэгтэйгээр томилдог.²⁵⁹ Мөрдөн шалгах ажиллагаа дууссаны дараа нээлттэй хуралдаанд хариуцагчийг дууддаг. Хуралдааны үеэр Шүүхийн үйлчилгээний газрын дарга Хууль зүйн сайдын нэрийн өмнөөс ярьдаг бол илтгэгч гишүүн танилцуулгаа уншдаг.²⁶⁰ Уг танилцуулгад тулгуурлан Сахилгын зөвлөл зөвлөлдөх тасалгаанд зөвлөлдөж, шийдвэрээ гаргах бөгөөд шийдвэр нь хууль зүйн хувьд үндэслэгдсэн, олон нийтэд нээлттэй байдаг. Сахилгын зөвлөл нь сахилгын хэргийг шийдвэрлэх бөгөөд уг зөвлөлд Дээд шүүхийн ерөнхий шүүгч, таван шүүгч, нэг прокурор, Төрийн зөвлөлийн нэг гишүүн, нэг хуульч, бусад зургаан гишүүн багтдаг.²⁶¹

Италид Сахилгын хэргийг үүсгэх бүрэн эрх Хууль зүйн сайд болон Дээд шүүхийн Ерөнхий прокурорт байдаг бөгөөд ихэнх сахилгын хэргийг Ерөнхий прокурор үүсгэдэг. Дээд шүүхийн Ерөнхий прокурор нь өөрийнх нь анхааралд өртсөн бүх зөрчлийг мөрдөн шалгаж нотлох ажиллагаа явуулах ёстой.²⁶² Шүүхийн дээд зөвлөл нь сахилгын зөрчил байж болзошгүй асуудлыг Хууль зүйн сайд болон Ерөнхий прокурорт мэдэгдэж болох бөгөөд шүүхийн газрын тэргүүнүүд сахилгын зөрчлийн талаар мэдэгдэх үүрэгтэй. Хууль зүйн сайд, Ерөнхий прокурор, Шүүхийн дээд зөвлөл, шүүх газрын тэргүүнүүд иргэдийн гомдлыг авч үздэг. Шүүхийн дээд зөвлөлийн нэг нэгж болох Сахилгын комисс шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэдэг бөгөөд Шүүхийн дээд зөвлөл нууц санал хураалтаар гишүүдээсээ зургааг уг комиссын

²⁵⁸ Acquaviva Nais, Castagnet Florence, and Evangelhelou Morgane, "A Comparative Analysis of Disciplinary System for European Judges and Prosecutors" (The 7th edition of the THE-MIS Competition, 2012), 12.

²⁵⁹ Garapon, "Judicial Independence in France," 291.

²⁶⁰ Garapon, 291.

²⁶¹ Nais, Florence, and Morgane, "A Comparative Analysis of Disciplinary System for European Judges and Prosecutors," 10.

²⁶² Giuseppe Di Federico, "Judicial Independence in Italy," in *Judicial Independence in Transition*, ed. Anja Seibert-Fohr (Springer Science & Business Media, 2012), 381.

бүрэлдэхүүнд сонгодог. Сахилгын комиссыг Шүүхийн дээд зөвлөлийн дэд ерөнхийлөгч даргалж, парламентаас сонгогдсон нэг гишүүн, Дээд шүүхийн нэг шүүгч, гурван шүүгч багтдаг.²⁶³ Хууль зүйн сайд өөрийн хяналт шалгалтын газрын хуульчдаар мөрдөн шалгуулсны дараа сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх хүсэлт гаргадаг. Хууль зүйн сайд Ерөнхий прокурорын тодорхойлсон зөрчил дээр зөрчил нэмж оруулах боломжтой байдаг байна.²⁶⁴ Хэдийгээр Хууль зүйн сайд болон Ерөнхий прокурор хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх бүрэн эрхтэй боловч Ерөнхий прокурор албан ёсны мөрдөн шалгалт явуулж, Сахилгын комиссын өмнө нотлох чиг үүрэг гүйцэтгэдэг.²⁶⁵

Пост-коммунист зарим улсад шүүгчийн сахилгын зөрчлийг шалгах, хянан шийдвэрлэх чиг үүргийг өөр өөр субъект хэрэгжүүлж эхэлсэн байна. Тухайлбал, Польшид сахилгын төлөөлөгч сахилгын хэргийг шалгаж, сахилгын шүүх шийдвэрлэдэг.²⁶⁶

Монгол Улс

Шүүхийн захиргааны тухай 2012 оны хуулийн 33.2-т зааснаар Шүүхийн ёс зүйн хорооны гишүүд нь сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах, гомдол, хүсэлтийг шалгаж, дүгнэлт гаргах, сахилгын хэргийг шалгаж, шийдвэрлэх бэлтгэл хангах, ажлыг зохион байгуулах, Шүүхийн ёс зүйн хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох зэрэг эрх, үүргийг хэрэгжүүлэхээр хуульд заажээ. Үүнээс үзвэл Шүүхийн ёс зүйн хорооны гишүүн нь сахилгын хэрэг үүсгэх, сахилгын хэргийг шалгах, сахилгын хэргийг шийдвэрлэх гэсэн гурван чиг үүргийг нэг дор хэрэгжүүлж байна. Одоогийн Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд зааснаар гишүүн сахилгын зөрчлийг шалгах, нотлох, шийдвэрлэх бүх чиг үүргийг давхар хэрэгжүүлж, шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх процессын бүх үе шатанд оролцдог.

²⁶³ Nais, Florence, and Morgane, "A Comparative Analysis of Disciplinary System for European Judges and Prosecutors," 10.

²⁶⁴ Garapon, "Judicial Independence in France," 381.

²⁶⁵ Di Federico, "Judicial Independence in Italy," 382.

²⁶⁶ П.Баярцэцэг, Монгол улс дахь шүүгчийн сахилгын процесс: тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам, Магистрын дипломын ажил, (УБ 2016), 63.

Шүүхийн тухай хуулийн төслийг шинээр боловсруулахдаа дараах гурван үндэслэлээр шүүгчийн сахилгын зөрчил гарсан тухай гомдлыг шалгах, нотлох чиг үүргийг хэрэгжүүлсэн этгээд тухайн хэргийг шийдвэрлэх бүрэлдэхүүнд ордоггүй байх зохицуулалтыг оруулах шаардлагатай.²⁶⁷

Нэгд, шалгах, нотлох чиг үүрэг болон шийдвэрлэх чиг үүргийг салгах нь хороо үр нөлөөтэй ажиллах үндэс болно. Хорооны гишүүн нь орон тооны бус байвал үндсэн ажлын хажуугаар ачаалалтай ажиллана. Ийм нөхцөлд шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргийг хорооны гишүүн хамтад нь үр нөлөөтэй гүйцэтгэхэд цаг хугацаа хүрэлцдэггүй байх, дутуу дулимаг гүйцэтгэх магадлалыг нэмэгдүүлдэг.

Хоёрт, шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргүүдийг салгаж өөр өөр этгээд хэрэгжүүлэх нь процессын шударга байдалд илүү нийцдэг. Нэг хүн өөрөө шалгаж, нотлогдсон эсэхийг танилцуулсан хэргээ шийдвэрлэхэд таслах эрхтэй оролцох нь тухайн гишүүний төвийг сахисан байдлыг сулруулах эсхүл тийнхүү харагдах боломжтой. Шалгах, нотлох явцад тухайн асуудлаар тодорхой итгэл үнэмшилтэй болох боломжтой бөгөөд үүнийхээ дараа уг маргааныг хөндлөнгийн байр сууриас шийдвэрлэж чадах уу гэсэн шүүмжлэл гардаг. Түүнчлэн, Шүүхийн сахилгын хорооны үнэлдэг баримтад нотлох баримтын шаардлага тавигддаг болох хэрэгтэй. Энэ тохиолдолд тодорхой баримт нь шаардлага хангахгүй гэдгээр нотлох баримтад тооцогдохгүй болж болох ч түүнийг цуглуулсан этгээдийн итгэл үнэмшил хэвээр үлдэж хэргийг шийдвэрлэхэд нөлөөлөх боломжтой.

Гуравт, эдгээр чиг үүргүүдийг салгах нь шүүгчийн сахилгын хэргийн мөн чанарт илүү нийцнэ. Эдгээр чиг үүргийг салгахгүй бол хорооны гишүүн нэг талаас шалгах чиг үүрэгтэй боловч нөгөө талаас гомдлоо тодорхой хэмжээнд нотлохыг гомдол гаргагчид шууд бусаар үүрэгжүүлдэг. Гэвч, шүүгчийн сахилгын хэрэг нь маргааны талуудад нотлох үүрэг хүлээлгэдэг хувийн эрх зүйн маргаан биш, харин нийтийн ашиг сонирхол хөнддөг нийтийн эрх зүйн маргаан юм. Учир

²⁶⁷ Мэргэжлийн хариуцлагын хороо дотор эдгээр гурван чиг үүргүүдийг салгаж өөрөөр этгээдээр гүйцэтгүүлж байна. О.Мөнхсайхан, “Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2015) батлагдвал хуульчийн мэргэжлийн хариуцлагын тогтолцооны үр нөлөөтэй, хараат бус, шударга байдал алдагдана,” Шүүх эрх мэдэл, дугаар 3 (2015): 29–32.

нь, шүүгч сахилгын зөрчил гаргасан бол энэ нь шүүх болон хуульд итгэх олон нийтийн итгэлийг үгүй хийдэг ноцтой үр дагавартай. Тиймээс, шүүгчийн сахилгын хэргийн талуудад гомдол гаргагчийг багтааж ойлгохгүй байх хандлага бий.

Шүүгчийн сахилгын зөрчлийг шалгах, нотлох чиг үүрэг болон шийдвэрлэх чиг үүргийг салгах хэрэгтэй. Шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь хагас шүүхийн шинжтэй ажиллагаа тул эдгээр чиг үүргийг салгах нь илүү зохистой. Эрүүгийн процессод гэмт хэргийг мөрдөн шалгах чиг үүргийг мөрдөн байцаагч, яллах чиг үүргийг прокурор, гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тогтоож шийдвэрлэх чиг үүргийг шүүгч хэрэгжүүлдэг. Үүнтэй адил шүүгч сахилгын зөрчил гаргасан эсэхийг шударгаар тогтоохын тулд энэ чиг үүргүүдийг салгах шаардлага тулгарч байна.

Шүүгчийн сахилгын зөрчлийг мөрдөн шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргийг бүгдийг Сахилгын хорооны гишүүн гүйцэтгэвэл төвийг сахисан байр сууриа алдах эсхүл төвийг сахиагүй гэж хардагдах эрсдэлтэй. Гомдлыг мөрдөн шалгаж, нотолсон хорооны гишүүнд тухайн шүүгчийн талаар урьдчилсан таамаг үүссэн байж болох тул сахилгын зөрчлийг шийдвэрлэх явцад нэг тийш давамгайлах магадлалтай. Өөрөөр хэлбэл, сахилгын зөрчил гаргасан эсэхийг шалгаж, нотолж байгаа гишүүн хорооны хуралдаан дээр цагаатгах байр суурь барих эсэхэд олон нийт эргэлзэж магадгүй. Гэтэл, шүүх нь хариуцлагатай, хараат бус, нэр хүндтэй гэж үнэлэгддэг улсуудад ийм маргааныг мөрдөн шалгах, нотлох, шийдвэрлэх чиг үүргийг тусад нь салгадаг. Үүний үр дүнд ажил үүргийн хувиар нь нарийвчлагдан тус тусын чиг үүргээ хангалттай гүйцэтгэх төдийгүй эцсийн дүндээ шүүгчид хариуцлага тооцох механизм хангалттай сайн ажиллах, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлдэг.

ШТХ-ийн төслийг үзэхэд Сахилгын хорооны гишүүн нь өөрийн шалгасан сахилгын хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохоор байгааг өөрчлөх саналтай байна. Энэ нь 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Шүүгчид хариуцлага хүлээлгэх журмыг хариуцлага зайлшгүй байх" гэж илэрхийлсэнд бүрнээ нийцнэ.

Санал. ШТХ-ийн төслийн 109.5-д “Сахилгын хорооны тогтоолыг хэргийн оролцогчоос эс зөвшөөрч гаргасан гомдлыг давж заалдах журмаар гишүүдийн гуравны дөрвөөс доошгүйн ирцтэйгээр хянан хэлэлцэж, хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж магадлал гаргана.” гэсний араас “Энэ хуулийн 107.3-д заасны дагуу шалгалт хийсэн гишүүн сахилгын хэргийг нийт гишүүдийн хуралдаанд танилцуулах боловч тухайн хэргийг шийдвэрлэхэд оролцохгүй.” гэсэн өгүүлбэр нэмэх.

6.6. ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ШИЙДВЭРИЙГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХЭД ДАВЖ ЗААЛДАХ

Сайн туршлага

НҮБ-ын суурь зарчмын 20-д зааснаар Шүүгчийн эсрэг сахилгын арга хэмжээ авах, түдгэлзүүлэх, огцруулах ажиллагааг хараат бус хяналтаар хянуулах боломжтой байхыг шаарддаг. Шүүгч биш хүмүүсээс олонх нь бүрдсэн бүрэлдэхүүнээр шүүгчийн сахилгын зөрчлийг хянан шийдвэрлүүлэх нь шүүгчийн хараат бус байдалд халдах эрсдэлтэй байж болох ч уг бүрэлдэхүүний шийдвэрийн талаарх гомдлыг Дээд шүүхэд гаргах боломжтой байдаг учраас уг эрсдэлээс сэргийлж чаддаг. Олонх улсад шүүхийн сахилгын хорооны шийдвэрийн талаарх гомдлыг хамгийн дээд шатны шүүхэд гаргаж хянуулснаар давж заалдах эрх нь хангагдсанд тооцдог бөгөөд шүүхийн хоёр эсхүл гурван шатыг заавал дамжихыг шаарддаггүй. Жишээлбэл, АНУ-ын хувьд мужийн дээд шүүхэд гомдол гаргаагүй бол шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан шүүхийн сахилгын хорооны шийдвэр эцэслэгддэг эсхүл шүүхийн сахилгын хорооны шийдвэр зөвлөмж хэлбэртэй гарч Дээд шүүхээр хянагддаг байна.²⁶⁸ Шүүхийн сахилгын хороо Дээд шүүхийн шүүгчтэй холбоотой гомдлыг шийдвэрлэж түүнд гомдол гаргасан бол уг шүүгчтэй хамт ажилладаг шүүгчид

²⁶⁸ Cynthia Gray, A Study of State Judicial Disciplinary Sanctions, vol. 28 (AJS and SJI, 2002).

нь уг асуудлыг хянаж шийдвэрлэх болдог. Дээд шүүхийн шүүгчтэй холбоотой гомдлыг хянан шийдвэрлэх ажиллагааг хараат бус, төвийг сахисан байлгах төдийгүй ийм ойлголтыг олон нийтэд өгөхийн тулд АНУ-ын зарим мужид Дээд шүүхийнхээс өөр шүүгчдээр уг гомдлыг хянуулдаг байна. Хэд хэдэн мужид Дээд шүүхийн шүүгч сахилгын зөрчил гаргасныг шүүхийн сахилгын хороо тогтоосон бол түүнтэй холбоотой гомдлыг дээд шүүхийг орлох бүрэлдэхүүнээс хянуулдаг бөгөөд ийм бүрэлдэхүүнд ихэвчлэн давж заалдах шатны шүүгчдээс шодож эсхүл албан тушаалын эрэмбээр томилдог байна.²⁶⁹ Жишээлбэл, Пенсилвания мужийн Дээд шүүхийн шүүгчийн сахилгатай холбоотой эцсийн шийдвэрийг сугалаагаар сонгосон долоон шүүгчээс бүрдсэн тусгай бүрэлдэхүүн гаргадаг.²⁷⁰

Европын улсуудын хувьд ч шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн байгууллагын шийдвэрийн талаар шүүхэд гомдол гаргаж хянуулах боломжтой байдаг бөгөөд дийлэнхдээ Дээд шүүхэд ханддаг байна. Жишээлбэл, Францын Шүүхийн дээд зөвлөл (Сахилгын зөвлөл)-ийн шүүгчийн сахилгатай холбоотой шийдвэр Төрийн зөвлөл (Захиргааны дээд шүүх)-ээр хянагдах боломжтой. Шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийн талаарх гомдлыг хэлэлцэхдээ Төрийн зөвлөл нь хяналтын шатны шүүхийн үүрэг гүйцэтгэж, тухайн шийдвэр хэлбэрийн (харьяалал, процессын) болон агуулгын хувьд хуульд нийцсэн эсэхийг л хянадаг бөгөөд тухай сахилгын хэргийн фактын асуудлыг хянадаггүй.²⁷¹ Мөн, Италийн Шүүхийн дээд зөвлөлийн Сахилгын комиссын шийдвэр дахь хуулийн асуудлаар Дээд шүүхийн иргэний танхимд гомдол гаргах боломжтой.²⁷²

Монгол Улс

2014-2018 онд Шүүхийн ёс зүйн хорооны сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийн 30 буюу 61.2%-ийг хүчингүй болгож, 6 буюу

²⁶⁹ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 417.

²⁷⁰ Combs, "Judicial Discipline Commissions," 10.

²⁷¹ Garapon, "Judicial Independence in France," 292.

²⁷² Di Federico, "Judicial Independence in Italy," 382.

8.1%-ийг дахин шалгуулахаар буцааж, 2 буюу 0.4%-ийг сахилгын шийтгэлийн төрлийг өөрчилж, 11 буюу 4.4%-ийг сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрийг хэвээр баталж шийдвэрлэсэн байна.²⁷³ Шүүхийн ёс зүйн хорооноос сахилгын шийтгэл ногдуулсан дийлэнх магадлалыг шүүхээс хүчингүй болгож ирсэн нь тус хорооны шийдвэрийг шүүхийн хяналтаас гаргах саналыг гаргахад хүргэсэн. Жишээлбэл:

Одоогийн байдлаар Шүүхийн ёс зүйн хороонд хариуцлага тооцох шийдвэр гардаг хэдий ч ихэнх нь шүүх дээр очоод хэрэгсэхгүй болдог байдал давамгайл байна. Шүүхийнхээ хяналтад зориуд аваачаад шүүгч нар нь шүүгч нараа өмгөөлж хамгаалаад хариуцлага тооцож чадахаа байчихлаа гэдэг олон нийтийн хардлага хүчтэй байна. Тийм учраас ёс зүйн хорооны доторх хяналт механизмыг илүү нарийн болгож, эрх зүйн орчныг нь сайн болгоод ШЁЗХ-ны шийдвэр эцсийн байдаг болгоход болохгүй зүйл байхгүй.²⁷⁴

2012 оны Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуулиар уг хорооны шийдвэрийн талаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах боломжтой болсноороо шүүгчийн хараат бус байдалд зүй бусаар халдахаас хамгаалсан баталгаа болсон. Шүүхийн сахилгын (ёс зүйн) хорооны шийдвэрийг шүүхийн хяналтаас гаргана гэвэл тус хорооны бүрэлдэхүүний ядаж талыг шүүгчдийн төлөөллөөс бүрдүүлж байж шүүгчийн хараат бус байдалд зүй бусаар халдах эрсдэл буурна. Монгол Улсын хувьд ч Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүний олонх шүүгч биш байгаа тохиолдолд тус хорооны шийдвэрийг шүүхээс хянахыг бүхэлд нь үгүйсгэх бус харин оновчтой зохицуулах замаар шүүгчийн хараат бус байдал болон хариуцлагатай байдлын тэнцвэрийг олох боломжтой.

²⁷³ ШЁЗХ-ны статистик тоон мэдээлэл. ШЁЗХ-ны Ажлын албаны дарга Н.Ганбаатар. 2019 оны 01 дүгээр сар

²⁷⁴ “Шүүгчийн ёс зүй ба хариуцлага” сэдэвт хэлэлцүүлгийн үеэр Н.Лүндэндорж, хэлэлцүүлгийн тэмдэглэл, www.judoinstitute.mn, 2016 оны 4 сарын 26-нд үзсэн.

Олон улсын жишигт нийцүүлэн Шүүхийн сахилгын хорооны шийдвэр дэх хуулийн асуудлын талаарх гомдлыг зөвхөн Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимд гаргах боломжтойгоор зохицуулж, уг шүүхийн шийдвэр эцсийн болдог болох нь зүйтэй. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үр дагаварт, Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх төдийгүй Улсын дээд шүүхэд гомдол гаргах боломжтой болсноороо сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг хэт сунжруулж байна. Мөн, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчидтэй холбоотой гарсан шийдвэрийг хамт ажилладаг шүүгчид нь хянаж буй нь тийм ч зохисгүй зүйл биш бөгөөд шүүхийн хоёр шатыг дамжиж буй тохиолдолд үүнийг шийдвэрлэхэд төвөгтэй. Түүнчлэн, олон улсын сайн туршлагын дагуу Дээд шүүхийн шүүгчийн талаар гарсан Шүүхийн сахилгын хорооны шийдвэрт эрүү, иргэн, захиргааны хэргийн давж заалдах шатны шүүгчдээс таван шүүгчийг шодож гаргаад хянуулах зохицуулалт хийх боломжийг судлах нь зүйтэй.

Шүүхээс Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг хянах хүрээг оновчтой тодорхойлох боломжтой. "Шүүх бол хууль хэрэглээний байгууллага гэдэгт итгэлтэй байна. Шүүгч бол хууль хэрэглэж байж шийдвэрээ гаргадаг. Ёс зүйн асуудал дээр бол шүүх шийдвэрээ гаргахдаа ёс зүйн дүрэм баримтлаад шийдвэр гаргаад байгаа зөв, буруу эсэх дээр эргэлзээтэй байна" гэх шүүмжлэл гардаг.²⁷⁵ Шүүхээс тус хорооны шийдвэрт хэт их оролцож хянаж буйг шийдвэрлэх нэг гарц бол хяналтын шатны шүүхээс хорооны шийдвэр хэлбэрийн (харьяалал, процессын) болон агуулгын хувьд хуульд нийцсэн эсэхийг л хянадаг байхаар хуульчлах явдал. Энэ тохиолдолд шүүх тухай сахилгын хэргийн фактын асуудлыг хянахгүй. Тийм ч учраас, 2019.11.14-ний өдөр Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт оруулсан нэмэлт, өөрчлөлтийн "шүүгчийн хариуцлагыг дээшлүүлэх" гэсэн үзэл баримтлал, үүнийг УИХ-ын 2020.01.09-ний өдрийн 02 дугаар тогтоолын 3.2-т "Хорооны шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг гомдлын дагуу Улсын дээд шүүх эцэслэн хянах журмыг тогтоох" утгаар хууль боловсруулахыг заасан.

²⁷⁵ Мөн тэнд.

Санал: ШТХ-ын төслийн 111.4-т “Шүүхийн сахилгын хорооны магадлалыг хэргийн оролцогч эс зөвшөөрвөл түүнийг гардан авснаас хойш 14 хоногийн дотор хуулийг буруу тайлбарлаж хэрэглэсэн эсхүл хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн үндэслэлээр Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж нэмэх.

ШТХ-ын төслийн 111.5.5-д дараахыг нэмэх: “Улсын дээд шүүх сахилгын хэргийг дараахь байдлаар хянан шийдвэрлэж тогтоол гаргана:

111.5.1. магадлалыг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхих;

111.5.2. магадлалд өөрчлөлт оруулах;

111.5.3. магадлалыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгох;

111.5.4. магадлалыг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр Шүүхийн сахилгын хороонд буцаах.”

6.7. ИЛ ТОД БАЙДАЛ

Сайн туршлага

НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас 1985 онд дэмжсэн "Шүүхийн хараат бус байдлын тухай суурь зарчмууд"-ын 17-д "Эхний шатанд тухайн асуудлыг шалгах ажиллагаа нь шүүгч хүсэлт гаргаснаас бусад тохиолдолд хаалттай явагдана" гэж заасан байдаг. Сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхний шатанд шүүгчийн эрхийг хамгаалахын тулд хаалттай байх зарчим үйлчлэх²⁷⁶ боловч хэрэг хянан шийдвэрлэх сүүлийн үе шатанд олон нийтэд нээлттэй байх зарчим үйлчлэх, ялангуяа хуульд зааснаас бусад тохиолдолд сахилгын хэргийг шийдвэрлэх хуралдаан нээлттэй явах хэрэгтэй.²⁷⁷ Харин, Сахилгын хорооны хуралдааны товыг мэдэгдсээр байхад буруутгагдаж буй шүүгч эсхүл гомдол, мэдээлэл гаргагчаас хойшлуулах хүсэл ирүүлээгүй эсхүл удаа дараа ирээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй байхаар зохицуулах бөгөөд энэ нь Хорооны хуралдаанд ирэхгүй байх замаар хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахаас сэргийлэх хэрэгсэл болдог.²⁷⁸

АНУ-ын бүх мужид сахилгын зөрчил гарсан тухай гомдлыг мөрдөн шалгах бүх ажиллагаа хаалттай байдаг бөгөөд сахилгын

²⁷⁶ CDL-AD(2014)032, Joint Opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate of Human Rights and the Rule of Law (DGI) of the Council of Europe, on the draft Law on making changes to the Law on disciplinary Liability and disciplinary Proceedings of Judges of General Courts of Georgia, §§47-48.

²⁷⁷ CDL-AD(2014)032, Joint Opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate of Human Rights and the Rule of Law (DGI) of the Council of Europe, on the draft Law on making changes to the Law on disciplinary Liability and disciplinary Proceedings of Judges of General Courts of Georgia, §§26; CDL-AD(2011)033, Joint opinion on the draft law amending the law on the judiciary and the status of judges and other legislative acts of Ukraine by the Venice Commission and the Directorate of Justice and Human Dignity within the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, §60.

²⁷⁸ CDL-AD(2014)006, Joint opinion of the Venice Commission and the Directorate of Human Rights (DHR) of the Directorate General of Human Rights and Rule of Law of the Council of Europe, and of the OSCE Office for Democratic Institutions and Human Rights (OSCE/ODIHR) on the draft law on disciplinary liability of judges of the Republic of Moldova, §§77 and 78.

хороо нь шүүгчийн эсрэг гомдол ирсэн эсхүл шүүгчийн талаар мөрдөн шалгах ажиллагаа явуулж буй талаар мэдээлэл өгөх ёсгүй ажээ. Хаалттай мөрдөн шалгах ажиллагаа нь өс авах, буруутгах боломжийг хаах замаар гомдол чөлөөтэй гаргахыг болон гэрчийн мэдүүлэг өгөхийг хөхүүлэн дэмждэг; шалгагдаж нотлогдоогүй гомдлыг хэвлэн нийтлэхээс шүүгчийн хамгаалдаг; шүүгчийн зан үйл эсхүл чадамжийн талаар үндэслэлгүй гомдлыг олон нийтэд дэлгэхээс зайлсхийх замаар шүүхийн инстүүцэд итгэх олон нийтийн итгэлийг хадгалдаг.²⁷⁹ Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны зөрчлийг хянан шийдвэрлэх, гэмт хэрэг мөрдөх, шүүгчид нэр дэвшигчийг сонгох шалгаруулах зэрэг зүй ёсны зорилгоор эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөхийг мөрдөн шалгах ажиллагааны нууц хориглодоггүй байна. Харин, мөрдөн шалгах ажиллагааны үр дүнд шүүгч ёс зүйн зөрчил үйлдсэн гэх үндэслэл байвал нууцлал дуусгавар болж, энэ тухай шүүгчийг буруутгах дүгнэлт үйлддэг. Уг дүгнэлт, түүнд өгсөн шүүгчийн тайлбар, уг дүгнэлтэд үндэслэн сахилгын хэргийг хэлэлцэх хуралдаан, түүнээс гарсан шийдвэр зэрэг нь ил тод болдог.²⁸⁰

Шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа ил тод явагдах, уг хэргийг шийдвэрлэсэн шийдвэрийг хэвлэх нь сайн туршлагад тооцогддог. Ил тод болон хариуцлагатай байдлыг хангахын тулд шүүгчтэй гомдлыг хянан шийдвэрлэсэн шийдвэрийг хэвлэн нийтлэхийг хуулийн тодорхой зохицуулалтаар шаардах хэрэгтэй гэж Венецийн комисс үздэг.²⁸¹ Шүүгчид сахилгын шийтгэл хүлээлгэх чиг үүрэгтэй хорооны шийдвэр хэвлэн нийтлэгддэг байх хэрэгтэй гэж Киевийн зөвлөмжид мөн бичжээ.²⁸² Жишээлбэл, Франц, Итали зэрэг Европын улсуудад шүүгчид сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрүүд

²⁷⁹ Gray, 409–10.

²⁸⁰ Gray, 413.

²⁸¹ CDL-AD(2011)010, Opinion on the Draft Amendments to the Constitution of Montenegro, as well as on the Draft Amendments to the Law on Courts, the Law on the State Prosecutor's Office and the Law on the Judicial Council of Montenegro, §§41 and 44.

²⁸² OSCE ODIHR and Max Planck, Judicial Independence In Eastern Europe, South Caucasus And Central Asia: Judicial Administration, Selection and Accountability, (Expert Meeting in Kyiv, 23-25 June 2010), 7.

болон энэ талаарх Дээд шүүхийн шийдвэрүүдийг бусад шүүхийн шийдвэрийн нэгэн адил хэвлэдэг.²⁸³

АНУ-д шүүхийн сахилгын хэргийг шийдвэрлэх ажиллагааны ил тод байдлын талаар илүү нарийвчилсан зохицуулалттай. АНУ-ын холбооны шүүхийн шүүгчийн сахилгын зөрчил гаргасан гэх гомдол, түүнийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх товч мэдээллийг хэвлэхийн зэрэгцээ гомдлыг хэрэгсэхгүй болгосон эсхүл сахилгын шийтгэл ногдуулсан бүх шийдвэрийг хэвлэдэг.²⁸⁴ Нээлттэй шийтгэл ногдуулснаас бусад тохиолдолд холбогдох шүүгчийн нэрийг илчлэхгүйгээр хэвлэдэг байна. Муж улс дахь шүүгчийн сахилгын процесс илүү ил тод ажээ. Шүүгчийг албан ёсоор буруутгах дүгнэлт гаргасны дараа хянан шийдвэрлэх ажиллагааны хаалттай байдал дуусгавар болж, сахилгын хэргийг шийдвэрлэх хурал нээлттэй явагдахын зэрэгцээ нээлттэй сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэрүүд хэвлэн нийтлэгддэг.²⁸⁵ Түүнчлэн, холбооны болон муж улсын шүүгчийн эсрэг гомдол гаргах загвар болон холбогдох зохицуулалтыг цахим хуудастаа болон цаасан хэлбэрээр олон нийтэд хүртээмжтэй байлгадаг.

Монгол Улс

Шүүгчийн сахилгын зөрчил гарсан тухай гомдол, мэдээлэл гаргах журмын талаарх мэдээг ШЕЗ-ийн цахим хуудас дээр байрлуулахын²⁸⁶ зэрэгцээ Азийн сангийн санхүүжилтээр ийм агуулгатай хоёр төрлийн плакат хэвлүүлж Монгол Улсын зарим шүүх болон бусад байгууллагын иргэдэд мэдээлэл өгөх самбарт байрлуулсан. Мөн, шүүгчийн сахилгын зөрчилтэй холбоотой гомдол, мэдээлэл, сахилгын хэргийг хороо хэрхэн шийдвэрлэсэн тухай тоймыг ШЕЗ-ийн цахим хуудас дээр байршуулж хэвлэж ирсэн.

Шүүхийн ёс зүйн хорооны гишүүний гомдлыг шалгах чиг үүрэгтэй

²⁸³ Garapon, "Judicial Independence in France," 303; Di Federico, "Judicial Independence in Italy," 382.

²⁸⁴ Wheeler, "Judicial Independence in the United States of America," 553.

²⁸⁵ Gray, "How Judicial Conduct Commissions Work," 413.

²⁸⁶ Гомдол гаргах журам, <http://www.judcouncil.mn/ygshuun.html>

боловч уг шалгалт нь нууц эсхүл нээлттэй байх талаар хууль болон Шүүхийн ёс зүйн хорооны дүрэмд нарийвчлан заагаагүй байна. Мөн, гишүүний шалгалтын дүнг хянах гурван гишүүний хуралдаан нээлттэй эсхүл хаалттай явагдах эсэх нь тодорхой зохицуулагдаагүй бөгөөд ШЕЗ-ийн цахим хуудас дээр уг бүрэлдэхүүнээс гарсан тогтоолуудыг байрлуулж иржээ. Ингэхдээ гомдол гаргагч болон шүүгчийн нэр болон бусад мэдээллийг дардаггүй. Тиймээс, Шүүхийн ёс зүй хороо шүүгчийн сахилгын зөрчил гарсан тухай гомдлын 86 хувьд сахилгын хэрэг үүсгэхээс татгалздаг учраас үндэслэлгүй, нотлогдоогүй мэдээлэл хэвлэн нийтлэгдэж байна. Энэ нь тухайн шүүгчийн нэр хүндийг үндэслэлгүйгээр унагах, олон нийтийн шүүхэд итгэх итгэлд сэв суулгах шалтгаан болж байхыг үгүйсгэхгүй.

ШТХ-ийн төслийн 110.3-т "Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүдийн санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно" гэж заасан нь ил тод болон хариуцлагатай байх зарчмыг хангасан чухал зохицуулалт болжээ. Шүүгчийн нэр хүнд болон олон нийтийн шүүхэд итгэх итгэлийг хамгаалахын тулд сахилгын хэргийг хянан шийдвэрлэх хуралдааны өмнөх шат буюу гомдол мэдээллийг шалгах ажиллагаа нь хаалттай байх хэрэгтэй юм.

Санал: ШТХ-ийн төслийн 108.7-д "Хуульд өөрөөр заагаагүй бол гомдол, мэдээлэл шалгах ажиллагааг хаалттай явуулна" гэж заах.

Монгол Улсад шүүгчийн сахилгын хэргийг шийдвэрлэсэн Шүүгчийн сахилгын хорооны болон Шүүхийн сахилгын хорооны шийдвэрийг 2014 он хүртэл хэвлэж байгаагүй. 2014 оноос Шүүхийн ёс зүйн хорооны зарим шийдвэрүүд, түүнтэй холбоотой Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх магадлалыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудаст тусгай булан үүсгэж тавих болсон нь

дэвшилттэй болсон ч бүх шийдвэрүүд тавигдаагүй²⁸⁷ бөгөөд Улсын дээд шүүх (цаашид "УДШ" гэх)-ийн тогтоолыг энэхүү цахим хуудас дээр байрлуулдаггүй. Эдгээр шийдвэрийг цахим хуудас дээр хэзээ тавих талаар тогтсон журам байхгүй байгаа учраас энэ нь Шүүхийн ёс зүйн хорооны дарга, тус хорооны Ажлын албаны дарга, ШЕЗ-ийн цахим хуудас хариуцсан мэргэжилтэн зэрэг албан тушаалтны үзэмжээс хамаардаг.

Шүүхийн ёс зүйн хороо нь Монгол Улсад шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн өөрийн шийдвэрүүд болон тэдгээрийн талаарх гомдлын дагуу гаргасан Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх магадлал, Улсын дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны тогтоолуудыг Азийн сангийн дэмжлэгтэйгээр эмхэтгэл болгон 2017, 2019 онд хоёр удаа хэвлэсэн.²⁸⁸ Энэ нь Монгол Улсад анх удаа энэ төрлийн шийдвэрийг хэвлэсэн явдал болсон бөгөөд шүүгчийн ёс зүй болон сахилгын төлөвшилд өндөр хувь нэмэр болох алхам болсон. Гэвч, шүүгчийн сахилгын хэргийн шийдвэрийг цахим хуудаст байрлуулах болон эмхэтгэн хэвлүүлэх талаар хуулиар үүрэг болгоогүй учраас энэ сайн туршлага алдагдах эрсдэлтэй.

ШТХ-ийн төслийн 116.1-т "Гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны тогтоол, магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор ажлын албаны ажилтан цахим хуудсанд байршуулна" гэж заасан нь Сахилгын хорооны шийдвэрийг хэвлэн нийтэлж олон нийтээс шүүмж өгөх боломж олгох, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг хамгаалах чухал зохицуулалт болжээ. Гэвч, сахилгын хэргийг шийдвэрлэсэн төдийгүй

²⁸⁷ 2017.06.15-ны өдрөөс хойш тус хорооны магадлал ШЕЗ-ийн цахим хуудаст тавигдаагүй байна. Шүүхийн ёс зүйн хорооны магадлал, <http://judcouncil.mn/ys-magadlal/>; 2015.04.29-ний өдрөөс хойш ЗХДЗШШ-ийн магадлал цахим хуудаст тавигдаагүй байна. ЗХДЗШШ-ийн магадлал, <http://judcouncil.mn/davakhmagadlal/>

²⁸⁸ Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2013-2016) (Шүүхийн ёс зүйн хороо 2017); Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн шийдвэрийн эмхэтгэл: Шүүхийн ёс зүйн хорооны магадлал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх магадлал, Улсын дээд шүүхийн тогтоол (2017-2019) (Шүүхийн ёс зүйн хороо 2019).

сахилгын хэрэг үүсгэсэн эсхүл үүсгэхээс татгалзсан агуулгатай захирамж, тогтоол, магадлалыг ч хэвлэн нийтлэхээр өргөн хүрээтэй болсон нь сахилгын зөрчийн талаарх гомдол, мэдээлэл хаалттай явагдах зарчимтай зөрчилдөх эрсдэлтэй байна. Иймээс, Сахилгын хорооны зүгээс зөвхөн хэргийн агуулгыг эцэслэсэн шийдвэрийг хэвлэн нийтлэх байдлаар хүрээг нь хумьж заах саналтай байна.

Санал. ШТХ-ийн төслийн 116.1-ийг “Шүүгчид сахилгын шийтгэл оногдуулсан эсхүл сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, шүүгчийг цагаатгасан бол Сахилгын хорооны магадлал болон Улсын дээд шүүхийн тогтоол хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш долоо хоногийн дотор цахим хуудсанд байршуулна.” гэж өөрчлөх.

“Хуулийн төслийг 2020 оны 1 сарын 31-ний өдөр ХЗДХЯ-ны цахим хуудсанд нийтлэгдсэн хувилбараар шууг хуулбарлан авав.

ТӨСӨЛ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны ... дүгээр сарын ... -ны өдөр

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагаа, шүүгчид тавих болзол, шаардлага, бүрэн эрх, түүний эрх зүйн байдал, шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангах, Шүүхийн ерөнхий зөвлөл болон Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг тогтоох, шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Шүүхийн хууль тогтоомж

2.1. Шүүхийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. “шүүх” гэж Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдан хэрэг, маргааныг хянан шийдвэрлэж, заавал биелүүлэх шийдвэр гаргадаг шүүгч, шүүх бүрэлдэхүүнийг;

3.1.2. “дагнасан шүүх” гэж эрүү, иргэн, захиргаа зэрэг шүүн таслах ажиллагааны төрлөөр дагнан байгуулагдсан шүүхийг;

3.1.3. "шүүгч" гэж хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдон, шүүгчийн тангараг өргөсөн шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг;

3.1.4. "нөлөөллийн мэдүүлэг" гэж хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх үйлдлийг тэмдэглэн баталгаажуулсан баримт бичгийг;

3.1.5. "шүүгчийг сэлгэн ажиллуулах" гэж шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажлын дадлага эзэмшүүлэх туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүгчийг адил шатны өөр шүүхэд ажиллуулахыг;

3.1.6. "шүүгчийг шилжүүлэн ажиллуулах" гэж шүүхийг татан буулгах, өөрчлөн зохион байгуулах болон энэ хуульд заасан бусад тохиолдолд шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн адил шатны шүүхэд шилжүүлэн ажиллуулахыг.

4 дүгээр зүйл. Шүүхийн эрхэм зорилго

4.1. Шүүх дараах эрхэм зорилготой байна:

4.1.1. Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, Үндсэн хуульт байгууллыг бататган бэхжүүлж, хамгаалах;

4.1.2. хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсэн эрхийг сэргээн эдлүүлэх;

4.1.3. хууль дээдлэх, шударга ёсыг бэхжүүлэх;

4.1.4. хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, эрх зүйн соёлыг дэлгэрүүлэх.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХ ЭРХ МЭДЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗАРЧИМ

5 дугаар зүйл. Шүүхийн тогтолцооны нэгдмэл байдал

5.1. Монгол Улсын шүүхийн тогтолцоо /цаашид "Шүүхийн тогтолцоо" гэх/ нэгдмэл байх бөгөөд шүүх зохион байгуулалтын хувьд бие даасан байна.

5.2. Шүүхийн тогтолцоо, зохион байгуулалтыг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуулиар тогтоож, шүүхийн тогтолцооны нэгдмэл байдлыг хангана.

5.3. Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасны дагуу байгуулагдсан шүүх хэрэгжүүлнэ.

5.4. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

6 дугаар зүйл. Шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдал

6.1. Шүүх эрх мэдэл бүрэн эрхээ хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс хараат бусаар бие даан хэрэгжүүлнэ.

6.2. Шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд захирагдаж, аливаа этгээдийн хүсэл зоригоос хараат бус байж шүүх эрх мэдлийг бие даан хэрэгжүүлнэ.

6.3. Бүх шатны шүүхийн шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, тухайлсан хэрэг, маргаантай холбоотой заавар өгөх, удирдамжаар хангах, шүүгчид тодорхой хэрэг, маргааныг нэр заан хуваарилах зэргээр шүүгчийн хараат бус байдалд халдахыг хориглоно.

6.4. Шүүх нь Монгол Улсын олон улсын гэрээгээр нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрөөс бусад гадаад, дотоодын хувь хүн, хуулийн этгээдээс аливаа хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглоно.

6.5. Бүх шатны шүүхийн шүүгчийн орон тоо нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдлыг хангаж, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд хүрэлцээтэй байна.

6.6. Шүүх бие даасан төсөвтэй байх бөгөөд шүүхээс үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөхцөлийг төр хангана.

6.7. Шүүхийн төсөв Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум, сум дундын, дүүргийн шүүх, дагнасан шүүхийн болон Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны төсвөөс тус тус бүрдэнэ.

6.8. Шүүхийн хэвийн үйл ажиллагааг тасралтгүй явуулах, дэмжлэг үзүүлэх, аюулгүй байдал болон судалгаа мэдээллээр хангах үндсэн чиг үүрэг бүхий захиргааны байгууллага байх ба түүний эрх зүйн байдалтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

6.9. Шүүх өөрийн байртай байх бөгөөд төрийн хамгаалалтад байна.

6.10. Шүүхийн байранд шүүн таслах ажиллагаанаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

7 дугаар зүйл. Шүүх хууль дээдлэх, гагцхүү хуульд захирагдах

7.1. Хууль дээдлэх нь шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.

7.2. Шүүхээр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

7.3. Шүүх хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн, хүчин төгөлдөр хууль, Монгол Улсын олон улсын гэрээг хэрэглэнэ.

7.4. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд хэрэглэх хууль, Монгол Улсын олон улсын гэрээ нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй, эсхүл

харшилсан гэж шүүх үзвэл тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлж, тухайн хууль, Монгол Улсын олон улсын гэрээний талаарх саналаа Улсын дээд шүүхэд гаргана.

8 дугаар зүйл. Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх

8.1. Монгол Улсад хүн бүр үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол болон бусад байдал, түүнчлэн хуулийн этгээдийн өмчийн хэлбэр, төрлөөс үл хамаарч хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

9 дүгээр зүйл. Мэтгэлцэх зарчим

9.1. Шүүн таслах ажиллагааг мэтгэлцэх зарчмын үндсэн дээр явуулна.

9.2. Шүүгдэгч, түүний өмгөөлөгч, нэхэмжлэгч, хариуцагч, тэдгээрийн төлөөлөгч, прокурор болон бусад оролцогчдыг шүүх хуралдаанд мэтгэлцэх эрхээ хэрэгжүүлэх боломжоор тэгш хангана.

9.3. Шүүх хуралдааны үеэр мэтгэлцэх журмыг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар зохицуулна.

10 дугаар зүйл. Гэм буруутайд тооцож үл болох

10.1. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.

11 дүгээр зүйл. Шүүхийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо

11.1. Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ ил тод байдал, шударга ёс, олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор иргэдийн төлөөлөгчийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

12 дугаар зүйл. Шүүн таслах ажиллагаа явуулах хэл

12.1. Шүүн таслах ажиллагааг монгол хэлээр явуулна.

12.2. Монгол хэл мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлийн улмаас өөрийн хууль ёсны ашиг сонирхлоо илэрхийлэх чадвар хязгаарлагдмал хүн өөрийн эх хэл, эсхүл сайн мэдэх хэл, бичиг, дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан орчуулагч, хэлмэрчийн тусламж авах эрхээр хангагдана.

13 дугаар зүйл. Шүүхийн үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх

13.1. Шүүхийн үйл ажиллагаа олон нийтэд нээлттэй, ил тод байна.

13.2. Шүүх хуралдааныг хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд нээлттэй явуулна.

13.3. Шүүх хуралдааны явцын дуу, эсхүл дуу-дүрсний бичлэгийг шүүгч, шүүх бүрэлдэхүүн шаардлагатай гэж үзсэн эсхүл хэргийн оролцогчийн хүсэлтийг үндэслэн зохих журмын дагуу баталгаажуулж, архивт хадгална.

13.4. Шүүх өөрийн цахим хуудастай байх бөгөөд шийдвэр, үйл ажиллагаагаа нийтэд тогтмол мэдээлж байна.

13.5. Шүүх хэрэг, маргааныг хэрхэн шийдвэрлэсэн тухай төрийн болон албаны, хувь хүн, хуулийн этгээдийн хуулиар хамгаалагдсан нууцад хамаарахаас бусад мэдээллийг олон нийтэд мэдээлж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ШҮҮХ

14 дүгээр зүйл. Шүүхийн тогтолцоо

14.1. Шүүхийн үндсэн тогтолцоо нь Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэнэ.

14.2. Анхан болон давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.

14.3. Шүүхийг эрүү, иргэн, захиргаа зэрэг шүүн таслах ажиллагааны бусад төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

15 дугаар зүйл. Шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах

15.1. Шүүхийг Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу зөвхөн хуулиар байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.

15.2. Улсын дээд шүүхийг Монгол Улсын Үндсэн хуульд заасан журмын дагуу байгуулна.

15.3. Улсын дээд шүүхээс бусад шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, байршлыг тогтоох асуудлыг Улсын дээд шүүх, Засгийн газартай тус тус зөвшилцсөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Улсын Их Хурал байгуулж, өөрчлөн байгуулж, татан буулгана.

15.4. Шүүхийг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгахдаа түүний харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын тоо, шийдвэрлэгдсэн хэрэг, маргааны тоог харгалзан үзнэ.

16 дугаар зүйл. Шүүхийн бүрэлдэхүүн

16.1. Бүх шатны шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

16.2. Шүүхийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч тэргүүлнэ.

16.3. Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний бүрэн эрх, шүүгчийн нийтлэг бүрэн эрхийг энэ хуулиар, шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхтэй

холбогдсон тодорхой бүрэн эрхийг хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх холбогдох хуулиар тус тус зохицуулна.

16.4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд түүнийг тухайн шүүхэд хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа танхимын тэргүүн, бусад шүүхийн Ерөнхий шүүгчийн түр эзгүйд түүнийг тухайн шүүхэд хамгийн олон жил шүүгчээр ажиллаж байгаа шүүхийн танхимын тэргүүн, эсхүл шүүгч тус тус орлоно.

16.5. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгч адил шатны өөр шүүхэд томилолгоор ажиллаж болно. Томилолгоор ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

17 дугаар зүйл. Шүүгчийн нийтлэг бүрэн эрх

17.1. Шүүгч дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

17.1.1. шүүх хуралдааныг даргалах;

17.1.2. шүүх хуралдааныг товлон зарлаж, түүний оролцогчдыг тогтоох;

17.1.3. шүүх хуралдааны бэлтгэлийг хангах ажлыг шүүхийн тамгын газар, хэлтэстэй хамтран зохион байгуулах;

17.1.4. хэрэг, маргааныг шүүх бүрэлдэхүүнээр хянан шийдвэрлэхэд оролцох;

17.1.5. хуульд зааснаар дангаараа хянан шийдвэрлэх хэрэг, маргааныг Монгол Улсын нэрийн өмнөөс шийдвэрлэх;

17.1.6. шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж байгаа хэргийн талаар шүүгч саналаа бие даан гаргах, тусгай саналтай бол танилцуулах;

17.1.7. баривчлах, цагдан хорих асуудал хариуцсан шүүгчийн хувьд баривчлах, цагдан хорих санал, хүсэлтийг хянан шийдвэрлэх;

17.1.8. шүүн таслах ажиллагааг хуульд заасан дэг, журам, хугацааны дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэх, шаардлагатай бол шүүх хуралдааны дэг зөрчсөн хэргийн оролцогч болон бусад этгээдэд хуульд заасан арга хэмжээ авах, шийтгэл оногдуулах;

17.1.9. ерөнхий шүүгчид, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгчид нэрээ дэвшүүлэх, хуульд зааснаар Ерөнхий шүүгчийг орлох;

17.1.10. албан үүргээ цалгардуулахгүйгээр хууль зүйн чиглэлээр оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр багшлах болон эрдэм шинжилгээний ажил эрхлэх;

17.1.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

17.2. Шүүгч холбогдох хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, бусад мэдээлэл, тэдгээрийн хуулбарыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь оролцогчдын хүсэлтээр зохих байгууллага, албан тушаалтан, иргэнээс шаардан гаргуулах эрхтэй бөгөөд

тухайн этгээд шүүгчийн шаардсан баримт бичиг, мэдээллийг үнэ төлбөргүй гаргаж өгөх үүрэгтэй.

17.3. Шүүгч энэ хуулийн 17.2-т заасан баримт бичгийг үрэгдүүлэхгүй байх, эх хувиар авсан баримт бичгийг буцааж өгөх үүрэг хүлээнэ.

18 дугаар зүйл. Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

18.1. Ерөнхий шүүгч энэ хуулийн 17 дугаар зүйлд зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

18.1.1. тухайн шүүхийг дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

18.1.2. энэ хуулийн 19.1-д заасан шүүгчдийн зөвлөгөөнийг товлон зарлах, хуралдуулах, удирдах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

18.1.3. шүүх хуралдааныг даргалах, хуульд өөрөөр заагаагүй бол шүүх хуралдаан даргалагч болон шүүх бүрэлдэхүүнийг томилсон шийдвэрийг албажуулах;

18.1.4. иргэдийг хүлээн авах ажлыг хуулийн дагуу зохион байгуулах;

18.1.5. иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулах;

18.1.6. шүүгчид энэ хуулийн 74.1.10-т заасан үндэслэлээр эдгээрт зааснаас богино хугацааны чөлөө олгох эсэхийг шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцүүлэн шийдвэрлэх болон Хөдөлмөрийн дотоод журамд заасан чөлөөг дангаар олгох;

18.1.7. хэргийн хөдөлгөөний ерөнхий удирдлага, хяналтыг хэрэгжүүлэх;

18.1.8. шүүхийн практик, тоон мэдээлэлд үндэслэн шүүн таслах ажиллагааны чанар, үр дүнгийн талаар Шүүгчдийн зөвлөгөөнд мэдээлэл хийх;

18.2. Ерөнхий шүүгч бүрэн эрхийн асуудлаар захирамж гаргана.

19 дүгээр зүйл. Шүүгчдийн зөвлөгөөн

19.1. Шүүхэд тухайн шүүхийн нийт шүүгчээс бүрдсэн шүүгчдийн зөвлөгөөн /цаашид "Зөвлөгөөн" гэх/ ажиллана.

19.2. Зөвлөгөөн тогтмол хуралдаж, дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ:

19.2.1. тодорхой хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхээс бусад шүүхийн дотоод ажлын зохион байгуулалт, журмыг хуульд өөрөөр заагаагүй бол тогтоох;

19.2.2. шүүх хуралдаан даргалагчийн дарааллыг тогтоох;

19.2.3. хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх шүүгчийг болон шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хэрэгт оролцох шүүгчийг томилох дарааллыг тогтоох;

19.2.4. шүүгчийг мэргэшүүлэх сургалтын саналаа Шүүхийн ерөнхий зөвлөлд уламжлах;

19.2.5. тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшүүлэх, томилох;

19.2.6. хэрэг хуваарилах журмыг батлах;

19.2.7. шүүн таслах ажиллагаанаас бусад тухайлсан асуудлыг хариуцсан шүүгчийг Ерөнхий шүүгчийн санал болгосноор сонгох;

19.2.8. энэ хуулийн 18.1.8-д заасан мэдээлэлтэй танилцах;

19.2.9. хуульд заасан бусад бүрэн эрх.

19.3. Тухайн шүүхийн шүүгчдийн олонхын саналаар шүүгчдийн ээлжит бус зөвлөгөөнийг зарлан хуралдуулж болно.

19.4. Зөвлөгөөн хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

19.5. Зөвлөгөөн энэ хуулийн 19.2-т заасан асуудлыг зөвлөгөөнд оролцсон шүүгчдийн олонхын саналаар шийдвэрлэж тогтоол гаргах бөгөөд уг тогтоолын биелэлтийг Ерөнхий шүүгч зохион байгуулна.

20 дугаар зүйл. Шүүгчдийн зөвлөл

20.1. Шүүх эрх мэдлийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх зорилго бүхий анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчдийн олонх, Улсын дээд шүүхийн шүүгчдээс бүрдсэн шүүгчдийн зөвлөл /цаашид "Зөвлөл" гэх/ ажиллана. Зөвлөл хоёр жил тутам хуралдах бөгөөд дараагийн хурлын товоо өөрөө тогтооно.

20.2. Зөвлөл дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

20.2.1. үйл ажиллагааны журмыг батлах;

20.2.2. Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны бүрэлдэхүүнд орох шүүгчийг сонгох, эгүүлэн татах;

20.2.3. Шүүгчийн ёс зүйн дүрмийг батлах;

20.2.4. шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомжийг боловсронгуй болгох саналыг Улсын дээд шүүхэд уламжлах;

20.2.5. Шүүхийн ерөнхий зөвлөл, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг сонсох;

20.2.6. шүүхийн үйл ажиллагаатай холбоотой бусад асуудлыг авч хэлэлцэх, зөвлөмж гаргах.

20.3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн гаргасан, эсхүл бусад шүүхийн Ерөнхий шүүгчдийн олонхын саналд үндэслэн Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг зохион байгуулж болно.

20.4. Зөвлөлийн хуралдаанд сонгогдсон нийт шүүгчдийн талаас илүү нь оролцвол хүчинтэйд тооцох бөгөөд шүүгч биеэр оролцох боломжгүй тохиолдолд түүнийг цахимаар санал өгөх боломжоор хангана.

20.5. Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнд нэр дэвшигч шүүгчийг нууц санал хураалтаар сонгоно.

20.6. Шүүгчээр 5 жил ажиллаагүй, сахилгын шийтгэл хүлээсэн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүнээр сонгохгүй.

20.7. Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж, тогтоол гаргана.

20.8. Зөвлөлийн хуралдааны зохион байгуулалтын асуудлыг Шүүхийн ерөнхий зөвлөл хариуцна.

21 дүгээр зүйл. Шүүхийн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас

21.1. Шүүх соёмбо, өөрийн нэр бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэгтэй байх бөгөөд албан бичгийн болон шүүхийн шийдвэрийн хэвлэмэл хуудас хэрэглэх, албан хэрэг хөтлөх журамтай байна.

22 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр

22.1. Шүүх шийдвэрээ Монгол Улсын нэрийн өмнөөс гаргана.

22.2. Шүүхийн шийдвэрийг бичих аргачлал, журмыг Улсын дээд шүүх тогтооно.

22.3. Шүүх хэрэг, маргааныг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

22.3.1. анхан шатны шүүх шийтгэх ба цагаатгах тогтоол, шүүхийн шийдвэр, шүүгч шийтгэвэр;

22.3.2. давж заалдах шатны шүүх магадлал;

22.3.3. хяналтын шатны шүүх тогтоол.

22.4. Энэ хуулийн 22.3-т зааснаас бусад тохиолдолд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүх тогтоол, шүүгч захирамж гаргана.

22.5. Шүүх хамтын зарчмаар хэрэг, маргааныг хянан хэлэлцэхдээ олонхийн саналаар шийдвэр гаргах ба цөөнх болсон шүүгч тусгай саналаа, хэрэв хэд хэдэн шүүгч тусгай саналтай бол тэдгээрийг нэгтгэж, хавтаст хэрэгт хавсаргана.

22.6. Шүүх бүрэлдэхүүнд оролцсон бүх шүүгчид шийдвэрт гарын үсэг заавал зурна.

22.7. Бүх шатны шүүх шийдвэрээ өөрийн цахим хуудсанд байршуулж, хэвлэн нийтэлнэ.

23 дугаар зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх

23.1. Шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт оршин суугаа хувь хүн, үйл ажиллагаа явуулж байгаа хуулийн этгээд заавал биелүүлэх үүрэгтэй.

23.2. Шүүхийн шийдвэрийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.

23.3. Хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийг санаатай биелүүлээгүй, эсхүл биелүүлэхэд зориуд саад учруулсан этгээдэд хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

23.4. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбогдсон харилцааг хуулиар зохицуулна.

24 дүгээр зүйл. Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн

24.1. Шүүхийн судалгаа, шинжилгээ, тоон болон бусад мэдээлэл, сургалтын асуудлыг хариуцсан Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэн Улсын дээд шүүхийн дэргэд ажиллана.

24.2. Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн бүтэц, орон тоог Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч батална.

24.3. Судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн чиг үүрэг, ажиллах журмыг Улсын дээд шүүхийн ерөнхий шүүгч нь Шүүхийн ерөнхий зөвлөлтэй зөвшилцөн батална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

25 дугаар зүйл. Улсын дээд шүүх, түүний бүрэн эрх

25.1. Улсын дээд шүүх нь Монгол Улсын шүүхийн дээд байгууллага бөгөөд хяналтын шатны шүүх мөн.

25.2. Улсын дээд шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэн, захиргааны хэргийн зэрэг дагнасан танхимтай байна.

25.3. Улсын дээд шүүх нь Ерөнхий шүүгч, хорин дөрвөөс доошгүй шүүгчээс бүрдэнэ

25.4. Улсын дээд шүүхийн шүүгч энэ хуулийн 25.2-т заасан танхимын аль нэгд харьяалагдана.

25.5. Хяналтын шатны шүүхийн тогтоолд үг, үсэг, тооны зэрэг техникийн шинжтэй алдаа гарсан бол танхимын шүүх бүрэлдэхүүн хуралдаж, залруулга хийж болно.

25.6. Улсын дээд шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

25.6.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1-д заасны дагуу хуулиар тусгайлан харьяалуулсан тохиолдолд хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

25.6.2. хуульд заасан үндэслэл, журмын дагуу давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянах;

25.6.3. шүүхийн шийдвэр, практикт үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлтэй хамтран сургалт зохион байгуулах, зөвлөмж гаргах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа хууль санаачлагчид уламжлах;

25.6.4. Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;

25.6.5. хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

25.6.6. хуульд зааснаар танхим байгуулах;

25.6.7. энэ хуулийн 7.4-т заасан саналыг хэлэлцэж үндэслэлтэй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцэд хүсэлт гаргах;

25.6.8. Үндсэн хуулийн цэцийн гишүүнд нэр дэвшүүлэх, гишүүнээс чөлөөлөх, эгүүлэн татах тухай санал гаргах;

25.6.9. Хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн хэргийн тогтоолд Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч дүгнэлт гаргасан, эсхүл Улсын ерөнхий прокурор эсэргүүцэл бичсэн бол хэргийг хянан шийдвэрлэх;

25.6.10. бүх насаар нь хорих ял оногдуулсан шүүхийн шийдвэртэй хэргийг гомдол, эсэргүүцэл гарсан эсэхээс үл хамааран хянан шийдвэрлэх;

25.6.11. хуульд заасан бусад бүрэн эрх.

26 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан

26.1. Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн хуралдаан /цаашид "Нийт шүүгчдийн хуралдаан" гэх/-аар энэ хуулийн 25.6.4, 25.6.5, 25.6.6, 25.6.7, 25.6.8, 25.6.9, 25.6.10-т заасан асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, тогтоол гаргана.

26.2. Нийт шүүгчдийн хуралдааныг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, түүний түр эзгүйд албан үүргийг орлон гүйцэтгэж байгаа Улсын дээд шүүхийн Танхимын тэргүүн даргална.

26.3. Нийт шүүгчдийн хуралдаанд Улсын дээд шүүхийн нийт шүүгчдийн гуравны хоёроос доошгүй нь оролцсон бол хуралдааныг хүчинтэйд тооцно.

26.4. Нийт шүүгчдийн хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг олонхын саналаар шийдвэрлэнэ. Шүүгчдийн санал тэнцсэн тохиолдолд хуралдаан даргалагчийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

26.5. Нийт шүүгчдийн хуралдаан дэгээ өөрөө тогтооно.

27 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

27.1. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 18.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

27.1.1. танхимын тэргүүний ажлыг удирдах;

27.1.2. танхимын бүрэлдэхүүнийг батлах, хуульд заасан үндэслэлээр хүрэлцэхгүй байгаа шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон тохиолдолд шүүх бүрэлдэхүүнийг томилох;

27.1.3. хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяаллын талаар шүүх хооронд гарсан маргааныг шийдвэрлэх;

27.1.4. Улсын дээд шүүхийн тамгын газрын дарга, судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн захирлыг томилох, чөлөөлөх;

27.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

28 дугаар зүйл. Улсын дээд шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

28.1. Танхимын тэргүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

28.1.1. танхимыг тэргүүлж, танхимын шүүгч, шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн даргын ажлыг удирдан зохион байгуулах;

28.1.2. танхимын эрхэлсэн шүүн таслах ажиллагааны төрлөөр иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх;

28.1.3. хуульд заасан журмын дагуу шүүх хуралдааныг даргалах;

28.1.4. энэ хуулийн 17.1-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

28.1.5. хуульд өөрөөр заагаагүй бол хэргийн харьяалал тогтоох.

28.2. Танхимын тэргүүн бүрэн эрхийнхээ асуудлаар захирамж гаргана.

ТАВДУГААР БҮЛЭГ ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ

29 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүх, түүний бүрэн эрх

29.1. Давж заалдах шатны шүүх нь аймаг, нийслэлийн болон захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс бүрдэнэ.

29.2. Давж заалдах шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.

29.3. Аймаг, нийслэлийн шүүх шүүн таслах ажиллагааны төрлөөр хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх эрүү, иргэний хэргийн танхимтай байж болно. Танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална.

29.3. Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 29.3-т заасан танхимын аль нэгэнд харьяалагдана. 11

29.4. Давж заалдах шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

29.4.1. анхан шатны шүүхийн шийдвэрийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан гомдол, прокурорын эсэргүүцлийн үндсэн дээр давж заалдах журмаар хянан шийдвэрлэх;

29.4.2. хуулиар тусгайлан харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

29.4.3. шүүн таслах ажиллагааны практикийг судалж мэдээлэл хийх, зөвлөмж гаргах, хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын дээд шүүхэд уламжлах;

29.4.4. хуульд заасан бусад бүрэн эрх.

30 дугаар зүйл. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн бүрэн эрх

30.1. Давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 18.1-д зааснаас гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

30.1.1. энэ хуулийн 29.4.1-д заасны дагуу хэрэг, маргааныг давж заалдах журмаар шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүнийг Зөвлөгөөнөөр хэлэлцүүлж, томилсон шийдвэрийг албажуулах;

30.1.2. тодорхой хэрэг, маргааны харьяаллын талаар анхан шатны шүүх хооронд гарсан маргааныг хянаж, харьяаллыг тогтоох;

30.1.3. тухайн шүүхийн шүүн таслах ажиллагаанд танхим харгалзахгүй оролцох;

30.1.4. Танхимын тэргүүний ажлыг удирдах

30.1.5. хуульд заасан бусад бүрэн эрх.

31 дүгээр зүйл. Давж заалдах шатны шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

31.2. Давж заалдах шатны шүүхийн танхимын тэргүүн энэ хуулийн 28.1-д заасан бүрэн эрхээс хэргийн харьяалал тогтоохоос бусдыг хэрэгжүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ АНХАН ШАТНЫ ШҮҮХ

32 дугаар зүйл. Сум буюу сум дундын, дүүргийн болон захиргааны хэргийн шүүх, түүний бүрэн эрх

32.1. Сум буюу сум дундын, дүүргийн болон аймаг, нийслэлийн захиргааны хэргийн шүүх нь өөрийн харьяалах нутаг дэвсгэрт анхан шатны шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлнэ.

32.2. Анхан шатны шүүхийг тойргийн зарчмаар байгуулж болно.

32.3. Анхан шатны шүүх нь тодорхой хэрэг, маргааны төрлөөр танхимтай байж болно.

32.4. Энэ хуулийн 32.3-т заасан танхимыг Ерөнхий зөвлөлийн саналыг харгалзан Улсын дээд шүүхийн шийдвэрээр байгуулж, бүрэлдэхүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч батална.

32.5. Анхан шатны шүүх шүүн таслах ажиллагааг иргэдэд ойртуулах зорилгоор нүүдэллэн ажиллаж болох бөгөөд ажиллах нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

32.6. Анхан шатны шүүх дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

32.6.1. хуулиар харьяалуулсан хэрэг, маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

32.6.2. анхан шатны шүүхийн шүүн таслах ажиллагааны практикт үндэслэн хууль тогтоомжийг боловсронгуй болгох тухай саналаа Улсын дээд шүүхэд уламжлах;

32.6.3. хуульд заасан бусад бүрэн эрх.

33 дугаар зүйл. Анхан шатны шүүхийн танхимын тэргүүний бүрэн эрх

33.2. Анхан шатны шүүхийн танхимын тэргүүн энэ хуулийн 28.1-д заасан бүрэн эрхээс хэргийн харьяалал тогтоохоос бусдыг хэрэгжүүлнэ

ДОЛООДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ ШҮҮГЧИД ТАВИГДАХ БОЛЗОЛ, ШААРДЛАГА

34 дүгээр зүйл. Шүүгчид тавигдах болзол, шаардлага

34.1. Шүүгч нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон дараах шаардлагыг хангасан байна:

34.1.1. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;

34.1.2. шүүгчид нэр дэвших үед гэмт хэрэгт холбогдоогүй буюу эрүүгийн хэрэг үүсгэгдэж, яллагдагчаар татагдаагүй;

34.1.3. шүүгчээр ажиллахад харшлах өвчин, сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий эмнэлгийн мэргэшсэн эмчийн магадлагаатай байх;

34.1.4. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх.

34.2. Шүүгчээр томилогдоход харшлах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга хамтран батална.

34.3. Давж заалдах шатны шүүхийн шүүгч энэ хуулийн 34.1-д зааснаас гадна анхан шатны шүүхэд шүүгчээр зургаагаас доошгүй жил ажилласан байна.

34.4. Улсын дээд шүүхийн шүүгч Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан болзол болон энэ хуулийн 34.1-д зааснаас гадна доор дурдсан шаардлагыг хангасан байна:

34.4.1. анхан шатны шүүхэд шүүгчээр арван жил, эсхүл давж заалдах шатны шүүхэд таваас доошгүй жил шүүгчээр ажилласан;

34.4.2. өмгөөлөгч, прокуророор арваас доошгүй жил ажилласан.

34.5. Улсын дээд шүүхийн шүүгчээр сүүлийн зургаан жилд Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Дэд сайд, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын удирдлага, бүх шатны Засаг дарга, улс төрийн намын дарга, удирдах албан тушаал хашиж байсан хүнийг томилохыг хориглоно.

34.6. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч энэ хуулийн 34.1, 34.3, 34.4-т заасан тухайн шатны шүүгчид тавигдах шаардлагаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

34.6.1. анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч тухайн шатны шүүхэд таваас доошгүй жил ажилласан;

34.6.2. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч шүүгчээр арван жил ажилласан байх.

НАЙМДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ, ТОМИЛОХ

35 дугаар зүйл. Шүүгчийг сонгон шалгаруулах, томилох журам

35.1. Хуульчдаас шүүгчийг шилж олох, сонгон шалгаруулах, Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгчийн албан тушаалд нэр дэвшүүлэх ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл зохион байгуулна.

35.2. Бүх шатны шүүхийн Ерөнхий шүүгч дараах тохиолдолд тухайн шүүхэд шүүгчийн сул орон тоо гарсан талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ:

35.2.1. шүүгч хүсэлтээрээ чөлөөлөгдөх, өндөр насны тэтгэвэрт гарах, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол уг орон тоо гарахаас нэг сарын өмнө;

35.2.2. энэ хуулийн 35.2.1-д зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн сул орон тоо гарсан бол тухайн өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор.

35.3. Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 35.2-т заасан мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын арван өдрийн дотор шүүгчийн сул орон тоонд нэр дэвшүүлэх болзол, шаардлага, өргөдөл хүлээн авах, бүртгэх, шалгаруулах хугацаа, журам, газрыг тодорхойлсон зарыг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтлэх ба цахим хуудсандаа байршуулна.

35.4. Энэ хуулийн 35.3-т заасан зарыг тухайн шүүгчийн ажиллах аймаг, нийслэлийн өдөр тутмын хэвлэлд нийтэлж болно.

36 дугаар зүйл. Шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчийг сонгон шалгаруулах, өргөн мэдүүлэх

36.1. Шүүхийн ерөнхий зөвлөл нь Мэргэшлийн хорооны үнэлгээг үндэслэн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилуулах

нэр дэвшигчээс илээр санал хурааж, олонхийн санал авсан хүнийг шүүгч, Ерөнхий шүүгчээр томилуулахаар ажлын таван өдрийн дотор Ерөнхийлөгчид өргөн мэдүүлнэ.

36.2. Энэ хуульд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн шүүгч тухайн шүүхийн Ерөнхий шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

36.3. Анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд шүүгчийг сонгон шалгаруулахад энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтална.

37 дугаар зүйл. Шүүгчийг томилох

37.1. Анхан болон давж заалдах шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор, хяналтын шатны шүүхийн шүүгчийг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч 14 хоногийн дотор томилно.

37.2. Шүүхийн ерөнхий зөвлөлөөс санал болгосон нэр дэвшигч нь шүүгчид тавигдах болзол, хангаагүй гэж Ерөнхийлөгч үзвэл энэ тухай Шүүхийн ерөнхий зөвлөлд албан ёсоор мэдэгдэнэ.

37.3. Шүүхийн ерөнхий зөвлөл Ерөнхийлөгчийн үндэслэлийн дагуу дахин нягталж, томилохоос татгалзсан шалтгаан тогтоогдоогүй тохиолдолд тухайн нэр дэвшигчийг дахин санал болгох, нотлогдсон тохиолдолд Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуульд заасан журмаар өөр нэр дэвшигчийг санал болгоно.

37.4. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор шүүгчдийнх нь дотроос Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

37.5. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн Ерөнхий шүүгчийг тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөс, Танхимын тэргүүнийг тухайн шүүхийн Ерөнхий шүүгч гурван жилийн хугацаагаар тус тус томилох бөгөөд нэг удаа улируулан томилж болно.

37.6. Ерөнхийлөгч шүүгчийг томилсон тухай зарлиг гаргана.

38 дугаар зүйл. Шүүгчийг мэргэшүүлэх

38.1. Анхан шатны шүүхийн шүүгчийн албан тушаалд шинээр томилогдсон шүүгчийг шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд мэргэшүүлэн дадлагажуулах зорилгоор мэргэшүүлэх сургалтад хамруулна.

38.2. Давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүхэд шүүгчээр томилогдсон шүүгчийг өөрийнх нь хүсэлтээр мэргэшүүлэх сургалтад хамруулж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН БҮРЭН ЭРХ ҮҮСЭХ, ДУУСТАВАР БОЛОХ

ҮНДЭСЛЭЛ ЖУРАМ

39 дүгээр зүйл. Шүүгчийн бүрэн эрх үүсэх, шүүгчийн тангараг, түүнийг өргөх журам

39.1. Шүүгчийн бүрэн эрх нь Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хуульд заасан журмын дагуу томилогдон, тангараг өргөснөөр эхэлнэ.

39.2. Шүүгч томилогдсон өдрөөсөө хойш ажлын гурав хоногийн дотор "Шүүгч би шүүх эрх мэдлийн ариун журамт үүрэг, Монгол Улсын Үндсэн хуульт байгуулал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж хэрэг, маргааныг хэнээс ч хараат бус, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд нийцүүлэн шийдвэрлэж, шүүгчийн ёс зүйг чанд сахиж явахаа ард түмэндээ батлан тангараглая. Хэрэв миний бие өргөсөн тангаргаасаа няцвал шүүгчийн албан тушаалаас нэн даруй огцорч хуульд заасан хариуцлага хүлээнэ." гэж Монгол Улсын Үндсэн хууль болон Төрийн сүлдэнд тангараг өргөнө.

39.3. Шүүгчийн тангараг өргөх журам, шүүгчийн өмсгөлийн загвар, хэрэглэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

40 дүгээр зүйл. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх

40.1. Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч доор дурдсанаар шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлнэ:

40.1.1. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн;

40.1.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн болон Сахилгын хорооны орон тооны гишүүнээр сонгогдсон;

40.1.3. сураггүй алга болсонд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон.

40.2. Шүүгчийн бүрэн эрхийг энэ хуулийн 40.1.2-т заасан үндэслэлээр түдгэлзүүлсэн нь түүний халдашгүй байдал, цалин, эдийн засаг, нийгмийн хангамжийн баталгааг хасах үндэслэл болохгүй.

40.3. Сахилгын хороо шүүгчид эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай эрх бүхий байгууллагаас ирүүлсэн саналыг хянан үзээд түдгэлзүүлсэн бол шийдвэрээ Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулна.

40.4. Энэ хуулийн 40.1-д заасан үндэслэл арилсан бол Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч шүүгчийн бүрэн эрхийг сэргээнэ.

41 дүгээр зүйл. Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох

41.1. Шүүгч хуульд заасан өндөр насны тэтгэвэр авах насанд хүрсэн, шүүгчээр 25 жил ажилласан, төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэн бол тэтгэвэрт гарах буюу шүүгчийн албан тушаалаас өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөж болно.

41.2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн Ерөнхийлөгч дараах үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгож чөлөөлнө:

41.2.1. шүүгч албан тушаалаасаа чөлөөлөгдөх хүсэлтээ бичгээр гаргасан;

41.2.2. эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боломжгүй болсон;

41.2.3. шүүгч өөр ажил албан тушаалд шилжсэн, томилогдсон, сонгогдсон;

41.2.4. Монгол Улсын харьяатаас гарах болсон, эсхүл гадаад улсын нутаг дэвсгэрт байнга оршин суух эрх авсан;

41.2.5. шүүгч Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд нэр дэвших болсон;

41.2.6. шүүгчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

41.2.7. хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгосон;

41.2.8. шүүгч нас барсан, эсхүл нас барсанд тооцох тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон бол;

41.2.9. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

41.2.10. ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшингээр шүүгчийн албан тушаалд тэнцэхгүй талаар Мэргэшлийн хорооны дүгнэлт гарсан.

41.3. Шүүгчийг түдгэлзүүлэн, чөлөөлсөн, огцруулсан үндэслэл хууль бус байсан нь эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр, хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр тогтоогдсон бол шүүгчийн бүрэн эрхийг сэргээж цалин хөлсийг нөхөн олгоно.

41.4. Ерөнхий шүүгч, танхимын тэргүүнээр ажиллах хугацаа дууссан нь шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох үндэслэл болохгүй.

41.5. Шүүгч огцорсон нь шүүгчийн албан тушаалд дахин нэр дэвших, сонгон шалгаруулалтад оролцохгүй байх үндэслэл болно.

42 дугаар зүйл. Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг тоолох

42.1. Шүүгчийн бүрэн эрх дуусгавар болох хугацааг дараах байдлаар тоолно:

42.1.1. Ерөнхий шүүгч, танхимын тэргүүний хувьд бүрэн эрх нь дуусгавар болох сарын сүүлийн өдрөөр;

42.1.2. шүүгчээр ажиллаж болох насны дээд хязгаарт хүрсэн бол уг насанд хүрэх сарын сүүлийн өдрөөр;

42.1.3. энэ хуулийн 42.1.1, 42.1.2-т зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох шийдвэр гарсан бол уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөр.

АРАВДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ХАРААТ БУС БАЙДАЛ, ТҮҮНИЙГ ХАНГАХ БАТАЛГАА

43 дугаар зүйл. Шүүгчийн хараат бус байх зарчим, баталгаа

43.1. Шүүгч шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхдээ аливаа этгээдээс хараат бус байж, гагцхүү Монгол Улсын Үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан, албан ёсоор нийтлэгдсэн бусад хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд захирагдана.

43.2. Шүүгчийн хараат бус байдал халдашгүй байх бөгөөд шүүгчийн хараат бус байдлыг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулиар баталгаажуулна.

43.3. Шүүгчийн хараат бус байдлыг дараах баталгаагаар хангана:

43.3.1. Монгол Улсын Үндсэн хууль болон энэ хууль, Шүүгчийн ёс зүйн дүрэмд зааснаас бусад үндэслэлээр шүүгчийн бүрэн эрхийг хязгаарлах, түдгэлзүүлэх, дуусгавар болгохыг хориглох;

43.3.2. шүүгчийг өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр өөр албан тушаалд болон өөр шүүхэд шилжүүлэх, эсхүл сэлгэн ажиллуулахыг хориглох;

43.3.3. хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд хугацаагүй томилогдож, захиргааны болон гуравдагч этгээдийн санаачилгаар чөлөөлөгдөхгүй, огцрохгүй, аливаа дайчилгаа болон цэргийн жинхэнэ албанд татахгүй байх;

43.3.4. шүүгчийн эрх зүйн байдлын онцлогт нь нийцүүлэн эдийн засгийн болон нийгмийн хангамж, халамжийн тогтолцоог энэ хууль болон бусад хуулиар бүрдүүлэх, хангах;

43.3.5. шүүхийг татан буулгасан, өөрчлөн зохион байгуулсан, аль нэг шүүхийн шүүгчийн орон тоо цөөрсөн тохиолдолд Шүүхийн ерөнхий зөвлөл шүүгчийн өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн орон тоо дутуу байгаа адил шатны шүүхэд, адил шатны шүүхэд орон тоо байхгүй бол доод шатны шүүхэд шилжүүлэн томилуулах;

43.4. шүүгчийн орон тоо цөөрсөн, шүүхийг татан буулгах болон өөрчлөн зохион байгуулахтай холбоотойгоор шүүгчийг өөрчлөн зохион

байгуулагдсан шүүх, эсхүл өөр шүүхэд шилжүүлэн томилохоос Ерөнхийлөгч татгалзаж болохгүй.

43.5. Шүүгчийн мэргэжил, ур чадварыг сайжруулах, шүүн таслах ажиллагааны дадлага эзэмшүүлэх, туршлага судлуулах, шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, шүүхийн хүний нөөцийг оновчтой байршуулах зорилгоор шүүгчийг өөрийнх нь зөвшөөрлийг үндэслэн шүүх хооронд сэлгэх буюу шилжүүлэн ажиллуулж болно.

43.6. Улсын дээд шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгч гадаадад байх, зорчих хугацаанд дипломат эрх ямба эдэлнэ.

43.7. Шүүгчийн хараат бус байдалд хуульд зааснаас бусад үндэслэл, журмаар халдсан, үл хүндэтгэсэн хэн боловч хууль зүйн хариуцлага хүлээнэ.

44 дүгээр зүйл. Шүүгчийн хараат бус байдалд халдсан этгээдэд хүлээлгэх хариуцлага

44.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.2. Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

44.3. Энэ хуулийн 44.2-т заасны дагуу хариуцлага хүлээсэн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг Монгол Улсаас албадан гаргаж, дахин ирэх эрхийг нь 10 хүртэл жилээр хасна.

45 дугаар зүйл. Шүүгчийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг хориглох

45.1. Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын гишүүн болон Засгийн газрын гишүүн, төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөл, Мэргэшлийн болон Сахилгын хорооны гишүүн, ашгийн төлөө бус хуулийн этгээд, бусад аливаа байгууллага, албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөхийг хориглоно.

45.2. Энэ хуулийн 45.1-д заасныг зөрчсөн этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага ногдуулна.

45.3. Хуульд өөрөөр заагаагүй бол шүүгчээс хянан шийдвэрлэж байгаа болон хянан шийдвэрлэсэн хэргийнх нь талаар өөрийг нь холбогдуулан мөрдөн шалгах ажиллагаа явуулж байгаа байгууллага, албан тушаалтан тайлбар, мэдүүлэг авахаар шаардахыг хориглоно.

45.4. Хавтаст хэргийн баримттай танилцуулахыг хэргийн оролцогчоос бусад этгээд шүүгчээс шаардахыг хориглоно.

45.5. Ерөнхий шүүгч, шүүгч, тамгын газрын ажилтан энэ хуулийн 19.2.2, 19.2.3-т заасан журмыг зөрчсөн бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

46 дугаар зүйл. Нөлөөллийн мэдүүлэг хөтлөх

46.1. Тухайн хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгч, шүүх бүрэлдэхүүнд аливаа этгээдээс нөлөөлөх гэж оролдсон бүх тохиолдлыг тэмдэглэн баталгаажуулж нөлөөллийн мэдүүлэг хөтөлнө.

46.2. Энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлгийн загвар, түүнийг хөтлөх, шийдвэрлэх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

46.3. Шүүгч нөлөөллийн мэдүүлгийн зорилго, хууль зөрчсөнөөс үүсэх үр дагаврын талаар хэрэг үүсгэсэн даруйд тухайн хэргийн оролцогчдод тайлбарлан, энэ тухай баримтжуулна 46.4. Нөлөөллийн мэдүүлэг хөтөлсөн шүүгч нөлөөллийн мэдүүлгийг хэрэгт хавсарган, хувийг Шүүхийн ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

46.5. Шүүхийн ерөнхий зөвлөл энэ хуулийн 46.1-д заасан нөлөөллийн мэдүүлэгт тэмдэглэн баталгаажуулсан тухайн этгээдийн үйлдэл нь шүүхийн бие даасан, шүүгчийн хараат бус байдалд халдсан гэж үзвэл түүнийг шалгуулахаар холбогдох эрх бүхий байгууллагад хандаж, шийдвэрлүүлнэ.

46.6. Нөлөөллийн мэдүүлгийг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн саналыг эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шийдвэрлэж, Шүүхийн ерөнхий зөвлөлд хариу мэдэгдэнэ.

46.7. Шүүхийн ерөнхий зөвлөл эрх бүхий байгууллагаас ирүүлсэн шийдвэрийг олон нийтэд тухай бүрд мэдээлнэ.

47 дугаар зүйл. Шүүгчийн эдийн засгийн баталгаа

47.1. Шүүгчийн албан тушаалын цалингийн хэмжээ нь эдийн засгийн хувьд бусдаас хараат бус ажиллах, амьдрахад хүрэлцээтэй, баталгаатай байх боломжийг хангасан байна.

47.2. Тухайн шүүгчийн үндсэн цалингийн хэмжээ шүүгчээр ажилласан тав дахь жилээс эхлэн жил бүр өмнөх оныхоос хоёр хувиар нэмэгдэнэ.

47.3. Шүүгчийн цалин хөлс нь албан тушаалын цалин болон шүүн таслах ажиллагааны, төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн, докторын зэрэг, цол зэрэг нэмэгдлээс бүрдэнэ.

47.4. Шүүгчийн албан тушаалын цалин, нэмэгдлийн хэмжээ, шүүгчийн орон тоог Шүүхийн ерөнхий зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

47.5. Шүүхийн төсвийг батлахдаа шүүгчийн цалин хөлсний бүрэлдэхүүн, хэмжээг бууруулж болохгүй.

47.6. Шүүгчийн албан ёсны айлчлал, томилолт, төрийн ёслол, хүндэтгэлийн болон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдсон бусад арга хэмжээний зардлыг шүүхийн төсвөөс санхүүжүүлнэ.

47.7. Шүүгч ээлжийн амралтаараа дотоодын амралт, сувиллын газарт, эсхүл өөрийн болон эхнэр /нөхөр/-ийн төрсөн нутагт амрах тохиолдолд

түүний очих, ирэх замын зардлыг хоёр жилд нэг удаа шүүхийн төсвөөс авто замын зорчигч тээврийн зардлаар тооцож олгоно.

47.8. Шүүгчид ногдох хэргийн ачааллын шалгуур үзүүлэлт, шүүгчид урамшуулал олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

47.9. Шүүхийн төсвийн боловсруулж батлахад дараах журмыг баримтална:

47.9.1. Шүүхийн ерөнхий зөвлөл нь бүх шатны шүүхийн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгө оруулалтын төсвийг төлөвлөн жилийн төсвийн саналаа Төсвийн тухай хуульд заасан хугацаанд санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

47.9.2. Засгийн газар жилийн төсвийн төслийг шүүхийн төсвийн саналыг өөрчлөхгүйгээр холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

47.9.3. Улсын Их Хурал жилийн төсвийн төслийг хэлэлцэн батлахдаа Ерөнхий зөвлөлийн санал, Засгийн газрын дүгнэлтийг хэлэлцэж шийдвэрлэх.

48 дугаар зүйл. Шүүгчийн зэрэг дэв

48.1. Шүүгч Монгол Улсын шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гутгаар түшээ, дөтгөөр түшээ, тавдугаар түшээ гэсэн зэрэг дэвтэй байна.

48.2. Шүүгчид зэрэг дэв олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

48.3. Шүүгчид зэрэг дэв олгохдоо албан тушаал, хуульч мэргэжлээр ажилласан хугацаа, ажил хэргийн чадвар, ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзан үзнэ.

48.4. Шүүгчийн албан тушаал буурах тохиолдолд түүний зэрэг дэв хэвээр үлдэнэ.

48.5. Шүүгчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулахдаа эрхэлж байгаа албан тушаалын ангилал, зэрэглэл, цалин хөлс, зэрэг дэвийг бууруулахгүй.

49 дүгээр зүйл. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний нийгмийн баталгаа

49.1. Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгалын хураамжийг улсын төсвөөс хариуцна. Шүүгч эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалаас хэтэрсэн зардал, түүнчлэн өвчтэй эсхүл хөгжлийн бэрхшээлтэй болсон бол түүний цалин хөлсийг бүрэн хэмжээгээр олгоно.

49.2. Шүүгчийн амь нас, эрүүл мэндийн даатгал дараах хэлбэр, хэмжээтэй байна:

49.2.1. шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь хохирол учирснаас нас барсан бол даатгалын төлбөрийг түүний авч байсан сүүлийн 15 жилийн цалинтай тэнцэх хэмжээгээр шүүгчийн өв залгамжлагчид олгох;

49.2.2. шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад бие махбодь гэмтсэн буюу эрүүл мэндэд нь цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж чадахааргүй хохирол учирсан бол даатгалын төлбөрийн хэмжээ нь тухайн шүүгчийн сүүлийн гурван жилийн цалинтай тэнцэх;

49.2.3. шүүгчийн бие махбодь, эрүүл мэндэд хохирол учруулсан нь түүний хөдөлмөрийн чадварыг цаашид мэргэшлийн үйл ажиллагаа эрхлэхэд саад болохоор алдагдуулаагүй бол даатгалын төлбөрийн хэмжээ нь тухайн шүүгчийн сүүлийн нэг жилийн цалинтай тэнцэх.

49.3. Энэ хуулийн 49.2-т заасан даатгалыг даатгалын байгууллагаас төлнө.

49.4. Шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад гэмтсэн болон эрүүл мэндэд нь хохирол учирснаас цаашид мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх боломжгүйгээр хөдөлмөрийн чадвараа алдсан бол түүнд шүүгчээр ажиллаж байхдаа авч байсан цалингийн 70 хувьтай тэнцэх хэмжээний нөхөн олговрыг сар бүр олгоно.

49.5. Шүүгч албан үүргээ гүйцэтгэх явцад нас барвал түүний асрамжид байсан хүүхдийг 18 нас хүртэл, гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүнд шүүгчийн авч байсан албан тушаалын цалингаас ногдох хэмжээгээр тэтгэмж /нөхөх төлбөр/-ийг сар бүр олгох бөгөөд түүнд улсын төсвөөс төлсөн даатгалын төлбөр, тэжээгчээ алдсаны болон бусад төрлийн тэтгэвэр, цалин, тэтгэлгийг оруулан тооцохгүй.

49.6. Шүүгчийн өндөр насны тэтгэвэрт гарах насны дээд хязгаар 65 нас байна. Тавин таван насанд хүрсэн эмэгтэй шүүгч, 60 насанд хүрсэн эрэгтэй шүүгч, эсхүл шүүгчээр нийт 25 жил ажилласан шүүгч өөрөө хүсвэл өндөр насны тэтгэврээ тогтоолгож болно.

49.7. Шүүгчийн тэтгэвэртэй холбоотой харилцааг холбогдох хуулиар, ээлжийн амралтын үндсэн болон нэмэгдэл амралтын хугацааг энэ хууль болон Хөдөлмөрийн тухай хуулиар тогтоох бөгөөд шүүгчээр ажилласан таван жил тутамд ажлын гурван өдрийн нэмэгдэл амралт олгоно.

49.8. Шүүгчийг орон нутагт шилжүүлэн ажиллах болон сэлгэн ажиллуулах тохиолдолд орон байраар хангана.

50 дугаар зүйл. Шүүгчийн мэргэшлийн түвшнийг дэмжих

50.1. Шүүгч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, мэргэшлээ дээшлүүлж байх үүрэгтэй бөгөөд жил бүр сургалтад хамрагдана.

50.2. Шүүгч мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдах хугацаанд түүнд шүүгчийн цалин хөлсийг хэвээр олгоно.

50.3. Шүүгчийн мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхтэй хамтран зохион байгуулна.

51 дүгээр зүйл. Шүүгчийн халдашгүй байдал

51.1. Шүүгч халдашгүй байх эрхтэй бөгөөд түүнийг Үндсэн хууль, энэ хууль болон бусад хуулиар хамгаална.

51.2. Шүүгчийн халдашгүй байдалд дараах зүйл хамаарна:

51.2.1. амь нас;

51.2.2. ажлын байр, хувийн болон албаны орон сууц;

51.2.3. эзэмшиж, ашиглаж байгаа хувийн болон албаны тээвэр, холбооны хэрэгсэл;

51.2.4. өөрийнх нь мэдэлд байгаа бичиг баримт, ачаа тээш, бусад эд хөрөнгө;

51.2.5. захидал харилцааны нууц.

51.3. Шүүгч эрх мэдлээ урвуулан ашигласан, илт хууль бус шийтгэх тогтоол, шийдвэр, шүүхийн бусад акт гаргасан, гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдсон нь хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр нотлогдоогүй тохиолдолд бүрэн эрх нь дуусгавар болсны дараа шүүн таслах ажиллагааг эрхэлж байх үедээ илэрхийлсэн санал, гаргасан шийдвэрийнх нь төлөө түүнийг ямар нэгэн хариуцлагад татахыг хориглоно.

51.4. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний амь нас, эрүүл мэндэд аюул занал учрах нөхцөл үүссэн тухай мэдээлэл авсан бол цагдаагийн байгууллага энэ байдлыг таслан зогсооход чиглэсэн арга хэмжээг даруй авах үүрэгтэй.

51.5. Энэ хуулийн 51.4-т заасан арга хэмжээг авах нөхцөл, журмыг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

51.6. Шүүгч нь аюулгүй байдлаа хамгаалах зорилгоор бие хамгаалах тусгай хэрэгслийг эзэмших, биедээ авч явах эрхтэй.

51.7. Шүүгчийг гэмт үйлдлийнх нь явцад, эсхүл гэмт хэргийн газарт эд мөрийн баримттай баривчилсан бол энэ тухай Сахилгын хороонд 48 цагийн дотор мэдэгдэнэ.

51.8. Сахилгын хороо ажлын 2 өдрийн дотор шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг анхан шатны хуралдаанаар тухайн шүүгчийг оролцуулан шийдвэрлэнэ.

51.9. Сахилгын хороо шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсэн бол Шүүхийн ерөнхий зөвлөлд танилцуулна.

51.10. Энэ хуулийн 51.7-д зааснаас бусад тохиолдолд шүүгчийг Сахилгын хорооны зөвшөөрөлгүйгээр баривчлах, цагдан хорих, орон байр, албан тасалгаа болон биед нь халдах, үзлэг, нэгжлэг хийхийг хориглоно.

51.11. Шүүгчийн бүрэн эрхийг энэ зүйлд заасан түдгэлзүүлсэн үндэслэл арилсан бол Сахилгын хороо шүүгчийн бүрэн эрхийг сэргээнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮГЧИД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

52 дугаар зүйл. Шүүгчид хориглох зүйл

52.1. Шүүгчид Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтаас гадна дараах зүйлийг хориглоно:

52.1.1. энэ хуульд заасан өөрийн бүрэн эрхээ урвуулан ашиглах;

52.1.2. албан үүрэгтэй нь холбоотой, эсхүл өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцыг задруулах;

52.1.3. шүүхээр хянан хэлэлцэгдэж байгаа хэрэг маргааны талаар хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гараагүй байхад өөрийн байр суурийг олон нийтэд мэдээлэх, илэрхийлэх;

52.1.4. албан ажлын хэрэгцээнд зориулсан материал, техник, санхүү, мэдээллийн хэрэгслийг шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зориулалтаар ашиглах;

52.1.5. олон нийтэд мэдээлэхийг хязгаарласан, эсхүл албаны бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж мэдсэн аливаа мэдээллийг олон нийтэд тараах, задруулах, шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхээс өөр зорилгоор ашиглах;

52.1.6. шүүгчийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан бусад шүүгчийн шүүн таслах ажиллагаанд хуульд зааснаас бусад хэлбэрээр оролцох, нөлөөлөх, заавар, удирдамж, чиглэл өгөх, авах, урьдчилан санал хэлэх;

52.1.7. шүүгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, хууль ёсны төлөөлөгч болон бусад иргэн, хуулийн этгээдээс шууд ба шууд бусаар тусламж авах, үйлчлүүлэх, ямар нэгэн давуу байдал, хөнгөлөлт, мөнгөн болон бусад урамшуулал, хууль тогтоомжоор зөвшөөрөгдөөгүй шагнал авах;

52.1.8. өөрийн, гэр бүлийн гишүүний, эсхүл албан байгууллагын эрх ашиг хөндөгдсөнөөс бусад тохиолдолд гуравдагч этгээдийн хууль ёсны төлөөлөгч байх;

52.1.9. шүүгч нь Ерөнхий шүүгч, шүүгчтэй гэр бүлийн гишүүн, төрөл, садны холбоотой бол шүүхэд ажиллах;

52.1.10. өөрөө, эсхүл итгэмжлэгдсэн этгээдээр дамжуулан аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх, аж ахуйн нэгж, тэдгээрийн холбоо, нэгдлийн удирдах бүрэлдэхүүнд орох, зохион байгуулалтын үйл ажиллагаа явуулах, эрх зүйн аливаа хэлбэрээр түр болон байнга оролцох;

52.1.11. Монгол Улсын олон улсын гэрээ, гадаад улсын шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцсоноос бусад

гадаад улс болон олон улсын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр багшлах, эрдэм шинжилгээний болон бусад ажил эрхлэх;

52.1.12. шинжлэх ухаанаас бусад гадаад улсын төр, олон нийтийн болон бусад байгууллагын хүндэт, тусгай цол, шагнал, одон, тэмдэг авах;

52.1.13. Монгол Улсын олон улсын гэрээгээр болон гадаад улсын шүүх, олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан тохиролцооноос өөр гадаад улс, олон улсын болон гадаадын байгууллага, гадаадын иргэн, харьяалалгүй хүний санхүүжилтээр гадаад улсад зорчих;

52.1.14. Монгол Улсын олон улсын гэрээгээр гадаад улсын холбогдох шүүх, олон улсын болон гадаадын байгууллагатай харилцан тохиролцооноос бусад Монголын Улсын нутаг дэвсгэрт оршин байгаа гадаад улсын болон олон улсын байгууллага, түүний салбар нэгжийн удирдах бүрэлдэхүүнд орох;

52.1.15. оюутанд үнэлгээ тавих эрхгүйгээр хууль зүйн чиглэлээр багшлах болон эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэхээс бусад хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсрах;

52.1.16. улс төрийн аливаа байгууллагын удирдах болон бусад албан тушаал эрхлэх, улс төрийн байгууллага, сонгуульд нэр дэвшигчийн талаар олон нийтэд хандаж үг хэлэх, сонгуулийнх нь сурталчилгаанд оролцох, улс төрийн сонгуульд нэр дэвшигчид санхүүжилт, хандив өгөх;

52.1.17. хэргийн нөгөө талыг байлцуулахгүйгээр нэг талтай уулзах;

52.1.18. хэргийн оролцогч болон бусад этгээдтэй харилцахдаа шүүхийн нэр хүнд, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох хувийн харилцаа тогтоох;

52.1.19. хэргийн оролцогч болон бусад этгээдтэй албан үүргийн хувьд харилцахдаа зүй бус авирлах;

52.1.20. амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгөө гэмт халдлагаас хамгаалах зорилгоор олгосон бие хамгаалах тусгай хэрэгслийг зориулалтын бусаар ашиглах, бусдад ашиглуулах.

53 дугаар зүйл. Шүүгчийн ашиг сонирхлын зөрчлийн зохицуулалт

53.1. Шүүгч шүүн таслах ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал байгаа бол оролцохоос татгалзах, эсхүл уг болзошгүй нөхцөл байдал үүсэж болохыг хэргийн оролцогчдод мэдэгдэж, тэдгээрийн татгалзан гаргах санал тавих боломжийг хангах үүрэгтэй.

53.2. Өөрийн хүсэлтээр шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөнөөс хойших хоёр жилийн хугацаанд өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

53.3. Шүүгчийн албан тушаалаас огцорсон, эсхүл өндөр насны тэтгэвэрт гарсан бол өмгөөллийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

54 дүгээр зүйл. Шүүгч, түүний гэр бүлийн гишүүний хөрөнгө, орлогын мэдүүлэг

54.1. Шүүгч нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан журмын дагуу хөрөнгө орлогын мэдүүлэг, хувийн ашиг сонирхлын мэдүүлгийг үнэн зөв гаргаж өгөх үүрэгтэй.

54.2. Баяр ёслолын арга хэмжээ, албан томилолтын болон албан ёсны бусад арга хэмжээтэй холбогдуулан бусдаас шүүгчид өгсөн бэлэг, дурсгалын зүйлийг төрийн өмчид тооцох бөгөөд хуулиар тогтоосон журмаар өөрөө худалдан авах саналаа гаргаагүй бол шүүгч тэдгээрийг өөрийн ажиллаж байгаа шүүхэд баримттайгаар хүлээлгэн өгнө.

55 дугаар зүйл. Шүүгчийн иргэний эрхэд тавих хязгаарлалт

55.1. Шүүх эрх мэдлийн бие даасан, шүүгчийн хараат бус, халдашгүй байдлын үндсэн зарчмаас хамааран шүүгчийн хувийн буюу иргэний эрхэд дараах хязгаарлалт тогтооно:

55.1.1. улс төрийн намд харьяалагдах;

55.1.2. улс төрийн нам, олон нийтийн бусад байгууллага болон иргэдэд улс төр, шашны асуудлаар байр сууриа илэрхийлэх;

55.1.3. хөдөлмөрийн маргаанаа зохицуулах зорилгоор албан үүргээ орхих буюу зогсоох.

55.2. Шүүгч улс төрийн сонгуульд улс төрийн аль нэг намаас буюу бие даан нэр дэвших бол тухайн сонгуулийн жилийн 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө хүсэлтээ Шүүхийн ерөнхий зөвлөлд өгч, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөн байна.

55.3. Шүүгч энэ хуульд заасны дагуу улс төрийн үйл ажиллагаанд оролцож, шүүгчийн албан тушаалаас чөлөөлөгдсөний дараа дахин шүүгчээр ажиллахыг хүсвэл чөлөөлөгдсөнөөсөө хойш гурван жилийн дараа шүүгчийн сонгон шалгаруулалтад орж болно.

АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮГЧИЙН ХАРИУЦЛАГА ШҮҮГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

56 дугаар зүйл. Шүүгчид хүлээлгэх хариуцлага

56.1. Шүүгч зөвхөн хуульд захирагдах, шударга ёсны зарчим болон шүүгчийн ёс зүйг зөрчсөн бол холбогдох сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл хуульд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

56.2. Шүүгчийн гаргасан алдаа, зөрчлийн улмаас хувь хүн, хуулийн этгээдэд учруулсан гэм хорыг Иргэний хуульд заасны дагуу төр хариуцан арилгана.

56.3. Шүүгч Шүүгчийн ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

57 дугаар зүйл. Шүүгчийн ёс зүйн зөрчил

57.1. Шүүхийн сахилгын хороо дараах ёс зүйн зөрчил (цаашид "шүүгчийн ёс зүйн зөрчил" гэх) гаргасан шүүгчид сахилгын шийтгэл оногдуулна:

57.1.1. энэ хуулийн 52 дугаар зүйлд заасан хориглосон үйл ажиллагааг зөрчсөн;

57.1.2. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн;

57.1.3. шүүхийн байгууллага дахь хөдөлмөрийн харилцааг зохицуулсан хуулиар тогтоосон журмыг зөрчсөн.

58 дугаар зүйл. Шүүгчийн мэргэжлийн хариуцлагын зөрчил

58.1. Шүүгч хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны журам болон хуулийн тодорхой заалтыг ноцтой зөрчсөн, хуулийг илтэд буруу хэрэглэсэн бол тухайн шүүгчийн мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварт дүгнэлт гаргуулахаар давж заалдах болон хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн тогтоол гаргаж, Мэргэшлийн хороонд хүргүүлнэ.

59 дүгээр зүйл. Шүүгчид ногдуулах сахилгын шийтгэл

59.1. Шүүгч ёс зүйн зөрчил гаргасан бол Сахилгын хороо доор дурдсан сахилгын арга хэмжээний аль нэгийг оногдуулна:

59.1.1. сануулах /хаалттай, нээлттэй/;

59.1.2. тодорхой хугацаагаар шүүгчийн ёс зүйн сургалтад суухыг даалгах;

59.1.3. зэрэг дэвийг зургаан сараас нэг жилийн хугацаагаар бууруулах;

59.1.4. огцруулах.

59.2. Сахилгын зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гаргаснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол шүүгчид сахилгын шийтгэл оногдуулж болохгүй.

59.3. Энэ хуульд заасан хугацааг тодорхойлох, тоолоход Иргэний хуулийн Наймдугаар бүлэгт заасан зарчмыг баримтална.

59.4. Шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс хойш 1 жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээгээгүй бол түүнийг сахилгын шийтгэлгүйд тооцно.

АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ

60 дугаар зүйл. Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн бүрэн эрх

60.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар анхан шатны шүүх эрүүгийн хэрэг, эрх зүйн маргаан /цаашид "хэрэг, маргаан" гэх/-ыг анхан шатны журмаар, хамтын зарчмаар хянан шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчийг оролцуулна.

60.2. Иргэдийн төлөөлөгч хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх анхан шатны шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу оролцоно.

60.3. Иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанаас өмнө хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн, хэрэг, маргааныг хэнээс ч хараат бусаар шийдвэрлэхээ батлан тангараглана.

60.4. Энэ хуулийн 60.3-т заасан тангараг өргөх журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

61 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчид тавих шаардлага

61.1. Иргэдийн төлөөлөгч дараах шаардлага хангасан байна:

61.1.1. эрх зүйн бүрэн чадамжтай, 25 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх;

61.1.2. тухайн анхан шатны шүүхийн харьяаллын нутаг дэвсгэрт байнга оршин суудаг байх;

61.1.3. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй.

62 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийн үйл ажиллагаанд хориглох зүйл

62.1. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгчид дараах зүйлийг хориглоно:

62.1.1. шүүх хуралдааныг орхин явах, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирэхгүй байх;

62.1.2. шүүх хуралдааны дэгийг сахин биелүүлэхгүй байх;

62.1.3. хэргийн оролцогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчтэй уулзах;

62.1.4. хэргийн талаар нотлох баримт цуглуулах;

62.1.5. өөрт нь итгэмжлэн мэдэгдсэн төрийн болон албаны, байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг задруулах;

62.1.6. хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд хэргийн талаар мэдээлэл өгөх.

62.2. Энэ хуулийн 62.1-д заасан заалтын хэрэгжилтэд Шүүхийн ерөнхий зөвлөл хяналт тавьж, зөрчсөн этгээдийн иргэдийн төлөөлөгчөөр сонгогдох эрхийг хасна.

62.3. Улс төрийн болон төрийн тусгай албан тушаалтныг иргэдийн төлөөлөгчөөр сонгохыг хориглоно.

63 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийн хараат бус байдал

63.1. Шүүгч, прокурор, өмгөөлөгч, хэргийн оролцогч болон бусад этгээдийн зүгээс иргэдийн төлөөлөгчид аливаа хэлбэрээр нөлөөлөхийг хориглоно.

63.2. Энэ хуулийн 63.1-д заасан нөхцөл байдал бий болсон гэж үзсэн тохиолдолд иргэдийн төлөөлөгч энэ хуульд заасан нөлөөллийн мэдүүлэг бөглөх бөгөөд нөлөөллийн мэдүүлгийн загварыг Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

63.3. Энэ хуулийн 65.1-д заасны дагуу сонгогдсон иргэдийн төлөөлөгчийн нэрсийг шүүгч, шүүхийн ажилтан шүүх хуралдаанаас өмнө задруулахыг хориглоно.

64 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт

64.1. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийг шалгаруулах журам, иргэдийн төлөөлөгчийг сургалтад хамруулах нэгдсэн төлөвлөгөөг тус тус батална.

64.2. Иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг анхан шатны шүүхийн тамгын газраас нутгийн захиргааны байгууллагатай хамтран гаргаж, баталгаажуулна.

64.3. Энэ хуулийн 64.2-т заасны дагуу гаргасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалт 2 жил хүчинтэй байна.

64.4. Энэ хуулийн 64.3-т заасан хугацаа дуусахаас гурван сарын өмнө шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтыг шинэчлэх бэлтгэл ажлыг хийнэ.

64.5. Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтад орсон иргэнийг энэ хуулийн 61 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгаж, мэдээллийн сан бүрдүүлнэ.

64.6. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчийн оролцооны талаар судалгаа, дүн шинжилгээ, тоон мэдээг тогтмол гаргана.

65 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг сонгох

65.1. Энэ хуулийн 64.2-т заасан иргэдийн төлөөлөгчийн нэрсийн жагсаалтаас иргэдийн төлөөлөгчийг шалгаруулах ажлыг тухайн шүүхийн тамгын газар зохион байгуулна.

65.2. Шүүх энэ хуулийн 64.2-т заасан нэрсийн жагсаалтаас 14 хоног тутам 10-15 хүний нэрийг тохиолдлын журмаар сонгон тухайн шүүхийн тамгын газрын даргаар батлуулна.

65.3. Шүүх хуралдааны тов гармагц энэ хуулийн 65.2-т заасан жагсаалтад орсон иргэдийн төлөөлөгчдөөс шүүх хуралдаанд тохиолдлын журмаар оролцуулна.

65.4. Шүүх хуралдаанд оролцох иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэнд шүүх хуралдаан болохоос ажлын таваас доошгүй өдрийн өмнө мэдэгдэх хуудсаар мэдэгдэж, баримтыг хэрэгт хавсаргана.

65.5. Энэ хуулийн 65.4-т заасан шүүхийн мэдэгдэх хуудсыг хүлээн авсан иргэдийн төлөөлөгч хүндэтгэн үзэх шалтгаантай бол энэ тухайгаа тухайн шүүхийн тамгын газарт даруй мэдэгдэнэ.

65.6. Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчөөр сонгогдсон иргэний ажил олгогчид мэдэгдэл хүргүүлнэ.

65.7. Энэ хуулийн 65.6-д заасан ажил олгогч шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцох болсон ажилтандаа чөлөө олгож, аливаа байдлаар саад учруулахгүй байх үүрэг хүлээнэ.

66 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг татгалзан гаргах

66.1. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа иргэдийн төлөөлөгч өөрөө татгалзан гарах, эсхүл хэргийн бусад оролцогчдоос түүнийг татгалзах хүсэлт гаргасан бол шүүх бүрэлдэхүүн шийдвэрлэж тогтоол гаргана.

67 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгчийг мэдээллээр хангах

67.1. Шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчдөд шүүх хуралдаанд оролцохоос нь өмнө эрх, үүрэг, хүлээх хариуцлага, шүүх хуралдааны дэгийн талаар мэдээлэл өгнө.

67.2. Шүүхийн ерөнхий зөвлөл иргэдийн төлөөлөгчдөд зориулсан гарын авлага боловсруулж, шүүхүүдэд хүргүүлэх бөгөөд тухайн шүүхийн тамгын газар иргэдийн төлөөлөгчийг гарын авлагаар хангана.

67.3. Шүүх хуралдаанд иргэдийн төлөөлөгчөөр оролцохын ач холбогдлыг иргэдэд ухуулан таниулах ажлыг Шүүхийн ерөнхий зөвлөл болон тухайн шүүхийн тамгын газар хариуцан ажиллана.

68 дугаар зүйл. Иргэдийн төлөөлөгч оролцох

68.1. Хэрэг, маргааныг анхан шатны журмаар шүүх бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд 3 хүртэл иргэдийн төлөөлөгч оролцоно.

68.2. Энэ хуулийн 65.3-т заасан иргэдийн төлөөлөгч шүүх хуралдаанд оролцох боломжгүй бол нөөцөд байгаа иргэдийн төлөөлөгчдөөс оролцуулна.

69 дүгээр зүйл. Иргэдийн төлөөлөгчийг ажиллах нөхцөлөөр хангах, хөлс олгох

69.1. Иргэдийн төлөөлөгчийн ажиллах нөхцөлийг тухайн шүүхийн тамгын газар хариуцан ажиллана.

69.2. Иргэдийн төлөөлөгчийн хөлс болон албан томилолт, замын зардлыг шүүхийн төсвөөс олгоно.

69.3. Иргэдийн төлөөлөгчид хөлс болон албан томилолт, замын зардлыг олгох журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛ, БҮРЭЛДЭХҮҮН, БҮТЭЦ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

70 дугаар зүйл. Шүүхийн захиргаа

70.1. Шүүхийн захиргаа нь Шүүхийн ерөнхий зөвлөл /цаашид "Ерөнхий зөвлөл" гэх/, түүний ажлын алба, бүх шатны шүүхийн тамгын газар болон бусад туслах нэгжээс бүрдэнэ.

70.2. Шүүхийн захиргаа нь шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс хэрэг, маргааныг шийдвэрлэхэд арга зүй, мэдээлэл, судалгаа, санхүү, аж ахуй, техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэн, ажиллах нөхцөлөөр хангах үндсэн чиг үүрэгтэй байна.

71 дүгээр зүйл. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд баримтлах зарчим

71.1. Шүүхийн захиргааны үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

- 71.1.1. бие даасан, хараат бус байх;
- 71.1.2. шүүн таслах ажиллагаанд оролцох, нөлөөлөхийг хориглох;
- 71.1.3. мэргэшсэн, тогтвортой байх;
- 71.1.4. шүүхийн үйлчилгээ шуурхай, хүртээмжтэй байх;

72 дугаар зүйл. Ерөнхий зөвлөл, түүний чиг үүрэг

72.1. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Ерөнхий зөвлөл шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилго бүхий шүүхийн захиргааны төв байгууллага мөн.

72.2. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

- 72.2.1. захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх;
- 72.2.2. шүүхийг хүний нөөцөөр хангах;
- 72.2.3. шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах;
- 72.2.4. шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах;
- 72.2.5. мэдээллээр хангах.

72.3. Ерөнхий зөвлөл соёмбо бүхий тамга, тогтоосон загвараар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

73 дугаар зүйл. Захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх

73.1. Ерөнхий зөвлөл захиргааны удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

73.1.1. Шүүх эрх мэдлийн тогтолцоо, бүтцийг боловсронгуй болгох асуудлыг судалж, санал, шийдвэрийн төсөл боловсруулан холбогдох байгууллагад уламжлах;

73.1.2. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн байршлыг тогтоох, шүүх байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах асуудлыг боловсруулан Засгийн газар болон Улсын дээд шүүхтэй зөвшилцөн Улсын Их Хуралд уламжлах, гарсан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах;

73.1.3. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн шүүгчийн орон тоо, бүх шатны шүүхийн шүүгчийн цалин хөлсний хэмжээг тогтоох тухай саналыг Улсын Их Хурал өргөн мэдүүлэх,

73.1.4. шүүх эрх мэдлийн хүрээнд дагаж мөрдөх хууль тогтоомж, эрх зүйн бусад акт, бодлогын баримт бичгийн төсөл боловсруулах, санал өгөх, эрх бүхий этгээд, хууль санаачлагчид уламжлах;

73.1.5. өөрийн эрх хэмжээний хүрээнд холбогдох стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх;

73.1.6. шүүхийг хэвийн, тасралтгүй ажиллах зохион байгуулалтын нөхцөлөөр хангах;

73.1.7. шүүхийн тамгын газрыг байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаар, үйл ажиллагааны нийтлэг дүрмийг тогтоох,

73.1.8. шүүхийн тамгын газар, шүүхийн төрөлжсөн төв архивд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх,

73.1.9. шүүхийн тамгын газрын ажлын үр дүн, түүний даргын ажил үүргийн хуваарийг тодорхойлох, ажлын гүйцэтгэлийн чанар, үр дүнг үнэлэх;

73.1.10. шүүх дэх захиргааны албыг удирдаж, энэ талаар Төрийн албаны зөвлөлтэй хамтран ажиллах,

73.1.11. шүүхийн тамгын газрын үйл ажиллагаанд мэдээллийн технологи, шүүхийн үйлчилгээ, удирдлагын шинэ хэлбэрийг нэвтрүүлэх нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх,

73.1.12. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүртгэл, хяналтын нэгдсэн систем, программ хангамжийг хөгжүүлэх, хэвийн ажиллагааг хангах,

73.1.13. шүүхийн тамгын газар хэргийн хөдөлгөөний удирдлагын чиг үүргээ хэрэгжүүлж байгаа байдалд дүн шинжилгээ хийж, нэгдсэн аргачлал, загвар батлах, мөрдүүлэх,

73.1.14. шүүх хуралдааны дуу авиа, дүрс бичлэг хийх, тэдгээрийг архивлах болон хэргийн оролцогчийг шүүх хуралдаанд зайнаас оролцуулах ажлыг зохион байгуулах журмыг хуульд заасны дагуу батлах;

73.1.15. шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн хуульд заасан эрх, үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл, лавлагаагаар хангах, аливаа нөлөөллөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах, иргэдийн төлөөлөгчийн хориглосон үйлдэлд хяналт тавих, үйлдэл гарсан тохиолдолд холбогдох байгууллагад хандах;

73.1.16. шүүх дэх эвлэрүүлэн зуучлах үйл ажиллагааны зохион байгуулалтыг хангах;

73.1.17. өөрийн эрх хэмжээний хүрээнд иргэдийн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хянан шийдвэрлэх, энэ талаар шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг шалгах, хяналт тавих;

73.1.18. шүүхийн тээвэр, холбоо, мэдээлэл шинжилгээ, программ хангамж, тэдгээрийн ашиглалт, хамгаалалт, засвар үйлчилгээг зохион байгуулах;

73.1.19. техник хэрэгсэл, түүнийг ашиглах мэргэжилтнээр хангаж, засвар үйлчилгээг зохион байгуулах;

73.1.20. шүүхийн нэгдсэн сүлжээнд шүүх болон шүүхийн захиргааны байгууллагыг холбож, түүнийг ашиглах техникийн нөхцөлөөр хангах;

73.1.21. шүүхийн байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, холбогдох дүрэм, журам баталж мөрдүүлэх;

73.1.22. шүүгч, түүний гэр бүлийн гишүүний аюулгүй байдлыг хангах талаар шаардлагатай арга хэмжээг цаг тухайд нь зохион байгуулах;

73.1.23. Шүүх хуралдааны дэг сахиулах, шүүгч, шүүх бүрэлдэхүүн, шүүх хуралдаанд оролцогчдын аюулгүй байдлыг хангах, яллагдагчийг хуяглан хүргэх, шүүхийн дуудсанаар ирэхгүй байгаа яллагдагч, гэрч, зохигч, хэргийн оролцогчийг албадан ирүүлэх, шүүхээс оргон зайлсан яллагдагч, ялтныг эрэн сурвалжлах үүргийг цагдаагийн байгууллага гүйцэтгэх ба журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

73.1.24. Монгол Улсын олон улсын гэрээ болон хууль тогтоомж, Засгийн газраас баталсан журмын дагуу гадаад улсын адил түвшний байгууллага, эсхүл олон улсын байгууллагатай өөрийн эрх хэмжээний асуудлаар байгууллага хоорондын гэрээ байгуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэх;

73.1.25. хэргийн хөдөлгөөний хяналтын болон мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, бүх шатны шүүхүүдийн шүүх хуралдааны товыг нэгдсэн системд байршуулах;

73.1.26. хуульд заасан бусад бүрэн эрх.

74 дүгээр зүйл. Шүүхийг хүний нөөцөөр хангах

74.1. Ерөнхий зөвлөл нь шүүхийг хүний нөөцөөр хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

74.1.1. хүний нөөцийн бүртгэл, судалгаа, төлөвлөлт, хуваарилалт, хангалтыг зохион байгуулах, шүүхийн захиалга, судалгаанд үндэслэн шүүхийн хүний нөөцийн хөдөлгөөнийг удирдах;

74.1.2. шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх, сонгон шалгаруулах ажлыг энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулах;

74.1.3. шүүгчийг томилуулах, шилжүүлэх, сэлгэн ажиллуулах, албан тушаалаас нь чөлөөлүүлэх, түдгэлзүүлэх, огцруулах тухай саналыг Ерөнхийлөгчид өргөн мэдүүлэх;

74.1.4. Мэргэшлийн хорооны үйл ажиллагааг удирдлага, зохион байгуулалтаар хангах, дарга, гишүүдийг томилох, чөлөөлөх;

74.1.5. шүүгчид тавих болзол, шаардлагыг үнэлэх, шалгаруулах болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшний талаар дүгнэлт гаргах журам, шалгуурыг Мэргэшлийн хороотой хамтран боловсруулж, батлах, зохион байгуулах.

74.1.6. шүүгч болон шүүхийн захиргааны ажилтныг дадлагажуулах, мэргэшлийг нь дээшлүүлэх сургалтыг Улсын дээд шүүх болон сургалтын байгууллагатай хамтран зохион байгуулах;

74.1.7. шүүхийн захиргааны байгууллагын ажилтны ажил хэргийн ур чадвар, мэргэшлийн түвшинг тодорхойлох шалгуур үзүүлэлт, журмыг тогтоож хэрэгжүүлэх;

74.1.8. хууль тогтоомжийн дагуу шүүхийн захиргааны ажилтанд зэрэг дэв олгох, түүнийг төрийн шагнал, хүндэт цолд тодорхойлох, шүүхийн шагналын журмыг баталж, мөрдүүлэх,

74.1.9. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх;

74.1.10. гурван сараас дээш хугацаагаар эмчилгээ хийлгэх, зургаан сараас дээш хугацаагаар суралцах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх бол чөлөө олгох.

75 дугаар зүйл. Шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

75.1. Ерөнхий зөвлөл шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

75.1.1. энэ хуульд заасан шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах ажлыг хэрэгжүүлэх, зөрчигдсөн тодорхой тохиолдолд арга хэмжээ авах;

75.1.2. шүүгчийн хараат бус, халдашгүй байдалд сөргөөр нөлөөлсөн, шүүгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөх нөхцөл үүссэн тохиолдолд холбогдох арга хэмжээ авах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх.

75.1.3. шүүх дэх авлига, ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг хуульд заасны дагуу зохион байгуулах;

75.1.4. хуульд заасан бусад.

76 дугаар зүйл. Шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах

76.1. Ерөнхий зөвлөл шүүхийн санхүү, эдийн засгийн баталгааг хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

76.1.1. бүх шатны шүүхийн үйл ажиллагааны болон хөрөнгө оруулалтын төсвийг төсвийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, Засгийн газартай зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

76.1.2. шүүхийн төсвийг зориулалтын дагуу хуваарилан, төсвийн гүйцэтгэлийг үр ашигтай зохион байгуулах;

76.1.3. шүүхийн эдийн засаг, санхүү, хөдөлмөр, ажлын нөхцөлийн болон бусад баталгааг хангах ажлыг зохион байгуулах, шаардлагатай бол эдийн засаг, нийгмийн хамгааллын болон материал, техник хангамж зэрэг асуудлыг Засгийн газарт танилцуулж, шийдвэрлүүлэх;

76.1.4. шүүн таслах ажиллагааг хэвийн явуулах, мэтгэлцэх зарчмыг хэрэгжүүлэх, олон нийтэд нээлттэй байлгах, аюулгүй байдлыг хангах стандартад нийцсэн шүүхийн байр, хуралдааны танхим болон бусад барилга байгууламж барих, засвар хийх хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг төлөвлөх, зураг төсвийг захиалан боловсруулж, гүйцэтгэлийг хангах.

76.1.5. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн санхүү, эдийн засаг, нягтлан бодох бүртгэлийн ажлыг зохион байгуулж, хянан шалгаж удирдах;

76.1.6. шүүхийг орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр хангах нэгдсэн бодлого батлах, хэрэгжүүлэх;

76.1.7. шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах.

76.2. Шүүх, шүүгч нь үйл ажиллагаагаа хараат бусаар явуулахад шаардагдах байнгын болон нүүдэллэн ажиллах байр, иргэдийг хүлээн авах болон шүүх хуралдааны танхим, тээвэр, холбоо, мэдээллийн болон тусгай зориулалтын техник хэрэгсэл, тавилга, тоног төхөөрөмж, хамгаалалтаар хангагдсан байх бөгөөд тэдгээрийн стандарт, нөхцөлийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

77 дугаар зүйл. Мэдээллээр хангах

77.1. Ерөнхий зөвлөл мэдээллээр хангах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

77.1.1. шүүхийн болон гэмт хэргийн статистик мэдээлэл гаргах;

77.1.2. шүүхийн статистикийн нэгдсэн тайлан, мэдээг гаргах, судлах, боловсруулалт хийх;

77.1.3. шүүхийн шүүн таслах болон захиргааны ажлын практикийг судлах;

77.1.4. шүүхийн цахим болон бусад хэлбэрийн мэдээллийн сан бүрдүүлэх;

77.1.5. эрх зүйн онол, практикийн судалгаа, гарын авлага зэрэг албан хэрэгцээний сан бүрдүүлж, тогтмол шинэчлэх, ашиглалтыг зохион байгуулах.

77.1.6. шүүхийг Монгол Улсын хуулийн албан ёсны эхээр тогтмол хангах болон хууль тогтоомжийн актын бүртгэл, лавламжийн ажлыг зохион байгуулах;

77.2. Ерөнхий зөвлөл болон шүүхийн тамгын газар дараах байдлаар олон нийтийг мэдээллээр хангана:

77.2.1. шүүхийн бие даасан байдлыг хангах, шүүхийг захиргааны удирдлагаар хангах, шүүгчдийг шилж олох, шүүгчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах бүрэн эрхийн хэрэгжилтийн талаар цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тогтмол мэдээлэх;

77.2.2. шүүхийн шийдвэр, тогтоолыг эмхэтгэн хэвлэх болон цахим хуудсанд тогтмол байрлуулах;

77.2.3. шүүхийн цахим хуудсыг тогтмол шинэчлэх;

77.2.4. мэдээлэл, лавлагааны үйлчилгээг зохион байгуулах;

77.2.5. шүүхийн үйл ажиллагааны талаар олон нийтийн саналыг бичгээр болон цахим хэлбэрээр авах ажлыг зохион байгуулах.

78 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүн, бүрэн эрхийн хугацаа

78.1. Ерөнхий зөвлөл арван гишүүнээс бүрдэх бөгөөд тэдгээр нь дөрвөн жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа ажиллана.

78.2. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос /цаашид "Байнгын хороо" гэх/ гурав, Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс хоёрыг тус тус нээлттэйгээр зохих журмын дагуу нэр дэвшүүлж томилох бөгөөд ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох таван шүүгчийг Шүүгчдийн зөвлөлөөс нууцаар санал хураан сонгосон Улсын дээд шүүх, давж заалдах шатны шүүхийн тус бүр нэг, анхан шатны шүүхийн гурван шүүгч тус тус орно.

78.3. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгч нь шүүгчээр таваас доошгүй жил ажилласан, бусад гишүүд нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

78.4. Ерөнхий зөвлөлийн даргыг нууц санал хураалтаар гишүүд дотроосоо орон тооны гишүүдээс олонхийн саналаар сонгоно.

78.5. Ерөнхий зөвлөлийн гишүүдийн Шүүгчдийн зөвлөлөөс сонгогдсон болон Байнгын хороо, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын

гишүүнээс томилогдсон тус бүр нэг гишүүн орон тооны, бусад гишүүд нь орон тооны бус байна.

78.6. Ерөнхий зөвлөлийн гишүүдийн гуравны хоёр нь бүрдсэнээр түүнийг бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцно.

78.7. Ерөнхий зөвлөлийн орон тооны гишүүн нь төрийн өндөр албан тушаалтны зэрэг, зиндаа, түүнтэй адилтгах албан тушаалтны зэрэглэлд тохирсон цалин хөлс авч, зайлшгүй шаардлагатай бусад хангамж эдэлж, хуульд заасан баталгаагаар хангагдана.

78.8. Ерөнхий зөвлөлийн дарга, орон тооны гишүүний цалингийн хэмжээ, орон тооны бус гишүүнд урамшуулал олгох журмыг тус зөвлөлийн өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал тогтооно.

78.9. Ерөнхий зөвлөлийн гишүүний ёс зүйн дүрмийг тус зөвлөл баталж, мөрдөнө.

79 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох, сонгох журам

79.1. Байнгын хороо Ерөнхий зөвлөлийн гишүүнийг дараах журмаар нэр дэвшүүлж, томилно.

79.1.1. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас жараас доошгүй хоногийн өмнө Байнгын хорооноос Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах тухай олон нийтийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр мэдээлнэ.

79.1.2. Энэ хуульд заасан шаардлагыг хангасан иргэн сонгон шалгаруулалтыг нийтэд мэдээлснээс хойш гуч хоногийн дотор нэр дэвших тухай хүсэлтээ Байнгын хороонд хүргүүлнэ.

79.1.3. Байнгын хороо ажлын хэсэг байгуулж, 15 хоногийн дотор сонгон шалгаруулалт явуулна.

79.1.4. Байнгын хороо 7 хоногийн дотор хэлэлцэж, Байнгын хорооны гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар Ерөнхий зөвлөлийн гишүүнийг томилно.

79.1.5. Байнгын хороо нэр дэвшигчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнд томилохоос татгалзсан бол арван дөрвөн хоногийн дотор энэ хуульд заасан журмын дагуу өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

79.1.6. Байнгын хороо нэр дэвшигчийг татгалзсан тохиолдолд тухайн хүний нэрийг дахин дэвшүүлж болохгүй.

79.2. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилохдоо энэ зүйлийн 79.1.1, 79.1.2, 79.1.3, 79.1.4, 79.1.5, 9.1.6-д заасан журмыг баримтлах бөгөөд Ерөнхий зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, томилох журмыг Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

79.3. Ерөнхий зөвлөлийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг Шүүгчдийн зөвлөлийн төлөөлөгчид дундаасаа нэр дэвшүүлж, нууцаар санал хурааж сонгоно.

79.4. Ерөнхий зөвлөлийн гишүүнд шүүгчийг нэр дэвшүүлэх, сонгох ажиллагаанд шүүгчийн хараат бус, нээлттэй, ил тод байдлыг хангах журмыг Шүүгчдийн зөвлөл баталж, мөрдүүлнэ.

79.5. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, эсхүл хугацаанаас өмнө чөлөөлөгдсөн буюу эгүүлэн татагдсан бол дараагийн гишүүнийг эрх бүхий этгээд сул орон тоо гарснаас хойш 60 хоногийн дотор нөхөн томилох буюу сонгоно.

79.6. Нөхөн сонгогдсон буюу томилогдсон Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь орон гарсан гишүүний бүрэн эрхийн үлдсэн хугацаатай адил байна.

80 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн ажлын алба

80.1. Ерөнхий зөвлөл өөрийн гишүүдэд үүргээ гүйцэтгэхэд нь туслалцаа үзүүлэх, Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүрэг бүхий ажлын албатай байх бөгөөд Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангана.

80.2. Ерөнхий зөвлөл батлагдсан төсвийн хүрээнд зохион байгуулалтын бүтцээ өөрөө тогтоох бөгөөд ажлын албаны үйл ажиллагааг дүрмээр зохицуулна.

80.3. Ерөнхий зөвлөл ажлын алба нь энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлэх мэргэшсэн нэгжээс бүрдэнэ.

80.4. Ерөнхий зөвлөлийн дэргэд иргэний болон захиргааны хэргийн хавтаст хэргийн төрөлжсөн төв архив, бүх шатны шүүхийн тамгын газарт түүний салбар архив ажиллана.

81 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн хуралдаан, түүнээс гарах шийдвэр

81.1. Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь зөвлөлийн хуралдаан /цаашид "Хуралдаан" гэх/ байх бөгөөд хуралдаанаас тогтоол гаргана.

81.2. Хуралдааныг сард хоёроос доошгүй удаа хийх бөгөөд гишүүдийн олонхийн ирцтэйгээр хэлэлцэн, хуралдаанд оролцогчдын дийлэнх олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

81.3. Ерөнхий зөвлөл хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

81.4. Ерөнхий зөвлөлийн ээлжит бус хуралдааныг Ерөнхий зөвлөлийн даргын санаачилгаар, эсхүл гишүүдийн олонхийн шаардсанаар зарлан хуралдуулна.

81.5. Ерөнхий зөвлөлийн дарга гарын үсэг зурж, тамга дарснаар энэ хуулийн 81.1-д заасан тогтоол хүчин төгөлдөр болно.

81.6. Ерөнхий зөвлөлийн орон тооны болон орон тооны бус гишүүд саналын тэгш эрхтэй оролцоно.

82 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн даргын бүрэн эрх

82.1. Ерөнхий зөвлөлийн дарга нь гишүүний бүрэн эрхээс гадна дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

82.1.1. Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааг удирдах;

82.1.2. Ерөнхий зөвлөлийг тэргүүлж, түүнийг дотоод, гадаадад төлөөлөх;

82.1.3. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаараа Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, холбогдох бусад байгууллага, албан тушаалтантай харилцах;

82.1.4. Улсын Их Хурлын нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаан, Засгийн газрын хуралдаанд Ерөнхий зөвлөлийн байр суурийг илэрхийлэх, төсвийн болон бусад асуудлыг шийдвэрлүүлэх;

82.1.5. Ерөнхий зөвлөлийн хуралдааныг товлох, даргалах, хуралдааны бэлтгэл, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

82.1.6. Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

82.1.7. Ажлын алба, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах,

82.1.8. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын даргад нэр дэвшүүлэх, сахилгын шийтгэл ногдуулах,

82.1.9. Ерөнхий зөвлөлийн ажлын албыг ерөнхий удирдлагаар хангах;

82.1.10. Шүүгчийн хараат бус байдлыг хангахтай холбоотой Ерөнхий зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Улсын дээд шүүхэд жил бүр танилцуулах,

82.1.11. Ерөнхий зөвлөлийн ажлын тайланг Шүүгчдийн зөвлөлд танилцуулах,

82.1.12. Шүүхийн төрийн захиргааны албан хаагчдын зэрэг дэвийг холбогдох журмын дагуу олгох,

82.1.13. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

82.2. Ерөнхий зөвлөлийн дарга нь Ерөнхий зөвлөлийн ажлын алба, аймаг, нийслэл, сум, сум дундын, дүүргийн болон дагнасан шүүх, шүүхийн захиргааны бусад байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч байна;

82.3. Ерөнхий зөвлөлийн дарга бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ Засгийн газрын гишүүнтэй адил бүрэн эрхийн баталгаа, хангамжтай байна.

82.4. Ерөнхий зөвлөлийн даргын түр эзгүйд түүний үүргийг хамгийн ахмад настай орон тооны гишүүн нь орлон гүйцэтгэнэ.

82.5. Ерөнхий зөвлөлийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

83 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн гишүүний бүрэн эрх

83.1. Ерөнхий зөвлөлийн гишүүн дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

83.1.1. орон тооны гишүүний хувьд Ерөнхий зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүлэх чиг үүргийг хариуцах;

83.1.2. Ерөнхий зөвлөлийн хуралдаанаар тодорхой асуудал хэлэлцүүлэх санал оруулах;

83.1.3. Ерөнхий зөвлөлийн хуралдаанд таслах эрхтэй оролцох;

83.1.4. Ерөнхий зөвлөлийн шийдвэрийн биелэлтийг хангуулах;

83.1.5. Ерөнхий зөвлөлийн хуралдааныг зарлан хуралдуулахаар шаардах;

83.1.6. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

84 дүгээр зүйл. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах

84.1. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

84.1.1. бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон;

84.1.2. тэтгэврийн насанд хүрсэн болон эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгаанаар албан үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон;

84.1.3. өөрөө хүсэлт гаргасан болон өөр ажил, албан тушаалд томилогдсон буюу сонгогдсон.

84.2. Ерөнхий зөвлөлийн дарга, гишүүнийг дараах үндэслэлээр огцруулна:

84.2.1. хуралдааныг удаа дараа хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан;

84.2.2. ёс зүйн ноцтой алдаа гаргасан;

84.2.3. гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрээр тогтоогдсон.

84.3. Шүүгчдийн зөвлөл энэ хуулийн 84.2-т заасан үндэслэлээр шүүгчийг Ерөнхий зөвлөлийн гишүүнээс эгүүлэн татна.

85 дугаар зүйл. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга, түүний бүрэн эрх

85.1. Ерөнхий зөвлөлийн гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь Ажлын албаны төсвийн шууд захирагч байх бөгөөд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

85.1.1. Ерөнхий зөвлөлийн ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах;

85.1.2. Ерөнхий зөвлөлийн ажлын албаны ажилтныг Ерөнхий зөвлөлийн даргатай зөвшилцөн томилох, чөлөөлөх;

85.1.3. ажлын албаны төсвийг захиран зарцуулах, тайлагнах;

85.1.4. Ерөнхий зөвлөлийн хуралдааны бэлтгэл, түүний шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

85.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

85.2. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга хууль зүйн дээд боловсролтой, шүүхийн байгууллагад ажилласан туршлагатай, Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.1-д заасан тэргүүн түшмэлийн ангилалд хамаарах албан тушаалд тавигдах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэн байна.

85.3. Гүйцэтгэх нарийн бичгийн даргыг Ерөнхий зөвлөлийн даргын санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

85.4. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга бүрэн эрхийнхээ асуудлаар тушаал гаргана.

85.5. Гүйцэтгэх нарийн бичгийн дарга нь үйл ажиллагаагаа Ерөнхий зөвлөлд хариуцан тайлагнана.

86 дугаар зүйл. Шүүхийн мэргэшлийн хороо

86.1. Шүүхийн мэргэшлийн хороо /цаашид "Мэргэшлийн хороо" гэх/ улсын хэмжээнд нэг байна.

86.2. Мэргэшлийн хороог есөн орон тооны бус гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд гишүүдийг Ерөнхий зөвлөл таван жилийн хугацаагаар томилно.

86.3. Мэргэшлийн хороо нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээр 10-аас доошгүй жил ажилласан шүүгч, эрдэмтэн, хуульчаас бүрдэнэ.

86.4. Мэргэшлийн хорооны зургаан гишүүн нь Улсын дээд шүүх буюу давж заалдах шатны шүүхийн шүүгч байх бөгөөд тэдгээрийг Шүүгчдийн зөвлөлөөс сонгож, Ерөнхий зөвлөлд санал болгоно.

86.5. Мэргэшлийн хорооны бусад гишүүдийг Ерөнхий зөвлөл нэр дэвшүүлж, томилно.

86.6. Мэргэшлийн хорооны бүрэлдэхүүнд анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.

86.7. Мэргэшлийн хорооны даргыг гишүүдийн санал болгосноор Ерөнхий зөвлөл томилж, чөлөөлнө.

86.8. Мэргэшлийн хороо шүүгч, Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс энэ хуульд заасан шалгалт авч, үнэлгээ өгөх, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн тогтоолыг үндэслэн шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшнийг тогтоож дүгнэлт гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

86.9. Мэргэшлийн хороо шүүгчийг ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшний хувьд албан тушаалдаа тэнцэхгүй гэж үзэн дүгнэлт гаргасан бол Ерөнхий зөвлөлд хүргүүлнэ.

86.10. Мэргэшлийн хорооны үйл ажиллагааны болон гишүүний ёс зүйн дүрмийг Ерөнхий зөвлөл батална.

86.11. Мэргэшлийн хорооны гишүүний үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

86.11.1. шүүн таслах ажиллагаанд хөндлөнгөөс оролцох;

86.11.2. шүүгчийн хараат бус байдалд аливаа хэлбэрээр нөлөөлөх;

86.11.3. нэр дэвшигчийн сонгон шалгаруулалтын болон үнэлгээ, шалгалтын баримт бичгийг урьдчилан ил болгох, тодорхой нэр дэвшигчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр байр сууриа илэрхийлэх;

86.11.4. нэр дэвшигчийн үнэлгээг үндэслэлгүйгээр өөрчлөх.

86.12. Мэргэшлийн хороо бие дааж, хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах нөхцөлийг Ерөнхий зөвлөл бүрдүүлнэ.

86.13. Шүүгчид нэр дэвшигчийн эрх зүйн мэдлэг болон шүүгчийн ажил хэргийн чадвар, мэргэшлийн түвшин шалгаж, дүгнэлт гаргахад шаардлагатай баримт бичиг бүрдүүлэх, судлах, шалгалтын ажлыг зохион байгуулах, нэр дэвшигчийг товлосон цагт бэлэн байлгах зэрэг Мэргэшлийн хороонд туслах чиг үүрэг чиг үүргийг Ерөнхий зөвлөлийн ажлын алба хэрэгжүүлнэ.

87 дугаар зүйл. Шүүгчид нэр дэвшигчийг бүртгэх

87.1. Энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан гэж үзсэн иргэн шүүгчид нэрээ дэвшүүлэх эрхтэй.

87.2. Шүүгчид нэр дэвшигч /цаашид "Нэр дэвшигч" гэх/ энэ хуулийн 32 дугаар зүйлд заасан болзол, шаардлагыг хангасан тухай баримтыг өргөдөл, анкет, байнга оршин суугаа газрын хаяг, гэр бүлийн болон эд хөрөнгийн байдлын тодорхойлолт, Монгол Улсын иргэний үнэмлэх, мэргэжлийн боловсролын диплом, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хөдөлмөр эрхэлж байгааг нотлох бусад баримт бичгийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбарын хамт Ерөнхий зөвлөлд цахимаар болон цаасаар хүргүүлнэ.

87.3. Ерөнхий зөвлөл нэр дэвшигчийн бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авч, бүрэн гүйцэд, үнэн зөв эсэхийг нягтлан шалгана.

87.4. Нэр дэвшигчийг бүртгэх, эсхүл бүртгэхээс татгалзах тухай Ерөнхий зөвлөлийн тогтоолыг цахим хуудас болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

87.5. Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийн талаар олон нийтээс хуульд заасан шаардлага хангасан хэлбэрээр ирүүлсэн мэдээллийг шалгана.

87.6. Ерөнхий зөвлөл шүүгчид нэр дэвшигчийг бүртгэж дууссаны дараа энэ хуулийн 88 дугаар зүйлд заасан үнэлгээ гаргуулахаар холбогдох баримт бичгийг Мэргэшлийн хороонд хүргүүлнэ.

88 дугаар зүйл. Мэргэшлийн хорооны үнэлгээ

88.1. Мэргэшлийн хороо Ерөнхий зөвлөлөөс шүүгчид нэр дэвшигчийг бүртгэсэн тухай холбогдох баримт бичгийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчээс суурь болон тусгай шалгалт, давж заалдах болон хяналтын шатны шүүхийн шүүгч, анхан болон давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгчид нэр дэвшигчээс шатлан дэвших зарчмыг үндэслэн тусгай шалгалт авч, хүн тус бүрээр үнэлгээ гаргана.

88.2. Суурь шалгалт нь монгол хэлний бичгийн болон ярианы чадвар, Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэг, мэдээллийн технологийн хэрэглээний программ ашиглах чадвар, эрх зүйн баримт бичгийн боловсруулалт, хууль хэрэглэх ур чадвар зэргээс бүрдэнэ.

88.3. Тусгай шалгалт нь хувь хүний зан төлөв, ёс зүй, нэр хүндийн байдал, Үндсэн хуулийн болон салбар эрх зүйн мэдлэг, шүүхийн шийдвэрт дүн шинжилгээ хийх чадвар, хуульчийн болон шүүгчийн ёс зүйн байдал, хууль тайлбарлан хэрэглэж эрх зүйн дүгнэлт өгөх чадвар, шүүн таслах ажиллагааны туршлага, удирдан зохион байгуулах авьяас, манлайлах ур чадвар зэргээс бүрдэнэ.

88.4. Мэргэшлийн хороо нэр дэвшигчээс шалгалт авч, хүн тус бүрээр гаргасан үнэлгээг онооны дарааллаар эрэмблэн холбогдох баримт бичгийн хамт Ерөнхий зөвлөлд 7 хоногийн дотор хүргүүлнэ.

88.5. Анхан шатны шүүхийн шүүгчид нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлтийг Ерөнхий зөвлөлд 7 хоногийн дотор хүргүүлнэ. Нэр дэвшигчийн мэргэшил, ур чадвар, нэр хүндийн талаарх дүгнэлт гаргах журмыг Ерөнхий зөвлөл батална.

88.6. Ерөнхий зөвлөл Мэргэшлийн хорооны үнэлгээг тухай бүр олон нийтэд мэдээлнэ.

88.7. Энэ зүйлийн 88.1-д заасан үнэлгээ хоёр жилийн хугацаанд хүчинтэй байна.

89 дүгээр зүйл. Шүүхийн тамгын газар

89.1. Шүүх Тамгын газартай байна.

89.2. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газар үйл ажиллагаагаа Шүүхийн ерөнхий зөвлөлд тайлагнана.

89.3. Шүүхийн тамгын газрын бүтэц, орон тоог тухайн шүүхийн ажлын ачаалал, онцлогийг харгалзан Шүүхийн ерөнхий зөвлөл батална.

89.4. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын үйл ажиллагааны нийтлэг журмыг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

89.5. Шүүхийн тамгын газар нь тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

90 дүгээр зүйл. Шүүхийн тамгын газрын чиг үүрэг

90.1. Шүүхийн тамгын газар захиргааны удирдлагын дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

90.1.1. энэ хуулийн 72-75-д заасан чиг үүргийг тухайн шүүх дээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

90.1.2. шүүхийг өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

90.1.3. шүүхийн хөдөлмөр зохион байгуулалт, дотоод журмын биелэлтэд хяналт тавих;

90.1.4. шүүхэд хэрэг, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авч, бүртгэх;

90.1.5. шүүхийн бичиг хэрэг, захидал харилцаа, шуудан, архивын үйл ажиллагааг зохион байгуулах;

90.1.6. шүүхийн эд хөрөнгийн бүртгэл, тооллого, эзэмшил, ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулж, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах арга хэмжээ авах;

90.1.7. хэргийн эд мөрийн баримтыг хадгалах, зөөвөрлөх, шийдвэрлэх,

90.1.8. тухайн шүүхийн шүүн таслах болон бусад ажиллагааны тоон мэдээлэл гаргах.

91 дүгээр зүйл. Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрх

91.1. Шүүхийн тамгын газрын дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

91.1.1. шүүхийн тамгын газрыг өдөр тутмын удирдлагаар хангах;

91.1.2. шүүхийн тамгын газрын ажилтныг томилох, чөлөөлөх;

91.1.3. шүүхийн тамгын газрын төсвийг захиран зарцуулах, тайлагнах;

91.1.4. шүүхийн тамгын газрын ажлын тайланг тухайн шүүхэдээ танилцуулах;

91.1.5. хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх

91.2. Шүүхийн тамгын газрын дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргана.

91.3. Улсын дээд шүүхээс бусад шүүхийн тамгын газрын дарга үйл ажиллагаагаа Шүүхийн ерөнхий зөвлөлийн өмнө хариуцан тайлагнана.

91.4. Шүүхийн тамгын газрын даргын бүрэн эрхийг Ерөнхий шүүгч болон шүүгч хэрэгжүүлэхийг хориглоно.

92 дугаар зүйл. Шүүхийн захиргааны ажилтан

92.1.1. Шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн тамгын газрын ажилтан нь шүүхийн захиргааны ажилтан байна.

92.2. Шүүхийн захиргааны ажилтан дараах шаардлагыг хангасан байна:

- 92.2.1. Монгол Улсын иргэн байх;
- 92.2.2. Төрийн албаны тухай хууль болон бусад хуульд заасан болзол, шаардлагыг хангасан байх;
- 92.2.3. эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй;
- 92.2.4. хуульд заасан ёс зүйн шаардлагыг хангасан байх;
- 92.2.5. тухайн ажил үүргийг гүйцэтгэх мэдлэг, боловсрол, туршлагатай байх.

93 дугаар зүйл. Шүүгчийн туслах

93.1. Шүүгч туслахтай байх бөгөөд шүүгчийн туслах эрх зүйч мэргэжилтэй хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан байна.

93.2. Шүүгчийн туслах шүүгчийн удирдлага дор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

93.2.1. шүүхэд ирүүлсэн тодорхой хэрэг, маргааны талаарх бичиг баримтын бүрдлийг судалж, шүүгчид танилцуулах;

93.2.2. хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан шүүгчээс даалгасан ажиллагааг гүйцэтгэх;

93.2.3. шүүгчийн үйл ажиллагаанд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх;

93.2.4. хэрэг, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай хууль тогтоомжийн талаар болон бусад мэдээлэл бэлтгэх зэргээр шүүгчид туслах;

93.2.5. хавтаст хэргийг хөтлөх;

93.2.6. тодорхой хэрэг, маргааны талаарх мэдээллийг нэгдсэн цахим санд оруулах;

93.2.7. шүүх хуралдааны бэлтгэл, зохион байгуулалтыг хангахад оролцох;

93.2.8. шүүхийн шийдвэр, тогтоол, шүүгчийн захирамжийн төсөл боловсруулах;

93.2.9. тэмдэгтийн хураамж төлөгдсөн эсэхийг хянах.

93.3. Шүүгчийн туслахаар гурваас доошгүй жил ажилласан анхан шатны шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад оролцох эрхтэй.

94 дүгээр зүйл. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга

94.1. Бүх шатны шүүхэд шүүх хуралдааны нарийн бичгийн дарга ажиллах бөгөөд нарийн бичгийн дарга эрх зүйч мэргэжилтэй байна.

94.2. Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга шүүх хуралдааныг даргалагчийн удирдлага доор дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

94.2.1. шүүх хуралдааны техник, зохион байгуулалтын бэлтгэлийг хангах;

94.2.2. шүүх хуралдааны тэмдэглэл хөтлөх;

94.2.3. шүүх хуралдааныг дуу болон дуу-дүрсний бичлэгээр баталгаажуулах;

94.2.4. шүүх хуралдааны тэмдэглэлийг хэргийн оролцогчид хуульд заасан хугацаанд танилцуулан, шүүгчээр баталгаажуулж, хэрэгт хавсаргах.

94.3. Шүүх хуралдааны тэмдэглэлийг мэдээллийн технологи ашиглан автоматаар бичиж болно.

95 дугаар зүйл. Шүүхийн захиргааны бусад ажилтан

95.1. Шүүхийн зохион байгуулалт, мэдээлэл зүйн болон аж ахуй, санхүү, архив, бичиг хэргийн ажил, аюулгүй байдал, техникийн үйлчилгээ зэргийг хариуцсан шүүхийн тамгын газрын ажилтны чиг үүргийг Шүүхийн ерөнхий зөвлөл тогтооно.

95.2. Шүүхийн захиргааны ажилтан энэ хуульд заасан чиг үүргээс гадна хэрэг, маргаан хянан шийдвэрлэх холбогдох хуульд заасан тусгай эрх, үүрэг болон төрийн захиргааны албан хаагчийн хувьд төрийн албаны тухай хууль тогтоомжид заасан нийтлэг эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

96 дугаар зүйл. Шүүхийн захиргааны ажилтны ёс зүй

96.1. Шүүхийн захиргааны ажилтан төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг дүрэм, хэм хэмжээг мөрдөхөөс гадна ёс зүйн дараах ерөнхий шаардлагыг биелүүлж ажиллана:

96.1.1. шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг, маргааны талаар тухайн хэргийн оролцогч, сонирхогч этгээдэд зөвлөгөө, мэдээлэл өгөхгүй, аливаа хэлбэрээр бусдад зуучлахгүй байх;

96.1.2. шүүхээр эцэслэн шийдвэрлэгдээгүй хэрэг, маргааны талаар хувийн таамаглал, урьдчилсан дүгнэлтээ бусдад илэрхийлэхгүй байх;

96.1.3. хэргийн оролцогчидтой хувийн харилцаа тогтоохгүй байх;

96.1.4. ажлын бус цагаар шүүхийн нэр хүндэд харшлах аливаа зохисгүй үйлдэл гаргахгүй байх;

96.1.5. шүүхэд хүндэтгэлтэй хандаж, ажлын байр, олон нийтийн дунд биеэ зөв авч явах.

97 дугаар зүйл. Шүүхийн захиргааны ажилтны ёс зүйн зөрчилд гомдол гаргах, түүнийг шийдвэрлэх

97.1. Шүүхийн захиргааны ажилтан мэргэжил, ёс зүйн зөрчил гаргасан гэж үзсэн этгээд тухайн шүүхийн тамгын газрын даргад гомдол гаргана.

97.2. Ёс зүйн шаардлагыг зөрчсөн шүүхийн захиргааны ажилтанд Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу эрх бүхий албан тушаалтан сахилгын шийтгэл оногдуулна.

98 дугаар зүйл. Шүүхийн захиргааны ажилтны сургалт

98.1. Шүүхийн захиргааны ажилтан Шүүхийн ерөнхий зөвлөлөөс зохион байгуулсан мэргэжлийн сургалтад хамрагдана.

АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРОО

99 дүгээр зүйл. Шүүхийн сахилгын хороо

99.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын бусад шийтгэл оногдуулах чиг үүрэг бүхий бие даасан байгууллага болох Шүүхийн сахилгын хороо /цаашид "Сахилгын хороо" гэх/ ажиллах бөгөөд улсын хэмжээнд нэг байна.

99.2. Сахилгын хороо есөн гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд энэ хуулийн 99.4-т заасан байгууллагаас томилогдсон тус бүр нэг гишүүн орон тооны, бусад нь орон тооны бус байна.

99.3. Сахилгын хорооны гишүүн нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хууль зүйн болон шүүн таслах ажиллагааны туршлагатай, эрх зүйч мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, шүүгч, хуульчаас бүрдэнэ.

99.4. Сахилгын хорооны гишүүнд Шүүгчдийн зөвлөлөөс гурав, Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос гурав, Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гурван хүнийг тус тус сонгож, томилно.

99.5. Анхан болон давж заалдах, хяналтын шатны шүүхийн шүүгчдээс тус бүр нэг шүүгчийг болон орон тооны гишүүнийг шүүгчдийн зөвлөл нийтээрээ, чөлөөтэй, шууд, тэгш сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, олонхийн саналаар сонгоно.

99.6. Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо болон хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр 3 хүнийг томилно.

99.7. Сахилгын хорооны бүрэлдэхүүнд Ерөнхий зөвлөлийн болон шүүхийн захиргааны байгууллагын ажилтан, өмгөөлөгч, прокурор орохыг хориглоно.

99.8. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд түүнийг 1 удаа улируулан сонгож, томилж болно. Гишүүний бүрэн эрх сонгож, томилсноор эхэлж, дараагийн гишүүн сонгогдож, томилогдсоноор дуусгавар болно.

99.9. Сахилгын хорооны орон тооны гишүүний албан тушаалын зэрэг зиндаа, цалин хөлс, орон тооны бус гишүүний ажилласан хугацааны урамшуулал олгох журмыг Улсын Их Хурал тогтооно.

99.10. Сахилгын хорооны дарга нь орон тооны гишүүн байх бөгөөд даргын бүрэн эрхийн хугацаа гишүүний бүрэн эрхийн хугацаатай адил байна.

99.11. Сахилгын хороо бүрэн эрхийнхээ хүрээнд гомдол, мэдээлэл, сахилгын хэргийг дангаар болон хамтын зарчмаар хянан хэлэлцэж, шийдвэрээ олонхийн саналаар гаргана.

99.12. Сахилгын хорооны дарга, гишүүн нь хүний эрхэм чанар, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, зарчимч, шударга байх, төвийг сахих, хууль дээдлэх, ялгаварлан гадуурхахгүй байх, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх, гишүүний үүрэгтээ үнэнч байх, гишүүний нэр хүндээ эрхэмлэх зарчмыг баримтална.

99.13. Сахилгын хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр хуралдаан байна.

99.14. Сахилгын хороо хуралдааныхаа дэгийг өөрөө тогтооно.

99.15. Сахилгын хорооны гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусахаас өмнө орон гарсан, эсхүл бүрэн эрхийн хугацаа дууссан бол тухайн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн гишүүнийг сонгосон эсхүл томилсон байгууллага энэ хуулийн 99.4-99.6-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

99.16. Сахилгын хорооны гишүүд сонгогдсон эсхүл томилогдсоноос хойш 7 хоногийн дотор Сахилгын хорооны нийт гишүүдийн зөвлөгөөн (цаашид "зөвлөгөөн" гэх)-ийг зохион байгуулна.

99.17. Сахилгын хорооны даргыг зөвлөгөөнөөс гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

99.18. Сахилгын хорооны дарга, гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх, заавар өгөх, үйл ажиллагаанд нь саад учруулахыг хориглоно.

99.19. Сахилгын хорооны ажлын албаны дарга, ажилтнуудын цалинг Засгийн газар тогтооно.

99.20. Ажлын албаны бүтэц, бүрэлдэхүүн, төсөв, ажлын албаны ажиллах журмыг Сахилгын хороо зөвлөгөөнөөр хэлэлцэж батална.

99.21. Сахилгын хорооны бие даан ажиллах, үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах, үндсэн чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх санхүүгийн баталгааг төр хангана.

99.22. Сахилгын хороо хэвлэмэл хуудас, тамга, тэмдэгтэй байна.

100 дугаар зүйл. Сахилгын хорооны даргын бүрэн эрх

100.1. Сахилгын хорооны дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

100.1.1. ажлын албыг удирдан зохион байгуулах, хуралдааныг даргалах, бүрэлдэхүүнийг томилох;

100.1.2. хуралдаан даргалагчийг гишүүдээс томилох, хуралдааныг товлон зарлах;

100.1.3. гомдол, мэдээлэл шалгасан гишүүний хүсэлтийн дагуу шалгах хугацааг 30 хоногоор сунгах, уг ажиллагааг түдгэлзүүлэх, сэргээх;

100.1.4. Сахилгын хороог дотоод, гадаад харилцаанд төлөөлөх;

100.1.5. өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар төрийн байгууллага, албан тушаалтантай харилцах;

100.1.6. хуралдааны бэлтгэл, шийдвэрийн биелэлтийг хангах, хяналт тавих;

100.1.7. ажлын албаны даргыг томилох;

100.1.8. төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд төсвийн төсөл боловсруулж, Улсын Их Хурал, Засгийн газарт өргөн мэдүүлэх;

100.1.9. ажлын тайланг нэгтгэж, Сахилгын хороо, Улсын дээд шүүх болон бусад шүүхүүд, Шүүгчдийн зөвлөлд танилцуулах;

100.1.10. хуульд заасан бусад бүрэн эрх.

100.2. Сахилгын хорооны даргын эзгүйд Сахилгын хорооны орон тооны хамгийн ахмад гишүүн орлоно.

100.3. Сахилгын хорооны дарга хуралдаанд таслах эрхтэй оролцох бөгөөд гишүүний бүрэн эрхийг нэгэн адил хэрэгжүүлнэ.

100.4. Сахилгын хорооны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал, захирамж гаргана.

101 дүгээр зүйл. Сахилгын хорооны гишүүний эрх

101.1. Сахилгын хорооны гишүүн /цаашид "Гишүүн" гэх/ дараах эрхийг хэрэгжүүлнэ:

101.1.1. гомдол, мэдээллийг шалгахтай холбогдуулан оролцогчийг дуудан ирүүлэх, нотлох баримт гаргуулж авах, цуглуулах, хууль сануулж тайлбар авах;

101.1.2. гомдол, мэдээллийн дагуу шүүгчид сахилгын хэрэг үүсгэх, үүсгэхээс татгалзах;

101.1.3. сахилгын хэргийг шалгаж шийдвэрлэх бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;

101.1.4. ажлын албаны ажилтанд даалгавар өгөх;

101.1.5. Сахилгын хорооны хуралдаанд таслах эрхтэй оролцох;

101.1.6. шаардлагатай тохиолдолд Сахилгын хорооны даргад гомдол, мэдээллийг шалгах ажиллагааны хугацаа сунгах, түдгэлзүүлэх, сэргээх тухай хүсэлт гаргах;

101.1.7. хуульд заасан бусад бүрэн эрх.

102 дугаар зүйл. Сахилгын хорооны дарга, гишүүдийн үүрэг

102.1. Сахилгын хорооны дарга, гишүүн дараах үүрэгтэй.

102.1.1. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хараат бусаар гүйцэтгэж, гишүүний хараат бус байдалд хүндэтгэлтэй хандах;

102.1.2. албаны үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль зүйн мэдлэг, ур чадварыг эзэмших, шүүгчийн ёс зүй, сахилгын талаарх сургалтад хамрагдах, бие даан суралцах;

102.1.3. ажилдаа чин сэтгэлээсээ хандаж, хүчин чармайлт гаргах, шуурхай, зохион байгуулалттай ажиллах;

102.1.4. өөрийн эсхүл бусдын хувийн ашиг сонирхлыг хангах зорилгоор уг албан тушаалын нэр хүндийг урвуулан ашиглах, зохисгүй байдал гаргахгүй байх;

102.1.5. сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэг талыг байлцуулахгүйгээр нөгөө талтай харилцах, тийм санаачилга гаргах, зөвшөөрөх;

102.1.6. бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад олж авсан төрийн болон албаны, байгууллагын, хувь хүний нууцтай холбоотой мэдээллийг албан үүрэгтэйгээ холбоогүй зорилгоор задруулах, ашиглах;

102.1.7. өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдсөнөөс бусад тохиолдолд шүүхэд хэрэг, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, бусдыг төлөөлөх;

102.1.8. сахилгын хэргийн оролцогч болон хянан шийдвэрлэх ажиллагаанд ашиг сонирхол нь хөндөгдөх этгээдээс бэлэг, зээл, эд хөрөнгө, хандив, үйлчилгээ, бусад үнэ бүхий зүйл авах;

102.1.9. хараат бус, төвийг сахих байдалд харшлах улс төрийн үйл ажиллагаанд оролцох.

102.1.10. хуульд заасан бусад үүрэг.

102.2. Дарга, гишүүн дараах тохиолдолд сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарах үүрэгтэй:

102.2.1. гомдлыг өөрөө, эсхүл түүний ажилладаг байгууллага гаргасан,

102.2.2. хэргийн оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садан, хэргийн оролцогчтой хувийн харилцаатай;

102.2.3. ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон;

102.2.4. тухайн хэргийг шударгаар шийдвэрлэж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээ байвал;

102.2.5. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албан тушаалтанд тавигдах хориглолт, хязгаарлалтыг сахин мөрдөх.

102.3. Сахилгын хорооны гишүүний ёс зүйн дүрмийг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр батална.

103 дугаар зүйл. Сахилгын хэргийн оролцогчийн эрх, үүрэг

103.1. Хэргийн оролцогч сахилгын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах эрх, үүрэгтэй оролцоно.

103.1.1. гомдол, мэдээлэл, шалгалтын баримт бичигтэй танилцах, тэмдэглэл хийх, баримтыг хуулбарлан авах, амаар болон бичгээр тайлбар гаргах, төлөөлөгч, өмгөөлөгч авах, нотлох баримт гаргаж өгөх;

103.1.2. Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдаанд биечлэн оролцох, тайлбар гаргах, хуралдааныг хойшлуулах талаар хүсэлтийг нэг удаа бичгээр гаргах;

103.1.3. Сахилгын хорооны гишүүнээс хуульд заасан үндэслэлээр татгалзах хүсэлт гаргах;

103.1.4. хэргийн оролцогч монгол хэл мэдэхгүй, эсхүл хэлгүй, дүлий, бичгээр харилцах чадваргүйн улмаас мэргэжлийн болон бусад шаардлагатай туслалцаа авах боломжгүй бол ажлын албанаас орчуулагч, хэлмэрч, өмгөөлөгч, төлөөлөгчийн тусламж авах;

103.1.5. гишүүний гаргасан захирамж, сахилгын хорооны тогтоол, магадлалыг эс зөвшөөрч, энэ хуульд заасны дагуу гомдол гаргах;

103.1.6. хуралдааны танхимд байгаа хэргийн оролцогчид болон бусад хүмүүс Сахилгын хороог хүндэтгэх, хуралдааны танхимд тогтоосон дэгийг сахих, хуралдаан даргалагчийн шийдвэрт захирагдах;

103.1.7. хэргийн оролцогч тайлбар өгөх, гишүүдийн асуусан асуултад хариулахдаа суудлаасаа босно. Өвчний улмаас хэргийн оролцогч хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр суудлаасаа босолгүй үг хэлэх.

103.2. Хэргийн оролцогч дуу, дуу-дүрсний бичлэг хийх, утсаар ярихыг хориглоно. Энэ хориглолт нь энэ хуульд заасны дагуу хуралдааны тэмдэглэл хөтлөх зорилгоор дуу, дуу-дүрсний бичлэг хийхэд үйлчлэхгүй.

103.3. Согтуурсан буюу мансуурсан этгээдийг хуралдаанд оруулахыг хориглоно. Хуралдааны дэг зөрчсөн этгээдэд хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Дахин зөрчил гаргасан этгээдийг хуралдаан даргалагч хуралдааны танхимаас гаргаж энэ тухай хуралдааны тэмдэглэлд бичиж, хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

104 дүгээр зүйл. Сахилгын хорооны ажлын алба

104.1. Сахилгын хороо ажлын албатай байх бөгөөд дарга нь хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, шүүхийн ажлын дадлага туршлагатай, эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй Монгол Улсын иргэн байна.

104.2. Ажлын алба нь дарга, гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

104.3. Ажлын албаны дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

104.3.1. Ажлын албыг өдөр тутмын удирдлагаар хангах, ажилтанг томилж, чөлөөлөх, төсвийг захиран зарцуулах, ажлын тайланг Сахилгын хороонд тайлагнах;

104.3.2. хуульд заасан бусад бүрэн эрх.

104.4. Ажлын албаны үйл ажиллагааг Сахилгын хорооны зөвлөгөөнөөр баталсан дүрмээр зохицуулна.

104.5. Ажлын албанд сахилгын хэргийг хянан шалгах нэгж байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

104.5.1. Сахилгын хороонд харьяалагдах гомдол, мэдээллийг ажлын албаны бичиг хэргийн ажилтнаас хүлээн авч бүртгэх, Сахилгын хорооны даргад танилцуулах, хуваарилагдсан гишүүнд шилжүүлэн өгөх;

104.5.2. гомдол, мэдээлэл гаргагчид туслалцаа үзүүлэх, Сахилгын хорооны үйл ажиллагаа, журам, хяналт шалгалтын явцын талаар мэдээлэл өгөх;

104.5.3. Сахилгын хорооны болон ажлын албаны дарга, гишүүний өгсөн үүрэг, даалгаврыг зохих журмын дагуу шуурхай гүйцэтгэх;

104.5.4. гишүүдэд шалгалтын үр дүнгийн талаар танилцуулга бэлтгэхэд нь туслах;

104.5.5. гишүүдийг шаардлагатай хууль тогтоомж, холбогдох мэдээллээр хангах;

104.5.6. дарга, гишүүдэд техник, зохион байгуулалтын туслалцаа үзүүлэх.

104.5.7. харьяаллын бус, хуульд заасан шаардлага хангаагүй гомдол, мэдээллийг гишүүнд танилцуулж, буцаах шийдвэр гаргуулах;

104.5.8. Сахилгын хорооны хуралдааны бэлтгэлийг зохион байгуулах, шийдвэрийг албажуулах, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлөөр хангах;

104.5.9. Сахилгын хорооны шийдвэр, албан бичиг бусад баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх;

104.5.10. гомдол, мэдээлэл, Сахилгын хорооноос гаргасан шийдвэрийн талаар бүртгэл хөтөлж, тайлан гаргах;

104.5.11. сахилгын хэрэг, сахилгын хорооны шийдвэр, албан бичиг, бусад баримт бичгийг хадгалах, хамгаалах, зохих журмын дагуу архивлах;

104.5.12. хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ САХИЛГЫН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ

105 дугаар зүйл. Шүүгчид холбогдох сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ерөнхий нөхцөл

105.1. Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа нь энэ хууль болон Шүүгчийн ёс зүйн дүрмээр тогтоосон шүүгчийн ёс зүйг зөрчсөн тухай гомдол, мэдээлэл /цаашид "гомдол, мэдээлэл" гэх/-ийг хүлээн авах, шалгах, хянаж шийдвэрлэх, давж заалдах болон хяналтын журмаар гомдол гаргах, шийдвэрлэх ажиллагаанаас бүрдэнэ.

105.2. Сахилгын хороо шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэхдээ хууль дээдлэх, шударга, ил тод байх, төвийг сахих, гомдол, мэдээллийг заавал хянан шийдвэрлэх зарчмыг мөрдлөг болгоно.

105.3. Гомдол, мэдээллээсээ татгалзсан эсэхээс үл хамааран сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг заавал явуулна.

105.4. Сахилгын хороо гомдол, мэдээлэл шалгах явцад гомдол мэдээлэлд дурдагдаагүй боловч Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн байж болзошгүй үйл баримт илэрвэл хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.

105.5. Гомдол, мэдээлэл гаргагч, шүүгч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг сахилгын хэргийн оролцогч гэнэ.

105.6. Сахилгын хороо иргэд, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдол, мэдээллийг 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ.

106 дугаар зүйл. Гомдол, мэдээлэл гаргах

106.1. Шүүгчийн ёс зүйн дүрмийг зөрчсөн гэж үзсэн иргэн, албан тушаалтан, хуулийн этгээд шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр Сахилгын хороонд гомдол, мэдээлэл гаргана.

107 дугаар зүйл. Гомдол, мэдээллийг хүлээн авах, хуваарилах

107.1. Гомдол, мэдээллийг ажлын албаны ажилтан хүлээн авч, хавсаргасан баримт, хуудасны тоог бүртгэх дэвтэрт бичиж, гарын үсэг зуруулан, баримт үйлдэх ба хуудасны тоо, огноо, цаг, минутыг тэмдэглэн баталгаажуулна.

107.2. Ажлын албаны ажилтан гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш 3 хоногийн дотор Сахилгын хорооны даргад танилцуулна.

107.3. Сахилгын хорооны дарга гомдол, мэдээллийг шалгуулахаар гишүүдийн нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар 3 хоногт багтаан хуваарилна. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас дээрх журмыг хэрэглэх боломжгүй тохиолдолд дараагийн гишүүнд нэн даруй хуваарилна.

108 дугаар зүйл. Гомдол, мэдээллийг шалгах

108.1. Гишүүн гомдол, мэдээллийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор шалгаж, сахилгын хэрэг үүсгэх, эсхүл үүсгэхээс татгалзах тухай захирамж гаргана.

108.2. Гишүүн гомдол, мэдээллийн хувийг шүүгчид тайлбар авахаар хүргүүлнэ. Шүүгч гомдол, мэдээллийн хувийг хүлээн авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор тайлбар, нотлох баримтын хамт тухайн гишүүнд хүргүүлнэ.

108.3. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нотлох баримт нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31-42 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан байна. 108.4. Гишүүн шаардлагатай гэж үзвэл захирамж гарган нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах даалгаврыг ажлын албаны ажилтнаар гүйцэтгүүлэх бөгөөд захирамжид ажилтны хийх ажлын үндсэн чиглэлийг тодорхой заана.

108.5. Гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд иргэн, төрийн болон бусад байгууллага, албан тушаалтнаас дэмжлэг үзүүлэх, шаардлагатай нотлох баримт, мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

108.6. Сахилгын хорооны дарга гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн үндэслэл арилмагц хэргийн оролцогч болон гишүүний хүсэлтээр хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж, хугацааг үргэлжлүүлэн тоолно.

109 дүгээр зүйл. Сахилгын хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа, бүрэлдэхүүн

109.1. Сахилгын хэргийг анхан шатны журмаар хянан хэлэлцэж, шийдвэрлэх хуралдаанд шүүгч, хэргийн оролцогч оролцож болно. Шүүгч, гомдол, мэдээлэл гаргагч хуралдаанд оролцох хүсэлтээ бичгээр гаргасан боловч хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүрэлцэн ирээгүй бол хуралдааныг тэдгээрийн бичгээр гаргасан хүсэлтийн дагуу нэг удаа хойшлуулж болно.

109.2. Хэргийн оролцогчдод хуралдааны товыг мэдэгдсэн боловч оролцох хүсэлтээ бичгээр ирүүлээгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй нь хуралдааныг хойшлуулах үндэслэл болохгүй.

109.3. Бүрэлдэхүүнд орсон гишүүнийг татгалзан гаргах тухай хэргийн оролцогчоос хүсэлт гаргавал тухайн гишүүнийг байлцуулахгүйгээр бүрэлдэхүүн уг асуудлыг шийдвэрлэнэ. Бүрэлдэхүүний санал тэнцсэн тохиолдолд тухайн гишүүнийг татгалзан гаргаж, хуралдааныг хойшлуулах тухай тогтоол гаргана. Харин бүрэлдэхүүнээр нь буюу олонхыг татгалзан гаргах хүсэлт гаргавал Сахилгын хорооны дарга 2 өдрийн дотор шийдвэрлэнэ.

109.4. Гишүүний гаргасан захирамжийг хэргийн оролцогчоос эс зөвшөөрсөн гомдлыг анхан шатны журмаар 5 гишүүний бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж тогтоол гаргана. Тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд тогтоолд даргалагч, гишүүд гарын үсгээ зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд тогтоолд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

109.5. Сахилгын хорооны тогтоолыг хэргийн оролцогчоос эс зөвшөөрч гаргасан гомдлыг давж заалдах журмаар гишүүдийн гуравны дөрвөөс доошгүйн ирцтэйгээр хянан хэлэлцэж, хуралдаанд оролцогчдын олонхын саналаар шийдвэрлэж магадлал гаргана. Магадлал танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд магадлалд даргалагч, гишүүд гарын үсгээ зурж, тамга дарж албажуулна. Бүрэлдэхүүнд орсон гишүүд магадлалд гарын үсэг зурахаас татгалзах эрхгүй.

109.6. Нэг шүүгчид холбогдуулан гаргасан хэд хэдэн гомдол, мэдээлэл, мөн хэд хэдэн шүүгчид холбогдуулан гаргасан нэг агуулга бүхий гомдол, мэдээллийг нэгтгэн шалгаж, хянан шийдвэрлэнэ.

109.7. Ажлын албаны ажилтан хуралдаан болохоос 7 хоногийн өмнө товыг хэргийн оролцогчдод мэдэгдэж, энэ тухай баримт үйлдэж хэрэгт хавсаргана.

109.8. Анхан болон давж заалдах шатны хуралдаан болохоос 3 хоногийн өмнө ажлын албаны ажилтан захирамж, тогтоол, бусад баримтыг хувилж, хуралдаанд оролцох гишүүдэд хүргүүлнэ.

109.9. Анхан болон давж заалдах шатны хуралдаанаас гаргах тогтоол, магадлал нь удиртгал, тодорхойлох, үндэслэх, тогтоох хэсэгтэй байна.

109.9.1. удиртгал хэсэгт тогтоол, магадлалыг хэзээ, хаана гаргасан, бүрэлдэхүүнд орсон гишүүдийг нэрлэн заана;

109.9.2. тодорхойлох хэсэгт гомдол гаргагчийн гомдол болон шүүгчийн тайлбарын агуулгыг тусгана;

109.9.3. үндэслэх хэсэгт гэрчийн мэдүүлэг, шинжээчийн дүгнэлт, шалгалтын танилцуулга зэрэг гомдлыг хянан шийдвэрлэхэд үндэс болсон нотлох баримтыг үнэлж, хууль зүйн үндэслэл, түүнийг хэрхэн дүгнэсэн тухай заана;

109.9.4. тогтоох хэсэгт гомдлыг хянан шийдвэрлэхэд үндэслэсэн хуулийн болон Шүүгчийн ёс зүйн дүрмийн холбогдох заалт, шийтгэлийн төрөл гомдол гаргах журмыг тодорхой тусгасан байна.

109.9.5. захирамж, тогтоол, магадлалын тогтоох хэсэг нь захиран тушаах хэлбэртэй байна.

109.10. Ажлын алба нь сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн захирамж, тогтоол, магадлалыг албажуулснаас хойш 7 хоногийн дотор хэргийн оролцогчдын оршин суугаа /оршин байгаа/ газар болон ажлын газрын аль нэг хаягаар баталгаат шуудангаар, эсхүл ажлын албаны ажилтнаар хүргүүлнэ.

109.11. Энэ хуулийн 109.10-т заасны дагуу хүргүүлснээр захирамж, тогтоол, магадлалыг гардан авсанд тооцно.

109.12. Ажлын албаны ажилтан захирамж, тогтоол, магадлалыг хэргийн оролцогчдод гардуулан өгсөн буюу хүргүүлсэн тухай баримт үйлдэж, хэрэгт хавсаргах бөгөөд энэ нь гомдол гаргах хугацаа тоолох үндэслэл болно.

110 дугаар зүйл. Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдаан

110.1. Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдаан доорх дарааллаар явагдана:

110.1.1. Сахилгын хорооны хуралдаан даргалагч хуралдааныг нээж, хянан шийдвэрлэх гэж байгаа хэргийн талаар мэдэгдэнэ;

110.1.2. хуралдааны ирцийг нарийн бичгийн дарга бүртгэж, ирээгүй оролцогчид, хуралдааны товыг урьдчилан мэдэгдсэн эсэх, ямар шалтгаанаар ирээгүй болохыг хуралдаан даргалагчид танилцуулна;

110.1.3. хэргийн оролцогчидтой танилцаж, төлөөлөх, өмгөөлөх бүрэн эрхийг шалгаж, эрх, үүргийг тайлбарлана;

110.1.4. хуралдаан даргалагч бүрэлдэхүүнийг танилцуулан, татгалзан гаргах эрхийг хэргийн оролцогчдод тайлбарлан өгнө;

110.1.5. шинээр нотлох баримт гаргаж өгөх эсэхийг асууна;

110.1.6. хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэнэ;

110.1.7. гишүүн сахилгын хэргийн талаар илтгэж, хэрэгт авагдсан нотлох баримтууд, гомдол, мэдээллийн шалгалтын талаар танилцуулна;

110.1.8. гомдол гаргагчийн гомдлын үндэслэлийг сонсоно;

110.1.9. хэргийн оролцогчдын тайлбарыг сонсоно;

110.1.10. нотлох баримтыг шинжлэн судална;

110.1.11. гишүүд хуралдаанд оролцогчдоос асуулт асууж, хариулт авна;

110.1.12. хэргийн оролцогчдоос нэмэлт тайлбарыг сонссоны дараа хуралдаан завсарлаж, бүрэлдэхүүн шийдвэр гаргахаар зөвлөлдөх тасалгаанд орно.

110.2. Зөвлөлдөх үед гишүүд хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хурааж, олонхын саналаар шийдвэрлэнэ. Гишүүдийн санал тэнцвэл захирамж, Сахилгын хорооны тогтоол хэвээр үлдэнэ. Гишүүн санал өгөхөөс татгалзах, түдгэлзэх эрхгүй. Гишүүд нэрийн эхний үсгийн цагаан толгойн дарааллаар саналаа хэлнэ. Зөвлөлдөх явцад гаргасан гишүүний санал нууц байна.

110.3. Сахилгын хорооны анхан болон давж заалдах шатны хуралдааныг нээлттэй явуулна. Хэргийн нотлох баримт, үйл явдал нь төрийн болон албаны, хувь хүний нууцад хамаарах бол хэргийн оролцогчийн хүсэлтээр, эсхүл гишүүдийн санаачилгаар хуралдааныг бүрэн, эсхүл зарим хэсгийг хаалттай явуулж болно.

110.4. Сахилгын хорооны захирамж, анхан болон давж заалдах хуралдааны тогтоол, магадлал хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байна.

110.5. Анхан болон давж заалдах шатны хуралдааны тэмдэглэлийг ажлын албаны ажилтан хөтөлж, 3 хоногийн дотор албажуулж, тэмдэглэлд хуралдаан даргалагч болон ажилтан гарын үсэг зурж, тэмдэг дарна.

111 дүгээр зүйл. Захирамж, тогтоол, магадлалд гомдол гаргах

111.1. Захирамж, тогтоол, магадлалыг хэргийн оролцогчид хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гомдол гаргах эрхтэй .

111.2. Гомдлыг ажлын албаны ажилтан хүлээн авч, хэргийн бусад оролцогчдоод танилцуулан тайлбар гаргуулан хэрэгт хавсаргана.

111.3. Захирамж, тогтоол, магадлалд хэргийн оролцогчоос гомдол гаргасан тохиолдолд шийдвэрийн биелэлт түдгэлзэнэ.

111.4. Гомдлыг сахилгын хороо анхан болон давж заалдах шатны хуралдаанаар, Улсын дээд шүүх хяналтын шатны журмаар 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

111.5. Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдааны магадлалыг эс зөвшөөрч гаргасан гомдлыг Улсын дээд шүүх танхим харгалзахгүйгээр 5 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэх бөгөөд бүрэлдэхүүнийг нийт шүүгчдээс тохиолдлын журмаар сонгож Ерөнхий шүүгч томилно.

111.6. Хяналтын шатны шүүх хуралдаан хэзээ хаана болохыг хэргийн оролцогчдоод Улсын Дээд шүүхийн шүүгчийн туслах мэдэгдэж, баримтыг хэрэгт хавсаргана.

111.7. Хэргийн оролцогчдоод шүүх хуралдааны товыг мэдэгдсэн боловч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шүүх хуралдаанд ирээгүй нь хэргийг хянан шийдвэрлэхэд саад болохгүй.

111.8. Улсын дээд шүүх сахилгын хорооны хэргийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 127 дугаар зүйлд заасан журмын дагуу хянан шийдвэрлэж тогтоол гаргана.

111.9. Хяналтын шатны шүүхийн тогтоол гармагц хуулийн хүчин төгөлдөр болох бөгөөд эцсийн шийдвэр байна.

112 дугаар зүйл. Сахилгын хорооны анхан шатны хуралдааны шийдвэр

112.1. Анхан шатны хуралдаанаар сахилгын хэргийг хянан хэлэлцээд дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

112.1.1. захирамжийг хэвээр үлдээх, хүчингүй болгох;

112.1.2. шүүгчид сахилгын шийтгэл оногдуулах;

112.1.3. сахилгын хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, шүүгчийг цагаатгах;

112.1.4. шүүгчид сахилгын хэрэг үүсгүүлэхээр ажлын албанд шилжүүлэх,

112.1.5. сахилгын хэргийг дахин шалгуулахаар ажлын албанд хүргүүлэх;

112.1.6. Шүүгчийн гэмт хэргийн шинжтэй үйлдлийг шалгуулахаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх.

113 дугаар зүйл. Сахилгын хорооны давж заалдах шатны хуралдааны шийдвэр

113.1. Сахилгын хэргийг давж заалдах шатны хуралдаанаар хэлэлцэж, шийдвэр гаргахдаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117, 118, 119, 120, 121 дүгээр зүйлд заасан журмыг баримтална.

114 дүгээр зүйл. Сахилгын хороо шүүгчийг огцруулах үндэслэл

114.1. Сахилгын хороо дараах үндэслэлээр шүүгчийг огцруулна:

114.1.1. Шүүгчийн албан тушаалтай хавсарч үл болох үйл ажиллагаа эрхэлсэн;

114.1.2. огцруулахаас бусад сахилгын шийтгэл хүлээсэн шүүгч нэг жилийн дотор сахилгын шийтгэл дахин хүлээсэн;

114.1.3. Шүүгчийн ёс зүйн дүрмийг ноцтой зөрчсөн;

114.1.4. гэм буруутайд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

114.2. Сахилгын хороо Улсын дээд шүүхийн шүүгчийг огцруулсан бол Улсын Их Хуралд, бусад шүүгчийг огцруулсан бол шийдвэрийг Ерөнхийлөгчид тус тус танилцуулна.

115 дугаар зүйл. Шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл, тайлан

115.1. Ажлын алба шүүгчийн сахилгын хэргийн бүртгэл хөтөлж, Сахилгын хорооны үйл ажиллагааны тайланг гаргана.

115.2. Энэ хуулийн 115.1-д заасан бүртгэл, тайланд хамаарах мэдээлэл хөтлөх журмыг Сахилгын хороо батална.

116 дугаар зүйл. Сахилгын хорооны шийдвэрийг цахим хуудаст байрлуулах, олон нийтэд мэдээлэх

116.1. Гишүүний гаргасан захирамж, Сахилгын хорооны тогтоол, магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 7 хоногийн дотор ажлын албаны ажилтан цахим хуудсанд байршуулна.

117 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

117.1. Энэ хуулийг 2020 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ